



**ХАР**ДОМЫН

**ТАЙЛАГДАШГҮЙ**  
НУУЦААС

ДЭВТЭР

5

Ид шид хар домын тайлагдашгүй нууцаас V

Эмхэтгэсэн: Маш нууц сонины газар

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Чөтгөр болсон андыгаа “хороож” нялх хүүхдийг аварсан түүх

Андын ариун тангараг тавьсан нөхөд гэдэг хэзээ ч нэгнийгээ өршөөн хэлтрүүлж, өмөөрч өмөлзөж явдаг гэнэ. Үнэхээр ч тийм бололтой. “Нууц товчоо” хэмээх үлгэрт гарч буйгаар өөрийг нь даран сөнөөх гэж улангассан, андын ёсыг умартсан Жамухыг Чингис хаан огт буруутгахгүй, харин ч өөрийнхөө дэргэд шадарлан сууж, эрх ямба эдлэхийг хүсдэг. Энэ мэт анд нөхдийн хагацашгүй цул нөхөрлөлийн тухай өгүүлсэн үлгэр домог, ном зохиол олон бий. Энэ бүхэн амьдрал дээр ч гэсэн биелж, бид бүхний нүдний өмнө өрнөж байдаг. Тэр бүү хэл Ертөнцийн бодит чанараас хагацаж сүнс хий үзэгдэл болсон анд нөхөр ч гэсэн нэгийгээ үгүйлэн санаж, үнэнчийн тангаргаа барьж явдаг байна.

Батхүү, Цэрэндондог хэмээх хоёр залуу хар багаасаа л үерхэж нөхөрлөн, тараг хоормог, ширхэг хуруудаа хүртэл хувааж иддэг байжээ. Чухамдаа тэдний эр бие тэгширсэн 1950-иад оны үед ч гэсэн нийгмийн дотор үнэнч сайхан нөхөрлөлийн талаарх үг сургамж элбэг байсан аж.

Урт мориндоо сундалдаж

Уужим дээлэндээ багтаж нөхөрлөдөг тухай сонсоогүй хүн үгүй биз. Батхүү, Цэрэндондог хоёр ёстой л урт мориндоо сундалдаж өссөн аж. Тэр хоёр уйлахдаа хүртэл нэг доор уйлна, инээхдээ бас нэг агшинд инээнэ. Энэ нь тэднийг дандаа хамт байж, буруу зөвийг цугтаа л хийж өссөн гэсэн үг л дээ.

Батхүү төрөлхийн хөл хазгар төрсөн. Гэхдээ чинээлэг айлын эрх танхи хүүхэд болохоор бие эрхтэнийхээ гажгийг мэдэхгүй өсчээ. Тэд 18 нас хүрч цэрэгт мордох болж,

Цэцэг нуурын хөвөөнөөс

Цэргийн албанд мордлоо доо хө хэмээн дуулалдан айл ах, дүүсээр орж, айраг цагаа эргүүлсээр морин “цэргийн” цуваагаар гарч өгсөн байна. Батхүү, Цэрэндондог хоёр ирээдүйн амьдралын сайн сайхныг мөрөөдөн хэлэлцэж, болж өгвөл бас л цугтаа нэг ангид хуваарилагдчих юмсан гэж хүртэл хүсч байв. Гэтэл Батхүү хөл муутайгаасаа цэрэгт тэнцэлгүй үлдэж, Цэрэндондог хот руу хөдлөх цэрэг татлагын машинд сууснаар салашгүй садан, сольшгүй содон болсон хоёр найз хагацан салжээ.

Цаг хугацаа гэдэг бүгдийг өөрчилж, бас мартуулж чаддаг болохоор Цэрэндондог ижил дасал болсон олон нөхдийнхөө дотор бужигнаж наадсаар хар багынхаа хазгар муу найзыгаа мартагнасан байна. Гэхдээ ар гэртээ захиа бичихдээ Батхүүгийнхээ мэнд амрыг асууж, өөрт нь захиа бичихийг сануулсан хэдэн өгүүлбар тавьдаг л байв.

Цэргээс халагдаад Цэрэндондог хотод үлдэж, говь нутгийн бүсгүйтэй гэр бүл болон үйлдвэрийн ажилчин хэмээн өөрөөрөө бахархаж байв. Үнэхээр ч тухайн үед хар ажилчдыг ажилчин анги төлөвшлөө хэмээн онгироож ялтай мал хариулсан малчдыг нэгдэлчин хэмээн адислаж байсан үе. Ажилчин ангийн эгнээнд элсэж эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө ажилласаар Цэрэндондог нутаг усандаа очилгүй арваад оныг үджээ. Үнэндээ аав, ээж нь

цөөн малаа зараад түүнийг цэргээс халагдахаас өмнө хот бараадсан байсан болохоор нутаг усаагэх сонирхол төдий л төрөхгүй өдий хүрсэн байв. Хот газар арав гаруй оныг үдээд, амьдрал тогтож үсэнд нь ганц нэг цагаан ширхэг үзэгдээд нэмэгдээд ирэхээр хүн чинь нутагтаа очиж хүүхэд нас, халуун залуугийнхаа дурдатгалыг сэргээж өөрийгөө эрч хүчээр сэлбэх бодол өвөрлөдөг байна.

Цэрэндондогийг нутагтаа очоод эхэлж ам нээхэд гарсан үг нь багын найз Батхүүгийн нь нэр байлаа. Батхүү аав, ээжээс ганцаар бөгөөд эрх танхидуу өссөн болохоор амьдралд нуруу туядаж мэдэх хүн байв. Аав, ээжийгээ нас барсанаас хойш сэтгэл санаагаар унаж, гашуун ундаанд орж хувь тавилангаа жигшиж зэвүүцсэн хүн л явах болов. Үеийнхэн нь түүнд үнэн үг хэлж, амьдралын ухаарал хайрласан нь нэгээхэн ч үгүй. Батхүү согтохоороо “Муу Цэрэндондог, чи надаас урвасан шүү” гэж гашуунаар үгэлж тархи толгойгоо баруун зүүнгүй балбадаг байв.

Энэ бүхнийг Цэрэндондогт уулзсан анхны хүн хэлэв. Ингэж уртавтар оршил хэлсэн нь Батхүүг нас барсныг хэлэх ивээс болгожээ. Цэрэндондогт жаахан эвгүй байв. Гэхдээ нутгийн ханагар нь “Батхүү чөтгөр болсон шүү. Баараггүй” гэж хэлээд хэн нэгнээс зугтах мэт мориндоо ташуур өгөн давхижээ.

Цэрэндондог нутагтаа очоод үнэхээр сайхан амрав. Гэхдээ цээж рүү нь хүйтнээр урсах нэгэн зүйл байсан нь Батхүүг чөтгөр болсон тухай яриа байлаа. Түнгэт хэмээх дэрс хулстай хөндийд Батхүү согтуу явж байгаад мориндоо чиргүүлж үхсэн юм гэнэ. Тэгээд тэр газар гүйдэлтэй гэгдэх болж, хаваржаа намаржааны бэлчээр болсон тэр хөндийд хүн мал очихгүй шахам болжээ. Шилрээд алга болчихсон ингээ хайж явсан

Янжив өвгөн Түнгэт хөндийд байхад нь дурангаар хараад очиж авч чадалгүй тэмээгээ гарч ирэхийг хүлээж ойролцоох айлд хонож өнжсөн ч удаатай гэнэ. Батхүү гэдэг нэртэй хүн Түнгэтийн чөтгөр болохдоо л ёстой нэг хүмүүсийг шуугиулж амьддаа хүртэл олны аманд ингэж завьжуулж байгаагүйгээрээ “хүлхүүлжээ”.

Цэрэндондог бодож байв. Хар багынхаа сайн нөхөртэйгөө уулзаж чадаагүй ч гэсэн сүнстэй нь уулзаж болох юм гэж. Тэр сүүлдээ өөрийнхөө энэ байдлыг маш зөв гэж итгэжээ. Тэгээд нэг орой богц цүнхэнд хоол унд төхөөрөөд, бас ганц галуун хүзүүт аваад Түнгэтийг зорьжээ. Хүн малын мөр эс хүрэх атар онгон Түнгэтийн хөндийд өвс ногоо халиурч, байгаль дэлхийн үзэмж төгөлдөр байдлыг илүүтэй бүрдүүлжээ.

Үдшийн гялаан тэмдгэрэх үед Цэрэндондог гурван чулуу тулгалан цай чанаж аваачсан махаа чанаж, бас галуун хүзүүтээ мултлаад нэг дугтарсан шигээ сууж байв.

Гэтэл гэнэт ард нь “Энэ чинь Дондогоо юу даа?” гэх Батхүүгийн дуу гарчээ. За даа ирлээ дээ гээд Цэрэндондог өндийж золгох гэж байгаа аятай ханцуйгаа сугаран байхад “Дондог оо, золгож яах юм бэ? Би чиний зүүн мөрөнд байна шүү дээ” гэжээ. Цэрэндондог ганц нэг хундага татаж зориг чангалаагүй бол сүнсээ зайлтал айх байлаа. Нэгэнт зориг орсон болохоор тэр “Батхүү чи яагаад миний зүүн мөрөн дээр байгаа юм бэ?” гэхэд “Чи намайг мартсан байна. Тэгээгүй бол би чиний баруун мөрөн дээр чинь суугаад юу хүссэн бүхнийг чинь л хийж байх байсан юм” гэжээ.

## Цэрэндондог ч Батхүүг буюу Түнгэтийн чөтгөрийг зуун

грамм татахыг хүсчээ. Тэгээд адилхан хоёр аяганд хувааж хийгээд байхад хажуугийн аяга огт хөдлөхгүй мөртлөө доторх архи нь алга болчихоод байв. Тэр зуураа үл үзэгдэх анд нь Цэрэндондогийг цэрэгт явсанаас хойшхи нутаг усны бүх сонин хачныг ярьж өгчээ. Энэ нь Цэрэндондогийн өөр хүмүүсээс сонсоноос ялгаагүй ажээ. Харин Батхүү өөрийнхөө үхсэн цагаас хойшхи зүйлийг огт өөрөөр ярих ажээ. Нялх хүүхэд түүнд илүү өхөөрдмөөр санагддаг гэнэ. Тэгээд л өхөөрдсөн хүүхдээ хорлож орхидог юм байх.

Энэ тэрийг ярилцсаар үл үзэгдэгч андын дуу согтуу байдалтай болж ирэв. Сүүлийн аяга архийг Цэрэндондог чөтгөрт шахсаар байж уулгахад (аяганд хийчихээд уу гээд байсан байна) багын найз Батхүүгийнх нь нэлээд хөгширч архи дарсанд идэгдсэн, анхаарал тавилгүй орхисон гэмээр нүүр царай өмнө нь ил болж болоо ч үгүй

“Хүрэн толгойн сүүдэр” хэмээн дуулж согтон найгаж байв. Чөтгөр болсон Батхүү, Цэрэндондог хоёул ингэж хээрийн хойморт тохмоо дэвсэн эмээлээ дэрлэж өвөр түрийндээ хоножээ. Өглөө нар дээр хөөрч, халааснаас болж Цэрэндондог сэрэв. Шөнө дөлөөр шал согтуу болохдоо үзэгдэж байсан Батхүүгийн сүнс дахиад л үзэгдэхгүй болж нууц байдалд орсон бололтой. Цэрэндондог хажуу тийшээгээ гараараа тэмтчиж “Хөөе Батхүү, чи байна уу?” гэж асуухад “Би байна аа хө” гэжээ. Чөтгөр болсон найз нь Цэрэндондогийг “Явахаасаа өмнө заавал уулзаарай” гэж захиад салжээ. Түнгэт рүү орж ирсэн хэдэн сувай үхрийг Цэрэндондог туугаад явж байтал холгүй байсан бололтой нэгэн эр ирж түүнтэй уулзаад “Таяасан аймшиггүй хүн бэ? Би наад хэдэн үхрийг чинь айгаад очиж авч чадахгүй байлаа” гэжээ. Цэрэндондог явахынхаа урд өдөр Батхүүгийн сүнстэй уулзахаар очиход тэр үл үзэгдэх боловч хүлээж байжээ.

Тэгээд салах ёсны хэдэн үг хэлэлцээд хоёр тийш болоход чөтгөр “Би ч бас ажил ихтэй. Бэлийн ганц айлын шинэ төрсөн хүүхдийг өнөө орой очиж хорлох ёстой” гэжээ. Энэ үгийг сонсоод Цэрэндондог “Чамайг яаж хүүхэд хорлодгийг би хармаар байна” гэснээр Батхүү чөтгөр “Шөнө дүлээр би очно. Тэр айлын зүүн хатавчаар чийгийн улаан өт болж орно. Тэгэхэд хүүхэд нь амьсгал хураана даа” гэжээ. Цэрэндондог тэндээсээ мордож нялх хүүхэдтэй айлд очиход шинэ төрсөн бүсгүй нэг настай эмгэний хамт айж тэвдсэн байдалтай байв. Хүүхэд нь өглөө гэнэт царай нь хөхрөөд ухаан алдчихсан сул амьсгаатай байгаа гэнэ. Ямар арга чарга байгааг эмгэн асууж Цэрэндондоогоос тус горьдсон байдалтай царайчлах аж.

Цэрэндондог бодож байгаад “Би та нарыг ийм байдалтай байхад яаж орхиод явах билээ. Энэ орой хоноё. Хээрийн ширмэн тогоо байвал гал дээр хуурайгаар улайстал нь халаагаад байж бай” гэжээ. Бүсгүй ч үл таних хүний эс ойлгомж үгэнд гайхаж байгаа нь илт. Харин эмгэн түүний үг бүрийг анхааралтай сонсож, дуулгавартай дагаж байв. Шөнө харанхуй болоход тогоо ч час улаан болжээ. Тэгж байтал гэрийн зүүн хатавчийг нэг үхэр ирж шөргөөхөд тосгуулан тавьсан сонин дээр нэг жижигхэн улаан өт годхийтэл унах нь тэр. Цэрэндондог түүнийг шүүрэн аваад улайссан тогоо руу хийж, хурдан гэгч нь таглажээ. Энэ үед “Дондог оо, чи яаж байна аа” гэсэн Батхүүгийн дуу түүндсонсогдоод чимээ тасарчээ. Таглаатай тогоог хатавчинд хонуулаад маргааш өглөө нь хогон дээр аваачиж тагийг нь нээвэл хувхайрсан сүүжний яс торхийн унасан гэдэг.

Эргээд ирэхэд нялх хүүхэд ч царайнд нь цус гүйж эрүүл саруул болсноор барахгүй эрхлэн тарвалзаж Цэрэндондог руу харан мишээж байсан ажгуу.

## Хөх даяанчийг дууриаж хөгөө чирсэн эр

Норовсүрэн хар багын л юм юм руу үсчиж явдаг зантай. Нэг удаа нутгийн өвгөчүүлийн яриаг сонсож суугаад даяанч болж эрдэм чадлаараа түмэн олныг бишрүүлье гэж боджээ. Яагаад ингэсэн вэ? гэвэл тухайн нутагт Хөх даяанч гэж нэг мэргэн лам байсан бөгөөд насныхаа ихэнхид аглаг ууланд сууж даяан хийж өнгөрүүлсэн тухай, түүний эгнэшгүй ид шидийн талаар өвгөчүүл “Базар ваань” гэж ирээд л сүсэглэж ярьдаг нь хүнээр сүсэглүүлж олны анхаарлын төвд явах дуртай түүний сэтгэлийн хязгааргүй шуналыг хөдөлгөсөн хэрэг байв. Үнэндээ тэр Хөх даяанчийн намтар цадиг, үзүүлдэг ид шидийн талаар овоо зүйлийг сонсож мэдсэн аж.

Хөх даяанч нь бор хайрханы энгэр бэлээр нутаглаж тэр уулын хийдэд үе үе хэн очиж шавилан ном эрдмийн үсэг муруйлгаад “Шоголын тоос үлээчихлээ шовоохойдоо очъё” гээд уулынхаа гэр рүү яваад өгдөг нэгэн байв. Нэг суухдаа тав зургаан жилээр явчихна. Тэр үед хүн амьтан очиж уулзахад төвөгтэй. Үнэн сэтгэлийг барьсан ганц нэг шавь нь очно. Тэгэхдээ “Бороо оруулж хайрла, ангийн олз хишиг уугаа хумтсан байна” гэх мэтээр олон нийтэд хамааралтай нэг бодлын “Нийгмийн асуудал” ярьж шийдүүлнэ. Даяанч тэр бүрт хүн болгоны хүссэнийг хийж гүйцэтгээд байхгүй. Болохгүй гэж хэлнэ. Болохгүй нь биш чадахгүй нь дийлсэн хэрэг байх аа хэмээн зарим хүн өөрт нь тааламжгүй хандсаны хариу болгож олны дунд ор үндэсгүй цуурхал тараана. Нэг удаа гурван жил орчим аглагт суугаад ирэхэд нь түүний үе үе хэн номын садангуудтайгаа уулздаг Гандандаржаалин хийдийг нурааж тарааж орхисон байв. Сүсэгтэн олон ч хувьсгалт төрийн энэ болчимгүй алхмыг ихэд дургүйлхэн Хөх даяанчийг горьдлого тээсэн нүдээр харан угтжээ.

Иймэрхүү чин сүжигт хүмүүсийн хажуугаар коммунизмаар оюун тархиа утсан хувьсгалчид түүний эсрэг ихээхэн явуулга хийжээ. Ёс журмыг машид сахиж, ертөнцийн туйлыг харж гэгээрсэн Хөх даяанч гуай энэ удаад л нэг архи ууж, элдэв ид шидийн зүйлийг үзүүлсэн гэдэг. Сүсэгтэн олон түүнд сөхрөн унаж мөргөж байлаа. Нурааж орхисон сүмийн ганжир дээрх бодь гөрөөсний хэлтэрхийг авч үлээгээд гараа их уулын зүг хандуулахад тэр даруйд л сөнөж үнс болсон хийд ариун дагшин амгалан төрхөөрөө дахин босч сүндэрлэн тэнгэр газар хоёроор гэрч татах орон зайд 3 өдөр, 3 шөнө оршин байсан гэдэг. Тэгээд Хөх даяанч бүхнийг сүйрсэн цайрсан бодит байдалд нь оруулаад мөнөөх хэмхэрхий бодь гөрөөсөө тарнидан үлээж, арц утлага болгоод хүн болгонд өгч байсан гэдэг. Хөх даяанч 1960 хэдэн онд “Энэ жаран дуусахад сайн цаг эхэлнэ” хэмээн айлдсан нь ардчиллын салхи сэвэлзэж, коммунист дэглэм журам унасантай яг давхацдаг юм гэнэ лээ.

Хөх даяанчийг нутгаа орхин хот руу орж ирэн шинээр эрдэмтэй лам нарыг энд тэндээс хайж ирж Гандан хийдээр ороход номын гэгээвчтэй болгон нь сөгдөж адис аван түүнд шавь орж байсан гэдэг. Тэр насны бөгсөнд Гандан хийдийн шашны сургуульд шавилдаг хүүхэд залуучуудтай дотносож үе тэнгийнх юм шиг тоглон хөөрөлдөж явдаг байжээ. 1966 оны айхавтар үерийн үеэр Ганданд шавилдаг байсан Эрдэнэбат хэмээх ламзалуутай мэргэн даяанч хамт явж байгаад ширүүн усанд өртжээ. Тэгэхдээ “Эрдэнэбат аа, би яахав. Харин чи л хөөрхий байна даа” гэж байсан гэдэг. Бороо ширүүсч, газар тэнгэр хоёрыг усаар холбочихсон юм шиг усан хөшиг татаж байхад гараараа толгой дээгүүрээ горьтог татаад л усанд норохгүй байжээ. Эрдэнэбат түүний хажууд наалдан явж бороонд орж, усанд норолгүй хувь хуурай

өнгөрч байснаа эдүгээ ч дурсан ярьдаг ажээ.

Норовсүрэн Хөх даяанчийн талаарх энэ мэтийн домог гэхэд үнэмшим, үнэн гэхэд итгэмгүй зүйлсийг сайн мэднэ. Мань эр тэгээд л ийм илбэ шидийг үзүүлсэн хувилгаан болох гэж хичээсэн байна. Хөх даяанчийн суудаг байсан уул руу намар орой болсон хойно Норовсүрэн ном бясалгалын хэрэгсэл мэтийг цуглуулан нэг хангинуур сүх бүсэндээ хавчуулаад л гарч өгсөн байгаа юм. Зорьсон газраа очиж мод гишүүгээр овоохой барьж нэлээд тухлан суусан байна. Үнэхээр ч бие сэтгэл хөнгөрөөд ирж байх шиг санагджээ. Шингэн хар цайнаас өөр ундгүй хүйтэн цагаар суусан түүнд үнэндээ хэцүү байв. Ядаж байхад чоно, нохой элбэгтэй. Нэг өглөө овоохойныхоо гадаа түлээ бэлтгэж байтал нүднийх нь үзүүрт нэг амьтан хөдлөх шиг болжээ. Лавлан харахад нэг лагс том чоно ирээд хэлээ унжуулан түүний хөдөлгөөн бүрийг гайхан харж байв. Тэр айсандаа муухай дуугаран орилох гэснээ даяанч хүн тэгж болохгүй гэж өөртөө шивнээд үс сахалдаа баригдсан чоно байтугай авгай нь аймаар болсон нүүр царайгаа энэрэнгүйн дорой байдалд оруулж ханцуйгаараа нүүрээ таглан зогссон газраа доош хараад л унаад өгчээ. Нөгөө хээрийн боохой ч мод гишүү дуугарган хажуугаар нь явж буй бололтой.

За, миний хаанаас эхэлж хазаад үмхэлж эхлэх бол гэж байж байгаад унтсан уу, ухаан алдсан уу Норовсүрэн “Даяанч” мэдээ алдсан байв.

Сэрсэнд ойр хавьд нь ямар ч амьтан алга. Нөгөө гайхал боохой яваад өгчээ. Эхэндээ Норовсүрэн “Яасан цатгалан дамшиг вэ?” гэсэн шүү юм бодов. Сүүлдээ өөрийнх нь ном бясалгалын хүчээр нөгөө аймшигт араатан сүүлээ хавчин зайлсан гэж бодогдож эхэллээ.

Бүр чонын толгой дээгүүр өчнөөн гэрэл цацран байсан юм шиг санагдаад байв. Бас ганцхан биш, сүрэг чоно түүнийг тойрон суугаад эзэндээ үнэнч зүтгэхээ амлаж байгаа юм шиг хүлцэнгүй номхон байсан даа гэж бодогджээ. Энэ бүхнийг тэрбээр гэр рүүгээ харихаар эзгүй уулнаас санд мэнд хальтиран унаж тусан явахдаа зохиомжилсон юм. Шөнө дундын үед гэртээ ирж эхнэртээ болсон явдлыг хэлээд илүү гэрт орж нуугдан цай хоол зөөлгөн тавлаж тансаглаж байв.

Ууланд суухаар явах гэж буйгаа сумынхаа бүх хүнд зарлачихсан болохоор хэдхэн хоноод ирчихжээ гэвэл түүний тэр ариун зорилго хөсөр нурж, нэр хүндийнх нь ноён нуруу дээвэр юугаа хаман яйрах байлаа.

Норовсүрэн 40 хоног гэртээ бүгэв. Түүнийг асуусан хүмүүс гэр орноор нь орж гарах юм. Зарим нь бүр эхнэрийг нь оролдож нөхөр нь орон доогуур нуугдаж байгаа болохоор эхнэр ч “Хэнийг ч ойртуулахгүй” байгаа нь үнэхээр “Шударга журам” медалиар шагнахад багадаа зүйл гэлтэй.

Норовсүрэнгийн нэг найз нь “Би маргааш ууланд гарч цаадахтай чинь уулзъя. Хэлж захих зүйл байна уу” гэж асуужбайна. Энэ нь Норовсүрэнг үнэхээр сандаргав. Өглөө эртлэн боссон Норовсүрэн арц хүж рашаан ус зэргийг савлаж аваад мань найзынхаа замыг тосон зогсчээ.

Хөтөлгөө морьтой өндөр рүү зүтгүүлж явсан найз нь өмнөөс нь сахал үсэндээ баригдсан “Хүн гөрөөс” ирж явааг хараад айн цочсон боловч “Манай Норовсүрэнгээс өөр хэн байх



билээ” гэж бодсон нь үнэн болж хоёр найз тийнхүү аглаг ууланд уулзжээ.

Гэртээ ирж бясалгалын рашаанаасаа хүн зондоо түгээж тэднийхээ авчирсан догшин хар архиар хоолойгоо зайлж хэсэг зуур саатав. Тэгээд аймгийн төв орж шүлэг зохиол оролддог нөхдүүддээ ариун рашаанаасаа амсуулна гэж явжээ.

Үнэндээ олон хоногоор орон доороо нуугдаж хэвтээд уйдаж цөхөрсөн сэтгэлээ засах арга эрсэн нь энэ байв. Аймгийн төвийн “Найрагчид” түүнийг гүн хүндэтгэлтэйгээр угтав. Мань Норовсүрэн ч нэг үзгээр бичдэг гэх тэднийгээ арц утлагаар ариулж, рашаан усаар угаагаад архидаж гарчээ. Өөрсдийгөө “Яг яруу найрагч мөн дөө” гээд ойлгочихсон хэдэн онгироодуу эр аймгийн төвөөр пижигнүүлж байгаад бүгд цагдаад баригдаж эрүүлжүүлэгджээ.

Шартаж үлбийсэн нөхөд нь арай чүү эрүүлжүүлэхийн мөнгө төлж гарч ирээд Норовсүрэнгээс “Алив чиний тэр хувилгаан шид чинь. Бид яаж дарвисан ч эрүүлжүүлэхэд орж үзээгүй, чамайг хийморийн сан тавьснаас хойш хийморь улам доройтчихлоо” гэх мэтээр агсамнажээ.

Мань Норовсүрэн хувилгаан “Та нар эрүүлжүүлэхэд ороогүй бол дарвиж яваад хэн нэг нь гудамжны хулигаанаар алуулах байсан юм” хэмээн ханцуйн доороо залбирсан гэдэг.

## **Шар толгойн хүүрийн газар тоглож өссөн найзууд бүгдээрээ цаг бусаар нас баржээ**

Шар толгой гэж нарлаг сайхан энгэр бий. Говь газрын намхан тачир харгана ортууз зэргээс өөр өвс ургамалгүй тэр элсэрхэг энгэрт аль өвгөдийн үеэс талийгаачдыг нутаглуулдаг болсныг хэн ч мэдэхгүй. Гэхдээ төрөл арилжсан нэгнээ хэнээс ч асуухгүйгээр тэнд аваачиж оршуулна. Монголын хөдөөх заншлаар ил тавих тул мөнөөх талийгч сүүлийн удаа нохой шувууг цатгах буяны үйлсэд биеэ зориулах амуй.

Ийм газарт ойр нутаглах малчдын үе тэнгийн хэдэн хүүхэд хонь хариулж явахдаа Шар толгойд очиж хүүрнүүдтэй ярилцаж, шоглож тоглоно. Чинбат гэдэг хүү “Үхчихсэн мөртлөө босоод суучихсан байдаг чинь юу вэ?” гээд халуунд хөөмөглөөд босчихсон байсан нэгэн хүүрийн гэдэс рүү гараа зангидаж байгаад шаасан гэдэг. Мэдээж битүү өмхийрч ногоорсон байсан шарил зад үсрээд л мань эрийг нялгадаж орхисон тохиолдол гарчээ. Тэд 10-аад км давхиж голын усанд очиж орж байж хүүрний өмхийгөөс салж байсан гэнэ.

Бас Дүгэрээ хэмээх хүү Санжид өвгөний толгойн ясыг аргамжаар оосорлож байгаад чирч давхин талын нэг тарааж орхижээ. Тэр өвгөн хүүхдүүдтэй их тоглодог хүн байсан тул таарсан жаалуудыг “хөнгөлөөд орхичих хүн” хэмээн айлгадаг байснаас Дүгэрээ ингэж хариугаа авсан байна.

Шар толгой руу “зочин” ирэх өдрөөр үеийн хэдэн дүрсгүй банди нар заавал очно. Хүмүүсийг оршуулахад хэрэглэсэн эд зүйлсээр нь дүгнэн ярилцана. Хар нялхаараа шахам үхсэнэмыдын холбоонд орж, үйл явдал хөвөрдөж өссөн тэднийг хожим бүгдээрээ цаг бусаар нас барцгаасан гэдэг. Энэ гэнэн томоогүй насны ухаангүй үйлдлээр дүрсгүйтэж явсан хүүхдүүдийн нэгд тохиолдсон явдлаас энд өгүүлбэ. Сүхээ нэг удаа Шар толгойд ирсэн шинэ “зочин” дээр очиж “уулзахад” сүрхий тансаг гар байжээ. Шарилын хажуугаар мөнгөн хазаар, эмээлийн хэрэглэл, аяга зэргийг ил задгай тавьчихсан байв. Мань Сүхээ моринд хорхойтой. Тэгээд ч мориороо гангарах гэж оролдоно. Бас мориороо гангарахын тулд морио гоёх ёстой гэдгийг ухаарсан байв. Сүхээ мөнгөн хазаарыг аваад гэрийнхээ ойролцоо аваачаад нуучихжээ.

Аав, ээжийнхээ нүдийг хариулж байгаад нөгөө ганган хазаараа сэмхэн үзнэ. Хонины хишиг өдөр таарахад нэг удаа өөрийн хатуу хар суран хазаараа мөнөөх мөнгөн хазаараар сольж морио хазаарлажээ. Түүний хонины цүдгэр хээр нь гял толь болсон хазаараар хазаарлуулчихаад байгаа үнэхээр алдар цуутай хурдан хүлгүүдээс дутахгүй хэмжээнд харагдаж байв. Хүү баярлан мориндоо ташуур өгч гийнгоо хадаан давхихыг хүсэв. Морь үнэхээр хурдан давхижээ. Өмнө хашин хоргоддог морины зангаар гэр рүү тэмүүлдэг байсан бол Шар толгойн энгэрт байгаа шинэ хүүр рүү харавсан сум шиг цойлж очжээ. Чихэнд салхи хүнгэнэхээс өөр чимээ үл сонстож байсан нь морь хэрхэн хурдалж байсныг үзүүлэх ажээ. Морь нөгөө хүүрийн хажууд очиж тонгойн зогсоод хараахан арьс яснаасаа салаагүй байсан эрүү толгойг муур мах зооглох шигажилжээ.

Энэ жихүүцэм зүйлийг хараад айхдаа Сүхээ мориныхоожолоог тасартал татаж, хичнээн ташуурдсан ч морь эс хөдөлжээ. Жаалхүүг хичнээн оролдсон ч морь түүнийг нь үл ажран нөгөө эрүү толгойг өвс амтархан идэх шиг шир шир дуугарган мэрнэ. Сүнсээ зайлтал айсан хүү мориноос бууж ташуураа барин уйлж орилсоор гэртээ харьжээ. Тэр даруйдаа хүү

бөмбөгнөтөл чичирч халууран, солиорч, дэмийрэн элдэв янзын үг хэлж байв.

Морь яасан? Хонь руу хээрийн боохой дайрсан уу гэх зэргээр эх, эцэг нь асуусан ч “Тэр хүн намайг тооноор хараад байна. Намайг авах гэж байна. Гарыг нь цаашаа болгооч” гэх мэтээр хэн ч үл ойлгох сонин юм ярьж гарав.

Эцэг нь ээжийг “Хүүгээ сайн харж бай” гээд мордож морийг хайж очиход хонины номхон хээр нь эзнийхээ өөдөөс ув улаан шүд гарган эгээтэй л идэх гэж байгаа юм шиг галзууран дайрчээ. Эзэн нь ч гайхаж “Хаая хүүе” гэж ташуур гозгонуулж байгаад тэсэлгүй зугтжээ. Хүү тэр шөнөдөө халуурч дэмийрэн ухаан оролгүй байсаар нас барсан бөгөөд тэрхүү эл хуль говь нутагт мөнгөн хазаартай галзуу хээр морь таарсан хүн мал руу дайрч сүйд хийж эхэлжээ. Олон хүн цуглаж ярилцаад түүнийг калибрийн сумаар л аюулгүй болгох ганц арга байна гэж тогтжээ.

Монгол хүн унаган морь руугаа буу шагайна гэдэг хэрэгжүүлэх байтугай хэлэхээс ч аймшигтай санагдах билээ. Хээр морь өдөр нь хүн мал руу дайрч муухай орилох мэт янцгаан явах бөгөөд орой болоход Шар толгойн хүүрийн газар очиж нөгөө талийгаачийн толгойн ясыг мэрэх аж.

Энэ бүхнийг тайлбарлах арга хөдөөний хүмүүст байсангүй.

Морь амьдаараа чөтгөр болохыг үзнэ гэдэг нэн аймшигтай ажгуу. Хээр морийг хэд хэдэн удаа буудсан боловч толгойноос нь гал манасхийгээд мөнгөн хазаарын хэлбэртэй хөх дөл суунаглан асаад унтрах тул түүнийг юунд ч дийлдэшгүй нь гэж бүр итгэжээ. Аргаа барсан тэр нутгийнхан Гялганы Дарь-Эх хэмээх нэгэн номтой авгай дээр очицгооход мэргэлж үзээд дээр өгүүлсэн талийгаач Сүхээ хүүгийн хийсэн бүгдийг ярьж морины толгойноос мөнгөн хазаарыг салгах хэрэгтэй гэжээ. Суманд ч даагдахгүй, хүнд ч баригдахгүй ид шидтэй мангас болсон хээр моринд халдах зоригтон байсангүй. Яах ч аргаа олж ядан байхад хээр морины хазаж хайрсан мал үхэж үрэгдээд халдварт өвчин шиг бусдад халдварлаж эхэлжээ. Хагацал зовлон үзэж сэтгэлээ харлуулсан Сүхээгийн аав, ээж мал сүргээ хиаруулж хотоо харлуулах нь гэсэн айдаст авгав. Гэтэл нутгийн нэгэн өвгөн санаа гаргав. Хээр морины ах, дүү ямар морь хаана байгааг тогтоох хэрэгтэй. Ялангуяа чөтгөр болсон түүний төрүүлсэн эх гүүний толгойг хаана тавьсан гэдгийг санах хэрэгтэй болжээ. Уналгын олон морь “төрүүлж” тэдний амьдралд “үнэлж баршгүй” хувь нэмэр оруулсан эх гүүгээр тогоо тослохдоо толгойг нь цагаан эргийн овоон дээр аваачиж тавьсан болохыг талийгаач Сүхээгийн эцэг санажээ.

Тэгээд очсонд овоон дээр үй олон адууны хувхай толгой байна гэнэ. Аль нь галзуу хээрийн ээж болохыг мэдэх аргагүй. Ямар чиргүүлтэй машин авч очоод бүх толгойг ачиж элсэн говь дундуур явалтай биш. Үнэхээр ч тийм хүчтэй техник байхгүй биз. Тэгсэнд мөнөөх хашир өвгөн бас л нэгэн сонин санаа гаргажээ. Тэгээд нутгийн өөрийгөө голдог тааруухан

төлгөчийг дагуулсан хэдэн хүн Цагаан эргийн овоог зорьжээ. Лам олдохгүй болохоор буцахдаа залсан өвгөн нь бас хэд гурван түвд үг хэлж ном уншиж овоон дээр сан тавьж байв. Тэгсэн чинь овоог тойруулж тавьсан олон адууны хувхайрсан толгой дотроос нь нэг толгой эргэж хөдөлж байна гэнэ. Урагш харж, үнэхээр ч сэтгэл дагасан уу яасан хүүрийн газар болсон Шар толгой руу хандаад дахин хөдлөхгүй болжээ. Тэд мөнөөх толгойг ганзагалан

очиход галзуу хээр анаа толгойг ил гаргахад зогтусан саатаад тэр даруйдаа номхорсон юм шиг харагджээ.

Талийгаач хүүгийн аав, галзуу хээр рүү ээжийнх нь толгойг барьсаар очиход тэр унаган араншиндаа орж толгойг үнэрлэн улайж мах шиг болсон галзуу нүднээс нулимс дусалсан гэдэг юм. Энэ зуур амжиж хээр морины толгойноос нөгөө хар дөл гаргадаг мөнгөн хазаарыг мултлан шидсэнээр хээр морь бүр юу болов гэмээр номхорч эзнээ үнэрлэн үүрсэж байжээ.

Түүнээс хойш галзуу хээрийг хэн ч унаж эдлээгүй бөгөөд жилийн дөрвөн улиралд сул чигээрээ шогшин адуу малаа бараадан явсан гэдэг. Харин нутаг болгонд байдаг шунал нь шуургалсан эрчүүдийн нэг болох Балжир гэгч хот газрын жолоочид өвлийн идэш болгон төхөөрч өгснөөр галзуу хээрийн тухай домог шиг яриа л үлдсэн ажгуу.

## Хар хэлтэй бүсгүйд таалагдсан Сайнбуянгийн амьдрал сүйрэх шахжээ

Сайнбуянг хэн ч харсан нүдэнд дулаахан хархүү байна даа гэж хэлэхээр нэгэн байв. Энэ бол одоогоос арваад жилийн өмнөх асуудал. Түүнийг Эрхүүгийн их сургуулийг дүүргээд орос хэлний багш, орчуулагч мэргэжилтэй болоод ирэхээр аав нь “за миний хүү болж дээ. Одоо амьдралаа бодсон нь дээр” хэмээн сургамжилжээ. Энэ нь хурдан эхнэр авч өөрийн голомтоо асаа хэмээсэн үг юм. Нийслэлийн нэгэн дунд сургуульд багшилж, бас эцгийн шахалт эр хүнийхээ зөн совин бие физиологийн шаардлагаар багш нараасаа өөрт тохирох бүсгүй хэн байна вэ? гэж битүүхэн харж явах болов. Сайнбуянгийн ангийг хөмсөг дундаа том хар мэнгэтэй намхан бор бүсгүй цэвэрлэх бөгөөд залуу багшид үеийн хүний хувьд хэд гурван үг хэлж ажил дээр оройтсон үедээ гэртээ дөхүүлж өгөхийг хүснэ. Сайнбуян сайхан зантай, соёлч боловсон харьцааг эзэмшсэн нэгэн болохоор Хандсүрэн хэмээх тэрхүү цэвэрлэгч бүгсүйн үгийг хүндэтгэлтэй сонсоно.

Хэдэн удаа ч гэрт нь дөхүүлж өгсөн байна. Хандсүрэн ааруул эзэгий, чацарганы тос зэрэг хот газар ховор олдох ялангуяа эхнэр, хүүхэдгүй эр хүнд санаанд нь оромгүй зүйлсийг олоод ирчихсэн “Сайнаа багш аа, танд...” хэмээн өгнө.

Сайнбуян ч баярлаж талархсанаа илэрхийлээд бүсгүйн өгсөн зүйлсийг амтархан хэрэглэнэ. Нэг жил өнгөрөхөд Сайнбуянгийн ажилладаг сургуульд Сүрмаа гэгч царайлаг бүсгүй математикийн багшаар иржээ. Сургуулийн хамт олон ч Сайнбуян, Сүрмаа хоёрыг тоглоом наргианаар боловч нийлүүлж ярьсаар мань хоёр нэг мэдэхэд харилцан сэтгэлтэй болсноор нэгэн шинэ гэр бүл бий болов. Хурим нь ч сайхан, дурсгалтай болж өнгөрөв. Сайнбуян багш цэвэрлэгч Хандсүрэн урьдын адил өөрт нь хандахаа больсныг анзаарав. Тэр нь ч дээр дээ. Сүрмаа буруугаар ойлгочихвол дэмий юм болно гэж боджээ. Хандсүрэн сургуулийн хонгил цэвэрлэнэ гэж аж ахуйн даргадаа хэлж Сайнбуянгийн ангийг цэвэрлэхээ больжээ.

Сайнбуян Сүрмаа хоёр нэгэн орой ирээдүйн амьдрал, хэдэн хүүхэдтэй болох зэрэг дотоод асуудлаа янагийн халуунтай хутган холин ярилцаж байв. Сүрмаа гэнэт “Миний цувны халаасанд нэг захиа байжээ” гээд нэгэн худсыг Сайнбуянд өгсөн нь тэдний халуун дулаан байдлыг эвдэж орхив.

“Сүрмаа чи Сайнбуянтай амьдраад хэрэггүй. Та хоёрын амьдрал зовлон гунигаар дүүрэн байх болно” гэсэн утгатай товчхон зурвас байв. Нэр усгүй учир битүүлэг зүйл тул Сүрмаа ч нөхрөө хардаж “юу, юу гэнэ вэ? Энэ чинь хэн бэ?” гэж ирээд дайрч давшилж гарчээ. Эмэгтэй хүмүүс болсон хойно хэрэгтэй хэрэггүй юмыг хамж шимэн ярилцаж хайран цагийг яйран болгодог нь хаа газрын ёсон.

Сүрмаа сургууль дээрээ очоод өөрийн дотночилдог багш нартаа мөнөөх зурвасны талаар яриу. Оюумаа багш “Манай сургуульд хүн бүхэн дөлдөг ганц л хүн бий. Яагаав цэвэрлэгч Хандсүрэн. Тэр гуч хүрсэн ч хүнтэй сууж хүүхэд гаргаж үзээгүй. Хөмсөг дундаа хөмхий зангидсан хар мэнгэтэй, хэл нь могой шиг эрээн цоохор юм гэдэг” гэх мэтээр бурж гарчээ. Хичээлийн эрхлэгч Отгонцэцэг түүнтэй нэг удаа яльгүй зүйлээс муудалцаад хүүхэд нь өвчилж, сүүлдээ Хандсүрэнг аргадаж байж эвлэрснээр зүгээр болсон ч гэх үг хэлжээ. Түүнээс хойш Сүрмаа Сайнбуян хоёрын хэн нь ч Хандсүрэнгийн ая эвийг олох гэж худлаа

үнэн инээж, ний нуугүй байдал үүсгэх гэсэн боловч тэр огтоос тоохгүй уруулаа жимийгээд хар цагаан дуугүй өнгөрөх болжээ. Сайнбуян дэмий л бухимдаж, өөрийгөө Хандсүрэнтэй ямар ч дотно холбоогүй байснаа мянгантаа хэлж түмэнтээ баталсан ч тэрхүү шинэхэн гэр бүлийн доторх жихүүцэнгүй уур амьсгал өөрчлөгдсөнгүй.

Сүрмаа 6 сартай жирэмсэн байсан үе бөгөөд хүүхэд нь хөдлөхөө болчихлоо гэж сандаргажээ. Эмч домч нар тийм тохиолдол байдаг юм. Хамгийн гол нь гам сайн сахих хэрэгтэй гэснээс өөр зөвлөгөө өгсөнгүй. Сүрмаагийн хэвлий хатуурч өвдөн, өрц цоройноосоо хүнд юм дүүжилчихсэн юм шиг хөндүүрлэх болжээ. ЭХО-гоор харуулахад урагийн хөгжил зогссон байж магадгүй гэснээр шинэхэн ханилсан хоёр анх удаагаа ламдах юм болжээ. Лам “Муу сэтгэлтэй... хүний бараан бодол гэр бүлийн дотор ноёрхжээ. Түүнийг аргалж болох дом байдаг юм” гэжээ. Мэдээж Сүрмаа, Сайнбуян хоёр уралдан “Яахав, юу хийхэв” гэгцгээв. Лам ямар нэгэн аргаар Хандсүрэнгийн үснээс сэв олж ир гэжээ.

Энэ бас л бүтэхгүй эд болохоор Сүрмаа Сайнбуян уруу хардангуй нүдээр харж “Чи л олж ирнэ дээ” гэжээ. Үүнээс болж тэдний гэр бүл дотор бас л нэгэн зөрчлийн салхи босчээ. Сайнбуян боджээ. Хандсүрэнг барьж байгаад үснээс нь зулгаалтай биш. Эсвэл нэг оронд орж толгой түрүүг нь илбэлтэй биш. Эр хүний арван гурван мэхийг хийхээс өөр аргагүй. Хандсүрэн ядаж байхад үсчинд очдоггүй бололтой. Өтгөн хар үс нь сарлагийн саваг шиг сагсайж сэгсийж байдаг ажээ. Тэр үед цэргийн баяр болох гэж байсан тул эмэгтэй багш ажилчид эрчүүлдээ зориулж тоглолт бэлтгэх хэрэгтэй гэсэн санаачлагыг Сайнбуян гаргахад захирал нь ч дэмжсэн байна. Цэрэг малгай өмсөхөд Хандсүрэнгийн гэзэг үс тохиромжгүй байсан тул жаахан шингэлж засуулах болсноор Сайнбуян Сүрмаа хоёрын гарт хар мэнгэтэй бүсгүйн гэзэгнээс туг үс орж иржээ. Лам тэрхүү үсийг шатааж Сүрмааг утаад, хиншүү хярвасыг нь Хандсүрэнгийн зам дээр хаяулжээ. Түүнээс хойш Сүрмаагийн хэвлий доторх хүүхэд ямар ч хүндрэлгүй хэвийн бойжсоор сараа гүйцээж төрсөн байна.

Ер нь хүний амьдралд санаатай санаагүй юм тохиолдохыг алийг тэр гэхэв. Амьдрал гэдэг тайлагдашгүй оньсого, учир битүүлэг зүйлсээр дүүрэн байдаг болохоор хэнд юу ч тохиож болохыг хэлэхийн арга үгүй ажээ.

## **Чөтгөр шүглэснээс болж хүүгээ буудаж өөрийнхөө хоолойг хэрчжээ**

Гэээгт Аюуш гэж нутаг усныхандаа сайн нэртэй ажилсаг нэгэн байжээ. Ажил үйлс дэвжин дээшилж, хэний ч өмнө нүүр улайхааргүй амьдарч байсан түүнийг муу ёрын див шүглэснээс балмад хэрцгий хэрэг үйлдсэн гэдэг. Аюуш ангийн хорхойтой нэгэн байв. Том хүү нь тусдаа гарсан. Хоёр бага нь нас биенд хүрсэн болохоор ёстой л жаргах насан дээрээ байсан Аюуш нэгэн өдөр хүүгийн дээ оржээ. Буу барьчихсан орж ирэхэд бэр нь хадам эцгээ юунд яарч яваа юм бол. Буугаа гэр дээр тавьчихаад ороод ирж болмоор юм гэж дургүйхэн угтжээ. Хадам эцэг нь олон юм ярьсангүй. Хүүгээ хаачсаныг асуугаад гарчээ. Сүргээсээ тасраад явчихсан хоёр мориныхоо эрэлд явсан болохыг сонсоод гарч одсон нь тэр.

Гэээгт Ааяа хүүгээ тосож байгаад шууд буудчихжээ. Аавыгаа юу хийж байгааг төдийлөн ойлгож амжаагүй байхдаа хүү амьсгал хураасан байна. Гэээгт гэртээ орж том балиус аваад гол уруу явах замдаа хоолойгоо хэрчиж явдал дундаа цусаа ханаж амиа егүүтгэжээ. Тэр явдлаас хойш тэднийхний нутагладаг байсан өвөлжөөнд айл амьтан ойртохоо больж чөтгөр шүглэсэн газар хэмээн дөлөх болжээ. Голомтоороо шахам сүйрсэн Ааяагийн гэрийг ах, дүү нар нь сэжиглээд ойртолгүй бариастай чигээр нь орхисон байна. Айл нутгийн нэгэн эр мал эрж яваад ганц гэр байхаар нь өлсөж цангасандаа баярлаад очсон байна. Ямар учиртай гэр болохыг мэдэхгүй эрлийн хүнийг гэрт ороход бүдэг гэрэл бүтэлзэж, зуухны амааргал асч байжээ. Гэрт гэээг үс, сахал самбайндаа баригдсан хижээл насны хар хүн тамхи татан сууж байх юм гэнэ.

Хоолой засч дохио өгөөд мэндэлбэл гэрийн эзэн хариу мэндлээд гадаа хүйтэн байгаа эсэхийг лавлаж байв. Эрлийн хүн ч гэрийн эзний царай зүс болоод халуун зунаар шахам өвөлжөөндөө сууж байгаа зэргээс бяцхан сэжиг авсан ч түүнийг зочломтгой занд авгаж гутал хувцсаа тайлан тухалжээ. Гэрийн эзэн зочиндоо бүхэл мах чанаж дайлжээ. Мах гөрөөснийх байв. Өлссөн эр ч том том огтлон идэж, хэд хэдэн аяга цайгаар даруулжээ. Тэгээд морь хараад элдвийг ярилцаж байгаад эрлийн хүн ч унтаад өгчээ.

Шөнө унтаж байгаад сэрэхэд түүний дээрээс нэгэн хүн тонгойн харж байв. Нүднээс нь хөх дөл үе үе манасхийх нь аймшигтай. Айсандаа ухасхийн босох гэтэл гар хөл нь өөрийн мэдээгүй болчихож. Толгой нь болж буй үйл явдлыг бүдэг бадагхан мэдэрч байсан ч өөрийн бодолд захирагдахгүй болсон хөл гараа удирдаж дийлэхгүй байв. Эрлийн хүн үл мэдэгдэх далдын хүчинд авгаж хэн нэгний асуултад хариулахаас өөр аргагүй. Нөгөө сахал үсэндээ баригдсан хар хүн өөрийнхөө хувь заяаны талаар ярьж байв. Тэр нэг удаа шуудайтай юм олжээ. Шуудайг тайлж үзвэл дүүрэн торго байж. Баярлахдаа авч гэртээ ирсэн гэнэ. Гэтэл торгонуудыг гаргаж байтал дундаас нь нэгэн нялх хүүхдийн шарил гарч иржээ.

Түүнийг үзсэн эр тэр даруйдаа үхгээ айж ухаан санаа нь элий балай болсон гэнэ. Нялх хүүхдийн хацар нь бумбалзаж хөдөлж шуухинаа амьсгаатай байсан нь түүнийг улам айлгасан аж. Тэгээд дээр өгүүлсэн хэрэг явдлыг ярьж, төрсөн хүүгээбуудаж өөрийгөө егүүтгэсэндээ харамсаж байдаг гэсэн байна. Эрлийн хүн ч унтаа сэрүүний завсар аймшигт түүхийг сонсоод өглөө болгоход нөгөө гэээгт эр аль хэзээний алга болсон байжээ. Чөтгөр болсон хүний гэрт орж дайлуулаад, айдаст автсан мөнөөх эрлийн хүн ухаан жолоогүй давхисаар харьсан гэдэг юм.

Хожим сонсоход тэрхүү заяа муутай эрийн бариастайгаа хоцорсон гэр арваад жил өнгөрсөн ч нар салхинд элэгдэж урагдаагүйгээр барахгүй, амьжиргаатай ажилсаг эзний гараар үргэлж тордуулж байдаг юм шиг цэвэрхэн цэмцгэр байсан аж. Мөнөөх эрлийн эрд ч энэ хэрэг явдал муугаар нөлөөлөөгүй гэдэг.



## **Чөтгөртэй нөхөрлөж, түүнийг мохоож явсан аюуш хувилгааны нэгэн тохиолдол**

Хүний амьдралын үл тайлагдах нууцыг гаталсан хүмүүс олон байжээ. Тийм хүмүүсийн нэг бол Аюуш хувилгаан юм. Түүний бусад мэргэдээс ялгарах онцлог нь чөтгөрийг хүртэл хүн шиг өмөглөж, өмөөрөн нөхөрлөдөг байсан гэлцдэг.

Аюуш хувилгаан “Хүн бол чөтгөр, чөтгөр ч гэсэн хүн. Чөтгөрийг харин бил хүмүүжүүлж чадна” хэмээдэг байсан гэдэг. Хүмүүст тус болно. Номынхоо ид шидээр чөтгөрийг мохооно. Тэгэхдээ чөтгөрийг хөөж, шинэ төрөл авахуулах гэхгүй. Чөтгөр мухардалд орж, хорлох чадалгүй болохоороо ёстой хорхойд ч хоргүй амьтан болдог аж. Энэ бүхэн Аюуш хувилгааны үзэл бодол гэвэл зохилтой.

Аюуш хувилгаан бас хэрж тэнэдэг нэгэн байжээ. Гэхдээ бадарчин шиг бэдэрч зүдэрч явахгүй. Тарган морь унаж, торгон дээл углаж, айраг сархад эргүүлсэн шигээ амьдарч байв. Түүнийг нэгэн айлд морилоход гэрийнхэн нь хөл алдан угтжээ. Аюуш хувилгаан хэзээ ч хэн нэгний урилгаар залардаггүй. Өөрийн тааллаар морилдог байжээ. Нэгэнт тийм хууль ёс шиг заншил ноёлсон болохоор “Өнөөдөр хувилгаан манайхыг таалж мориллоо” хэмээн гэрийн эзэд байж суух газраа олж ядаж байв. Аюуш хувилгаан

- Танайд би нэг хүү авчирлаа. Аав, ээждээ ачлалтай сайн хүн болно гэжээ. Хоол унд, айраг сархад болж нэлээд орой болсон хойно,

- Та нар тэр хүүхдээ яаж авах юм бэ? гэж халамцуухувилгаан шаардсан байна. Гэрийн эзэн ч жаахан ичингүйрэн

- Хувилгааны дэргэд нүгэл байгаа даа гэж эхнэртэйгээ энгэр зөрүүлэхийг шаардах байх хэмээн тулгамджээ. Эхнэр нь царайгаа минчийгтэл улайлган,

- Бид хоёр хонио манаж хонох уу? хэмээсэн гэдэг. Аюуш хувилгаан “Та хоёр чөтгөр үзсэн юм шиг надаас яагаад зугтаад байгаа юм” гэж хөлчүүрхсэнээ тэр даруйхнаа сайхан аашгай болж тачигнатал хөхрөөд гэрийн эзэгтэйг дуудаж “Миний урдуур гар” гэжээ. Амьд бурхан гэх нь холгүй шүтэгддэг гэгээн ламын өмнүүр зорчин алхах зүрх бүсгүйд байсангүй. Гэхдээ ламын өөрийнх нь хүсэл тул эмээсхийгээд л гүйцэтгэжээ.

Аюуш хувилгаан баруун гараараа бүсгүйн хонгон дээр хуруугаа тэнийлгэн хүргэж,

- Аюушийн Дэмбэрэл гэж арван нас хүртэл нь дуудаж бай. Түүнээс цааш ааваараа овоглож яваг гэсэн гэдэг.

Үнэхээр хүүхэд заяахгүй байсан тэр айлд жилийн дараа хүү төрж “Аюушийн Дэмбэрэл” гэдэг давхар нэртэй болсон байна. Аав нь хүртэл хүүгээ “Аюушийн Дэмбэрэл ээ, миний хүү” гэж дууддаг байжээ. Хүүгийн нуруун дээрх таван хурууны ором арван нас хүрэхэд нь яг Аюуш хувилгааны гартай адилхан хэмжээтэй болсон аж.

Аюуш хувилгааныг явсан газраа хээр гадаа унтаж хонодог, ялангуяа чөтгөртэй газрыг

сонгодог гэж ярилцдаг байв. Гүйдэлтэй газрын ойролцоо нутагладаг хүмүүс хувилгаанд айраг сархдыг аргалж байгаад ахиухан хүртээхийг чухалчилна. Омголон зантай хувилгаан хол морилж чадахгүй гүйдэлтэй газар хонож, чөтгөрийг номхотгох учиртай тул өөрсдийн тусынүүднээс хүмүүс ингэдэг байжээ. Хөдөө газар байсгээд л онцгой хүчтэй чөтгөр бий болж, айлууд буурь бууцандаа хүрч чадахгүй айж азнадаг. Нэг удаагийн тийм тохиолдлоор нутгийнхан олноороо Аюуш хувилгаан дээр очиж чөтгөрийг дарж өгөхийг хүсэн мөргөж залбирчээ. Аюуш хувилгаан,

- Тэр чинь олох ёстой төрлөө л олсон байна. Түүнийг дарж устгах юм бол бас нэг төрлийн нүгэл болно. Сүхбалсан хошуу амьтныг айлгаж байгааг бодоход сүрхий чөтгөр болжээ хэмээгээд мориндоо ташуур өгөн чөтгөрт эзлэгдсэн нутаг болох Чацарганатын ам руу давхиулжээ. Түүнийг Чацарганатын амны хулсан дотор чөтгөртэй гурав хоног найрласан гэж зарим хүн нүдээ бүлтийлгэн байж баталдаг.

Сүхбалсан гэж хошууны айл амьтдаар зарцлагдан голоо зогоодог өнчин өрөөсөн нэгэн байгаад мод түлээ бэлтгэж яваад осолдож амиа алдсан нэгэн байжээ. Хүний төрөл олсон байхдаа зовж зүдэрсэн тэр амьтан “онолоор” бол сраз диваажинд морилох учиртай боловч тэгсэнгүй аж. Аюуш хувилгаан Сүхбалсангийн сүнстэй ярилцжээ. Тэгэхдээ түүнийг урьд өмнө нь “танилцаж” нөхөрлөж явсан чөтгөрүүдээсээ илүү хорлонтой хатуу чанга чаралбаа болсныг нь мэдэв. Чацарганатын аманд ойртсон болгоныг хорлож хөнөөнө гэдгээ тэр Аюуш хувилгаанд мэдэгджээ.

Сул талыг нь олж мэдэх гэж хувилгаантан гурван хоног хамт байгаад юу ч олж чадсангүй. Түүнийг дарж сөнөөх нь Аюуш хувилгааны үзэл бодолд үл нийцэх тул өөр арга бодож олжээ. Хувилгааныг ирэхэд хүмүүс цугларчихсан “яав, ийв” гэлцээд сүйд болж байв. Хувилгаан тэдэнд ганц тарнийг хагасдутуу цээжлүүлээд “Энэ л та нарын аврал. Өөрөөр би түүнийг яаж ч чадахгүй юм байна” гэж үнэнээ хэлжээ. Тэгээд л тухайн нутгийнхан ч хувилгаантны тарнийг ам хуурайгүй уншиж явах болов. Нэг өдөр хувилгааныг өөдлөөгүй байхад гэрийнх нь гадаа Сүхбалсангийн сүнс ирээд дуудаж байна гэнэ. Аюуш дээлээ нөмгөн өмсөөд гарахад чөтгөр аргаа барсан байдалтай хэлсэн нь:

- Сонин юм даа. Миний хорлох гэсэн хүмүүс бүгдээрээ доголон дарь эх болчихсон байх юм. Би яаж ч чадахгүй байна. Энэ нутгаас зайлъя даа гэжээ. Түүнээс хойш Чацарганатын амны чөтгөр хаашаа ч юм цагаачлаад яваад өгсөн байна. Чөтгөр хүмүүсийг “Доголон дарь эх” гэж харсны учир нь Аюуш хувилгааны зориудаар тарнийг хагас дутуу цээжлүүлснээс тухайн хүмүүс чөтгөрт доголон болж харагдсан гэдэг. Чөтгөр царайлаг, нуруутай туруутай хүмүүсийг сонгох гоо сайхны таашаал, мэдрэмжтэй ч юм бил үү, хэн мэдлээ.

## **Арабууд монголын говьд үхэр нядалж, эзнийх нь сүнсэнд хоригджээ**

Жил жилийн хаврын баяраа тэмдэглэх гэж лалын шашинтнууд Монгол руу цувах болсон нь нууц биш. Говь нутгийн тарган үхэрнүүд тэдний баярын золиос болно. Өнгөрсөн хавар Наурызын баяраа тэмдэглэх гэж Арабын нэг омог хүмүүс Улаанбаатарт буужээ. Хүчит шонхор захын малын нядалгаан дээр ажилладаг залуусыг тэд хөлслөөд л говь руу гараад өгсөн байна. Хөлсний ажилчдынх нь дотор миний танил Гантөгс явсан учир энэ түүхийг надад ярьсан юм. Арабууд хэдэн том машинтай гарч тарган тарган шаруудыг мөнгө харамлахгүй худалдан аваад ачиж байв. Тэдний очсон нутагт олон үхэртэй эмгэн байгаад Цагаан сарын өмнөхөн нас барсан гэнэ. Түүний үхэр мал тухайн нутагтаа сор болсон амьтад байв.

Өв залгамжлагч нь Улаанбаатар хотод нэг хувийн сургуульд багшилдаг хүн байдаг бололтой. Хүү нь эмгэнийг нас барахад ирж толгойг нь түшээд хамаатныхаа айлд үхэр малыг нь үлдээж, нэг бүрийг нь 200-400 мянган төгрөгийн хооронд тооцож ирэх хичээлийн жилийн өмнө мөнгө авахаар тохироод буцсан байна.

Талийгаачийн малыг хариуцаж үлдсэн хамаатныхан нь мөнгөтэй арабуудад өндөр үнээр шахаад өөртөө хэдэн төгрөг унагах сонирхолд автжээ. Үүний буруу гэж ч юу байхав. Арабууд ч тэдний малын тарган цатгалан, нас бие гүйцсэнд нь сэтгэл хангалуун байсан тул шууд мөнгө хаяж авчээ. Хаврын битүү сартай салхи шуургатай өдөр арабууд мах ачсан машинуудаа

гурван жийпээр дагаж явав. Улаанбаатар орох замдаа зарим үхрүүдийн бодийг хөтөлж аллах тэнгэртээ өргөл өргөх юм болов. Таван үхрийн хүзүүг хэрчиж орчмын газрыг нь улаанаар будаж аллахдаа айлтгал өргөж байтал арабуудын майханд өтөл дорой нэгэн эмгэн орж иржээ.

Нядалгааны монголчууд тусгай майханд байсан тул эхэндээ мэдээгүй ажээ. Хэлмэрчээр ажиллаж байсан Мусальманы сүмийн ажилтан казах эр ирж монголчуудад хэлснээр тэд арабчуудын майханд очжээ.

Тогоо, тогоо дүүрэн мах тавьчихсан идэж цацаж байгаа арабуудын дунд нэгэн эмгэн сууж байх юм гэнэ. Юм ч ярихгүй. “Хайран мал, хогшил минь” гэж харамссан байдалтай. Арабууд ч өгөөмөр сэтгэл гаргаж нэг үхрийн хэлийг уртаашаа зүсэн эмгэнд өгөх гэжээ. Эмгэн “Хөөрхий, муу Улаадайн маань хэлийг хэрччихэж. Буруу номын буянаа орхисон ландармууд!” гэж зүхэх аж. Эмгэний хамаатны нэг эр тэдний машинд дайгдан Улаанбаатар орохоор явж байсан тул болж буй хэрэг явдлыг тайлбарлаж өгчээ. Энэ эмгэн бол хоёр сарын өмнө өөд болсон бөгөөд үхрийн эзэн нь мөн болох талаар ярьжээ. Арабууд ч аллах, энэ тэрээ дуудаж нүүрээ алгаараа таглан сөхрөн мөргөж гарчээ.

Монголчууд тэр үед монгол чөтгөрөө дэмжиж арабуудад хандан “Алах хүний үгийг сонсож, алсан малын цусыг авдаг” монгол заншлыг тайлбарлаж арабуудын зэрлэг балмад үйлдлийг шүүмжилжээ. Арабчууд ч хүн юм болохоор айж сэжиглэн өглөө эртлэн хөдлөхөөр зэхжээ. Гэсэн ч эмгэний сүнс тэднээс салсангүй. Нэг харахад жийпний ачааны даруулгандээр сууж явна. Амьд үлдсэн үхрүүдийнхээ уяаг тайлах гэж оролдоно. Нутгийн хилийн дээсийг алхах үед эмгэний сүнс улам ихээр бачимдан уурлаж, урд явсан жийпний цонхыг балбаж гарав.

Залуус бурхан багшаа дуудаж, арабууд аллах тэнгэрээсээ аврал хүссэн боловч ямар ч тусыг олсонгүй. Нэг араб эр ганц үхрийг машинаас буулгаж орхиод эмгэний сүнсийг залилах арга сүвэгчлэв. Эхэндээ эмгэн зам дээр торойн үлдэх ганц үхрээ илж, маажин эрхлүүлэв. Мөнөөх араб эр өөрийгөө нэлээд сиймхий ухаантай эр гэж додигор явжээ. Гэсэн ч төдөлгүй сүнс тэдний урдах зам дээр сүүмийн зогсож байв. Гэгээн Мухамедээ хурдан ирж туслахыг гуйж, ариун коран судраараа зам харгуйгаа цэвэрлэх гэж урдаа барьцгаасан боловч тусыг олсонгүй.

Тэд аргагүйн эрхэнд аяллаа зогсоож монголчуудаас хий үзэгдэл, сүнс сүгийг яаж аргадан тайтгаруулдаг тухай асууж байв. Говь нутагт мэргэн лам нар мэр сэр бий тул тийм нэгнийг олж арга чарга хийлгэх хэрэгтэй гэж монголчууд хэлжээ. Дэмчигийн хийдээс өртөө газар нутагладаг өвгөнийхийг тэд зорив. Үхэр ачсан машиныг эмгэний сүг сүнс болон хэдэн монгол нядлаачин сахиж үлджээ. Нутгийн хилээс гарах үед хүнд даацын машины давхар том дугуй пас пасхийн хагарч сүүлдээ машин ч асахаа больсон болохоор ингэхээс өөр арга байсангүй.

Жав хэмээх тэр өвгөн толгой түрүүгээ алчуураар боосон харь хүмүүсийг хараад төдийлөн таашаасангүй.

- Яах юу байхав. Үхэр малыг нь үлдээгээд л явахгүй юугэжээ. Монголчууд өвгөнийг гуйж “Эд бид нар шиг хүний л зарц хийж яваа хүмүүс. Өдий олон хоногоор явчихаад хоосон очвол эзэн нь эдний хүзүүг нь хэрчиж Аллах тэнгэрийн гэсгээлийг үзүүлнэ. Эд нар ямар ч байсан хүн шүү дээ. Та л тус болж үз” гэх мэтээр ятгав. Өвгөн нэлээд зүрхшээж байгаа бололтой.

- Би та нарыг тэр чөтгөрөөс салгаад явуулж болно. Харин өөрөө түүнээс яаж салах юм. За, яахав. Ямар ч байсан очихоос доо гээд дуртай дургүй хувцсаа өмсчээ. Тэдний ачаа хөсгийн барааг хараад өвгөн “Чойрын богд минь. Энэ чинь тээр жилийн хэрэг явдал шиг юм болсон байна. Аливаа юм жаран жил дотроо давтагддаг юм байна” гэжээ. Сониуч залуус жаран жилийн өмнө юу болсон тухай шалсаар байж өвгөнөөс нэгэн түүх сонсчээ.

Өвгөн хоолой засаад:

- Манай говь нутаг чинь хэзээнээс нааш үхэр цөөтэй нутаг. Тэр үед би хүүхэд байсан. Халхын голын дайн болж Орос цэргийн цуваа хэдэн шөнө зүүн тийшээ цуварсан юм. Түүний дараахнаас л “Орос ах нар манай эх орныг хамгаалахаар ирээд байна. Орос цэргүүдийн хүнсэнд олигтой үхрээ өг” гэж сум, багийн дарга нар ухуулж явсан юм. Манай суманд Дарь гэж харамч хахир гэгдсэн чавганц байсан. Хэдэн сайхан үхэртэй хүн байсан даа.

Тэр эмгэн үхрээ цэргийн хүнсэнд өгөхгүй гэж дарга нартай хэрэлдэж. Дарга нар ч нам засгийн бодлогоор далайлгаж байгаад хэдэн цаасан төгрөг үлдээгээд аваад явсан. Тэр үед хөдөөнийхөн цаасан мөнгийг тоохгүй. Арилжааны хэрэгсэл нь цалин цагаан мөнгө байсан. Эмгэн тэдний хойноос “Энэхувхай цаасаар чинь би юугаа хийх юм” гэж үсээ зулгаан орилж хоцорсон гэдэг юм. Тэгээд л Дарь эмгэнийг хэдэн үхрийнхээ хойноос харамсаж шаналсаар удалгүй өөд болсон гэж ярьцгаадаг байсан. Эмгэний сүнс тал нутгаар сүүмэлзэн явж аргал түүдэг, хүний бараанаар юм шидэх зэрэг хачин хөдөлгөөн үзүүлж өөртөө ойртож очихыг хориглодог байсан гэдэг. Өвгөн ингэж яриад:

-Энэ эмгэн чинь урд сумын хүн байх чив гэжээ. Тэднийг очиход мөнөөх эмгэний сүнс байсгээд л машинаас машин дамжин үзэгдэж, зориудаар бэлтгэсэн өндөр хашлаганы цаана мөөрөлдөх үхэрнүүдээ илж эрхлүүлж байгаа харагдав. Өвгөн ойролцоох толгой дээр гарч арц хүж уугиулан ном уншиж, арабууд ч өөр шашныг үл тэвчих тул жийпэндээ сууж хаалга, цонхоо тас хаажээ. Тэр явдлыг монгол залуус болохоор сониучирхаж харж “Тэр! Тэр хараа. Өнөөх эмгэн чинь өвгөний сууж байгаа толгой руу очиж явна” гэлцэв. Үнэхээр эмгэний сүнс намхан толгойн ар талаас мацаж байв. Ойрхон газар тул өвгөн номоо үргэлжлүүлэн уншиж, эмгэний цайвар саарал дүр төрх нь дээрээсээ урагдаж лаа шиг хайлан алга болов. Тэр агшинд залуус гүйлдэн очиход мань өвгөн номынхоо нэг хуудсыг эргүүлэх гээд гар нь чичирч өргөж даахгүй байгаа юм шиг харагджээ. Номын хуудсан дээр нэг аалз огт хөдлөхгүй арвайж сарвайн байж байв. Өвгөн нүдээрээ дохисонд нэг залуу аалзыг авч хаявал номын хуудас эргүүлэгдэж, мөнөөх аалз гаансны үнс болжээ. Энэ бүхний дараа арабууд замд орхисон нэг үхрээ өвгөнд үлдээгээд Аллах тэнгэртээ тахилга өргөхөөр Монголын нийслэл рүү зам шулуудсан байна.

## Охиных нь сүнс шоронгоос аавыгаа гаргажээ

Огцом гэдэг нэртэй газар Налайхын ойролцоо байсан гэдэг. Тэр нь Ок симм буюу охин минь гэсэн үгнээс гаралтай нэр байжээ. Нургуль гэдэг казах охин, Баяр нэртэй монгол залуу хоёр хайр сэтгэлтэй болж, янаг амрагийн харьцаа тогтоожээ. Казах заншлаар казах охид өөр үндэстэнтэй гэрлэх ёсгүй хатуу хуультай тул тэдний амьдрал санаснаар болсонгүй. Тэгээд ч казах охид эрийнхээ гэрт орж байж энгэр зөрүүлдэг ёс заншил бий тул Нургулийн янаг амрагийн явдалдаа яарсан нь үндэсний заншилдаа үнэнч эцгийнх нь уурыг барж ичгүүрийг бий болгожээ. Нургуль, Баяр хоёр барилгын ТМС-д хамт суралцаж улмаар Налайхын уурхайд нэгнийгээ бараадан очсон билээ. Амралтын өдөр болохыг залуу хосууд тэсч ядан хүлээж ууланд жимс, самар түүх нэрээр хоёр биений жаргал, сэтгэлийн цэнгэлийг ханатал эдэлдэг байв. Нэг тийм намрын нарлаг өдөр тэднийг жимсэнд явж “төөрөх” үеэр Нургулийн эцэг дагажээ.

Тэр хоёрыг хөтлөлцөн тэврэлдэн гүйлдэж онгон догшин байгаль эхээс өөр ичих юмгүй байхад ногтон сахалтай казах эр тэднийг модны завсраар хилэнтэйеэ харж, царайгаа цус хуртал мэнчийлгэн байжээ. Нургулийн цэвэрхэн цагаан бие нүцгэрч, Баяр бие сэтгэлийн билүү улаан илдээ сугалан гаргаж байтал урт хутга өмнөө тас атгасан хэрцгий казах эр гарч ирсэн байна. Айж сандраад хийж буй үйлдлээсээ ичихээ мартсан Баяр:

- Та хэн бэ? гэхээс өөр үгийг хэлж чадсангүй. Казах эр үг хэлсэнгүй нүдээ аймшигтайгаар эргэлдүүлэн дайрсанд

Баяр амжин босч хагас дутуу тайлсан хувцсаа нэг нэгээр гээж зугтжээ. Хар ажилд бие, тэвчээр нь төмөр шиг ширээгдсэн эр түүнээс амар салсангүй. Мод сүлжин хөөсөөр. Баяр төдөлгүй эцэж ядран хэлээ унжуулан унахад тэр казах эр эргэлзсэнгүй шууд урт хутгаа ууц нуруунд нь зоож орхижээ.

Дөрвөн мөчөө сарвайлган амь тавьж байгаа түүнийг том орос бакиалаар хэдэнтээ дэвсэж гүйцээсэн тэр алуурчин газрын хөрсийг хөлөөрөө тээж, талийгаач залуугийн цогцсыг хөвдөөр булж орхиод юу ч болоогүй юм шиг тоомсоргүй эргэв. Аллах тэнгэрийн зарлигийг биелүүлсэн түүнийг охин дээрээ ирэхэд Нургуль гарт нь байгаа цусанд бялдсан том хутгыг харж.

- Аав аа, та яаж байгаа юм бэ? Хүн алчихлаа ш дээ. Баяр аа... Баяр аа... гэж хашгирчээ.

Телейбек хүчирхэг гараараа охиноо базан чирч зодож занчсаар гэртээ авчирсан боловч охин нь уйлж орилон сэтгэлт залуугийнхаа нэрээр дуудан байсаар орой нар жаргахын үед солиорч эхэлжээ. Нүд нь аливааг онож харахгүй болж, нэг сүүмийн нэг томоор эргэлдэн амнаас нь цагаан хөөс сахран байснаа гарч зугтсан байна. Нэгэнт харанхуй болсон тул Телейбек охиноо олсонгүй. Дэмий л “Ок симм, Ок симм” - Охин минь ээ! гэж хашгирсаар хоолой нь сөөж, шөнийн харанхуй, мунхагийн харанхуй хоёрт эзлэгдэн сөхрөн унажээ.

Маргааш өглөө нь усны тохойноос Нургулийн цагаан өмсгөл хөвөн гарч ирснээр түүнийг усанд амиа үйж үхсэнийг мэдсэн байна. Нэгэнт хэрэг явдал их дуулианыг дагуулсан болохоор

Телейбекийг цагдаагийнхан баривчилж тэр шорондоржээ. Түүнээс хойш голын хөвөөгөөр цагаан өмсгөл хээ гарган хатгасан казах гоёлтой бүсгүй янаг амрагийн дуу дуулан алхаж байхтай олон хүн таарчээ. Нургуль охины сүнс сүг тэр үзэсгэлэнт газар уснаас үл дайжив. Цаазаар авахуулах ялнаас мултарсан Телейбек шоронд 25 жил хоригдох болж, шоронгийн наар цэвэрлэн халхын овгоруудын алцайн зогссон хөлийн тоостой гутлыг долоож эхэлжээ. Телей уг нь навчнаас тасалж төрсөн, нарнаас халхалж явсан ганц охин Нургулиа уурын мунхгаар хайр сэтгэл хамаг юмтай нь хөнөөж орхисондоо гэмшиж, хийсэн нүглээ улам ихээр ухааран шаналж байв.

Дээр нь овгоруудын дарамтанд нүднээс гарсан аж. Нэг удаа Хэлтгий хочтой Шаагаа гэгч овгор Телейбекийг зодож, нүүр нүдгүй өшигчин өмд бандаашаа угаалгаж байтал түүний хажуугаар нэгэн гар орж иржээ. Нургуулийнх нь турьхан цагаан гар мөн байв. Аавыгаа ядарч зүдэрч байхад туслалцаж, тэр хувцсыг угааж өгөхийг хүссэн байна. Түүнээс хойш охиных нь сүнс Телейбекийг ядарч зүдэрсэн үед үзэгдэж, амьд сэрүүн үеийнх шигээ үс толгойг нь илбэж эрхлэх шиг болно. Телейбек шоронд охинтойгоо хамт байна гэж бодоод сэтгэл санаагаар унахгүй, ажилд сайн тул ялын хугацаагаа богиносгож хөлс дуслуулан зүтгэсээр хугацаанаасаа өмнө суллагджээ.

Түүнийг шоронгоос гарч ирэхэд Нургуулийн усанд үйж үхсэн газар түүний сүнс байнга үзэгддэг тухай ах, дүүс нь ярьжээ. Телейбек охины араас ариун бүхнийг хийхсэн гэж бодно. Усанд улаан ямааны хүзүүг хэрчиж цусыг нь гоожуулж байгаад байгаль дэлхийдээ хайртай монголчуудад уул, ус бохирлож бузарласан гэж зодуулж үзжээ. Телейбекийг гарч ирснээс хойшхэд хоногийн дараа Нургуулийн сүнс үзэгдэхээ больжээ. Зарим хүн түүнийг Баярын амийг хөнөөсөн уул руу явчихсан гэж үздэг. Яагаад гэвэл усны тохойд “Ок симм” гэх дуу орой үдэш тасрахгүй сонсогддог байгаад “Баяр аа... Баяраа” дуу мөнөөх уулын хад чулуунаас эдүгээ хүртэл цуурайтаж байдаг гэлцэнэ. Учрыг эс мэдэх жимсчид тэр дуу чимээнд хууртаж Баяр гэдэг хүнийг нэгэн эмэгтэй хайж явна лээ гэж ярьсан ч удаатай билээ. Ингэж казах, монгол хоёр залуугийн хайр сэтгэлийн харамсмаар ул мөр хад чулуунд хүртэл цав суулгасан нь энэ аж. Харин хүний сэтгэлд суусан цав хад чулууныхаас хурдан ч аньдаг юм шиг санагддаг даа.

## Хөөргөнд шүглэсэн чөтгөр буюу түүнийг өвөртлөж явдаг ламтан

Ийм нэгэн ид шидтэй хүн байх. Хайдавжамбал өөрийгөө хувилгаан удамтай гэсэн. “Над шиг муу ламаар юм үзүүлэх хэрэггүй. Ганданд очоод номоо уншуулчих” гэнэ. Яасан үнэтэй эр вэ гэж зарим хүн дургүйцэх боловч ямар нэгэн онцгой увидастай учраас ингэдэг байх гэж түүнийг царайчилна. Түүний энэ араншинг рекламдаж байгаа хэрэг гэж үзэх хүн ч бий. Хайдавжамбалыг нэгэн айлд залагдан ном уншиж байхад нь би таарсан юм. Уг айлын гэртээ хүүхэд гаргасан охин нь гэв гэнэтхэн нас барсан байна. Орой зүгээр л инээж ханиаж ярьж хөөрч байгаад л унтсан. Тэгээд сэрээгүй байна. Хүнтэй суугаагүй боловч хүүхэд гаргасан тэр золгүй бүсгүй “Ээж, хүү хоёрынхоо төлөө” гар хумхилгүй хөдөлмөрлөж, аль л хүнд хүчир ажлыг нугалж байжээ. Амьдын хугацаандаа амар заяа үзээгүй, үхэх хүртлээ таван цаас яаж олохов гэж явсан түүнийг “жаргал үзсэнгүй дээ, хөөрхий” гэж ээж нь нулимс асгаруулан халаглаж байсан. Настайчуул л болсон хойно талийгаачийн хойноос ээж ном судар арвин их уншуулж хойдын буянг нь хийжээ.

Гэсэн хэдий ч талийгаач охин нь шөнө болгон зүүдлэгдэнэ. Зүүдлэгдэхдээ баахан үхэр туучихсан ирээд “Ээж ээ, миний хойноос яваад очоорой. Би танд сайхан цай чанаж өгье” гэдэг байна. Хөөрхий дөө, надад цай чанаж өгөхөөрөө л нэг болсон амьтан юмсан. Юундаа ингэж зүүдлэгдээд байдаг юм бол. Энэ нэг л биш ээ гэж бодсон хөгшин Хайдавжамбал дээрочжээ. Мань Хайдавжамбал бас л үнэрхэж “Нутгийн настай хүн байтлаа та над дээр эрт ирэхгүй яасан юм бэ? Охины чинь сүнс төрөл олоогүй юм байна. Одооны лам нар чинь мал гэсэн үг. Лам гэдэг нэрийг араас нь уншуулахдаа л таарсан амьтад” гэж мэргэжил нэгтнүүдээ доош нь хийж, өөрийгөө рекламдаад авахаа ч мартсангүй. Хөөрхий зовлон үзсэн хөгшин түүнийг гуйж, үнсэж үглэсээр байж гэртээ авчирсан байсантай нь би таарсан. Намайг хөгшнийд ороход хүрэл бор царайтай догшиндуу байрын хүн нэлээд халамцуу сууж байна.

Ширүүн харцаар харж “Энэ ямар хүн ороод ирэв. Хувилгааны удамтай уулзах хувьтай л эр юм” гэж байна. Жижигхэн хаш хөөрөг гаргаж тамхилаад “Энэ хөөргөөр мэндээ мэдүүлсэн хүн ноён” хэмээв. Овоо л бүлтэрдэг гар байна даа гэж бодоод тэр үгийг дагамаар аядаж дэргэд нь очиж суув. Ширээн дээр хонх дамар, даллаганы сум, ном судар тэргүүтнийг гаргаж тавьсан нь тэр хувилгаан гэх эр ид ном заслын ажилтай байсан бололтой.

Хөгшин ч намайг “Ном сонин бичдэг сайн хүү байгаа юм. Энэ хүүгээс бишүүрхэх хэрэггүй. Ажлаа цааш үргэлжлүүл” гэж байна. “Би дийлэхгүй юм шиг байна. Уг нь зөөлөн аргаар аргалчихъя гэсэн. Танайд нохой бий биз дээ? Чихнээс нь хоёр гурван дусал цус аваад ир” гэж Хайдавжамбал лүндэнэв. Хүүхэд, залуус гарч номхон шар нохойгоо гаслуулан байж чихийг нь имнээд хэдэн дусал цусыг сэтэрхий аяганд хийж ирэв. Аягатай цусан дээр мань эр архи задлан хийж байна. Өөрийнхөө хийж байгаа зүйлийг байнга тайлбарлалчих бололтой юм гээч. Аяганы ёроолд архитай холилдон исч нөжирсөн цусыгхүн болгонд харуулж “Ямар хэлбэртэй байна? Хүний дүрстэй байгаа биз?” гэснээ ном уншиж гарав. Аягатай юм эргэлдэн хөдөлж, мань эрийг ном уншихаа болиход зогсож байв.

Сүсэг багатай миний хувьд үүнд огтхон ч гайхах сэтгэл төрсөнгүй. Яагаад вэ гэвэл Хайдавжамбал ном уншиж байгаад болихдоо өөрийн тэнгэр язгууртайг шагшин гайхаж, бас огтын хамаагүй намайг зөв сэтгэлтэй хүн байна, авьяаслаг хүн байна гэх нь архинд дуртай



хүний араншин мөн санагдсанаас л тэр. Тэгж хий дэмий юм бурж согтуурхаж байгаад дахиад хэдэн төвд үг хэлэх юм.

Ямартаа ч байсан түүнийг ном уншиж эхлэхэд аягатай архин доторх цус хөдөлж байв. Хэсэг зуур энэ байдлыг хэдэнтээ давтсаны дараа аяга руу зааж “Цус одоо ямар хэлбэртэй байна вэ? Шувуу шиг болчихсон байх ёстой” гэж байна. Хүн болгон хэрэгт дурлаж, аягатай руу тонгойн харвал үнэхээр нөжирсөн цус шувуу шиг хэлбэртэй болчихсон байв. Энэ нь Хайдавжамбал ламтан сэржим өргөж байгаа нь тэр гэнэ.

Гэрийн эзэн хөгшин нүдээ анин залбирч суугаад хоёр нүднээс нулимсан дусал урсгаж байв. Хөгшний хэлснээр Хайдавжамбал ламын сахиус нь ирж байгаа гэнэ. Тэр хийрхүү эр ч хөгшний үгийг сонсоод ширүүн цочмог харцаар ийш тийш харан, заримдаа тооно өөд ямар нэгэн юм эрэх мэт харц шилжүүлэн гэрт байгсдыг айлгах аядана. Тэгж байснаа Хайдавжамбал аягатай архийг аваад нэг амьсгаагаар хөнтөрчихөв. Түүний хэлснээр охины сүнс шувуу болон нисч тонилох байсан хэдий ч тэр хувилгаан эр сүнсийг идэж, сайн төрөл олгож байгаа нь тэр гэнэ. Мань эр тэгж байснаа амныуншлага болсон Гандангийн лам нарыгаа муулах ажилдаа орно.

Өөрийнхөө ширмэл савтай бор зандан аяга руу зааж “Энэ далай ламын урд талын дүртэй хамт Төвдөд ном үзэж байсан Урианхайн их хувилгааны аяга” гэж рекламдав. Бас түүнийг барьж үзсэн хүн ноён болдог юм гээд байсан хөөрөг дотроо чөтгөр байгаа гэнэ. Чөтгөрийг өвөртлөж, үнэрлэж явах хувь тавилан тэр ламтанд тохиолдсон юм байх аа.

Нэг удаа Хайдавжамбал айлд залагдан очоод чөтгөрийг даржээ. Түүний номын хүчинд гэрээр нэг гал дүрэлзэж, чөтгөр орох газраа олохгүй хулгана болж, нэг ялаа болж нэг үзсэн гэнэ. Тэгж байгаад түүний хөөрөг рүү яваад орчихож. Мань лам ч хөөргөө таглаж аваад хамрын тамхи болгож хувиргаад үнэрлэж явдаг болсон юм байх. Түүний хөөрөгний тамхи хэзээ ч дуусдаггүй, цаанаасаа нэмж дүүрч байдаг гэнэ лээ.

## “Ална шүү” гэдэг үгийн хор сүнсийг нь авч оджээ

“Ална шүү”. Энэ үг энгийн хэрэглээ, бүр гоё үг шиг сонсогдох болсоор уджээ. Төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон төрийн түшээд хүртэл ам булаацалдан хэлсээр энэ үгийн эрэлт үлэмж нэмэгдэв. Монголчууд “амны билгээс ашдын билэг үүднэ” хэмээж эрт дээр үеэс хортой муу үг хэлэхийг цээрлэж ирсэн байдаг. Бүр хэлний нүгэл гэж шашны тусгайлсан ойлголт хүртэл бий. Ална гэхээр алчихдаггүй амны л нэг уншлага гэж ойлгох, хамар доорх хагархайгаа хамаагүй зүйлд урчих шахдаг хүмүүст сургамж болгох үүднээс нэгэн тохиолдлын талаар өгүүлье.

Базарсад Их засаг, ханын материалын чиглэлд микро барьдаг нэгэн. Жолооч нарын “янхан” гэж дургүйцдэг үгийн бай болж, бусдын урдуур зүтгэж, хөдөлгөөний дүрэм зөрчиж хэдэн хүүхэддээ талхны мөнгийг нь олох гэж өдөржингөө л бусадтай хэрэлдэж, хэмхэлдэж, торгуулахдаа торгуулж л явдаг. Нэг удаа “Өргөө” кино театрын буудал руу эргэх замаар баруун тийшээ явж байхад өөр нэг машин урдуур нь дайрчихжээ.

Базарсад барсайтлаа уурлаж “Чи муу П-...да. Чи заавал түрүүлж явах ёстой юм уу” гэж бархиран машинаа хоёр тийш гулжигануулан мушгижээ. Хойно нь явж байсан саарал “Марк-2”-ын жолооч түүний хажуугаар орж ирээд бас л “Чи муу П... яаж яваад байгаа юм бэ. Ална шүү!” гэж хашгирсан байна. Нэлээд биерхүү, хажуудаа бас булиа залууг суулгаж явсан түүнийг Базарсад хараад нөгөө айхавтар уур омог ньдарагдаж “Чи алуурчин юм уу?” гэж шингэн дуугаар янцгаажээ. Нөгөө “Марк-2” ч гэрлээ олилзуулан ирж өмнө нь хөндөлсөөд “Буугаад ир!” хэмээн зандарчээ. Базарсад гол харайж, замын машин бүхнийг зандарч явсан “нүглээ” наминчлан машиныхаа радиод анхаарлаа хандуулж зэрэгцэн сууж явсан зорчигчдоос дэмжлэг эрсэн нүдээр харжээ. Тэднийг буудал дээр очиход саарал “Марк-2”-ынхан булчин шөрмөсөө зангируулан мулзан толгойноосоо нарны гэрэл ойтол шилээ шөргөөн тосох нь тэр. Базарсадын тостой цамцны энгэрээс өм цөм атган чирч гаргасан тэд үхлийн гэмээр аймшигт том нударгыг гаргаж далайхад зорчигч авгай нар “Болиоч ээ. Хүн аллаа” хэмээн орилолдон байж салгажээ. Базарсадын хамаг бие чичрэн, зүрх нь хэдэнтээ зүсэгдэж, нимбэгний хальс шиг хогийн сав руу шидэгдсэн мэт санагдаж байв. “Ална шүү. Хэрээ мэдэж яваарай. Хоолны чинь савыг хага дэлсэнэ шүү, таавчиг минь” зэрэг үгсийг түүний чихэнд хадааж орхиод “Марк-2”-ынхан машиндаа суугаад арилж одсон аж.

Хүчирхэг гараар заамдахад хоолой нь боогдсоноос өмдөндөө үл мэдэг дусаасан Базарсад тэр өдөр өөдөлсөнгүй дугуй нь хагарч зогсоно. Эсвэл хэд гуравхан хүнтэй хотын нэг захаас нөгөө зах хүрнэ. Дэмий л хүчтэний дэргэд хүчгүй нь буруутай гэгчээр кондуктор бандийгаа “Орилооч, ачаач” хэмээн загнаж явсаар шөнийн 01 цаг болоход гэрийн бараа харжээ. Хашаандаа орох гэж байгаад хаалгаа мөргөж микроныхоо урд талыг гэмтээж авав. Бүх юм сулавгар, уур хилэн нь хэнд ч юм асч авалцаад болдоггүй. Урд нь “Хэдэн төгрөг олж ирдэг амьтан энэ л юм чинь” гэж эхнэрийнхээ долигонон бэлтгэсэнхоолыг ховдоглон иддэг байсан бол энэ удаа орж өгсөнгүй. Ядаж байхад эхнэр нь “Яагаад хоолоо идэхгүй байгаа юм бэ? Гуанзанд орчихсон юм уу” гэж түймэр дээр нь гал нэмнэ. Тэгэхдээ тэр гэр орондоо дүвчигнэж, уур амьсгалыг нь тундр болгож үзээгүй болохоор орон дээрээ гарч лампиран тааз өөдөө гөлрөн хэвтээд өгчээ. Өглөө 06 цагт босч ажилдаа гардаг Базарсад харсан чигээрээ л таазаа ширтэн хэвтэж байв. Нөгөө муу эхнэр нь босчихсон сав суулга түчигнүүлэн

нөхрийнхөө цай хоолыг бэлдэж байна.

Базарсад гөлийсөн чигээр хэвтэж, голийсон амьтан шиг эхнэртээ харагджээ.

- Чи ажилдаа явахгүй юм уу? Үхсэндээ уурлаад байгаа юм гэж эхнэр нь хэрүүл өдөв. Нөхөр нь дуугарах ч үгүй, хөдлөх ч үгүй тааз ширтсэн чигээрээ. Хоёр шанааг нь дагаж тунгалаг нулимс бөнжийжээ. Түүнээс хойш Базарсад гарч бие засахаас өөрөөр орноосоо ч боссонгүй. Хоол унд ч идэхгүй. Тааз ширтэн хэвтэнэ. Аргаа барсан эхнэр нь түүнийг аль болох хөгжилтэй байлгах гэж дэмий л оролдоно.

- Ганц юм авч хоёулаа хувааж уух уу гэж хүртэл хэлж үзэв. Ямар ч хариу байдаггүй ээ. Долоон буудалд байдаг аав, ээжид нь хэл хүргүүлж авчирсан боловч Базарсад тэднийгээ огт тоохгүй. Аав, ээж, эхнэр, хүүхэд нь бүгдээрээ түүнийг гөлрөө өвчин тусчихаж, эсвэл саа дайрчихаж гэж үзжээ. Нууцаар эмч авчирч үзүүлсэн боловч “өвчтөн” юу ч эс хэлэв. Нөгөө л таазандаа анхаарлаа тавьсан хэвээрээ. Яах ч аргаа олохгүй болохдоо хүн гэдэг амьтан ямар нэгэн юманд шүтэж эхэлдэг бололтой юм. Угаасаа шүтлэг сүсгээр маруухан тэднийхэн

“Тэнд нэг сайн хүн байдаг юм гэсэн, очихоос” гэгцгээжээ.

Базарсадын лам гэж үсээ хусуулчихсан түнжин толгойтой бүдүүн хар авгай иржээ. Орос, Хятадгүй явж олон хүнд тус болсон хүн гэж өөрийгөө танилцуулжээ. Үндсэрхэг үзэлтэй эцэг нь хужаа нарт тус болсон гэхэд нь жаахан дурамжхан байж. Авгай лам зоос татаж, шоо хаяж үзээд үгийн бузар шингэсэн байна гэжээ. Базарсадын аав, ээж нь “Миний хүү амьдралдаа ганц удаа уурлаж, эхнэр хүүхдээ муухай харж үзээгүй юм. Яахлаараа муу үгэнд өлгөгдөж, мухар хавцалд шахагддаг билээ” гэж гайхацгаажээ. Тэгснээ Улаанбаатар хотынхоо микронуудын нүүр царайг санав бололтой бөглөрөл түгжрэл үүссэнээс “Юугаа ч хэлж, хэнтэй ч муудаж явдаг юм билээ. Хэн мэдэхэв” гэгцгээжээ. Тэгээд яавал Базарсадыг тааз ширтэгч биш болгож буцааж микрог нь жолоодуулахав гэсэн ухаантай л юм ярьцгаажээ. Лам авгайгаас гуйжээ. Бүдүүн хар лам өөрөө хичээх учиртай шүү гэж нэгэн тарни бичиж өгчээ. Тэр нь юу гэсэн тарни байсан бэ гэвэл:

“...Сод-гү-рү-нан ди-ни сара мани ши-ши рү рү хү-ра на-на...” хэмээх уншлага байсан бөгөөд 108 удаа уншвал зохино гэжээ. Мэдээж тааз ширтээд таг хэвтчихсэн Базарсадад бага сага засал хийж, өөрийнхөө төлөө өргөл мөргөл үйлдэх ухаан санаатай болгосон гэх. Лам авгай муу үгнээс болж сүнс нь зайлсан байжээ гэж шивнэн хэлсэн байна. Засал хийлгэсний дараа Базарсад муухан мишилзэж, гэрт байгаа хүмүүс рүү эргэж хараад дээр өгүүлсэн зам зуурын хэрүүлийнхээ талаар ярьсан нь энэ юм.

Лам авгайн дээрх тарнийг олон уншигчдад үсэг гээлгүйхүргэх гэж хуулбарлан буулгасан минь ч учиртай.Өнөөдөр ганцхан Базарсад ч биш олон хүн муу үгээр хэлэлцэж, мунхаг зангаараа уралдаж яваа билээ. Үүнийг улс төрчид нийгмийн бухимдал гэдэг бол лам нар арван хар нүглийн хамгийн ланжгар нь хэмээдэг.

Дээрх тарнийг 108 удаа уншаад Базарсад зуурдын өвчнөөсөө салж микрогоо жолоодоод мишилзэж явдаг болсон. Тэр хэзээ ч “Ална шүү, пиз минь” гэх мэт үгийг хэлэхгүй гэж билээ. Бодвол дээрх тарнийг амандаа дуржигнүүлж явдаг байж мэдэх юм шүү.

## Үхээрийн шувууг буудах гээд амиа алджээ

Цэрэнхүүгийн аав хорт хавдраар өвчилжээ. Эдгэршгүй тэр өвчнийг анагааж болдог гэсэн эртний нэгэн домогт итгэхээс өөр ямар ч найдвар үлдсэнгүй. Юу гэвэл өмөн үү туссан хүнд шар шувууны мах идүүлж шөлийг нь уулгавал эдгэрдэг гэсэн яриа бий. Тэгээд Цэрэнхүү шар шувуу агнах гэж нэг нөхөртэйгээ харанхуй шөнөөр хад асга нэгжжээ. Санжаа өвгөний шар шувуудтай гэсэн газарт очиход үнэхээр шөнийн тэр амьтан байсан гэнэ. Нялх хүүхэд уйлж байгаа юм шиг чарлаж байснаа төдөлгүй ёозгүй хөхрөх тэр амьтныг яаж агнадаг аргыг ч Цэрэнхүүд Санжаа гуай зааж өгчээ. Хав харанхуй нөмөрсөн арсгар бүрсгэр хадтай аймаар газар үхээрийн шувуу гэгддэг шар шувуу байдаг аж. Өдрөөр ил гардаггүй болохоор шөнө л түүнийг агнаж болдог байна. Цэрэнхүү нөхрийн хамт мацсаар нэг хад руу өнгийвөл урдаас нь аймаар том алаг нүд гэрэлтэж харагджээ. Тэднийг харсан шар шувуу сар сүрхийлгэн далавчаа хөдөлгөн ойрхон нисч буугаад толгойны үс босч айдас төрмөөр зэвүүнээр инээжээ. Санжаа өвгөн “Алдаж буудаж болохгүй шүү. Тэгвэл голомтоороо сүйрдэг юм гэнэ лээ” гэж захисан байж.

Ойртож очоод гар чийдэнгийн гэрэл тусгахад л шөнийн нүдтэй тэр шувуу агшин зуур сохордог. Гэрэл тусгаж байж буудахгүй бол найдвар бага гэдгийг Цэрэнхүү ч ойлгож байлаа. Шувууны нисч буусан газар руу гэтэж мярайсаар ойртож очиход нэгэн хадны хонхорхойд нуугдан суугаад байх шиг харагджээ. Гар чийдэнгээ огцом асаагаад гэрлийг нь тусгахад шар шувуу ноостой нүүртэй өвгөн хүн шиг харагдахад Цэрэнхүү айн цочжээ. Гэрэлд сохорсон тэр амьтан ийш тийш харах гэж оролдовч хөдөлж чадахгүй байлаа. Хайртай эцгийн нь өвчнөөс салгах ганц эм нь тэр зэвүүн шувуу гэж бодох тул Цэрэнхүү чичирсэн гараар замгаа татаж гохоо мулталжээ. Харанхуй хад доргин чичирч, хадны нөгөө талд нисч гарсан шар шувуу хорлонтой зэвүүнээр чарлан инээжээ. Цэрэнхүү “Түй, цус” гэж хэлээд анхны сумаар унагаж чадаагүйдээ сэтгэлээр унажээ. Нэг сумаар унагаж чадахгүй бол үхээрийн тэр шувууны хараалаар нэг хүн байтугай голомтоороо амиа алддаг гэж сонссон болохоор Цэрэнхүү түүний хойноос улайран хөөцөлдөж, хад чулуу нураан улангасаж байв. Шөнийн нам гүмийг эвдсэн шар шувууны муухай дууг тэр огт тоохгүй болжээ. Хоёр нүд нь харанхуйд шар ногооноор эргэлдсэн гэрэл болж харагдан Цэрэнхүүг өдөх шиг явгалан гүйж энд тэнд нь гаран зэвүүн муухайгаар хөхөрч инээж байв. Цэрэнхүү хэд хэд буудаад оносонгүй. Шар шувуу түүнийг дагуулан өндөр хад руу чарлан инээсээр өгсөж байв. Цэрэнхүүг айхаа больжээ. Харин дагалдан явсан нөхөр нь Цэрэнхүү хориглосон боловч “Чиний аав өвчтэй байсан бол чи ч гэсэн хүүгийн хувьд ингэх л байсан биз дээ” гэж амыг асуугаад мөнөөх зэвүүн бор цоохор шувууны хойноос явсаар байв.

Нэг шовх хадны орой дээр гараад сөрвөлзөн хөдлөх шар шувууг буудаж унагахад амархан санагдах боловч сумаа сул алдсаар л байв. “Гүүг-гүүг, хи-хи-хи” хэмээн дуугарах шувуу Цэрэнхүүгийн уурыг улам хүргэнэ. Тэр буугаа мөрлөж үүрээд мөнөөх шовх хаданд авирч гарлаа. Шар шувуу өөрийн мэддэгхамгийн муу газраа хүрсэн бол цаашаа явдаггүй юм гэж Цэрэнхүү сонссон байлаа.

- Ичээнд чинь орж байгаад барьж авна даа гэж шүд зуун зүтгэсээр хадны оройтой зэрэгцэн ирмэгц шар шувууны аймшигтай зэвүүн ногоон нүд нүүрэнд тулж хоёр махир савраараа Цэрэнхүүгийн нүүр рүү хүүхэд шиг чарлан самардахад тэр өөрийн эрхгүй барьж байсан

хаднаас гараа алдан гүнзгий хавцал руу нисчээ. Цэрэнхүүгийн бараа бологч нь шар шувуу аймшигтайгаар инээж баярлан хашгирч байгаа юм шиг бас өөрийг нь “Нааш ир, нааш ир” гэж дуудаж байсан хэмээн ярьжээ. Зүрхэндээ зүү шивүүлсэн юм шиг айсан бараа бологч Рагчааг унаж тусан гүйсээр мориндоо хүрч байхад өмөн өвчинд баригдсан Цэрэнхүүгийн аав амьсгал хурааж байжээ. Тэр хүн ганцхан хүүтэй байсан бөгөөд Цэрэнхүү өөрийг нь аврах гэж яваад хаднаас нисч, өөрөө ч яг нэг цагт ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн нь тэр гэдэг. Шар шувууны анд яваад сүнсээ зайлтал айсан Рагчаа хэд хоног өвдөж, арга чарга хайсны үр дүнд зүгээр болсон байна. Энэ түүхээс үзэхэд шар шувууг чөтгөрийн шувуу хэмээн нэрлэдэг нь дэмий зүйл биш ч байж мэдэх юм даа.

## **Талийгаачаа зөв зүгт нь гаргаж чадаагүйгээс сүнстэй нь зууралдах болов**

Талийгаач болсон хэн нэгнийг сүүлчийн замд нь үдэхдээ “алтан хайрцаг”-ийг нь нээлгэж зөв зүг, гар бие оролцох хүний жил мэнгэ, газар орных нь байршил, гараг эрхсийн тохиол зэргийг асуудаг. Энэ бүхнийг ёсчлон дагахгүй бол талийгаачийн хойдын буянд муугаар нөлөөлдөг л гэлцдэг. Үнэн ч биз, худлаа ч биз. Тэгэхдээ Улаанбаатар хотод шамбааралдан буусан гэр хорооллынхонд талийгаачаа сүүлчийн замд нь үдэхэд гарах ёстой зүг рүү нь гаргаж чаддаггүй нэгэн бэрхшээл тулгарч байна. Гудамж зам гаргахгүйгээр л хашаагаа хавирганд нааж барьсан замбараагүй байдал нь галын машин орохоос илүүтэй “эрлэгийн элчид” ч хүндрэл учруулж байгаа гэсэн аймшигт бодол төрнө.

Миний нэг танил ийм нэгэн явдлын талаар ярьсан юм. Түүний найз идэр настай нэгэн эр цаг бусаар насан эцэслэжээ. Мэдээж уй гашуу дүүрч, уйлж унжих нь талийгаачийн ар гэрийнхнийг бүрхэн авсан хар сүүдэр болов гэнэ. Талийгаач Д. харьцангуй залуу хүн байсан боловч найз нөхдийн хүрээ өргөнтэй наснаасаа эрт хэрсүүжсэн нэгэн байсан болохоор “Хамгийн сайныг нь хар эрлэг түрүүлж авах юм” гэсэн ард үлдэгсдийг нь доошоо хийсэн ярианд яг таарах нэгэн байв.

Хувийн компанитай залуухан найз нар нь зүг зүгээс ирж ажил төрөл нь сайн сайхнаар цогцолж, бараг диваажинд очихоос өөр газар түүнд үгүй гэж үнэмшиж болох аж. Талийгаачийг зүүн урагш гаргах төлгөтэй боловч гэрийн тэрталд хөршүүд нь шамбараалдан буусан байв. Талийгаачийн талынхан хөршөөсөө “Танай хашаагаар хүнээ гаргая. Зүг нь тэгж таараад байгаа юм” гэж гуйжээ. Гэтэл хөршүүд сэжиглэн дургүйцэв.

- Гэр хашаандаа хүүр оруулахгүй. Муу ёрын юм ярих юм гэж ирээд хагацал үзсэн тэднийг ч хачин эвгүй сэтгэгдэл төрөхүйц загнажээ. Тэгээд арга буюу талийгаачийн шарилыг “Алтан хайрцаг”-т зааснаас нь өөр зүгт гаргаж оршуулсан байна. Түүнээс хойш удалгүй хөршийнх нь хэрүүлч эмгэн орж ирж “Танайх манай руу бузар юм хаясан байна. Ач хүү минь нойрмоглож уйлаад болохгүй юм” гэж үглэжээ. Талийгаачийн аав, ээж ч уурандаа шатаж,

- Миний хүү төрсөн гэрээсээ сүүлчийн замдаа явах ёстой. Манай нутгийн заншил ийм юм. Харин та цусанд төрж нулимсанд амьдарч яваагүй юм шиг битгий загна! гэх мэтээр үг сөржээ. Түүнээс хойш хэд хоног өнгөрөхөд хөрш эмгэний хэлсэн сэжиглэсэн нь бас чиг үнэний хувьтай болохыг талийгаачийн ар гэрийнхэн ойлгожээ. Яасан бэ? гэвэл шөнө оройхон талийгаачийн аав бие засаад гэртээ орох гэж явахад хашааных нь зүүн урд талд мод шажигнан дуугарч, хэн нэгэн хашаа давах гэж байгаа юм шиг чимээ гарчээ. Эцэг чимээ гарсан зүг рүү харсанд талийгаач болсон хүү нь хөрш айлын хашаан дээр сарны гэрэлд сууж харагдах юм гэнэ. Нас барахаасаа өмнө өмсөж байсан хувцас нь яг янзаараа. Уг нь хувцас хэрэглэлийг нь шатааж орхисон юмсанж. Талийгаач хашааг цаашаа давах гэж оролдоод ямар нэгэн юманд хоригдож буцаж байгаа нь түүний хөдөлгөөн үйлдэл бүхнээс нь харагдаж байжээ. Энэ ер нь буруу тийшээгээ хандсан юм болж байна гэдгийг гадарласан эцэг маргааш өглөө нь эртлэн босч Гончигсүрэн лам дээр очжээ. Өвгөний төсөөлж бодож байсан шиг юм болж талийгаачийг буруу зүг рүү гаргачихсан учраас сүнс нь төрлөө олохгүй төөрсөн байна гэж ламтан хэлсэн байна. Үүнийг явал аргалж болохыг асуухад “Буян сайн хий” гэсэн байгаа юм. Гүрэм ном уншуулж, давс шороо атга атгаар цацаад тэрхүү талийгаачийн гунигтай дүр

төрх үзэгдэж харагдсаар үдэш болоход өөрийн унадаг байсан машинд хүртэл хоргодож байх шиг харагдах болжээ.

Ламдаад байдлыг өөрчилж чадахгүйгээ мэдсэн талийгаачийн ар гэрийнхэн бөө, удганд очжээ. Өөрийгөө 14-р зууны үед амьдарч байсан зайрангийн хойд дүр хэмээн инээд хүрмээр, үнэмшилгүй юм ярьж өргөмжилсөн нэгэнд арга буюу үнэн учрыг хэлж хэрхэхийг асуужээ.

Тэр залуухан бөө “Би тийм юмтай харьцах хугацаа минь дутуу байгаа юм. Бараг долоо хоногийн дараа бол сүнс сүлдтэй хэлэлцэж хэрэлдэж, хөөж туух эрхтэй болно” гэжээ. Өөр ямар нэгэн арга үгүй тул бөөг ид шидээ бүрэн олж авахыг хүлээжээ. Тэр хугацаанд байдал өөрчлөгдсөнгүй. Үдэш болгон талийгаачийн сүнс зүүн урагшаа явах гэж хашааны модыг хөдөлгөн дуугаргаж зовлонтой хүмүүсийн сэтгэлийг улам улмаар өвтгөж байсан байна.

Бөөгийн хэлсэн хоног ч болж тэр ирээд их гал түлж дээгүүр нь үсрэн талийгаачийг оршуулсан газрын шороог зүүн урд зүг рүү цацаж цамнажээ. Мөнөөх хөрш эмгэн гарч ирээд “Бузар булай юмаа манайх руу хаяв” гэж хэрүүл үүсгэжээ.

Талийгаачийн машиныг өөрийг нь гаргах ёстой байсан зүг рүү хөдөлгөн зарах хэрэгтэй гэснээр хөрш эмгэнийг долоох шахан байж зөвшөөрүүлж хашаагаа задлан тэдний хажуугаар гаргажээ.

Түүнээс хойш оршуулах зүг нь төөрснөөс эргэж хургасан талийгаачийн сүнс тонилсон гэдэг.

## Далд ертөнцийг хардаг Раашийн учрал явдлууд

Нүдээр далдыг үздэг эгэлгүй хүмүүс байсан тухай эдүгээ домоглон ярьдаг. Манай нутагт далдыг хардаг Рааш гэдэг хүн байсан гэнэ. Түүнийг зарим хүн заль зохиож байна гээд тоохгүй. Газар дээрх ганц найз нь болох Гонгор гэдэг хүн л түүнд тохиолдсон олон явдлыг гэрчлэн хэлдэг байжээ.

Тэгэхдээ Рааш номтой мэргэн хүн биш. Далд ертөнцөд болж буй үйл явдлыг л харж, түүндээ ижил дасал болсон нэгэн байжээ. Рааш, Гонгор хоёр хөдөөх заншлаар айл хэсч, айраг цагаа эргүүлж явжээ. Нэг айлд бууснаа Рааш хэлж байна гэнэ.

- Энэ айлын тотгон дээр улаан нярай хүүхэд сарвалзан тарвалзаад хэвтэж байх юм. Чамд юм мэдэгдэнэ үү? гэжээ. Гонгор хичнээн хараад бүр нүдээ арчиж байж хараад юу ч олж чадсангүй. Харин гэрийн тотгон дээр хоёр багц улаан харгана зөрүүлж тавьсан байжээ. Гонгор “Улаан харгана улаан нялзрай хүүхэд болж Раашид харагддаг юм болов уу” гэж бодсон гэдэг.

Гэрт орвол шинэхэн амаржсан бололтой залуухан бүсгүй байв. Ааш муутай аж.

- Та нар үүдэнд байгаа шижмийг харсангүй юу? Настай хүмүүс байтлаа хөл хориотой айл гэж мэддэггүй юм уу гэжээ. Рааш сархданд нэлээд халчихсан болохоор,

- Хөл хориотой гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэжээ.

- Манайх шинэ хүнтэй болсон юм. Жаахан айлгаад байх юм гэж бүсгүй учирлав.

- Харин тийм юм шиг байна лээ. Хүүхэд чинь гэрт биш гадаа гарчихсан хариугүй морио хүлээгээд байх шиг харагдсан шүү гэжээ. Бүсгүйн нөхөр нь хүүхдээ айлгахад лам залахаар явсан байжээ. Ганц бие үлдсэн бүсгүй мань хоёроор хань татсан ч юм уу,

- Та хоёр жаахан саатвал саат л даа. Манай хүн удахгүй ирэх байх гэжээ. Бүсгүй хүүхдээ авч тэврэхэд шуухинан бүүдэг амьсгалж байх шиг Гонгорт санагджээ. Рааш аяга цай уугаад,

- Хүүхээ, чи тэр эрэгнэгнийхээ дээд талд байгаа бидонтой архиа гаргаад ир гэж авчээ. Эхлээд бүсгүй ойлгосонгүй.

- Юун архи? Хаана тийм архи байгаа юм бэ? гэсэн байна. Рааш,

- Өмнө нь нэг хүнд бүгдийг нь өгөх гэж байгаад согтоод ирэхээр нь аваад үлдчихсэн юм шиг байна. Түүнийг чинь л би уумаар байна гэжээ. Бүсгүй нэгийг санав бололтой босч эрэгнэгээ онгойлгож савгай архи гаргаж тэр хоёрын өмнө тавьжээ. Гонгор ч баярлан “Манай хүн тааж байгаад буудчихсан нь таарав бололтой” хэмээн боджээ. Рааш архины тагийг онгойлгож аягандаа хийснээ,

- Чи байж бай л даа. Би жаахан уугаатахья гэж хэн нэгний гарыг түлхээд байж. Гонгорыг харахад хэн ч харагдахгүй юм гэнэ. Тэгж байснаа Рааш явахаар завдан босч,



- Танай энэ хүн чинь надад аяга юм уулгахгүй нь бололтой. Явья даа, Гонгор оо! гэжээ.

Гонгор “Юу яриад байгаа юм, чи? Хэнтэй хэрэлдээд байгаа юм?” гэж гайхжээ. Рааш,

- Энэ нөхөрт архийг үлдээхгүй бол хүүхэд рүү очижөнгийгөөд байна гэжээ. Энэ бүхнийг сонсож байсан бүсгүй айж,

- Та хоёр хоорондоо юу яриад байгаа юм? Хүн айлгаад хаячихлаа. Битгий яв гэжээ. Рааш, Гонгор хоёр ч хүүхний хүсэлтээр ламыг ирэхийг хүлээхээр болжээ. Төдий удалгүй гэрийн эзэн лам дагуулсаар иржээ. Рааш ламын өөдөөс харж,

- Та хоёр зодолдож чадахгүй л болов уу. Та онохгүй байна шүү дээ. Хэнгэргээ чанга барьдаг ч болоосой гэжээ. Хэдэнтээ ном уншиж ширэг хийж ариулсны дараа лам,

- Та хэнгэргээ чанга барь гэж яагаад хэлэв? Би анзаарсан чинь хэнгэргээ буруу барьчихсан байсан юм билээ. Арай мэргэ төлгө үздэг байсан юм биш биз гэжээ. Тэгэхэд Рааш хэлж гэнэ.

- Таны хэнгэргийг сая гараад явчихдаг нөхөр л чангаалцаж булаалдаад байсан юм. Лам урагш сууж,

- Ямар нөхөр байсан бэ? Одоо гараад явчихсан уу? Хамт гаръя. Хаана байгааг нь зааж өг гэжээ. Рааш лам хоёр хамт гарахад тэр хэлжээ.

- Тэр хүн таны морины хажууд зогсож байна. Эмээлийн чинь хавтсан доогуур орчих шиг боллоо гэжээ. Тэр айлаас маргааш нь мордож явсан ламтан мориноосоо ойчиж бяцхан бэртэл авсан гэдэг. Рааш найзыгаа үнэн хэлээд байна уу, худлаа залаад байна уу гэдгийг мэдэхийн тулд Гонгор түүнийг чөтгөртэй гэх газраар дагуулж явж зүггүйтдэг байжээ.

Сайн малчин Даржаа гэдэг эрийг нас бараад сүнс нь төрөл аваагүй гэж нутгийнхан жиг жуг ярьдаг байжээ. Гонгор, Рааш нар түүний хонины хашааны хажуугаар өнгөрч яваадбууж, өвөлжөөн дээрээс нь зуух, яндан, тогоо олоод цай чанаж уужээ. Гэтэл Рааш шанагатай цайгаа хэн нэгэн рүү сарвайгаад суучихав гэнэ.

- Юу болов оо гэж Гонгорыг асуухад,

- Цаад Даржаа чинь бид хоёрыг ирснээс хойш хөрзөнгөө хураагаад байсан юм. Сая ирээд ам цангаад... гэж цай гуйхаар нь өгч байна гэжээ. Бас нэг удаа архи эргүүлж яваад нэг айлд оржээ.

- Дээшээ суу гэж гэрийн эзэгтэй ихэд хүндэтгэж байх юм гэнэ. Рааш ойр зуурын мэнд усаа мэдэлцээд,

- Одоо яарахгүй бол болохгүй гэж Гонгорыг чирэх шахан гарчээ. Юу болсныг асуухад,

- Цаад бүсгүйн чинь мөрөн дээр түймэр шатаад байна. Энэ лав сайн хүн биш гэж бодлоо гэжээ. Нэг удаа Раашийг нутгийн эрдэмтэй ламтан Гээжээ гэгч дуудуулжээ.

Тэгээд өөрт нь үзэгдэж харагддаг юмсын тухай асуужээ. Тэгээд ламтан хэлсэн нь,

- Чи доорд ертөнцийн хорлолтой амьдралыг илүү мэддэг юм байна. Тэгээд ч бас бусдад үзсэн, харсан юмаа хэлж тус буян болох чадалгүй. Тиймээс би чамд нэг зүйлийг өгье гээд шар модон иштэй хөнгөн балиус тарнидаж өгчээ. Рааш ч гайхаж,

- Гээжээ! Би хутгаар юу хийх юм гэжээ.

- Чамд таарсан юм бүхэн чиний хутганы ид шидийг амсах болно. Яаж хэрэглэхээ ч надаар заалгах хэрэггүй. Түрүүлж л явж болохгүй, бүснээсээ дээш хадгалж яваарай гэжээ. Түүнээс хойш Рааш айлд сууж байгаад гэнэт үсрэн босч мөнөөх хутгаа

гарган гэрийнх нь дээвэр туургыг сархинаг болтол нь дүрж орхиод, морины уяа хүртэл хэн нэгнийг хөөж очдог болжээ. Тэгээд уян дээр хэдэн морь байсан ч бүгдийнх нь дөрөөний таваг, сэнжийг дүрж, бүүрэгний нүх рүү хутгаар гүйлгэдэг байна.

Яагаад ингэдэг болсныг нь түүнээс асуухад “Хачин жигтэй юм харагдаад хөөж зайлуулсан юм” гэж хэлдэг байсан гэнэ.

## Далан давхарт буугаад моргт амьдарч байгаага мэдэв

Нэг хүнд оногдох газраараа дэлхийд толгой цохидог манай улсын нийслэлд газар аймшиг болсон. Ямартаа л үхсэнтэйгээ зэрэгцэн, бүр хашаан дотроо оруулж буудаг болсон байхав. Даландавхарын энгэр даруйхан хашааны газар болж, шилжин ирэгсэд оршуулгын газрын хавтанг онгичин талийгаачдын био хэмнэл, шарилын ялмагт тархи толгой, мэдрэл сэтгэхүйгээ сүйдүүлж эхэлжээ.

Монголд талийгаач газар эзэмшдэг тухай хууль байдаггүй. Тийм болохоор ард иргэдийнхээ газрыг албан тушаалтан нь булж, амьд байгаага болохоороо тэд үхсэн хүний шарилын газрыг өрсөлдөхгүйг нь бодолцож үзээд хашаа тойруулах болов. Шархүү гэдэг эр хөдөөнөөс нүүж ирээд айлын хашаанд хоёр жил толгой хоргодож, өөрийн гэсэн юмтай больё гэж санаа шулууджээ. Гэтэл хотод бараг таних хүнгүй түүнд газар олно гэдэг зангууны үлгэр аж. Арга буюу бусад хүмүүс яаж болж байгаа гэж дээ гээд Далан давхрын шарилын газарт буусан бөгөөд “Сэжгээр өвдөж сүжгээр эдгэдэг” гэсэн үгийг зарчмаа болгожээ. Эхний хэдэн хоногт юу ч мэдэгдсэнгүй. Гэхдээ шөнө орой болоход хүүхдүүдээ гэрээсээ гарч болохгүй гэж захидаг байв. Өөрийгөө Баржуу хэмээх нэгэн хэнэггүй эр шиг аймшиггүй байхаар шийдэж, түүндээ аль болох үнэмших гэж хичээж байлаа.

Гэхдээ шарилын хөлд унтаж байна, эсвэл хэн нэгний бунхалж орхисон газар давхарлан хэвтэж байна гэсэн бодолөөрийн мэдэлгүй толгойд нь орж ирнэ. Тэгэх бүртээ тэр “Баржуу шиг байж чадахгүй гэж үү, би?” гэж өөрийгөө зоригжуулдаг байв. Баржуу гэдэг нь Шархүүгийн нутгийн хүн ажээ. Тэдний сумын эмнэлгийн хашаанд морг гэж түц аятай жижигхэн цагаан байшин байдаг асныг Шархүү ч мэддэг байв. Эмнэлгийн галч Баржуу гуай нэг шөнө галаа түлчихээд харихаар явж байтал нөгөө цагаан байшингийн хаалгыг дотроос нь учиргүй балбаж байна гэнэ. Баргийн хүн бол айгаад зугтахаар байсан ч Баржуу гуай хэнэггүй хүн учир очиж, цүүгий нь онгойлготол өдөр нь бурхан болчихлоо гээд аваачаад тавьчихсан байсан үеийнх нь нэгэн өвгөн цагаан даавуугаа нөмөрчихсөн нүцгэн зогсож байжээ. Баржуу гуай танил өвгөндөө дээлээ нөмрүүлчихээд гэрт нь дагуулж очтол гэрийнх нь үхсэн хүн босоод ирлээ гэж айж зугтан орилж хашгиран сүйд болж байсан гэдэг. Энэхүү болсон явдлын талаар эргэцүүлэн санаж Шархүү өөрийгөө зоригжуулж байлаа. Гэсэн ч айхгүй боловч аягүй санагдаад болох биш. Тэр болгонд Баржуугийн явдлыг санаж өөрийгөө тайвшруулна.

Сүүлдээ тэр нойрон дотроо морг зүүдэлдэг болов. Түүний хашаа нь морг шиг санагдах аж. Зүүд нь өнжихөө больж, шөнө бүр л цагаан даавуу нөмөрсөн хүмүүс хашаан дотуур нь холхино. Арабын язгууртан аятай харагдах нь бүр ч жихүүцэл төрүүлнэ. Эхнэр, хүүхдүүд нь түүнийг шөнө болгон ингэж тарчилж байгааг огтоос мэдэхгүй. Нэг шөнө эхнэрийнхээ өвөрт орж чимээтэйхэн байтал Шархүүгийн чихэнд хэн нэг хүн “Ёо, ёо. Яасан хүнд юм бэ? Та хоёр болиоч” гэх нь сонсогдов. Эхнэр нь амьдралдаа зөндөө олон хийсэн нууц ажлынхаа ард сурсанзангаараа зөөлөн хурхирч байв. Тооноор тусах сарны гэрэлд эхнэр, нөхөр хоёрын орны доороос ямар нэг юм хөдлөх шиг болов. “Айхад аргал хөдөлж байгаа хэрэг” гэж бодсон боловч тэр тэсэлгүй өндийж орны хажуугаар харвал сарны хөхөлбөр гэрэл, бас тийм өнгөтэй гар өдөөс нь сарвалзан хөдөлж байв. Ухаан алдатлаа айж, хар хөлс нь цувсан Шархүү мяраалаг эхнэрээ тас тэвэрч наалдан хэвтсэн ч нөгөө үхээрийн муухай өнгө зүсгүй гар түүнийг эрж байгаа нь мэдэгдэж байлаа. Түүний тархины арьс нь салбарлан, түүнээс гарах

оюун бодол нь хүйтэн жихүүн амьсгалаар үлээгдэж, үсний ширхэг нь зумарч унах лугаа санагдана.

Төдөлгүй эхнэр нь яраглан хөдөлж, хөлс нь урссанаас хоорондоо наалдсан хоёр биений гуя хасыг салгаж хүчээр буруу харан хэвтэв. Шархүү өөрт нь төрсөн энэ аймшигт мэдрэмжийг эхнэртээ хэлэхгүй гэж бодож байсан болохоор амьдын тэр тарчлалдаа ганцаар баригдан үлдэхээр шийдэв. Хажуухандаа байсан ялааны цохиурыг таамгаар эрж олоод нөгөө хөх гарыг чангахан цохиод авчээ. Гар сарвас сарвас гэж байснаа алга болжээ. Шархүү хэсэг зуур хөдөлгөөнгүй хэвтэж, мөнөөх Баржуу гуайн аймшиггүй зоригийг өөртөө даллан дуудаж, бас мэддэг бурхан болгоныхоо нэрийг амандаа үглэж байв. Үнэхээр ч хэдэн хормын дараа тэр тайвширчээ. Босч гэрэл асаагаад тамхиа ямар ч зорилгогүй асаав. Хэдэнтээ сороод л ишинд нь тулсан тул зуухны хөвөө рүү шидэж орхиод “Унтана даа” гээд хэвтжээ. Зуухных нь тэндээс нэгэн сөөнгө дуу сонсогдов. “Болиоч, яагаад хүн галаар түлээд байгаа юм бэ?” гэсэн тагжирсан дууг тэр бүүр түүрхэн мэдэрч байв.

Ухасхийн өндийн дахин гэрлээ асаагаад улаан нүүрээрээ талийгаач нөхдүүдтэй үзэлцье гэж шийджээ. Бүр тэгэхээс тэгэх гэсэн юм шиг мөнөөх хаясан тамхиныхаа ишийг олоод тэр газарт бүтэн сонин базаж тавиад шүдэнз зурчихав. Аймшигт тамлалгаа үзсэн хүн л ингэдэг болов уу гэмээр муухай дуу хадаж, зуух хавьд нойрсож буй хүүрийн үглэх нь тасарчээ. Шархүү хүүрнүүдтэй үзэлцэж, нэг нэгээр нь сөнөөж байна гэж итгэсэн байлаа. Бүр тэр бодолдоо амтшин хөтлөгдөж гэрээсээ гарахаар шийдэв. Тэгэхдээ нэг л зориг дутах шиг.

Эхнэр рүүгээ харвал хөх дэлэнгээ унжуулаад, хөнжлөөрөө хагас хучсанаас салтаа нь хүртэл амар амгалангийн бэлгэ тэмдэг болон харагджээ. Хаалганыхаа жижиг цонхоор гадагш айсхийн шагайж үзэв. Юу ч харагдсангүй. Гадаа сарны гэрэл сүү мэт цайвалзан, энх амгаланг таниулах гэсэн харамгүй сэтгэл лугаа санагдаж байв аа.

Шархүү юмыг яаж мэдэхэв гээд шүүгээнээс балиус аваад гарчээ. Тэгтэл юу үзэгдсэн гэж санана. Зүүдэнд нь орж холхиод байдаг мөнөөх цагаан даавуу нөмөрсөн гайхал сүгнүүд нэг нэгнийхээ дотуур орж гаран аквариумын загас шиг тунгалаг сарны гэрлэн дундуур сүлжиж байв.

Тэд хөхөлбөр шөнийн сарны туяанд аз жаргалын сахиусан тэнгэр, аль эсхүл хүний ертөнцийн хүндэт харуулууд мэт эрхэмсэг хүйтэн харагджээ. Шархүү маш чангаар орилов. Сүгнүүд түүний дууг сонсоход нөмөрсөн цагаан даавуунууд нь салбайтал урагдаж, үзэшгүй муухай хэлбэр дүрсийг олоод түүний зүг тасарч унасан арай чүү төрж байна уу гэмээр араг яснууд болоод муухай хашгиралдан гүйлджээ.

Шархүү хаалгаа тасхийтэл хааж янгинатал цоожлов. Гадаа орилолдох сүнснүүдийн далд чимээнд эхнэр, хүүхдүүд нь тайван гэгч нойрсож байлаа. Эхнэрийнхээ хажуугаар орж хэвтэхэд сүг сүнснүүдтэй муудалцан тарчилах бүхэл бүтэн шөнийн тарчлаан түүнийг хүлээж байлаа.

## Тэнэг Цэрэндоржийн тэнхээг чөтгөр ч дийлээгүй гэдэг

Цэрэндорж гэж гартаа бүлтэй, толгойдоо товь малгай өмсдөг өвөрмөц нэгэн байжээ. Ядуугийн эрхээр ямбатан ноёдын зарц хийж, тээрэм татаж гурил хийдэг байж. Хос мориор хөдөлгөх учиртай том чулуун тээрмийг хяхнуулан хавируулж, эцэж цуцахыг мэдэхгүй ажилладаг байв. Түүн дээр нэг лам ирж “Чи эмэгтэй хүний ажил хийж байна. Гайхуулах юм биш” гэж өдөөд доромжлоод байж. Цэрэндорж тэвчээр алдаад нөгөө ламыг барьж аваад хэдэн метр хол шидэж орхижээ. Лам ч бэртэж гэмтсэн байна. Тэгсэн чинь төдөлгүй ноён “Миний бөхийг хэн бэртээв? Олж ир” гэж хиа нараа явуулжээ. Цэрэндорж “Энэ гэгцэл ажил хийлгэхгүй алиа балай үг хэлээд байсан юм. Түлхэж ноцолдоод байхаар нь өөрөөсөө холдуулсан. Миний буруу” гэхэд ноён “Чи тийм чадалтай юм уу?” гэж асуухад “Чадал байж магадгүй” гэжээ. Ноён түүнийг эрүүдэн шүүх гэж байснаа больж “Наадам хийнэ. Чи ирж барилд” гэж хэлээд явуулжээ.

Тэгээд Цэрэндорж тэр өдөр нь ирж барилдаад ноёны наадамд түрүүлжээ. Тэгээд ноён аргагүй сайн бөх, юм гэж шагнаж, хувцаслаад явуулжээ. Энэ үед ноёны бөх хүрээний бөх гэж хоорондоо өрсөлддөг байв. Хүрээний наадам болоход Цэрэндорж бухтай барилддаг хүрээний алдарт бөх Маажавтай үзүүрт үлдэн хаяхад ноён учиргүй баярлан түүнд сүргээсээ том цагаан морь, мөнгөн хэт хутгатай бэлэглэн дархалж, өөрт нь тариа тарих газар олгожээ. Цэрэндорж өөрийн гэсэн газартай

болсондоо баярлан тариа тарьж усалж арчилж байхад нэгэн өдөр ус тасарчээ. Юу болов гэж боолгон дээр ирж үзвэл лам нар усыг нь хаачихсан өөр шуудуугаар урсгаж байж.

Тэгэхэд нь Цэрэндорж том цагаан морио чөдөрлөөд, эмээлийг нь авч морио өргөн тавьж, усыг боогоод өөрийн шуудуугаар усыг урсгахад нь лам нар айж зугтаж, ноёнд очиж “Цэрэндорж ус аваад өгөхгүй байна” гэхэд “Цэрэндоржийн дараа ав” гэсэн гэдэг. Цэрэндоржийг ноёнд их нэр олсонд уурсаж хорлохоор шийдсэн лам нар түүнийг чөтгөрөөр айлгах гэж оролдох болов. Цэрэндорж огт тоохгүй “Үхсэн хүнээс байтугай амьд хүнээс айх шалтгаан надад байхгүй” гээд тоодоггүй байжээ.

Урд хар уулын хүүрийн газар ноёны сүрэг өнжжээ. Лам нар түүнийг зохион байгуулсан байж. Үдшийн гялаан гарсан даруйд тэр сүргийг авчрах зоригтой хүн олдохгүй нь ойлгомжтой. Тэгээд тэнэг тэнхээтэй Цэрэндоржийг л явуулах нь тодорхой гэж тооцоолсноор нь болжээ. Сүргийн манлай болсон ухна голдуу ямаанууд арсгар ууланд цахилан айдас хүйдэс, нуранги чимээ үүсгэх аж. Цэрэндорж гуугачин хашгирсаар хад чулуу дамжин түүний дуу алсарч хариуд нь ойрхноос хүмүүс дүнгэр дүнгэр ярьж нялх хүүхэд часхийн уйлах сонстжээ. “Яасан сүрхий чөтгөрүүд вэ?” гэж Цэрэндорж бодоод,

- Хамгийн чадалтай чөтгөрөө явуулчих. Хад саваад өгье гэж хашгирчээ. Хүүрийн хавцалд гал утаа манарах шиг болоод хэдэн хүн өөрийг нь зүглээд ирж явна гэнэ. Тэгснээ алга болчих юм. “Та нартай ингэж маяглахгүй шүү. Нуугдаж тоглох гээд байвал тэр бурхан мурхантайгаа тогло” гэж Цэрэндорж хэлжээ.

Гэнэт түүний өмнө таяг тулсан төө хэрийн сахалтай өвгөн бий болчихсон зогсож байна гэнэ.

- Чи тэгээд надтай үзэлцэх юм биз дээ гэж Цэрэндорж басамжилжээ. Ухасхийн барьж авах гэхдээ тэр хажуугийн хад мөргөөд ухаан алдах шахав. Нөгөө дүрс түүнийг шоолон дэвхцэж байв гэнэ. Цэрэндорж уурандаа ургаа хад ховхолж аваад түүн рүү шидчихжээ. Нөгөө өвгөний дүрс ч алга болчихов. Харин хажууханд нь ёолох чимээ гарч байв.

- Чамайг зовоож байхаар нэгмөсөн зүйл дуусгачихья гээд бас нэгэн чулуу аван далайтал,

- Үгүй, больё. Би чамд хор хийхгүй гэж хэлэх сонстжээ. Цэрэндорж хэнэггүй мангар нэгэн тул,

- Тэгвэл чи уул хадаар тарчихсан хонь, ямааг надад цуглуулж өг гэжээ. Төдөлгүй хаданд ассан ямаа түрүүлэн уулнаас бууж гэрийн зүг цувсан аж. Тэнэг амьтан гээд түүнтэй лам нар мөчөөрхөхөө үүнээс хойш больсон гэдэг.

## Тува бөөтэй тулам нэгтгэсэн хулгайч үзэгдэшгүй шидийг олжээ

Манай улсын баруун хойд хилийн дагуу нэгэн зартай хулгайч байжээ. Хулгайч Галданг барих гэж цагдаа сэргийлэхийнхэн хүч нэмэгдүүлж, гэр бүлийнхнийг нь барьцаалаад ч хүчрээгүй гэдэг юм. Галдан өөрийг нь барихаар ирсэн хүмүүсийг урьдаас мэддэг болохоор яаж ч хичээсэн өмнө нь тэр аль хэзээний зугтаж амждаг байв.

Олон удаагийн тохиолдлоор арга мухардсандаа сэргийлэхийнхэн түүнд мэдээлэл өгч байдаг хүнийг өөрсдийнхөө дотроос ч хайж үзсэн байна. Энэ бол 1960-аад оны үе юм. Түүнийг харин жирийн олон бол оргож явахдаа тува бөөтэй амьдарч байсан болохоор ид шидтэй болсон гэлцдэг байв. Үнэхээр зартай хулгайч байсан Галдангийн талаар уншигч танаа хүргэе.

Урд аймгаас адуу хөөж яваад илчлэгдэж, буу шийдэмтэй хүмүүс ч түүнийг салахгүй элдсэн байна. Өдөржин шөнөжин хөөцөлдсөн тэдний гараас салахын тулд Галдан хаврын ус үерлэсэн Тэсийн гол руу морьтойгоо давхиж оржээ. Улаан шаараар эргэлдэж буй их устай голоос түүнийг амьд гарна гэж хөөж явсан хүмүүс бодсонгүй. Үнэхээр ч Галдан гүнзгий гол руу ороод төдхөн эргүүлэгт авган мориноосоо салаад живж үхэх аюултай тулгарсан байна. Гэрт орж, гэгээнд мөргөж үзээгүй Галдан анх удаагаа “Бурхан Гончигсүм минь” гэж бодсон гэдэг. Тэгээд л ухаан алдсан байна. Хулгайчийг их усанд цохигдон хэдэнтээ сарвалзаад живж алга болоход хөөж явсан хүмүүс “Хэдэн морины өмнөөс хүний аминд хүрэв” хэмээн ёс жудгаа бодож ханцуй дотроо залбираад л буцсан гэдэг. Тэд байтугай Галдан ч өөрийгөө ингээд л үхдэг байж хэмээн бодсон аж. Түүнээс хойш хэдэн цагийн дараа мөнөөх үхсэн Галданд гэрэл гэгээ үзэгдэж, орчных нь ахуй ой мод усны чимээ сонсогджээ. Галдан бодсон байна. “Би сайн юм хийж яваагүй болохоор тамд унах нь тодорхой” гэж боджээ. Гэтэл нөгөө төрөлдөө ирсэн гэж байтал бодсон түүний чихэнд хөхөө донгодож, ой шуугин, ус гол шуржигнан урсаад л...

Тэр бүхнийг там гэж арай нэрлэмээргүй санагджээ. Мань хулгайч багадаа авга ламдаа шавилан ном үзэх гэж нэлээд зовсон билээ. Авга ламын хэлж байснаар тамд хүнийг шатаах, үхүүлэхгүйгээр бие махыг нь мөчилж өвдөлтийг мэдрүүлдэг. Тэр нь эцэс төгсгөлгүй байдаг. Тийм л том үйлийн үр, нүглийн хариу байдаг гэж сонссон байв. Галдан энэ бүхнийг дурсан санаад өөрийгөө арай амьд байгаа юм биш биз гэж боджээ.

Үнэхээр тэр амьдаар барахгүй голын тохойд ургасан бөхгөр улиасны мөчрөөс бүсээрээ өлгөгдсөн байгаагаа мэдэрчээ. Хулгайч ч амьд байгаадаа баярлаж, өлгөгдсөн мөчрөөсөө салах гэж оролдоод чадсангүй. Түүний дээд талын мөчир дээр суусан нэг том хар хэрээнээс өөр амьд амьтан нүдэнд нь эс үзэгдэв. Ямар хар хэрээнээс тусламж гуйлтай биш. Тэр хар шувуу түүний нүдийг ухах гэж байгаагаас түүнд туслах гэж хүлээж суугаагүй нь ойлгомжтой. Хэнэггүй нь дэндүү Галдан хулгайч:

- За найз минь, миний нүдийг чи хулгайлах гэж байна уу? Түүнээс өмнө чамтай наймаалцах болох нь ээ. Гэхдээ чи

ямар хүний хэрэгтэйг хэрэглэх биш. Овоот уулын агуйд миний нуусан эд хөрөнгө бий. Түүнийг хэн ч мэдэхгүй. Бас ээжээс нь өөр хэн ч мэдэхгүй хэдэн бутач хүүхэд бий. Ганцхан

хүсэл минь Гомбо буяны хээр зүсмийн адуунаас л тасалж хөөж чадсангүй. Хар залуугаараа модны мөчирт өлгөгдөж, хар хэрээ таны зоог болох юм чинээ санасангүй явлаа гэж үхэхийнхээ өмнө үг захиасаа үрдээ хэлж буй юм шиг ярьжээ.

Хар хэрээ гүн хар цогтой нүдээрээ түүнийг ширтэн үгийг нь анхааралтай сонсож байх шиг Галданд санагджээ.

Тэгэхээр Галдан:

- Чамаас гуйх юм байна. Нүдийг минь эхэлж тоншихгүй байхыг л гуйя. Зодуур даах хонго байна. Зоо нуруунаас минь эхэлж тоншоорой гэжээ. Хар хэрээ түүний үг бүхнийг анхааралтай сонсох шиг болоод нисэн оджээ. Галдан ч,

- За, цаадах чинь найзуудаа дагуулж ирээд найрлах нь дээ. Бас чиг шуналгүй эд юм гээч. Би л байсан бол бусаддаа хэл хүргэлгүй ганцаараа хэд хоног зооглох байсан юм. Олсоноо олонтойгоо хуваадаг нөхөр байх нь гэж шал дэмий юм бодож байв.

Гэтэл гишүү хугарч, өвс шажигнаад ямар нэгэн амьтан түүн рүү ирж явах шиг чимээ гарчээ. Яах аргагүй л хүний хөлийн чимээ мөн байлаа. Хүн, амьтан хоёрын хөлийн чимээг Галдан эс ялгавал өөр хэн ялгах билээ. Тэгсэн чинь эрэг рүү бөхийсөн модны хажуугаар нэгэн үзэсгэлэнт бүсгүй тонгойн харж байв. “Ээ, бурхан минь!” гэж хэлээд Галдан ухаан алджээ. Үзлийн муухай царайтай үс шүдээ арзайлгасан амьтан байсан бол тэр ингэхгүй байх байв. Түүний бодож, бодол санаандаатосохоор бэлтгэж байснаас огт өөр гэрэл гэгээ туссан бүсгүй байсанд тэр цочирджээ. Галданг ухаан ороход голын эрэг дээр гаргаж хэвтүүлсэн байв. Хажууханд нь мөнөөх бүсгүй гал түлж жижигхэн зэс савтай зүйлийг уур бургиулан буцалгаж байна. Галдангийн хөл, гарыг тэлж мөч бүрийнх нь чигт жижиг галуудыг түлсэн байжээ.

Ингэж гайхал хулгайч Галдан аврагдаж тува бөөгийн гэрт очжээ. Тэдний хойморт мөнөөх хар хэрээ сууж байх юм гэнэ. Шархоо хэмээх тэр бөө бяцхан хүүтэйгээ амьдардаг байна.

Бөөгийн ярьсан нь:

- Алив хүнд тус болох хүн гэж тусгай байдаг. Бас хор хүргэх хүн ч бас өөртэй нь хамт төрдөг. Туслах учиртай төрсөн хүнээ олж чадсан хүн л өөртөө бурхантай, хамгаалагчтай болдог. Харин хорлох сэтгэлтэнг түрүүлж олбол муу муухайг үзэж зовж шаналж насыг бардаг байна. Шархоо бөө бол Галдан хулгайчид туслах учиртай хүн нь мөн байжээ.

Түүнийг хөлгүй усанд живэхдээ “Гончигсүм минь” гэж хашгирсан нь бөөгийн сахиусанд сонсогдсон юм байх. Тэгээд л сахиус-хэрээ өрхөөрөө гарч нисээд мань Галданг эзэндээ “хэлж” аварсан нь тэр юм гэнэ. Үнэмшихгүй байвал чи сонс гээд Галдангийн хар хэрээд ярьсан бүхнийг Шархоо бөө түүнд хэлжээ. Галдан бөөг үнэхээр биширчээ.

Голын шугуй ялаа батгана бужигнасан тэр бөглүү газар ганц бие шахам суудаг Шархоо бөөгийн үзэсгэлэнт царай, ид шидийн чанартай үйлдэл нь Галданг ховсдон татжээ.

Орой болоход бөөгийн өвөр рүү орох уу, болих уу гэж боджээ хэвтгэл Шархоо хучлагаа сөхөн



хундан цагаан цээжээгаргаад:

- Чи ямар юм мэддэггүй хүн бэ? Чи юу л бодно түүнийг чинь би биелүүлэх учиртай юм шүү дээ. Нааш ир гэжээ.

Шархоо, Галдан хоёр өдрийн цагт гэр орны ажил хийж үхэр малаа хариулж, шөнө болоход ор дэрний хөдөлмөрт ор хоосонгүй байсаар гурван сар болжээ. Гэхдээ Шархоо өөрийн ид шидийн талаар нууц дэлгэхгүй.

- Чи нэгэнт ирсэн болохоор би хүн амьтанд тус болно гэхээ болилоо. Чамайг л хайж өдий хэдэн жил эзэнгүй шахам газар амьдарсан гэжээ. Үнэхээр Шархоо бөө өөрийг нь зорьж ирсэн тувачуудад бөөлж, муурч ид шид үзүүлэхээ зогсоожээ. Харин уугуул нутгийнхан нь энэ бүхнийг урд Монголоос ирсэн хулгайч Галдангаас боллоо гэж үзсэн учир түүнийг хорлох арга саам хайцгааж байв.

Тувачууд зуны цагт голд тор тавьж загас барина. Бас л монголжуу амьдралын улбаа үлдсэн болохоор хар халуунд малын амь таслахыг тэвчдэггүйдээ ингэдэг байна. Нэг өдөр Тагнын уулнаас гурван тува эр Шархоогийнд ирж хоножээ. Маргааш голд загас агнах юм гэнэ. Шархоо ч тэдэнд “нэрсэг” хэмээх саравчин дотроо ор засч өгсөн байна. Өглөө нь мань гурав явахдаа Галданг хамтдаа явья гэжээ. Бөөгийн хажуунаас төөгийн ч зайтай холдохгүй удсан Галдан тэдэнтэй явна гэж зүтгэжээ. Шархоо түүнд дун цагаан болтол нь цэвэрлэсэн гөрөөсний шагай өгөөд,

- Ямар нэгэн юм болбол хуруун завсраа морь унаж байгаа юм шиг хавчлуурай. Тэгвэл чи аюулаас зугтаж чадна гэсэн байна. Тувачууд ч Галдангаас,

- Шархоо чамд юу хэлэв, юм өгөв үү? гэжээ. Мань хулгайч тиймхэн юманд үг алдах, өчиг мэдүүлэх эр биш болохоор,

- Намар орой хүртэл хэрэглэх загас агнаж ирэхийг бодоорой гэсэн гэжээ.

Тувачууд ч усанд нүгэлгүй сайн юм гэнэ. Ширүүн урсгалт Тэсийн голыг хөндлөн гүйгээд л гаталчих юм. Торны цаад үзүүрийг голын эрэг дээр бэхлэх гэж нэг тува хүчрэхгүй Галданг дууджээ. Галдан бүх хувцсаа тайлаад гол руу орохдоо Шархоогийн өгсөн гөрөөсний шагайг сугандаа хавчуулчихжээ. Үнэхээр Галдангийн болгоомжилсон зөвдсөн байв. Тор тогтоох гэж гадас цохиж байсан тува эрийн муна “халтиран” Галдангийн толгой дээр гал манартал буужээ. Монголын хулгайч Галдан ингэж модын мунаар цохиулж үхэх хувьтай байжээ гэж бүүр түүрхэн бодоод өтгөн өвсөн дээр тэрбээр тэрий хадан ойчжээ. Голын нөгөө талаас тувачууд,

- Наад муу монголоо гүйцээчих. Шархоогоос айх хэрэггүй. Арыг нь бид мэднэ гэж хашгиралдаж байхад Галдан сэргэжээ. Том хусан муна далайсан биерхүү тува эрийн өмнөөс нүцгэн шалдан Галдан яах билээ. Ухаан орсноо мэдэгдэхгүйгээр мөнөөх гөрөөсний шагайгаа хайж байв. Холгүйхэн хэвтэж байхыг нь олж гарынхаа салаанд хавчуулаад авчээ. Гэтэл юу болсон гэж санана. Галдан аварга том загасны сэрвээн дээр суучихсан их уст голыг хээв нэг гаталжээ. Эрэгт тулж ирмэгц мөнөөх загас гур гөрөөс болж Галданг дээрээ суулган цохилж

гарсан байна. Голын нөгөө эрэгт байсан тувачууд ч түүний хойноос мориндоо мордож хөөсөн боловч гүйцсэнгүй. Галдан толгойгоо хусан мунаар хага цохиулчихсан гэрийнх

нь үүдэн дээр хэвтэж байхыг Шархоо бөө олж авчээ. Шархоо бөө тувачууддаа бурууг өгсөнгүй. Уурлаж хилэгнэж сүйд болсонгүй.

- Би чамд туслах одонд төрсөн, чиний сахиусны үүргээ биелүүлсэнгүй. Чи яв даа. Харин би энэ тува хүмүүстэй муудалцахгүй. Эд нар чинь үндэс угсаагаа бөөтэй, дуутай нь байлгах гэж тэмцэж байгаа хүмүүс гээд нэгэн хар хилэн цээживч өгчээ. Галдан нөгөөдүүлээсээ нуугдаж явсаар гол гаталж төрсөн нутагтаа ирсэн гэдэг. Тэгээд хулгай хийх, хүнд харагдахгүй байхыг хүссэн үедээ мөнөөх Шархоо бөөгийн өгсөн хар цээживчийг (майк) өмсдөг байжээ. Түүнийг нутгийнхан нь тува бөөтэй тулам нэгтгэж (ханилж дасаад) ид шидийг нь сурсан гэж ярилцсаар байдаг байж. Харин мөнөөх хар хилэн цээживчийг Галданг өвгөрч хулгай хийж худал хэлэхээ больсон тэр өдөр охин нь баахан хог новштой андууран шатааж орхисон гэдэг. Тэрхүү тува бөөгийн дурсгасан цээживч Галданд хэрэггүй болсон өдрөө галд хэрэгтэй болсон нь сонин юм. Дуртайяа ноцож шатаж байсан байх даа. Хүмүүсийн дунд ийм нэгэн яриа байдаг юм.

## Номонд хоргодсон сүнс

Ном цуглуулахаас өөрийг мэддэггүй нэгэн өвгөн байсан юм. Хааяа нэг нимгэн ном гаргадаг. Түүнийгээ том уран бүтээл хийчихсэн юм шиг онгирно. 60-аад оны манераар шүлэг бичнэ. Хамгийн гол нь Цэрэн гуайн ном дотор ховор нандин ном зохиол маш олон. Үнэхээр ийм номтой хүн хэзээ ч тийм шүлэг бичмээргүй санагддаг сан.

Хөдөөнөөс хот руу нүүж ирэхдээ хувцас хунаргүй шахам ч 10-аад шуудай номоо замын машинд гуйж ачуулаад ирсэн гэдэг. Номонд үнэхээр хайртай. Гэхдээ түүнийг хайрладаг шигээ уншиж авах юмаа авч үзээгүй нэгэн. Насаараа нягтлан бодогч хийсэн ч Цэрэн гуайн амьдрал ядруухан. Хүүхдүүд нь гэж “шаариг” дутуу төрчихсөн амьтад болохоор аав, ээжийгээ өөд татсангүй. Хөөрхий Цэрэн гуай хотын том зохиолчидтой уулзаж зиндаархаж үзсэн ч хашрууд хаанаас тэтгэврийн өвгөний дэмий балай шүлгийг уншиж суух билээ. “Танд зөвлөгөө өгч чадахгүй нь. Та бараг надаас олон жил шүлэг зохиол бичсэн туршлагатай хүн байна шүү дээ” гэж цэвэрхэн салж авна. Сүүнийхээ мөнгийг цуглуулж байж Зохиолчдын эвлэлийн гишүүнээр элсэх босго мөнгийг нь төлсөн билээ. Хүүхдүүд нь аавыгаа яруу найрагч гэж боддог байлаа.

Үнэхээр хаашаа ч хамаагүй замын машинд суугаад тэнээд алга болчихно. Газар нутаг үзэж, онгодоо сэргээж байна гэж өөрийгөө боддог байв. Хаа байсан Шилийн богд, Хэрлэн гол, Цамбагарав, Сутай хайрхан, Хөвсгөл далай гээд л очиж үзээгүй газар нутаг гэж Цэрэн гуайд байсангүй. Тэгээд л Шилийн Богд ч гэдэг юм уу газрын нэр тавьж байгаад л толгой холбосон тодорхойлолт биччихээд түүнийгээ тэр газар нутагт очиж онгодоо хөглөсний хүчинд хийсэн уран бүтээл гэж бодно. Түүндээ үнэн голоосоо итгэнэ. Нэг зун сумынх нь 70 жилийн ой болсон тул мань Цэрэн гуай нутаг усандаа очиж гутлынхаа улыг элэгдтэл дэмий тэнэсэн байна. Тэгээд л замын унаа машинд гар өргөж суусаар Улаанбаатартаа эргэж ирээд гэртээ цай ууж байгаад л гэнэт өөд болсон байна. Цэрэн гуай “Нутаг санагдаад байна. Нутагтаа нэг очоод ирье” гэж ярьсаар байж тэр жил сумын ойгоор далимдуулж нутаг руугаа явсан нь тэр байв.

Гэтэл нутагтаа очоод сэтгэл санаагаа тайван сайхан болголоо гэсэн чинь шал эсрэгээр эргэв. Түүний нас барсныг лам нар нутгийнх нь савдаг сүнсийг нь аваад хоцорчээ гэж ам нэгтэй хэлсэн байна. Сүнс нь хөдөө үлдэж, бие нь хотод оршуулагдсан гэх Цэрэн гуай ганц өмч нь номнууд нь байв.

Түүний насаараа цуглуулсан номуудыг эргүүлж нээж үзэх сийрэгхэн толгойтой хүү байсангүй. Хуучин номын дэлгүүрт аваачиж өгөх гэсэн боловч үнэ тохирсонгүй. Харин шүлэг зохиол оролддог нутгийнх нь нэгэн залуу 50 мянган төгрөгөөр бүх номыг нь худалдаж авсан байна. Түүнийг Батхишиг хэмээнэ. Ганц нэг дуу нь дуулагдсан хоёр ном хэвлүүлж, үс гэгзгээ ургуулсан тэрбээр өөрийгөө том зохиолч хэмээн үздэг болсон байна. Маш баялаг номын сантай болсон Батхишиг байшингийнхаа нэг жижигхэн өрөөг чөлөөлж номнуудыг байрлуулжээ. “Номонд эзэн байдаггүй. Номын хулгай бол хулгай биш” гэж ярилцдаг бөгөөд тэр нь бараг хүмүүсийн доторбичигдээгүй хууль болсон билээ.

Батхишиг номтой хүн болох гэснээс биш түүний доторхийг сөхөж, оюун тархиараа шүүж

тунгаасан нь үгүй. Гэрт нь ирсэн хүмүүст л олон номтой, оюуны чадавхи өндөртэй хүн болох гэж санаархсанаас түүнд өөр бодол байсангүй. Дэлхийн сонгодгуудын зохиолыг тэр уншаад уншаад ойлгохгүй. Харин өөрийнхөө хоёр нимгэн дэвтрийг дэндүү ойлгоно. Бусад шүлэг оролдогсод түүний номыг төдийлөн тоохгүй. Тэгэхээр нь тэр “Нэг л өдөр нэрд гарна. Дэлхийн сонгодгуудын ихэнх нь уран бүтээлийн эхнийхээ замд хэнд ч тоогддоггүй байсан” гэж бодох болжээ.

Нэг удаа Батхишигийн нэг найрагч иржээ. Тэр үнэхээр боловсролтой боловч бор дарсанд хэт орсон нэгэн байлаа. Тавиур дээр ярайтал өрсөн түүний номыг харж байснаа тэрбээр,

- Александр Дюма чинь олон нарийн бичгийн даргатай байсан. Мань эрийн олон бичээч нар нь утга зохиолын авьяастай хүмүүс байсан учраас тус тусдаа зохиол бичиж Дюма-д өгдөг байсан. Тэр түүнийг нь сайхан хольж хутгаад л ном хийчихдэг байсан. Түүнээс биш нэг хүн амьдралдаа 500 гаруй роман бичнэ гэж юу байдаг юм гэжээ. Үнэндээ Батхишиг Дюмагийн “Шадар гурван цэрэг”, “Монте Кристо гүн”-г ч уншаагүй нэгэн байлаа. Тийм болохоор Батхишиг өөрийгөө жаахан боловсруулъя гэж бодоод номын сантайгаа харьцаж эхэлжээ. Эхлээд санаа төрүүлснээр нь А.Дюмагийн “Монте Кристо гүн”-ээс эхэлье гэж шийдэв. Шөнө дөл болоход мань Батхишиг номыг нээж уншиж эхлэв. Ёстой гүн ухаантан шигтамхи асаагаад, шанаагаа тулан бодлогоширно. Үнэндээ “Монте Кристо гүн-г уншихад бодлогошироод гүн ухаантай мэт царай гаргаад байх шаардлагагүй. Төдөлгүй нүд нь анилдана. Авгай нь түүнийг аугаа их хүн гээд бодчихсон болохоор тэр шөнөжин сууж хонохгүй бол болохгүй. Энэ бол нэр хүндийн асуудал байлаа. Хоёр хуудас уншаад ширээ мөргөж донгодож эхэлжээ. Ном завсраа харандаа хавчуулаад гадаа гарч салхинд зогсов. Нойр нь хулжиж толгой нь сэргээд ирж байна гээч. Мань эр эргэж орж ирээд номоо үргэлжүүлэн унших гэтэл ном нь хамхигдсан байв. Тэр гайхав. Хуудасны завсар харандаа хавчуулаад гарсанаа тэр эрхбиш мэдэлгүй дээ. Гайхаж байснаа сөхөөд явж өгдөггүй эхний хэдэн хуудаснаасаа уншиж байснаа үргэлжлүүлэх гэтэл мөнөөх ном тасхийтэл хаагдаж байна. Дахиад л нээв. Дахиад тас!

Аргаа барахдаа Батхишиг хөргөгчнөөсөө нэг шил архи гаргаж ирээд томхон хийж залгилав. Гэтэл намхан навтгар хамартай, ширэг сахалтай өвгөн мөнөөх номых нь дээр гараад суучихаж. Тоглоомон хүүхэлдэй шиг жижигхэн биетэй юм. Сайтар ажиглавал түүний “найз” Цэрэн өвгөн мөн байв. Нүдээ хэдэн ч удаа арчиж хараад тэр үзэгдэл үнэн бодит болохыг Батхишиг мэдэв. Эхнэр, хүүхэд нь амар тайван унтаж байлаа. “Яруу найрагч” Батхишиг үлдсэн архиа ховх уугаад өглөө нь Яармаг руу явав. Тэнд талийгаач Цэрэн гуайнх байдаг юм. Очвол эмгэн нь байв. Юу ярих ая зүйгээ олохгүй байснаа,

- Цэрэн ахын хамгийн хайртай цээртэй юм нь юу байсан бол гэх мэтээр үг шигтгэн асуусаар “Номондоо л хайртай” байсныг нь мэдэв. Сүнс сүлд нь алтан хайрцаг дээр юу гэжгарсан тухай асуухад,

- Нутгийнх нь савдаг аваад үлдчихсэн гэжээ. Тэр нутгийн савдаг хайхрамжгүй нөхөр байсан уу, яасан бэ? Ямар ч байсан Цэрэн гуайн сүнс чөлөөлөгджээ. Тэгээд л номондоо хоргодож Батхишиг “Яруу найрагчийнд” хонож өнжин, хоол унд нэхэхгүй ч гэсэн айдас жихүүдэс дагуулан орогнодог болсон нь илт.

Номын ямар нэг хуудсанд тэр хоргодсон байх. Түүнээс биш дэлхий дахины өмч болсон

“Монте Кристо”-д түүний сүнс хоргодох учиргүй гэж нэг лам хэлжээ. Хөөрхий үзэмжийн сайхан яруу найрагч Батхишиг гэртээ ирж Монте Кристо”-гийн дэвтэр бүхнийг эргүүлж гүйлгэн харжээ. Бүр амтанд нь орох маягтай болов. Бараг амьдралдаа ном уншиж ард нь гарч үзээгүй Батхишиг найрагч Цэрэн гуайн сүнстэй булаацалдан байж “Монте Кристо”-гийн 2 дахь дэвтрийг уншиж дуусчээ. Нэг бодлын ном цуглуулахаас уншиж үзээгүй Цэрэн гуайн сүнс бас нэг номны өвчтэй мөртлөө унших чадваргүй Батхишигт тус болж романы хоёр дэвтрийг дуустал уншуулсан нь энэ байлаа. “Монте Кристо гүн”-гийн монгол орчуулгаар хэвлэгдсэн гуравдахь ботийн 97 дахь хуудсан дээр мань Батхишигийг давхиж байхад Цэрэн өвгөний сүнс ирэв. Тэр хуудасны дунд сунаж хэвтээд мөргөж байх юм. Тэр хуудсанд аймшигтай бас явдалтай юу ч байсангүй. “Шөнийн нэг цаг өнгөрч байв. Альберын өрөөнд нь оруулахад түүнийг халуун ус, хоол хүлээж байв. Сүйх тэрэгний ард зогсож ирсэн зарц түүнд үйлчлэв” гэх мэтийн хэнд ч анзаарагдамгүй, зохиолоо таслахгүй хөтлөхийн тулд “Зүүн” гараараа бичсэн өгүүлбэрүүд л байх аж.

Батхишиг чичирхийлсэн гараар хуудсыг урж аваад үнснийсаван дээр ноцоож орхив. Түүнээс хойш талийгаачийн бяцхан бие харагдахаа больж сүнс нь аль нэгтэйд тонилсон гэдэг. Номыг унших чадваргүй мөртлөө цуглуулж, хэн нэгнийг нээж салхи оруулахад дургүйцдэг байсан тэр талийгаач өвгөн “Монте Кристо гүн” романыг л амьдралдаа уншсан бөгөөд адал явдал, хурц үйл явдалтай тэр романаас маш муу өгүүлбэрүүдийг тогтоож аван түүндээ маш дуртай байсан бололтой.

Батхишиг найрагч жинхэнэ уран бүтээлч биш болохоор номуудыг гэрээсээ гаргаж контейнерт хийж орхисноор ийм нэгэн түүх унтарч ужгирсан нь саяхны л явдал ажгуу.

## **Оонын эвэр шиг ах, дүүс гуйлгачин болж нас бараад олон хүнд гай уджээ**

Оонын эвэр шиг ах, дүү хоёр баруун нутагт амьдарч байсан гэдэг. Ахыг нь Банди, дүүг нь Гомпил хэмээнэ. Угаас хөрөнгөлөг эцгийн хүүхдүүд тэднийг өдөр, шөнө шиг амьдарч явааг нутгийнхан гайхан хэлэлцдэг байв. Торон Банди, торгон Гомпил гэж хочилно. Юу гэвэл Банди элж сэмэрсэн хувцасны тамтаг өмсдөг, дүү нь харин торгонд боолгосон нэгэн аж. Эцгээс үлдсэн хөрөнгийг голомт залгамжлах дүү нь хүлээж аваад ах нь гар хоосон хоцорсон учраас хичнээн зүтгэж хөдөлмөрлөөд дээлийнхээ тамтгаас салж чадаагүй аж.

Гэхдээ Банди бас чиг шазруун нэгэн тул дүүгээсээ дэмжлэг хүсэхгүй. Ах, дүү хоёр явсан газар бүхэндээ нэгийгээ муулж, хүн амьтны сониуч занг хөдөлгөнө. Дүү нь,

- Манай сэмэрхийд тус болох хэрэггүй. Хүний ачийг ойлгодоггүй амьтан байгаа юм гэж нутгийнхаа сайхан сэтгэлт хүмүүсийг ятгадаг байв. Амьдралын даваа нугачаа бүхэнд ах, дүү хоёрын онхи өөр хувь тавилан мөр мөрийн замаар явсаар өвлийн нэг хүйтэн шөнө сэмэрхий Банди айлаас айл хэсэн замдаа төөрөн осгож үхжээ. Ойролцоох айл нь “Шөнө нэг хүн орилоод байсан юм. Хөөрхий, сэмэрхий Банди осгож байж. Нойрондоо харам манай тэр очоод үзчихээгүй юм. Тэгсэн бол хөөрхий ганц аяга цай, гамбир ааруулхан хороогоод л явж байх байж дээ” хэмээн худлаа харамсаад л өнгөрчээ. Үнэхээр Банди тэр шөнө “Гомпил оо! Би чамтай үхсэнийхээ дараа ч уулзана аа. Чиний торгон өмд, цамцнаас миний хувхай эрүүнэтэй болох вий” гэж төрсөн дүүгээ зүхэж, занаж байсан гэдэг.

Төдөлгүй зовж үхсэн Бандийг босоо ороолон болчихсон айлын амбаар савыг эргэж тойрон юм гуйж явна гэх болов. Гомпилын хатавчаар түүний палбигар хар гар орж ирээд “Өрөм өгөөч” гэсэн түүний бүтэнги дуу сонстсон ч гэж шуугилдана. Нэг удаа Бандийн сүнс дүүдээ “Намайг чи аятайхан оршуулчихгүй яав аа” гэж уйлсан гэж ч сонсогдов. Хүмүүс ч Гомпилыг дэндүү загналаа даа. Өөд болсон хүний ясыг өвгөдийнхөө газарт хүргээд нутаглуулчихаж болно оо доо гэгцгээж байв.

Бандийн сүнс нутаг хошуугаар тэнэсээр баян дүү нь ч тарган морио унаж, торгон дээлээ өмсөн найр наадам хэсч жаргал цэнгэл хөөсөөр даруй хэдэн жил өнгөрөхөд байдал шал ондоо болов.

Нэгэн өвлийн шуурганаар хамаг малаа алдсан нь Бандийн осгож үхсэн өдөртэй давхацдаг гэнэ. Мал хөрөнгийнхөө ихэнхийг алдсан Гомпил чөдрийн хэдэн морьтой үлдэж гарын үзүүрт зарцлагдсан байсан хүмүүс нь ч нүүр буруулан нүүж оджээ. Үрэхийг мэдэхээс биш үржүүлж өсгөхийг сураагүй тэр үгүйрч хоосроод Гомпилын бууц гэдэг нэгэн томоохон аргал хөрзөнтэй өвөлжөө л үлдсэн аж.

Гуниггүй явсан Гомпил гуйлгачин болсондоо гутарч ахынхаа нэгэн адил айлаас айл дамжин голоо зогоож явах болов. Угаас төрсөн хүүхэдгүй түүнийг хүмүүс “Буянтай ахыгаа ад үзсээр байж муугаар үхүүлээд өөрөө модоо барьсан нь энэ” гэх болов. Гомпил нэг орой морио чөдөрлөөд гэр рүүгээ буцаж явтал түүнийг хэн нэгэн нэрээр нь дуудах шиг болжээ. Харанхуйболоогүй байсан болохоор ойр хавьд юу байгааг харж болох байв. Гэтэл ямар ч хүн алга. “Гомпил оо, чи одоо миний яаж зовж зүдэрч явсныг ойлгож байна уу?” гэх дуу

талиЙгаач ахынх нь дуу мөн байв.

Энэ үед хүний мөсөөр тааруухан төрсөн чулуурхаг зүрхтэй Гомпил ахыгаа эргэн дурсаж, хэрхэн омойтож явснаа гэмшин уйлжээ. Төдөлгүй Гомпил ч өөд болж. Социализмын үед чөтгөр гэж байх ёсгүй болохоор түүний өвөлжөөн дээр нэгдлийн малчид өвөлжих болов. Гэвч буусан айл болгонд элдэв гай барцад, гэмт үйлдэл гарна.

Үнэхээр чөтгөр шүглэсэн газар гэдэг нь амьдралаар батлагдаж байв. Сүүлдээ тэр буурин дээр буух хүн олдохгүй болохоор намын гишүүн, аймгийн аварга малчин Нямаа гэдэг хижээл насны эр очиж буун үлгэр жишээ үзүүлэхээр шийдэв. Намын байгууллага ч тэгж шахаж шаардсан байна. Аварга малчны өвөлжөө тул банзан жорлон барьж, будаж шунхдан хашаа хороог нь үлгэр жишээ тохижуулсан байлаа. Аварга малчин Нямаа нэг хэсэгтээ чөтгөр байдаггүй гэж нотолж байв. Цагаан сар болох гэж байтал Нямаагийн эхнэр өглөө эрт бие засахаар жорлонд ороод тэндээ боож үхсэн хэрэг гарав. Дүнсгэр хөх модон жорлон түүнээс хойш босгож тавьсан авс шиг харагдах боллоо. Арга буюу сум, бригадынхан намын үзэл суртлаас нууцлан байж нэгэн номч өвгөнийг аваачин үзүүлэхэд “Жорлон дотор зовж үхсэн хүний яс байна” гэжээ.

Тэгсэн чинь тус өвөлжөөг засахад нэг нохой хээрээс нэгэн хөсрийн яс зууж ирээд хаячихсан нь мөнөөх жорлонгийн нүх рүү орсон байж ч мэдэх юм. Энэ мэтээр таамаглан ярилцсаар яг тагтэгсэн гэж хүмүүс бүгдээрээ итгэсэн гэнэ. Бохиртой зууралдаж ялгах аргагүй ясыг нүхнээс гаргаж хаях гэдэг бүтэшгүй ажил тул өвгөн лам сүү дусааж, хадаг нугалан нас барсан хүнийг яаж оршуулдаг вэ, тэр л зан үйлийг хийж гүйцэтгэн ерөөл буян хуруулснаар заслыг авсан гэж үзэцгээх болсон байна.

Нутгийн хамгийн тохитой тэр өвөлжөөг одоо хүн болгон өөрийн болгох гэж булаацалдах болсон аж.

## Нэгэн хийдийн шүтээнд тохиолдсон адал явдал

Ардын засаг сүм хийдийг эвдлэн сүйдэлж эхлэхэд Цалгарын хүрээний ядуу лам нар гар үйлдвэрийн артельд орж ууланд явж мод бэлтгэх болжээ. Лам нарыг буудах болохоороо санадаг ууланд гаргаж ажил хийлгэхдээ хоол ундгүй мартаж орхидог тийм цаг үе байсан аж. Тэр хэсэг лам ууланд мод бэлтгэж унд хоолоор тасарсан байна. Мэдээж ан гөрөө хийх боломжгүй. Лам нарт хурдан буу үүрүүлнэ гэдэг ардын засгийн номонд хазгай болохоор тэр талаар санахын ч хэрэггүй.

Гэтэл Доржцэвээн гэдэг уншлага маруухантай лам бие засахдаа аль болох хол очоод удаж удаж ирдэг байв гэнэ. Бусад лам нар ч хар уснаас өөр ходоод руугаа “холхол” хийлгэчих юм үгүй турж үхэхийн туйл болох гэж байв. Тэдний дотор л Доржцэвээн өлсөж цангаж, турж гурайтсан шинж үгүй нь ядарч туйлдсан бусад лам нарт сонин санагдаж байлаа. Майдар лам нэг удаа Доржцэвээнийг нууцаар дагажээ. Доржцэвээн хойноос нь хүн дагасан эсэхийг болгоомжтойгоор ажиглан сэм явсаар нэгэн том шинэсний доор очоод сөгдөн залбирч байна гэнэ. Түүний өмдний тэлээнээс нураагдсан хийдийн гол шүтээн болох Лхам бурханы жижигхэн дүрс санжиганаж харагдах аж. Тэгээд л тэр,

- Ээ, шүтээн минь. Хоол унд хайрла. Тарган хонины дал дөрвөн өндөр хайрла гэж өрөвдөлтэй дуугаар чичирхийлсэн хоолой гарган өгүүлэх аж. Майдар лам ч түүнийг сониучирхан нүдээ бүлтэртэл харжээ. Гэтэл үнэхээр нэгэн модон царанд уур савссан тарган мах бий болж, Доржцэвээн түрийнээсээ хутгагарган ховдоглон идэж гарчээ. Хэдэн хоног хоосон байсан Майдарын ходоод нь хоржигнон дуугарч бас хар амиа бодож өөрийгөө болгож яваа нөхөртөө гомдох сэтгэл дотрыг нь улам харанхуй болгожээ. Гэвч Майдар Доржцэвээнийг яахыг нь харах гэж тэсч тэвчиж байв. Төдөлгүй Доржцэвээн цадталаа идэж аваад тэлээнээсээ уясан Лхам шүтээнийг уруулдаа хүргэн үнсэж талархал илэрхийлээд буцаж гэр майхан руу алхав. Майдар түүний замыг тосон очиж,

- Чи яахлаараа ингэж хар амиа хоохойлж байдаг юм. Хүрээний гол шүтээнийг ногоон малгайт Цэвэг шатаачихсан гээд байсан чинь чи тэлээнээсээ зүүчихсэн шүтээний ид шидээр хоол ундаа зэхүүлж явдаг юм биз дээ гэжээ. Доржцэвээн хоорондоо зай гарч сам шиг болсон арзгар шар шүдээ арзайлган инээхэд шүднийх нь завсарт тарган хонины мах хавчуулагдсан байх нь өлсөж туйлдсан Майдарын уурыг улам хүргэжээ. Доржцэвээн,

- Чи харчихсан уу? Би энэ шүтээнийг ногоон малгайт Цэвэгийн гараас амь өрсөн байж нууж үлдсэн юм. За яахав, намайг аминд нь орсон болохоор л энэ шүтээн миний хүслийг биелүүлж байгаа юм. Чи хө, өөр хүнд хэлэхгүй байж чадах юм бол чамд хоол ундны юм гуйж өгч болох юм гэжээ. Өлсөхийн эрхэнд Майдар Доржцэвээний хүсэлтийг биелүүлж,

- Өөр хүнд хэлэхгүй. Хоёулаа л шүтээнээс нууцаар хоол гуйж байя гэж ам өчгөө өгчээ. Хэд хонож байж ар талынхан хоол ундтай залгасан бөгөөд тэр хүртэл Доржцэвээн, Майдар хоёр хамтдаа гарч орж ихэд дотносож байгаагийн цаад учрыг бусад лам нар нь анзаарсангүй. Гэтэл нэг бэрхшээл гарчээ. Шар будаатай шөл, хар талхны булан идэхээс Доржцэвээн, Майдар хоёрын хэн хэн нь ч залхаж “Хоол өгдөг” шүтээнийг хэн нэг нь дангаараа эзэмших бодолтой болжээ. Нэг шөнө Майдар өмдөө тайлаад гудас доороо нямбайлан тавиад унтсан



Доржцэвээний тэлээнээс мөнөөх шүтээнийг гулсуулж орхижээ. Тэр шөнөдөө маш нууц газар аваачиж нэгэн модны мөчрөөс нөгөө шүтээнийг өлгөөд ирж унтжээ. Доржцэвээн өглөө босоод юу болсныг мэдмэгц Майдарыг нүдээрээ дохиж дуудан хээр очиж зодолдсон боловч мань Майдар шүтээнийг нь гаргаж өгсөнгүй.

Тэр шөнө нэгэн сонин явдал тохиолджээ. Шархүү гэдэг эр гарч бие засаад орж ирэхдээ нүд нь орой дээрээ гарчихсан:

- Өвгөний уулын овооны цаахантай бурхан багшийн орхимж гэрэл гарч байна. Тэнд нэг сонин юм болжээ. Аль нэг хутагт хувилгаан заларч яваа юм болов уу гэх мэтээр олон үг хэлжээ.

Үнэхээр ч долоон өнгийн их гэрэл орхимж адил дугуйран эргэлдэж шөнийн харанхуйд онцгой содон дүрсийг бий болгож байв гэнэ. Түүний учрыг ганцхан Майдар л мэдэж байв. Юу гэвэл тэр их гэрэл түүний нуусан шүтээний гэрэл болохыг тэр таамаглаж байлаа. Тэгээд хашир эр,

- Хутагтын сүнс заларч байна. Түүнд ойртож болохгүй хэмээн лам дээлээ тайлсан ч сүсэг бишрэлээ төдий л тайлж амжаагүй бусдыгаа хорьж амжжээ. Харин Доржцэвээн л түүний ямар санаатай “Хутагтын сүнс энэ тэр” гэж байгааг мэдэж байсан гэдэг. Нуусан юм улам ил тод болдог болохоор шүтээний талаарх үг яриа газар авсаар ногоон малгайтнуудынчихэнд хүрчээ. Нэг өдөр буу шийдэм болсон гурван хүн ирж, мод бэлтгэж байсан лам нарыг баривчилснаар шүтээний талаар ганц үг ганхийх хүнгүй болж үдэш оройн цагаар үүд хаалгаа цоожилсон ганц нэг өвгөчүүл түүний талаар өвөр хоорондоо сэм хүүрнэлдэх болсон гэдэг.

10 жилийн ял аваад хугацаанаасаа өмнө суллагдаж ирсэн Майдар гэлэн мөнөөх шүтээнийг нуусан газраа хожим очиж түүнийг олж авсан гэдэг. Тэгээд үр хүүхэдгүй хүн тул зээ хүү болох Арьяа гэгчид “Зүүж яв. Аминд чинь өлзийтэй” хэмээн зангиа болгон хүзүүнд нь уяж өгчээ.

Арьяа гэгч нь морин дэл дээр салхи исгэрүүлэн давхиж тухайн үедээ нийгмийн тустай хөдөлмөрөөс хойш суусан ганган хээнцэр нэгэн байжээ. Түүнийг бас гар урттай, бусдын адуунд хазаар гүйлгэх донтой гэж ярилцдаг байж. Ямартаа л,

...Арав хориор адуу хаачив

Артелийн гуталтай Арьяа авчихав уу... гэсэн дуу нутгийн олны дотор гарч байхав. Арьяа олны дотор бий болсон “Шилийн сайн эр” гэсэн нэрийгээ хамгаалах гэж олон удаа алс холоос адуу мал хөөж байсан гэдэг. Нэг удаа Арьяа Тувагийн талаас адуу хөөжээ. Тэр нь Тувагийн хамгийн хараалч бөөгийн морьд байсан гэдэг. Арьяа адуу хөөж, араас нь бөөгийн хараал түүнийг хөөж байсан хэрэг. Хүзүүнээс нь зүүсэн шүтээн түүнийг хамгаалах тул түүнд ямар ч хараал хүрдэггүй ажээ. Гэвч түүнийг адуугаа алс хол аваачиж зарчихаад эргээд ирэхэд хүүхэд нь нас барсан байжээ. Нутгийн учир мэдэх нэгэн өвгөн түүнд,

- Хулгай хийхээ боль. Бөөгийн хараал чамд хүрэхгүй ч гэсэн үр хүүхэд ойр дотны чинь хүмүүсийг нэг нэгээр нь түүсээрдуусч байна. Наад хүзүүн дэх шүтээнээ ч байх газар нь орхи

гэжээ. Шүтээнийг хаана аваачиж байрлуулах талаар асуухад өвгөн,

- Наадах шүтээн чинь удахгүй чиний хүзүүнээс уяа нь тасарч унана. Тэгэхэд нь мэдээгүй юм шиг орхичих. Шүтээн өөрөө хаана унахаа мэдэж байгаа байлгүй гэж хэлсэн байна. Үнэхээр ч Арьяагийн хүзүүнд байсан мяндсан оосортой шүтээн нэг өдөр хүзүүнээс нь тасарч унасан байна. Арьяа мориныхоо амыг татан эргүүлж түүнийг авах гэснээ өвгөний үгэнд өө үгүй гэж бодоод орхисон аж. Түүнээс хойш олон жил улирч ардчиллын он жилүүд эхлэхэд Ховд аймгийн Дөргөн сумын нэг лам гэрэл гардаг ид шид, увидас жанлавтай газар бийг олж тогтоогоод тэр газарт нэгэн сац суварга босгожээ. Бас нэгэн сэрүүн дуганыг ч ард олны хандив дэмжлэгтэйгээр барьж аравнайлсан аж. Тэр лам энэ газрын талаар олон сонин тохиолыг ярих бөгөөд тэр нь дан ганц шүтлэгтэй ч холбоотой бус дотоод хүчний ид шидийн хүрээнд бий болсон зүйл ч бий хэмээнэ. Дуган, суварга барих газрыг хөөцөлдөж явахад тэр газарт орой үдшийн цагаар орхимж адил олон өнгийн гэрэл дугуйран цацарч харагддаг байж. Энэ зөвхөн тэр ламд ч харагдсан бус түүнийг замын жолооч хүртэл харснаа бусдад ярьсан байжээ.

## **Шаравсамбуу бөөгийн ном үйлчлэхгүй болохоор инээд алдаад байдаг гэнэ**

“Анагаахаар явлаа, ламдлаа, засралыг олохгүй нь бололтой. Бөөд очихоос” гэж Наран хэлээд гэрээсээ гарчээ. Түүний бага хүү нь зуны эхэн сард гэнэт дайрлага дайрсанаас хөл гар нь хөдлөхөө больж, үг ч хэлж чадахгүй гөлийн суух болжээ. Арван хэд хүртлээ хамрын ханиад ч тусч үзээгүй, эрүүл чийрэг хүүгээ нэг л өдөр ухаан санаагүй, амьсгалдаг цогцос болчихно чинээ аав ээж нь яаж бодох билээ. Хүүхдүүд л болсон хойно Алтан-Өлгийн гоё хөшөөтэй шарилуудын дундуур нуугдан гүйлдэж, байлдан тоглож байгаад Алтангэрэл хүү муухай орилоод л суун туссанаас ийм болсон ажээ.

Лам нар ч гэсэн түүнийг гүйдэлтэй газар тоглож байгаад ийм болжээ хэмээн мэргэлсэн гэдэг. Гэхдээ түүнийгээ эмнэж домнож эдгээж чадаагүй байна. Тэгээд л эцэг Наран нь бөөд очихоор болсон нь тэр ажээ. Шаравсамбуу гэж сүрхий бөө байдаг гэж нэг танилаасаа сонссон Наран хайсаар очжээ. Өөрөөс нь арваад дүү залуу ботинк дээр саарал даавуун тэрлэг өмсчихсөн хэнэггүйхэн угтжээ. Бөө Нарангийн үгийг анхааралтай сонсоод гэрт нь ирэв. Цүнхнээсээ хачин янзын арзгар сэрзгэр амьтны дүрс гаргаж хүүд нэг нэгээр үзүүлэв. Хүү тэднийг гөлийн ширтсээр. Улаан нүдтэй, шүд нь ярзагнасан нэг онгоныг үзээд хүү нүдээ тас аньжээ. Энэ сацуу Шаравсамбуу,

- За, танай хүүг үүний төрлийн амьтан л хорлосон байна гэж Наранд хэлжээ. Энэ нь их түүхтэй онгон гэнэ. Онгоныхоо талаар Шаравсамбуу бараг нэг бүтэн үлгэр ярьжээ. Юу гэвэлэнэ онгон нь урд төрөлдөө худал хуурмаг явдалтай байсан хуурамч нэгний сүнс юм байв. Тэр бусдыг мэхэлж өөрийгөө худлаа дөвийлгөж орчин цагийн хэллэгээр бол рекламдсаар байгаад өөрийнхөө байх ёстой газраас хальж өндөр сэнтийд суух болсон гэнэ. Тэгэхлээр Алтангэрэл хүүгийн айсан зүйл нь бас нэг тийм хуурамч замаар Алтан-Өлгийд нойрсох болсон нэгний сүнс байж таарах гэнэ. Бөө Шаравсамбуу нэмж хэлсэн нь,

- Алтан-Өлгийд дандаа хуурамч нөхдүүд байдаг. Амьддаа ч ард түмэнд өртэй, төрөл арилжсан хойноо ард түмнийг хуурч мэхэлсэн өөдгүй хүмүүс байдаг гэжээ. Бөө бөөлж эхэлснээ төдийгүй тачигнатал хөхөрч “Больё оо, больё. Би больё” гээд гэр дотуур тойрч гүйжээ. Өмнө Наран бөө бөөлж байхыг нэг биш удаа үзэж харсан байлаа. Гар хөл нь чичирч салгалаад завжаар нь цагаан хөөс сахран, энэ ертөнцөөс тасраад оюун санаа нь хаа нэгтээ одсон юм шиг аашилж аягладгийг нь эрхбиш гадарлах болжээ. Гэтэл Шаравсамбуу бөө цан хэнгэргээ ч дэлдсэнгүй. Тачигнатал хөхрөөд тойрч гүйгээд байх юм гэнэ. Гэтэл түүнийг хөдөлгөөнгүй ширтэж байсан хүү удалгүй даган инээж хөхөрч эхэлжээ. Наран инээж бөөлдөг бөөг анх удаа үзсэнээр барахгүй хүүхэд нь түүнийг дагаж элгээ хөштөл инээж байгаад ихэд гайхжээ. Түүнд хүүхэд нь бөөгийн хүчинд эдгэрч илааршиж байгаа сэтгэгдэл төрснөө бас “Юу л болоод байна даа” гэсэн хардлага бий болжээ. Гучаад минут хэртэй тасралтгүй инээж тойрч гүйсэн Шаравсамбуу савж унаад л үргэлжлүүлэн инээж гарч.

Тэгж байснаа арай чүү инээдээ барьж тогтоогоод хэлсэн нь:

- Би энэ хүүд үйлчилж чадахгүй юм байна. Энэ хүүд миний гижгийг хүргэсэн хорлол тусчээ. Тэгээд л намайг бөөлөх гэхээр шоолоод байна. Хүү хорлолтойгоо зуун хувь нэгдэж ад нь шингэжээ гэсэнгэнэ. Тэгээд мань бөө юм хүмээ хамж аваад явж одсон байна. Бөөг явсны

дараа хүү ч хуучин байдалдаа орж юуных нь инээхтэй манатай гөлрөө суумгай байдалдаа буцаж оржээ. Наран хүүгээ эрүүл саруул болгох гэж гүйсээр байгаа гэнэ лээ.

## Эрийн сайнаар бус ламын сайнаар эхнэр авчээ

Эрийн сайнаар биш ламын сайнаар сайхан эхнэр авсан хүн гэж Цогт-Очир багшийн тухай ярилцах нь бий. Тэр төрөлхийн тахир дутуу нэгэн бөгөөд энэ байдалтай нь эвлэрсэн аав, ээж нь бусад хүүхдүүдээс онцгойлон үзэж сургууль соёлын мөр хөөлгөсөн гэдэг. Түүхийн багш болсон хэдий ч хараажаар хэн нэгний тусламжтайгаар явж чаддаггүй ядахдаа суга таяггүйгээр явж барахгүй хөгжлийн бэрхшээлтэй түүнд эхнэр авна гэдэг санааны гарз байлаа. Гэхдээ Цогт-Очир багшийн хувьд сайн багш. Хичээл дээр нь зарим хүүхэд сахилгагүйтэж илэрхий доромжлох аяс гаргадаг боловч ихэнх нь тэр багшийн өрөвдөм байдалд хүндэтгэлтэй хандана. Энэ бол түүний ажиллах урам зоригийг улам бүр асаана. Хөөрхий Цогт-Очир багш өөрийнхөө өрөвдөм байдлыг мартан аав, ээжийнхээ нутагт очиж ажиллана хэмээн Улаанбаатар хотоос нэг өдөр хүлгийн жолоог хөдөө тийшээ залжээ.

Сумын төв дээр ч биш бригадын төв дээр очиж 8 жилийн сургуульд багшлах болов. Сургуульдаа ойр юм гэж дотуур байрны хүүхдүүдтэй хамт байранд байх болов. Аав нь уг нь аймгийн дарга байгаад дээшээ дэвшиж Намын төв хороонд хариуцлагатай алба хашдаг болсон нэгэн. Хар багаасаа сургууль соёлын мөр хөөгөөгүй ч цэргийн албанд мордож бичиг үсэгт тайлагдаж, чөлөөлөх дайнд оролцож гавьяа байгуулсан болохоор түүний өмнө дарга болох зам нь нээгдсэн хэрэг. Цогт-Очир багштай аавынх нь багын найз Жамьян гэдэг хүн нэг удаа ирж уулзан хүний хувь тавилан гэдэг нэг л өдөр сайнсаарын алинаар ч ёстой орвонгоороо эргэдэг юм гэх мэтийн зүйлийг хамж шимэн ярьжээ. Түүний ярьснаар Цогт-Очирын аав нь Жамьян гуайтай хамт хошууны тэнхимд сурч байсан гэнэ. Ангидаа хамгийн сурлага муутай, юм л бол оргож босч багш нарыгаа зовоодог нэгэн байж. Харин Жамьян гуай нэлээд сүрхий сурагчдын тоонд орж байсан боловч баг бригадын даргаас дээш гарсангүй. Хэдэн малын хойноос дагасаар насыг барах хувь тавилан л хүлээж байгаа гэжээ. Жамьян гуай энэ тэрийг ярьж байснаа

- Чи хө, одоо эхнэр авах хэрэгтэй. Чам шиг эрдэм номтой ийм хүнд халамжтай хүн л таарна. Түүнээс биш эрдэм мэдлэг энэ тэр гэж дэмий. Гунхсан сайхан нь чамайг тоохгүй, гутлаа чирснийг нь чи тоохгүй. Тийм болохоор байна шүү гээд шивнэжээ. Уг нь ямар боловч эр хүн болохоор Цогт-Очирт нэг бүсгүй онцгой харагдаж, заримдаа ор хөнжилд хамтдаа жаргаж байна гэж зүүдэлдэг байсан болохоор түүний царай улайсхийн,

- Харж явах бүсгүй бол байх л юм. Харахын заяа байхаас хазахын заяа үгүй төрсөн халтай л толгой юм даа гэж тэр өөрийгөө голсхийн хэлжээ. Жамьян өвгөн илтэд сэргэж,

- Үгүй ээ. Тийм биш шүү. Эр муу ч эмийн дээр, эмээл муу ч морины нуруунд гэж үг бий. Чи ер нь тэр хүнээ надад хэлээтэх. Тэгэж байтал энэ цэргээс ирсэн залуучуудын нэг нь түүнийг шүүрч аваад давхиж одно шүү гэв. Энэ нь үнэхээр гол руу нь хаггасан үг байсан болохоор Цогт-Очир багш,

- Манай сургуулийн цэвэрлэгч Жавзан гэж бүсгүй байна. Наймдугаар анги төгссөн юм билээ. Гэхдээ тэр малчин хүнийохин боловч харьцангуй суурин газар амьдрах бодолтой юм шиг байна лээ. Тэгээд ч царай зүс тэгш, жавхалзсан сайхан амьтан болохоор хонины зунгаг, хашаа хорооны өтөг бууцан дотор хутгалдаж явахаас тээршаадаг байх. Даанч намайг тоохгүй юм

шиг байна лээ. Аргагүй шүү дээ. Амьд сүг шиг чамтай тэр насан туршдаа тэвэрч хэвтэнэ гэж үү. Цогт-Очир багш өөрийнхөө сэтгэл доторхийг цөмийг нь уудалж яриад уртаар санаа алджээ. Жамьян өвгөн,

- Хөгшин залуу хоёр найзын уургын хуйв урт, ухааны цараа өргөн болохоор энэ хэргийг ядах юмгүй бүтээнэ. Чи завтай бол Намжил гуайнд надтай хамт очих хэрэгтэй болох нь ээ гэжээ.

Тэр хоёр тухайн нутагтаа л мэргэн түргэн гэгддэг Намжил гуайнд очжээ. Жамьян ороод элдвийн яриагаа дэлгэж байснаа,

- Намжил гуай, энэ Цогт-Очир багш чинь манай сумаас төрсөн ганц том даргын хүү шүү дээ. Яагаав бид нэг довон дээр тоглож өссөн дөө. Аав нь саяхан надад захидал бичсэн байна лээ. Хүүг минь харж хандаж байгаарай болбол эхнэр аваад өгчих юмсан гэсэн байсан гэв. Үнэндээ Даваа дарга багын найз Жамьяндаа захидал бичсэн байжээ. Болохгүй бол богтлоод ч гэсэн эхнэр авч өг гэж түс тасхийн хэдэн өгүүлбэрийг чухал баримт дээр цохолт хийж байгаа юм шиг тодоос тод бичсэн аж. Намжил гуай

- Мэдлэг мэргэжилтэй хүнд эхнэр хаанаас ч олдоно. Тэгээд ч хүний хайр сэтгэлийг хамаагүй хөндлөнгөөс зохицуулна гэдэг том нүгэл юм шүү гэж цааргалав. Гэсэн ч Жамьянгийн хөдөлгөхгүй шалалт, дарга аавынх нь холын нэр сүрэндтөдөлгүй дийлдэж эхнэр болгох хүсэлтэй байгаа бүсгүйнх нь жил нас, мэнгэ зэргийг асуужээ. Бас ямар чихэрт дуртайг нь лавлав. Тэр үеийн хөдөө нутагт хамгийн түгээмэл нь “Алтан шагай” гэдэг бор чихэр байсан болохоор Жавзан түүнд л дуртай нь тодорхой шүү дээ. Тэгээд Жамьян, Цогт-Очир хоёр Намжил гуайгаар хэдэн чихэр тарнидуулж аваад Жавзанд өгөхөөр замыг нь тосч эхэлжээ. Хүнд юм өгнө гэдэг хамгийн амархан зүйл байтал Жавзанд бор чихрээсээ атгуулах гэж Цогт-Очир ихээхэн хүч гаргажээ. Ядахдаа Жавзан Цогт-Очирын ангийг цэвэрлэхгүй. Тэгээд арван найм есөн настай годгоносон охин болохоор хөл муутай багшид гүйцэгдэнэ гэж үгүй. Хамгийн гол нь гурван ширхэг тарнитай бор чихрийг Жавзан Цогт-Очир хоёр нэгийг нь хувааж идээд үлдсэнийг нэг нэгээр нь аваад орой нар жаргах үед идэх ёстой байв. Тэгэж гэмээнэ нь Жавзан гоонь багшид голт зүрхнээсээ дурлаж, хойноос нь гүйсээр байж тэр хоёр амьдрал холбох учиртай билээ.

Намжил мэргэн ингэж зааварчлага өгсөн байлаа. Ашгүй нэг орой Жавзан цэвэрлэгээгээ хийгээд дуусч байтал Цогт-Очир сургуулийн коридорт таарав. Мэдээж эр хүн юм болохоор “ядарч байна уу? май” гээд нэг чихрээ гарган тал дундуур нь тас хазаад Жавзанд сарвайчихав. Бүсгүй гайхаж тээнэгэлзэж байснаа мөнөөх багшийг өөрөөс нь нүд салгалгүй ширтээд байхаар нь тал чихрийг идэж орхив. Түүнийг чихрээ идэж эхэлмэгц Цогт-Очир ч өөрийнхөө хувийг тэр даруйд нь явуулчихав. Тэгснээ багш хэлжээ.

- Чи завтай бол миний байранд очиж хананд нэг зураг тогтоож өгөхгүй юу. Би сандал дээр гарч чадахгүй юм гэжээ.

Жавзан ч харуй бүрий болоогүй байсан болохоор харих замдаа Цогт-Очир багшийн байранд очиж Марксын жаазтай зургийг хананд нь өлгөж өгчээ. Түүнийг явахад Цогт-Очир,

- Би энэ чихэрт их дуртай гээд бас нэг бор чихэр Жавзанд өгчээ. Тэр үед яг нар жаргаж

бүрэнхий болж байлаа. Жавзан чихрийг хүүхэд шиг авсан даруйдаа задалжиджээ. Тэгээд л бүсгүй гэртээ харьжээ.

Жавзанг шөнө унтаж байтал мөнөөх хөл муутай мөртлөө сайхан ааштай, нүдээрээ инээсэн Цогт-Очир багш зүүдлэгдээд бас энгэр нээж эр, эмийн үйл хийж байгаагаар төсөөлөгдөөд болохоо байжээ. Бүсгүй байж боломжгүй балай зүүднээс салах гэж хичнээн хичээгээд нэмэр болсонгүй. Бүр сүүлдээ зүүд нь зүүд биш үнэн явдал шиг санагдаж эхлэв. Цогт-Очир багшийн сайн сайхан чанарууд түүний нүдний өмнө жирийтэл бичээстэй. Жавзангийн зүрх булгилж, эмэгтэй хүнийх нь эсрэг хүйстнээ хүсэн тэмүүлсэн ад аяг нэвчиж ирээд тэвчиж болшгүйгээр өднө. Нойр нь хүрэхээ байжээ. Арга буюу тэр босч ахындаа байсан тул чимээ анир гаргахгүйгээр хувцаслаад гэрээс гарчээ. Өвлийн шөнө. Од мичид гялалзан хүйтний хөх амьсгал харанхуйг нэлд нь хучжээ. Жавзан Цогт-Очирын гэрт очиж үзмээр санагдав.

Бригадын айлуудад цахилгаан өгдөг дизель мотор аль хэдийнэ унтарч сууринг анир чимээгүйн дээр айдас хүрмээр харанхуй нөмөрсөн байлаа. Гэвч Жавзангийн сэтгэл зүрхэнд хаа нэгтэйгээс ирсэн хурц гэрэл, хурьцах сэрэл асан дүрэлзэж тэр аймшиггүйгээр харанхуй шөнийг зүсэн алхсаар Цогт-Очир багшийн цонхон дээр очиж амьсгалаараа цонхны цангхайлуулан ямар нэг үнэ цэнэтэй зүйлээ алдах гэж байгаа хүний нүдээр өлөлзөн өндөлзөн харжээ.

Цогт-Очир явган ширээн дээр нэг зузаан ном дэлгээд түүнийгээ лааны гэрэлд тонгойн харж суув. Жавзанд энэ удаад бүр тэсч тэвчихийн аргагүй жолоогоо аль хэдийнэ алдсан сэтгэлийн гүний дэлбэрэлт сонстож байв. Тэр өөрийн мэдэлгүй Цогт-Очирын өрөөний хаалгыг тогшиж зогсов. Цогт-Очир түүнийг хараад догонцон гүйж хувцасыг нь өлгөж хэрдээ л сүйд болж байв. Үнэндээ хэт баярлахад доглон хөл ч газар хүрдэггүй бололтой дог оо. Ингэж Цогт-Очир, Жавзан хоёр гурван бор чихрийн хүчээр нэг бор шөнийг нартай өнгөрөөв. Маргаашнаас нь Жавзан Цогт-Очирын бодож тооцоолж байснаас хэдэн хувь илүү түүнд татагдаж бага сагахан шалтгаанаар түүний ангид орж ирээд дэргэд нь зогсчихно. Зарим нэг сахилгагүй хүүхдийг багшийгаа элэг барилаа гэж Цогт-Очирын өмнөөс загнаж байх ч энүүхэнд.

Хоёр сарын хугацаанд Жавзан Цогт-Очир хоёр нэг гэрийн хүмүүс шиг дасал болж, хөдөөгийн бяцхан суурингийнхны ярианы сэдэв, ялааны цохиур болоотохсон байна. Хавар нь Цогт-Очирын аав Улаанбаатараас нутагтаа очиход түүний ах, дүү нар нь арван зүгээс цугларчээ. Цогт-Очирыг төдий л тоодоггүй байсан хүмүүс ч Даваа даргын хамгийн ойрын хамаатан болоодхож. Аав нь өрөөл татуу хүүдээ өргөө цагаан гэр тааруулж хуримыг нь хийгээд буцсан гэдэг.

Түүнээс хойш Цогт-Очир Жавзан хоёр тостой тогооноос хошуу холбож, тоонот гэрт толгой холбож аз жаргалтай амьдарч буй. Анхны хүүдээ яагаад ч юм аав нь Алтаншагай гэдэг нэрэгсэн бөгөөд түүхийн мэргэжлийн хүн болохоор Монголын язгуур нэрнүүдээс сонгон байж хүүдээ өгсөн хэрэг гэж олон хүн итгэдэг. Гэвч энэ нь Намжил гуайн тарнидаж өгсөн бор чихрийн нэр гэдгийг Цогт-Очирос өөр хүн мэддэггүй аж.

Өрөөл татуу нэгнийг сэтгэлээр нь бүтэн болгосон энэрэнгүй зөөлөн сэтгэлт лам Намжил гуайг зарим залуус “Тэр бүсгүйг надад сэтгэлтэй болгож аль” гэх мэтээр насан өөд болтол нь

ЗОВООСОН ХЭМЭЭДЭГ.



## Хэлмэгдсэн цэргийн сүнс олон машин эвдэлжээ

Лувсанчүлтэм гэдэг цэрэг 1930-аад оны үед хилсээр шийтгэгдсэн байна. Тэр цэргийн албанд татагдаж ирээд жолооч болжээ. Дорнодын талд тоос татуулан давхиж цэргийн хоол хүнс, буу зэвсгийг залгуулах болов. Нас бие ид жагсаж нам засгийн итгэл найдварыг биелүүлсэн тийм насандаа цэргийн машин техник эвдэж улс нийгэмд хор хохирол учруулсан гэх хэргээр цэргийн хээрийн шүүхээр буудан алах ял авчээ. Хээрийн шүүх ч гэж дээ түүнийг тайж гаралтай болохыг мэдэх нэг сүржигнүүр хувьсгалч хорлон сүйтгэх ажил явууллаа. Японы гар хөл болсон урвагч энэ тэр гэж байгаад л буудаж орхисон байна. Тэгээд түүний үйлдсэн хэрэг гэгч бяцхан зохион бичлэгийг хийж удаа дараагийн хорт үйлдлийг нь илчлэн тогтоосон хүн болж жүжиглэсэн гэдэг.

Шинэ цагийн амьдралд дасан татагдаж хөдөөх байдлаасаа хөгжингүй дэвшингүй хувь заяаны эргэлтэнд орж амьдралыг гэгээн сайхнаар харж явсан залуу эрийн хожмын сайн сайхан ирээдүйд хүйтэн сэтгэлт нэгэн хувьсгалч ийнхүү өөрийн дураар цэг тавьж орхижээ. Зүүн хязгаар түгшүүртэй байсан тэр цаг үед жолооч нарын хувьд бас нэгэн айдас бий болжээ. Юу гэвэл Лувсанчүлтэмийг чөтгөр болоод зам тосон гараа өргөн зогсох болов гэсэн үнэн худал нь мэдэгдэхгүй цуу сонстох болов. Цэргийн цуваанд хамт явдаг байсан нэг жолоочоос “Миний данхраатыг чи хэзээ өгөх юм” гэж нэхсэн ч гэх шиг. Сэтгэл хирдхийлгэсэн олон л яриа чих дэлсэнэ. Лувсанчүлтэмийн сүнс жолоочид нь харагдах юм бол ямар ч шинэ машин тэр даруйдаа эвдэрч саатдаг аж. Нэг удаа Цэрэнсамбуу гэдэг жолооч ганцаар Матадын цэргийн ангид хоол хүнсний зүйл хүргэж өгөх гэж яваад төөрсөн байна. Үүлтэй тас харанхуй шөнө байсан болохоор Цэрэнсамбуу одоо ч чиг зүгээ баримжаалах аргагүй тул элчилгүй талд хаашаа явахаа мэдэхгүй болов. Таамгаар давхиж бензин шатахуунаа дуусгавал түүнээс ч эс болох юм болно гэж хаширласан Цэрэнсамбуу машинаа унтрааж орхиод унтахаар хэвтжээ. Ид нойрон дундаа, амтат зүүдний аянд явж байсан түүнийг хэн нэгэн дуудаж, гараас нь татаж чангаах шиг санагджээ.

Цэрэнсамбуу гараа суга татан аваад нойроо харамлан буруу харж, машиныхаа арын ханатай наалдан хэвтжээ. Гэтэл нөгөө талаас нь бас л нэг хүн ирж татаж чангаан,

- Нойрноос морио чөмөгнөөс хутгаа гэдэг юм бос бос гэх шиг болжээ. Гэв гэнэтхэн зам тосдог чөтгөр болсон Лувсанчүлтэмийн тухай санаанд нь орсон Цэрэнсамбуу нүдээ аниатай чигээрээ ухасхийн кабиныхаа гэрлийг асаасанд толгойгоо цагаан даавуугаар боочихсон зэвхийдүү царайтай их гунигтай нэгэн цэрэг эр түүнийг ширтэн сууж байлаа. Айсандаа Цэрэнсамбуу муухай дуугаран хашгираад бууж зугтах гэжээ. Машинаасаа буусандаа тэр харамсав. Зүг бүрт нь хав харанхуй. Ёстой тамын харанхуй шиг том хар ангал шиг аймшигтай орчин тосч байв. Машин руугаа эргэж харсанд мөнөөх цэрэг машиных нь жолоог мушгин оролдоно. Толгойных нь үс өрвөсхийн босч хуйх нь халуу шатсан Цэрэнсамбуу жаахан сэхээ аваад очиж “Зис-5”-ынхаа модон хаалгыг онгойлгох гэсэнд дотроос нь түгжчихэж. Цэрэг чөтгөр Цэрэнсамбууг кабиныхаа хаалгыг хичнээн нүдсэн ч тоохгүй. Рультэй нь ноцолдож, машины хянах самбарыг ажиллуулж бүх юмыг нь ёстой мэргэжлийн хүн шиг шалгаж үзэж байв. Дагзандаа сум зоолгож нас барсан хүний сүнс яаж үхсэн бэ тэрнээсээ айж магадгүй гэж бодсон Цэрэнсамбуу гурван сумтай гар буугаа сугалан хий буудаж үзэв. Шөнийн нам гүмийг цочоон буун дуу аянга цахилгаан шиг нүүргэлжээ. Мөнөөх цэргийн сүнс агаарт уусч, урагдан

сэмрэх шиг алгуураар алга болжээ. Кабиных нь хаалга чахран дуугарч өөрөө онгойжээ. Цэрэнсамбуу айж чичрэн кабиндаа ороод машинаа асаах гэсэнд ассангүй.

Руль дээрээ гараа тавьтал төмрийн хөрөөгөөр хөрөөдөж орхисон юм шиг унаад ирж. Цэрэнсамбуу хоёр гараараа элгээ тас тэврэн суусаар үүр цайлгажээ. Бага үд болохын үед хойноос нь цэргийн цуваа иржээ. Тэр замаасаа нэг их хазайгаагүй байсан аж. Ачаагаа өөр машинд сольж ачаад машинаа чирүүлэн ангидаа очсоноо цэргийн чухал үүрэг даалгаврыг тэр биелүүлжээ. Хуягт тэрэгний алтан гартай жолооч Балдан-Очиртой хамтарч чөтгөрт эвдүүлсэн машинаа тэр арай чүү засч авчээ.

Лувсанчүлтэмийн сүнс энэ мэтээр олон машиныг эвдэлсэн гэдэг. Техникийн саатлыг тэр үеийн үзэл суртлын хийрхлээр харж, гэмгүй жолоочийг гэмт хэрэгтэн болгож хороосноос түүний сүнс амьддаа хийгээгүй үйлдлээ гүйцээж байсан нь тэр аж. Мэдээж тэр үед япон чөтгөрүүд эх орны хил рүү өнгөлзөж байсан болохоор монгол чөтгөрөөс айх тийм хулчгар хүн ховорхон байсан гэнэ лээ.

## Урд төрөлдөө бөө байсан эмэгтэй охиныхоо ид шидийг биширдэг

Тэр намайг гараараа дохиж зангаж дуудсан юм. Өөрийгөө бөө гэж хэлсэн. Нэрийг нь яльгүй өөрчлөөд түүнийг Саранзаяа гэж нэрлэе. Надад тэр “Таны өмнө хийх юм чинь бэлэн байна. Тэгээд түүнийгээ хийхгүй яагаад архи уугаад байгаа юм бэ?” л гэж загнах аястай асуусан юм. Би “Хүн болгон л архи уухгүй бол ажил амьдралаа аваад хүний дайтай амьдрах нь хууль шүү дээ. Энэ үгийг заавал бөөгөөс сонсоод байх хэрэггүй юм биш үү. Тэгэхлээр бөөгөөс ийм үг сонсох сонин биш байна” гэсэн тэрслүү хариу хэлсэн санагдана. Саранзаяа бид хоёр эвгүй үг зөрөлдүүлж, эегүй байдлаар танилцсан ч миний сониуч зан хөдлөөд түүнийг “ямархан бөө” болохыг мэдэх хүсэлдээ хөтлөгдөв.

Адилхан эмэгтэй хүн байж “Нэг нь тэнгэр гаралтай бөө болчихсон” байхад нөгөөх нь сонин сэтгүүлд элдвийн юм эрээчиж явах юм гэсэн эгшин зуурын атаархуу ч гэмээр бодол төрж билээ. Саранзаяа бөө охиныгоо сургуулиас нь авах гэж явсан нь тэр байлаа. Үнэндээ би архи дарсыг нэг их уудаг хүн биш. Эмэгтэй болж төрсөндөө энэ идээг хэт хэрэглэж, хэт хөлчихийг цээрлэх нь зүй шүү дээ. Үнэндээ түүнтэй уулзахын өмнө хэдэн найзтайгаа уулзаж шоудаад үүр цайхын алдад тэр “үйл ажиллагаагаа” зогсоож ертөнцөөс тасарсан байснаа буцаад залгагдаж, ажил амьдралын аар саарханд түүртэж явахдаа л Саранзаяатай таарсан хэрэг. Гэхдээ л би архи уусан гэж мэдэгдэхээргүй байсан юм. Бид хоёр тэдний охиныг авахаарсургууль руу нь орлоо. Багш нь охиныг нь загнаж байна. Би ч “Энэ бөө охиныг нь загнаж дэвтрээр нь дэлсээд авч байгаа тэр багшийг өршөөхгүй байх. Мэдээж охиных нь багш ч тийм амархан бууж өгөхгүй биз” гэж бодоод нэг хөөрхөн “тулаан” үзэхээр шартсан сэтгэл минь өөрийгөө мартан загатнаж байв. Хаалга онгойлгон харж байсан Саранзаяа над ру эргэж хараад ихэд сандарсан байдалтай,

- Энэ охин чинь яах гээд хичээл дээрээ онгодоо оруулаад байгаа юм бол? Багш нь түүнийг мэдэхгүй юм чинь хичээл хийсэнгүй гэж загнаж байна. Аргагүй л дээ мэдэхгүй юм чинь гэв. Төд удалгүй хичээл ч тарж, Саранзаяа багштай уулзахад багш шууд л гомдол мэдүүлж гарав. Охин нь хичээл дээр сууж байгаад ам хамраа мурийлгаж, толгойгоо тонгочуулан хөдөлгөж, нүдэнд нь өөр юм үзэгдэж байгаа юм шиг хажуу хавийнхаа юмыг анзаарахгүй болжээ.

Багш ч шууд очиж загнасан гэдгээ хэлж байна. Тэгсэн чинь охин миний гар хөдлөхгүй байна. Хичээлээ бичих гэхээр болохгүй юм гэсэн гэнэ. Уг нь Саранзаяа охиныхоо багшид түүнийг бөөгийн увидастай төрсөн надаас ч том бөө гэж өмнө нь хэлсэн байжээ. Гэхдээ багш тэсэлгүй энэ удаад “Та нарын бөө энэ тэр чинь энд хамаагүй. Энэ ангид чи яах гэж ирсэн юм. Хичээлээ хий битгий залхуураад бай” гэж мөр рүү нь дэвтрээр пис буулгаад авсан байв.

Саранзаяа инээж байв. Тэгснээ “Танай ангид далдын увидастай гурван хүүхэд байна. Сая гадагш гардаг дэлдгэр шар хүү бол увидастай юм. Аав, ээж нь түүнийг мэддэггүй л юм байх” гэв. Саранзаяа охиндоо хичээл дээрээ онгодоо оруулжболохгүй гэж захьсан гэнэ. Онгод нь яагаад ордог вэ гэхээр түүнтэй жил өдөр, ад од нь таарахгүй хүүхэд толгой тэргүүнд нь гар хүрэхээр сахиус нь уурладаг. Тэгээд л сонин байдал гаргадаг бололтой. Багш ч Саранзаяагийн хуучин танил тул түүний амыг дагуулан Баярцэцэгт дахин гар хүрэхгүй “Аюултай юм байна” гэж инээснээр салж авахын түүс болж байв. Саранзаяа үнэхээр яриа нэгэн аж. Бид хоёр тэдний гэрт очвол хойморт нь олон янзын хэлбэр дүрстэй онгон сахиус, бөөгийн хэрэглэл

зэрэг хар зүгийн хар бараан ертөнц дүүрчээ. Бөө бүсгүй Саранзаяатай хэдэн хором ярилцаж билээ.

- Бөө болох талаар хэдийнээс бодож эхлэв?

- Бөө болно гэж боддоггүй юм. Би чинь Өгөөмөр гэж говийн намхан хайрханы урдтай төрсөн. Аав, ээж минь малчин хүмүүс. Намайг сургууль номд сургах гэж бүх талаар нь хангаад үгээ хэлцгээсэн. Бараг найман жил суугаад би бичиг тайлагдаагүй. Зүүдэнд минь хааяа урт цагаан үстэй өвгөн хүн орж ирнэ. Тэр өдрөө би аав, ээж ах, эгч нарыгаа хүртэл танихгүй. Бүгдээрээ л миний хүүхдүүд шиг санагддаг. Хүмүүс намайг “өөрийгөө хараач ээ. Зуу хүрсэн өвгөн шиг явж сууж, ярьж хэлж байгааг нь ээ” гэж ирээд л шүүмжилнэ. Би өдий гуч хүртлээ уруулаа будаж, нүүрэндээ пудр тавьж үзээгүй. Төрөлх арьсаараа яваа гэх үү. Нийгэм дотор амьдарч яваа залуу, тэгээд эмэгтэй хүн байна гоо сайхандаа анхаарах гэж бодолгүй яахав. Гэсэн ч өнөөх буурал өвгөн зүүдэнд ирж намайг төрснөөрөө байхгүй бол “уг”-аа буцааж ав гэж айлгадаг. Жирийн шашны ойлголтоор бол сүнсээ эргүүлж авна гэсэн үг юм даа. Чамайг үхүүлнэ гэж заналхийлж байна гэж болно.

- Нөхөртэйгээ хэзээ суусан бэ? Өөрийг чинь хэдэн зуун жилийн өмнө амьдарч байсан өвгөн бөөгийн “уг” гэдгийг мэдэх үү?

- Миний “уг” бөө бол миний дүр төрхөнд хувилж ирэхээсээ өмнө нэг удаа төрөх гэж оролдсон юм билээ. Тэр үед халх Ойрадын зөрчил гэдэг нь болж байсан гэж надад мэдрэгддэг. Нэг ийм байдал харагдаад байна гэж түүх мэддэг хүнээс асуухад Тогоон тайшийн үе юм уу даа гэж байсан. Тийм нэг сэлэм жад, нум сум болсон дүр зураг л надад харагдаад байдаг юм.

- Чи ч яахав. “Уг”-тай бөө юм байна. Охин чинь бас яахлаараа бөө байдаг юм. Арай чи бөөгөөр занимаалдах гэсэндээ охиндоо хүртэл онгод сахиус уяж өгөөд байгаа юм биш биз дээ?

- Манай Баярцэцэг чинь надаас эртнийх. Язгуурын бөөгийн уг байгаа юм. Заримдаа би мартчихаад загнана. Тэгэхэд нүд ам нь гялалзаад хилэгнэж гарна шүү. Буцаж түүнийг аргадаж “та та” гэж байж уур хилэнг дарж авна шүү дээ.

- Бөө гэдэг юм уу таны хэлж байгаагаар төрөлхийн увидастай хүмүүс Монголд олон байдаг уу?

- Зөндөө бий. Харин өөрийгөө нээж таньж чаддаггүй. Би ч гэсэн Улаанбаатарт ирээд нөгөө л хачин зүүд совиндоо гайхаж бариад явж байсан. Азаар багштайгаа таарсан. Манай багш Пүрэвдоной гэж хүн бий. Завхан аймгийн харьяат. Тэр аль эрт арван хэдэн жилийн өмнө “Уг”-аа олж авсан хүн. Харин би дөнгөж энэ намар л “уг”-аа авч байгаа байхгүй юу.

- “Уг”-аа авахаар яадаг юм бэ?

- Нэг бодлын бөөлөх эрхээ үе үеийн бөөгийн тэнгэрүүдээс авч байна гэсэн үг. Бусад бөө нартаа гадуурхагдаж дарамтлуулахгүй болж байна гэсэн ухаантай юм шүү дээ.

-”Уг”-аа авахад юу хэрэгтэй байдаг юм?

- Маш их бэлтгэнэ. Хэнгэрэг дохиур, бөөгийн хувцас хунар, ташуур гээд л бүх зүйлийг өөрийн сэтгэл зүрхээрээ бүтээж бий болгодог. Би “Уг”-аа авахдаа алдаа гаргаж балрах шахсан. Манай нэг дүү хөдөөнөөс ирэхээр нь бөөгийн ташуур хийлгэж авсан. Хүнээр эд хэрэглэлээ хийлгэж авч болно л доо. Гэхдээ би үнийг нь өгөөгүй байгаа юм. Тэгээд л “уг” авах ёслол дээр зөвшөөрөгдөхгүй эрх хүлээгдсэн дээ.

- Бусад бөө нарын талаар юу хэлэх вэ?

- Дархадын бөө бол “уг” нь тасраагүй яваа. Манай баруун аймгаас гарч буй бөө нар бол олон зуун жилийн өмнөөс “уг” нь тасарсан. Монгол улс сэргэж мандах цаг болсон болохоор л ийм олноороо төрж ирж байгаа юм. Манайхан буриадуудтай таарч тохирдоггүй. Аргагүй шүү дээ эзэн Богд Чингис хааны онгон дээр өөрт нь огт хамааралгүй хүмүүс ирээд өөрсдийгөө түүний удам судар гэж зарлаад зальдаад байгаа юм чинь.

## **Хамбын овооны ламын чөмгөөр ганлин хийгээд шийтгүүлсэн нь**

Ад зэтгэрийн хорлолд өртсөн хүнийг жирийн хүн ч хараад таньж болдог гэнэ. Ааш зан, амьдралын хэвшил нь өөрчлөгдөнө. Сонин байдлаар инээмсэглэж, учир зүггүй хөөрч догдлоод байх нь ч бий гэнэ. Ер нь хорлолыг хүлээж авах бүх нөхцөл нь бүрдсэн хүнд л ад зэтгэрийн хорлол хүрдэг гэж бурхны ном, засалд тэмдэглэсэн байдаг аж.

Одоо цагт амар хялбар амьдрахын тулд мэргэн төлгөн болж зүсээ хувилган, олон сүсэгтнийг мунхруулан залилагчид жинхэнэ мэддэг чаддагаасаа тун ч олон болсон гэж болно. Ийм шунахай сэтгэлээсээ болж ад зэтгэрийн хорлолд өртсөн хуурамч ламын явдлыг уншигч танаа хүргэе. Баян-Очир хэзээ ч улс нийгэмд ажиллаж, хамт олны халуун дулаан уур амьсгал дунд байж үзээгүй билээ. Хотод орж ирээд аанай л ажилгүй, амар хялбар амьдрах арга зам юу байна гэж хий дэмий л бодож, гудамж хэмжигч хийн гутлаа элээж явав.

Гэтэл Сүхбаатарын талбайн урд хэдэн чулуу, зоос, шоо тэргүүтнийг тавьчихсан хүмүүс сууж байх юм. Зарим хэрэгт дуртай нөхдүүд очиж цөөн төгрөг өгөөд ажил үйлсээ бүтэх эсэх, хувь заяа хэрхэх зэргийг үзүүлдэг нь түүний нүдэнд боломж болж харагджээ. Мань Баян-Очир нэг л өдөр том цүнхтэй мөнгө өөрийг нь хүлээгээд зам дээр хэвтэж байх юм гэж боддог байсан болохоор “араб ардын үлгэр”-т гардаг шиг гэнэт баяжих замаа ингэж олжээ.

Тэр өмнө нь ид шидийн хүчээр ад зэтгэрийн хорлолыгдарах эрдэм чадалтай хүн болж ад зэтгэрийн аймшигт бэлгэ тэмдэг болсон, хохимдог толгой, гавлын ясан аяга, арван найман настай хир халдаагүй бүсгүй хүний дунд чөмөгний ясаар хийсэн ганлин бүрээ гээд л айдас хүйдэс хургам эд зүйлсийг хэрэглэдэг гэж сонссон байлаа. Энэ бүхнийг цуглуулж хувилгаан болох нь түүнд хамгийн тохиромжтой санагджээ. Бодож олсон зүйлээ тэр “оюуны өмч” хэмээн үзэж бусадтай хуваалцах буюу патентаа хулгайлуулах вий гэхээс болгоомжилж байв.

Гэтэл нэг удаа Хамбын овооны тэндээс түүний хайж байсан зүйл болох гавлын яс, хохимой толгой, дунд чөмөг гээд л хүний шарил олноороо гарч иржээ. Энэ тухай өдөр тутмын болон бусад сонин хэвлэлээр хэлмэгдсэн лам нарыг хоморголон устгасны баримт хэмээн шуугиж байв. Баян-Очир хүн амьтны хөл татарсан нэгэн өдөр хамбын овооны хайрга, шавар гаргадаг газар очиход түүний “ламын хэрэгслүүд” ёстой ёоз ёозоороо байж байв. Эхлээд гарт таарсныг нь барьж авч байснаа тэр сүүлдээ сонголт хийж хэлбэр хэмжээ, элс шороонд идэгдэж эвдэрч хэмхрээгүй, өнгө чанар сайтайг нь шилж сонгож билээ. Түүний дотор нэгэн жижгэвтэр чөмөг байсан бөгөөд золбин нохойтой булаацалдаж байж авчээ.

Тэгээд хэн нэгэн гарын дүйтэй хүний зөвлөснөөр газрын хөрсөнд олон жил дарагдсан тэр ясыг зэнхэртэй хорт усанд дүрж хонуулаад зусан цавуугаар будаж, хатаалга сайтай, бат бөх чанар суулгав. Чөмөгний толгойг нүхэлж, засч зүлгээд л догшид хутагтуудын хэрэглэдэг байсан ганлин бүрээг бий болгожээ. Магадгүй тэр чөмөгний эзэн байгаад хэлмэгдсэн лам арван наймтай байгаагүй юм гэхэд нас залуу, бие баганэгэн байсан нь гарцаагүй аж. Ийнхүү хувьсгалын эсэргүү хэргээр буудуулсан ламын дунд чөмгөөр өөрийн хэрэглэлийг бүрдүүлсэн шинэ цагийн лам Баян-Очир зурхай, сүнс судлалаар нэг л өдөр цоорох нь тэр. Зурхай, сүнс судлалын академийн гишүүн гэсэн нэгэн өргөмжлөлийг танил өвгөнөөсөө худалдаж аваад улаан, шар цагаан хадгаар давхар хүрээлэн гэрийнхээ хойморт байрлуулсан нь сүсэгтэн

олныг улам бишрүүлнэ. Зарим нэг сонинд хүртэл ярилцлага өгч тэрхүү шинэ амьдралдаа дасаад зогссонгүй, маанийн үсэг ч мэдэхгүй маанаг нэгэн гэдгээ огт мартаж ид шид бүрдсэн гэж өөртөө итгэж эхэлжээ. Өөрт нь үзүүлэх гэж ирсэн хүмүүсийн нүүр царайг харж байгаад санаанд орсон зүйлээ хэлчихнэ. Хувь тавилангаа үзүүлсэн хүнийх нь мэргэ нь заримдаа ойролцоо тусдаг ч биз. Зарим нь гайхаж “Тийм юм ёстой байхгүй дээ” гэнэ. “Миний зурхайд л тэгэж бууж байна. Тэгвэл би мэдэхгүй байгаа юм байлгүй” гээд гэдийчихнэ. Нүүрнийхээ хамаг арьсыг чинэрүүлэн, Налайхын нүүрс дүүртэл чихсэн нимгэн төмөр зуух шиг час улаан болоод ирэхийн үед мөнөөх сүсэгтэн ч,

- Нээрээ, нэг тийм юм тохиолдсон юм байна гэж дорой дуугаар өгүүлнэ. Баян-Очир нүдээ аньж мөнөөх сүсэгтнийхээ юу хэлэхийг сонсоогүй юм шиг “ертөнцөөс тасран” сууж байгаад,

- Тийм байгаа биз. Чи өөрөө ойлгоо биз гэж гэнэт сэрсэн юм шиг өгүүлнэ. Энэ үед сүсэгтэн юу ч ойлгоогүй мөртлөө “тийм” гэж толгой дохино. Юу ойлгуулах гэснээ ч мэдэхгүй мөртлөө Баян-Очирын нимгэн шар царайд гэгээ тусаад “тэгнээ тэр” гэж залирхаг бөгөөд ялан дийлсэн байдлаар инээмсэглэдэгбүлгээ. Шинэ хувилгаан Баян-Очирын ид шид гэгч нь энэ л дээ. Гэтэл түүнд жинхэнэ ид шидтэй зүйл тохиолджээ. Яасан бэ гэвэл эрхэм ламтан Толгойтоос Улиастайд залагдан очиж нэгэн зовлонд учирсан айлын гай барцад, ад зэтгэрийг хөөж хөөж ядраад, бас дээр нь зориг орох гэхдээ шүлстэйгээ хольж арвижуулаад уусан нэг шил архи нь толгойд нь гарч унтаад өгсөн байна. Тэгсэн чинь эрхэм ламын номын авшигт хүрэн улаан цүнх нь “амаараа” бөөлжөөд хамаг ламынх нь хэрэгслийг асгаад хаячихаж.

Баян-Очир өмнө нь баахан дүвчигнэж эхлээд чөмгөн бүрээ, гавлын яс, хонх дамар, дараа нь хүрэн модон аягаа хийж “Юм бүхэн эрэмбэ зохицолтой байдаг юм” гэж хоолойнхоо гүнээс сүжиглэнгүй хэлж байсан аж.

Гэтэл өөрийн гараар ариусгаж савласан эд хогшил нь “эрэмбэ зохицлоо” алдсанаар барахгүй амь орсон юм шиг асгарч цутгаад болсонгүй. Гэрт байсан хүмүүс гайхаж,

- Ламыг сэрээ. Энэ үнэхээр ид шидтэй хүн байна. Бидний гай барцад арилаагүйгээс энэ хувилгаан хүний сахиус багаж зэмсгийг нь буцаан асгав гээд түүнийг сэрээж, нэмж өргөл барьц өгөөд л шүтэхийн дээдээр шүтэж байв. Нүд нь улайж, архи нь сайн гараагүй Баян-Очир хувилгаан өндийгөөд,

- Юу болов? хэмээн зандарчээ. Хүмүүс ч болсон явдлыг хэлсэнд,

- За яасан, сүрхий чөтгөр гээч нь ийм байдаг байна гэж цээжээ хөдөлгөн босч суугаад ном заслын шинэ үзүүлбэр хийжээ. “Арван найман настай, хүнтэй хавьтаж бузартаагүй эмэгтэй хүний хөлний дунд чөмөг” гэж мөнөөх ганлингаацоллоод авч үлээх гэж амандаа барьтал тэр нүхэлсэн чөмөгний яс эрхэм ламтны ам руу өшиглөх байдлаар хэдэнтээ гударчээ.

Баян-Очир лам ч заль мэхтэй боловч цусанд төрсөн, усанд уярсан хүн болохоор айжээ.

- Сахиус намайг боль гэж байна гэснээ нэг хэсэг ноорхой цаас гарган их л чухал юм харснаа,

- Гурав хоногийн дараа ирье. Тэгэхэд энэ чөтгөрийн хүч тэнхээ сульдсан байх вий гээд такси

дуудуулаад ум хумгүй явжээ. Зовлонд учирсан айлынхан ч айж эмээн саяхан талийгаач болсон эрхэм хүндээ харамсах бус өширхөх сэтгэлтэй болжээ. “Үхэж чадахгүй, муу хүн байж дээ” гэж хэн нэгэн нь хэлснийг бүгдээрээ толгой дохин зөвшөөрсөн байна.

Баян-Очир гэртээ ирээд номын цүнхээ хоймортоо тавихад тэр нь амьд амьтан амьсгалж байгаа юм шиг бялхалзан хүлхэлзэн хөдөлж байв. Лам болсон болохоор ойр ойрхон мулз хусуулдаг халзан хуйхных нь арьс халуу оргиж, айдас хүйдэс арван зүгээс түүнийг ширтэн байх шиг санагджээ. Гэтэл цүнхний шар даалимбан үдээс тас тас үсрээд мөнөөх дунд чөмөг хамаг багаж зэмсгийг нь асгаж орхив. Чөтгөр дарна гэсэн биш чөтгөрийн чөмөг үүрч явдаг болсноо Баян-Очир тэрхэн зуурт ойлгожээ. Ямар нэгэн эрдэмтэй лам дээр очье гэсэн ч чадахгүй, зүрх хүрэхгүй байв. Учир нь тэр “Гандангийн лам нар гэж худалч, хуурамч новшнууд байдаг юм. Би бол жинхэнэ хувилгаан хүн байгаа юм” гэж нэг биш удаа цээжээ дэлдэж байсан билээ.

Тэгээд ч түүнд яваад оччихоор итгэлтэй лам байсангүй.

Нойр нь хүрсэнгүй. Мөнөөх чөмгөн бүрээ гэр дотуур нь тош тош гэтэл шал дуугарган гүйж явах юм гэнэ. Ухасхийн хөргөгчнөөс нэг шил архи гаргаад бэрхшээл зовлонгоо мартахын тулд залгилж орхив. Чөтгөрөөс байтугай юунаас ч айхгүй хүч чадал түүнд бүрэлджээ. Гадаа нь түүнд үзүүлэх гэсэн хүмүүс хоорондоо ярилцаж, зарим нь цонхны цаанаас харж байв. Баян-Очир “ламтан”:

- Би бууж өгөхгүй ээ. Дахин дахин архи залгилсаар тэр ухаан алдан ойчжээ. Толгойг нь ямар нэгэн юмаар тонших шиг болоход тэр сэргэж, нэг нүдээрээ сэм харвал халзан толгойг нь мөнөөх чөмөг нүдэж байв. Толгойд нь нэгэн бодол гялсхийн ороход ухасхийн босвол торгон шар өмдөө нэвтэртэл өмдөндөө чацга алдчихсан байжээ. Хувилгаан лам биш өвгөнтийн архичнаас л олж үнэртэж болох тийм үнэр биенд нь шингэжээ. Баян-Очир,

- Зодов гуайд л очье гэж шивнэн биеэ угааж, хувцаа солиод гэрээсээ гарчээ. Зодов гэдэг нь тийм сүрхий лам ч биш. Уул хадаар зуны цагт тэнэж, өвс ургамлын үндэс түүж явдаг хоббитой нэгэн билээ. Түүнийг өвгөний гэрт очиход ихэд хүндлэн,

- За, дүү хүү... Өнөөдөр ямар өдөр вэ? гэж эмгэнээсээ асуугаад сүйд болон угтжээ. Магадгүй тэр өвгөн Баян-Очирыг зүгээргүй лам байх гэж битүүхэн сүжиглэж байсан бололтой дог. Гэтэл мөнөөх аймшигтай хувилгаан нь дээр болсон хэрэг явдлыг нэгд нэгэнгүй яриад,

- Энэ чөтгөр шингэсэн чөмөгний яснаас яаж салж авахав би хэмээн түгшиж байв. Өвгөн,

- Жор мэддэггүй ламаас зовлон үзсэн чавганц дээр гэж үнэн үг байна шүү гээд түүнд хэлсэн нь:

- Хүн болгон лам хувраг, хутагт хувилгаан болж сахиус зүүж сахилгагүйтэж явдаг нь буруу. Ядахдаа ертөнцийн мөн чанарыг амьдралын хар ухаанаар таньж байж хүн амьтны сэтгэл санаанд халдаж, ид шид ийм тийм юмаа ярих хэрэгтэй. Энэ байдлаараа чи адын хорлолоос болж галзуурна” гэжээ. Хоёр жил шахам гэнэн тэнэг хүмүүсээс мэхэлж авсан эд хөрөнгөө бүгдийг нь өгөхөөр амлаж Баян-Очир Зодов гуайгаас аврал хүсчээ. Өвгөн оочны хэдэн цагаан



сахлыг илбэн инээмсэглэж,

- Би тийм сүрхий номтой судартай хүн биш шүү дээ. Гэхдээ өөртөө таарсан хэдэн тарни мэднэ гэжээ. Өвгөний хэлснээр бол ад зэтгэрийн хорлол тусвал чадахгүй зүйлийг чадах мэт бодогдоно гэнэ. Бие сэтгэл хямарна. Санах, сэрэх нь дорой болох бөгөөд ухаан санаа мансуурах шинж илэрнэ. Ялангуяа галзуугийн ад ядам хурууны судал дотроос зүрхний судалд шилжин орвол галзуурна. Мамын хорлол бол муухай дуугарна, айна. Зорилгогүй юм шиг мишээвэл хараалын гэм учиргүй баясч инээвэл тийрэнгийн хорлол гэх аж. Хутганы ишнээс бөгжийг авч тарнидан ядам хуруунд зүүлгэнэ. Манжин, лууван, уульны мах, болжморын толгой, тотины зүрхтэй найруулж уулгахад ямар ч адын галзууг дарна. Довчиндагвадорж хэмээн алдаршсан утлага үйлдэж “Ум аа хум базар гүрү бадма сида хум” тарнийг 21 тоолох хэрэгтэй гэнэ.

Тэгээд эцэст Дамдин Чойжоогийн гүрэм хийж ширнэн уншсанаар адыг бие сэтгэлээс гаргаж цэвэрлэх боломжтой байна. Өвгөний хэлж ярьсан зүйл хамгийн энгийн ойлгомжтой бөгөөд Баян-Очир “ламд” дэндүү хялбар санагдаж байжээ. Гэхдээ Зодов гуай дээрх ярианыхаа дагуу заслыг хийснээр чөмгөн бүрээний хэрүүл арилж сэтгэл нь амгаланшжээ. Чөмөгний ясыг авсан газраа аваачиж үдэш шөнийн зааг үеэр тавьснаар шинэ цагийн лам Баян-Очирын ид чадал нь үгүй болж, жанчаа тайлж, ажилгүйчүүдийн армидаа эсэн мэнд эргэж ирсэн аж.

## **Хэвлий дотроо үхээд, өмхийрчихсэн хүүхдийг хувьсгалын эсэргүү оточ огтлон авч байжээ**

Хаврын урь орж, цасан дороос яргуй хэнзэлсэн шаргал өдрийн нар залхуутайяа ээж хүн амьтан нозоорсон энэ өдөр Балигай бариач хэд хоног бүтсэн уулын агуйнаас гарч гэрийн зүг гэлдэрч явав. Сүм хийдэд сууж амны жаахан уншлагатай болсноос биш төрөлхийн авьяастай, удам дамжсан оточ тэрбээр цаг үеийнхээ өнгө шуургыг даган лам нэр зүүснээс дөрвөн зүг, найман зовхисоос хөврөн ирэх хүн зон Балигай оточ гэхээс бус шар, улааныг намируулсан байсан ч “Ламтаан” гэж дуудсан нь нэгэн удаа ч үгүй. Ардын засаг мандаад олон бүгдээр даган баясахад Ма вангийн цэргийн хүрээнд залран өвдсөн, хавдсан, шархдаж гэмтсэн цэрэг дайчдыг эмнэж явсныг нутаг нугынхан мэдэх билээ. Өнгөрсөн жил эхэлсэн их баривчилгааны үеэр сум, хошууны төлөөлөгчөөр ирсэн Цэгмэд гэгч хамисаарын хэлэх нь “Таныг том толгой лам хэмээн баривчил гэсэн нэрийн жагсаалт дотор байсныг арайхийн хасч аргалав. Ардын хувьсгалд туслаж байсан эмч хүн гэж орос зөвлөхийн амыг түр хаалаа. Энэ төрийн цөлх нэг биш болсон шүү. Цаашдаа та бодолтой яваарай. Дахиад би ирээ ч үү, үгүй ч үү. Цагийн байдал олны омгийг ажиж амьд гарах хэрэгтэй” гэсэн үгийг байнга санаж явтал зүүн аймгаас ирсэн гэсэн нэг банди ногоон малгайгаа духдуулан, нагаан буугаа бүсэндээ хавчуулан нэг л өдөр ороод иржээ.

Зүс шаргал, самсаа хянга, нүд онигор энэ хүү урьд нь хэд хэдэн удаа ирж эм тан залж байсан тул Балигай элдвийг бодолгүй дээш суу хэмээн урив. Халх аялгатай боловч нилээд сунжруулан дуудах яриагаар нь буриад хүн болох нь мэдэгдэх бөгөөд тэр холын зүүн зүгээс энэ хүртэл явж ирсэнийг бодвол бас зүгээргүй эрийн хугархай гэдэг нь бололтой хэмээн оточийг бодож суутал төлөөлөгч хархүү “Балигай гуай. Миний эхнэр хүүхэдтэй болоод дөрөв таван сар болсон боловч гэнэт хөдлөхөө больчихоод долоо найм хонов. Та нэг үзээд өгнө үү хэмээхэд “Үгүй хүүхээ, чи дагуулж ирсэн юм уу? Оруулахгүй юугаа хийж байгаа юм” гэж оточыг хэлэхүйеэ төлөөлөгч ухасхийн гарч одов.

Удалгүй тулгар биетэй бүсгүйг дагуулан орж ирж гэрийн зүүн талаар суув. Балигай оточ энэ нас хүртлээ эхнэр аваагүй гоонь хүн бөгөөд гэр орон, хоол хошны зүйлийг Танжид чавганц хийсээр насыг барж яваа билээ. Айлчин гийчин, өвчтөн зовлонтон хэнбугай ирсэн ч эмгэний гуулин домбо цайгаар дүүрэн, модон тэвш боов боорцгоор дүүрэн угтдаг нь гэм биш зан. “Эвий минь! Тулгар биетэй амьтныг сумын төвөөс энэ хол газар мориор авч ирнэ гэнэ ээ. Яасан арилсан дотортой амьтан вэ, чи” хэмээн эмгэн үглэнгээ цай аягалав. Хүүхний судсыг барьж үзсэн оточ нилээд бодлогширон сууснаа “За хүүхээ, хүүхдийн чинь хүй хүзүү хоолойг нь ороогоод амьсгал түгжирч хүн болох нь нэгэнт өнгөрч. Одоо харин эхийг нь яасхийгээд амьд авч үлдэх вэ гэдэг шалтгаан байна. Хажуу гэрийг галлаж, цэвэрлэ. Ингэсхийгээд бүсгүйг оруулж амраа. Чи надад туслахгүй бол би ганцаараа амжихгүй” гэж төлөөлөгч залууд хэлбэл “Би хичээ” гэснээс өөрийг өгүүлсэнгүй. Цэмбийтэл цэвэрлэж, гал өрдсөн гэрт бүсгүйг модон орон дээр хэвтүүлэн нэгэн зүйлийн өвс үнэрлүүлбэл бөх гэгч унтаж орхив.

Балигай оточ цагаан даавуунд боодолтой зүйлийг задласан нь чулуун хутга, зэс хавчаар, ясан зүү, хямсаа, мана, чүнчигноров гэх мэт үнэт чулуугаар хийсэн иржгэр, сэрзгэр, иртэй иргүй, хурц шовх олон багаж байхыг үзсэн төлөөлөгч ихэд гайхан “Та огтолж зүсэх гэж байгаа юм

уу” гэхэд Балигай оточ царай барайлган “Хүүхэд нь үхээд өмхийрчихсэн байна. Хэвлий дотор нь эвдэж авахаас өөр арга үгүй. Тулгар эмэгтэй хүн ийм үед өөрийнхөөрөө гаргачихна гэм номонд хазгай. Чи наад гараа сайн угаагаад миний хэлсэн багаж зэмсэгийг дөхүүлж өг. Цаг алдвал бүсгүйн чинь амь нас дээсэн дөрөөн дээр болох нь хэмээн зандрав. Бүсгүйн бэлхүүснээс доош биеийг угааж ариутгаад хоёр хөлийг алцайлган ханын хэцнээс уяж Балигай оточ ажилдаа оров.

Байсхийгээд зэс түмпэнд пял пял хийлгэн ямарваа нэгэн юмыг хаях бөгөөд тэрхүү зүйлийг үзье гэх зориг төлөөлөгч залууд байсангүй. Бонжигнотол урсах хөлсөө шувтран энэ хутга, тэр хямсаа, хайч тэргүүтнийг авч өгөн бэмбэгнэнэ. Цаг гаруй болсоны дараа Балигай оточ нэгэн төрлийн өвс ургамлын хандаар хүүхний доод биеийг угааж ариутгаад хэвлийг базлан засч биеийг зөв мөр хэвтүүлэн ухаан оруулав. Хүүхэн өвдсөндөө үрчийх боловч амьд мэнд байгаадаа баярлан инээлхийлэв. Өвчтөнийг Тамжид чавганцын асрамжинд орхиод гэрт орсоны дараа Балигай оточ олбогон дээрээ сөхөр тусан сууж “Би 10-д жилийн өмнө нэг ийм ажил хийсэнсэн. Их ховор байдаг юм. Удсан бол хүү ч үгүй, хүүхэн ч үгүй болох байж. Хэд хоногтоо эндээ байж тэнхрэг. Чи ажил төрлөө бод. Цаад чавганц чинь асарч тойглоод өгнө. Одоо санаа зоволтгүй” гэхэд төлөөлөгч хархүү ихэд баярлан гарч одов.

Түүнээс хойш гурав хоносны дараах шөнө нэгэн морьтон ирсэн нь төлөөлөгч залуу байсан бөгөөд эхнэртэйгээ баахан ярьж байснаа оточийн гэрт орж ирэв. Түүний царай хүн алсан мэт барайжээ. Зэлгээн цайнаас хэд балгасан тэрбээр ихэд санаа зовсон янзтай. “Балигай гуай. Төвөөс төлөөлөгч ирж лам хуврагуудыг баривчлан Ховдын төв рүү ачих гэж байна. Нэрийн жагсаалтад таны нэр ч байна. Та 10-аад хоногтоо гэртээ ирж болохгүй. Алтай тийш явсан гэсэн цуу тараахаа би мэдэе. Манай хүүхэн гайгүй сайн тэнхэрчээ. Аваад явья гэсэн чинь Тамжид чавганц тас загнаж байна гэхэд оточийн сэтгэлд улаан хядлагаас өөрийг нь авраад байгаа дээд тэнгэртээ залбирч үнэн сүжиг төрөн наминчлаад,

- За, хүүхээ. Би арав битгий хэл сар орчим уул хадаар явж эм тангийн юм түүж яваад ирье. Тус болсонд гялайлаа хэмээвээ. Түүнээс хойш хээрээр гэр, хэцээр дэр хийн явсаар өдгөө цаг дор төлөгдөн үзвээс аюул нэгэнт зайлсан байх тул гэрийн зүг алхаж яваа ажгуу. Балигай оточ гэртээ ирвэл Тамжид чавганц нэгэнт бурхан болоод харин төлөөлөгч хархүүгийн хүүхэн гэр орныг нь сахиад сууж байв. Нөхөр нь тэр шөнөөс хойш дахиж ирээгүй бөгөөд төвийн төлөөлөгчийг даган аймаг орж улмаар хүрээний зүг одсон сураг гарчээ. Энэ явдлаас хойш гурван жил өнгөрсөн ч нөхөр нь ирээгүй ба өөр зуураа ижил дасал болсон эр, эм хоёр сэтгэл нийлэн нэгэн өрх гэр болон суувай. Балигай оточ нутаг буурьт сэлгэлгүй тэр л голдоо насыг элтэл амьдарч найман хүүхдийн эх болсон буриад самганыхаа гарын цайг уусаар таалал төгссөн билээ.

## **Бөөгийн адууг хөөгөөд хөлийнхөө хурууг тасаргал хараалгав**

1930 оны намрын сар ид дундаа орж, өвсний өнгө шарлан айлууд намаржаандаа буусан үе байлаа. Үйзэн бээл Ландиажүгнээ ноёны хошууны үе дамнан суусан эгэл ард хөвүүн Жамъянгийнхан хуримыг хийж буй билэгт өдөр хуран чуулсан түмэн дуу хуур өргөн, архи дарсны хүч ид оргилдоо гарч найрын өнгө домогт Тэс голын хөнгөн урсгалыг сүлэн сэтгэлийн гунигийг сарниулах аж.

Ирсэн гийчид бэлэг шүлэг барьж хоёр хүүхдэд сайн сайхныг ерөөн ахуйд шинэ бэрийн ах Сэгсэлдэй хэмээх эр хуучин ч гэлээ цэвэрхэн дээлийнхээ захыг засан босч, хурц хар нүдээр зочдыг гүйлгэн харснаа хүнгэнэсэн дуугаар:

- Хоёр хүүхдийн ажил төрөл, ахуй амьдрал дэлгэрч дээшлэн, үр хүүхэд үрээ малаар арвин болог! Та нартаа өмч болгож дагад ижилтэй хүрэн азаргатай арван гурван тооны адууг өгсү гэхэд хүмүүс ам амандаа шивнэлдэн гайхаж:

- Унах унаагүй тийм хөрөнгө бий билээ хэмээн дооглох үгийг унагацгааж байв. Тэр өдрөөс хойш өдөр сар өнгөрсөөр хаврын урь орон Тэс нутгийн сайхан байгаль өнгө зүс орж, шар усанд гүйсэн мал ноосноосоо салж, чөмөг нь дүүрэх ахуйд гэнэт Сэгсэлдэй алга болов. Ам дамжих үгэнд тором унаж явсныг ганц нэг хүн харсан гэх боловч нотлох нь бэрх. Сэгсэлдэй алга болсноос даруй сар шахмын дараа унаж явсан гэх тором нь нутгийн захад ирснийг хэн хүнгүй үзээд арван баядын хөх Сэгсэлдэй амандаа багтах гээд амиа гээв гэсэн үгс салхиар тарлаа.

Нутаг хошуугаар ийм үг хөлхөж байхад омголон хар морины жолоог жигд татан сууж, үе үе дугтрахыг нь үл тоон салхи сэвэлзтэл исгэрэх Сэгсэлдэй эх захгүй уулнаа хоржигнох түргэн урсгалт горхийн дэргэд нар угтан хүрч морины жолоог бүүрэгт сойн хад болтол тушив.

Ойн гүнд түмэн хэлээр шулганан жиргэх шувуудын дуу их найрал түрэн авч сайхь эрийн сэтгэлийг уясгавч угаас бүдүүн баараг эр тул дээлийн ханцуйг бүсэндээ хавчуулж, хоёр том чулуун дээр гишгэж хаврын хөх усаар нүүр гараа угааж бүсний үзүүрийг тайлан арчив.

Төө гаран хаш соруултай гаансыг гутлын хоншоорт цохиж тамхи нэрээд алсын оргилыг ширтэн гүнээ бодлогширохуй тэр үе цагт дотор газраас авч ирдэг байсан хөх тамхины сайхан үнэр анхилан хамарт тааламжийг төрүүлнэ.

Нас гүйцсэн шарын арьсаар хийсэн том богцноос жижигхэн ууттай зүйлийг гаргаж, хуруугаар чимхэн хэлэн дээрээ тавьж хэсэг зуур тэнгэр ширтэн хэвтээд нүдээ анилаа.

Амандаа хийсэн тэр зүйл нь гурван жил хатаасан үхрийн борцыг ногоон цайтай холин нүдэж шар тосонд багсарсан тул хол явдлын хүн өлсөж ундаасахгүй, долоо хоногийн өл даах гайхамшигт монгол ухааны үр билээ. Шилийн эрсийн амин тэжээл авсаархан болоод амт чанар сайтай байх учиртай.

Тэндээс хөдлөн хөнгөн явдалт морины алхаагаар уулын онь дээр гарч ирэхэд цэлийсэн тал

дунд ганц гэр торойно. Тэр гэрийн гадна ирж буухад биерхүү хижээл авгай тоссон бөгөөд мэнд усыг мэдэлцэж, биесийг шинжин үзээд хэн хэний байдал төрх, үг ярианаас шил хөөж амьдрагсад гэдгээ тааварлалцаад цай, хоол унд болох зуур энэ тэр элдэв дээдийг хөөрөлдлөө.

Шингэх нарны хурц туяа унийн сагалдрагад унах үед морио аргамжих өвс сайтай газрыг асуувал:

- Тэр цагаан хадаар тагласан агуй руу сул оруул гэснээр очвол хөдөлгөх аргагүй том хад учир түүний дээгүүр харайлган орж морио сул тавилаа.

Хаврын шөнө богино тул яах ийхийн зуургүй үүр цайж босоцгоон агуй руу очвол авгай:

- Хадыг зайлуул гэв. Уг хадыг зайлуулах нь бүү хэл хөдөлгөж чадаагүйгээ хэлбэл авгай мөрлөн түлхэж зайлуулаад дотогш орцгооход эх захгүй их адуу багширч байлаа.

Түүнээс ижил нас зүсний арван гурван даагыг барин авч хоёул хамтаар туугаад тасралтгүй өдөр, шөнө долоо хоног явахад аяны уртад ядарсан Сэгсэлдэй морин дээрээ унтахад авгай ташуурдан сэрээж “Хэд хоногийн явдал даахгүй чамайг ямар эр гэх вэ?” гээд хөхөрч байв. Ийн явсаар зам замаа хөөх болж хоёр тийш одоходоо анд ёсны үгийг солилцон салсан билээ.

Сэгсэлдэй уг адууг дүүдээ авч ирж өгөөд нэг удалгүй тагнын уулыг зорин одов. Замд байх нэгэн гэрт орвол жар хол давсан эмгэн ганцаар тул мэнд ус солилцвол:

- Чи илүү юм харж яваа эр бололтой. Хойно байгаа гурван шаргатай адуунд гар хүрч болохгүй гэж хэлээд цай хоолоор дайлав.

Хоол унд идэж уугаад мордвол үнэхээр эмгэний хэлсэн адуутай таарч зураг шиг хэдэн морьдыг хараад тэсэлгүй хөөв.

Гэнэт их хар үүл гарч газар тэнгэр нүргэлэн цахилаад хүйтэн зад исгэрлээ. Тэгсэн хэдий ч морьдыг хөөн одов. Энэ явдлаар Сэгсэлдэйн баруун хөлийн чигчий хуруу тасарч гээгдсэн гэдэг.

Жилийн дараа Сэгсэлдэй нөгөө айлд буухад эмгэн:

- Би чамайг бүү ав! гэсэн малыг юунд хөөв, чи гэхэд нь

- Би аваагүй хэмээн гүрийвэл,

- Чи баруун гутлаа тайл, чигчий хуруу чинь энэ гэж чигчийг нь үзүүлснээр эмгэнд сөгдөж мөргөн үгийг нь сонсвол есөн үеийн удган байсан гэдэг. Тухайн цагт удганы уур хөдлөж хамаг онгодоо залан дуудаж Сэгсэлдэйтэй тэмцсэн боловч Сэгсэлдэйг харын зүгийн тэнгэрс хамгаалаад дийлдээгүй гэдэг. Эмгэн удган Сэгсэлдэйг буцахад нэг морь бэлэглээд үдсэн гэж нутгийн хөгшчүүл ярьсныг буулгав.

## “Толгойгоо шаах цаг ирнэ дээ” гэж хараагаад хэлсэндээ хүрчээ

Энэ явдал далаад оны үед болсон бөгөөд ногоон Ойдов хэмээх тэрхүү мэргэн түргэн хүний тухай Баянхонгорынхон одоо ч дурсан ярьцгаадаг бөлгөө.

Орон нутагтаа хулгайч Лутаа гэж алдаршсан нэгэн саваагүй эр хошуу алгасан адуу хөөх бодол өвөрлөн аян замынхаа өлзий мөрийг асуухаар шивээн дэрс бөхөгнөсөн намрын нэгэн орой мэргэн түргэн Ойдовынд дөрөө мулталжээ.

Сайхь эрийг хэрэг зориг, хэтийн явдлаа ярьж эхлэхэд нь ногоон Ойдов чимээгүй нилээд чагнаж сууснаа гэнэт дүрсхийтэл уурлаж ... Чи яахлаараа дандаа амьтан ах, дүү олон түмэнд муу санаж, хулгай зэлгий ярьж явдаг ямар хөө шиг дотортой болчихсон лүд вэ... Би хулгайч нарын заяа төөргийг үзэж суудаг хүн биш... Гарч зайл... гэжээ.

Тэгэхэд нь хулгайч Лутаа ч мөчөөгөө өгөлгүй... Юун сүртэй юм. Чи ганц мэргэлж түргэлдэг нь юм уу... Би мөрөөрөө ганц нэг адуу дэлсдэг болохоос ямар хүн алж, хүрээ талаа юу гэж данхалзахад нь...

За, хүү минь. Чи удахгүй хар толгойгоо шаана даа... гэж хараах, ерөөх хослуулах байдалтай хэлээд ногоон Ойдов хулгайч эрийг хөөн гаргажээ.

Тухайн үедээ энэ муу ногооны мэддэг, чаддаг гэж юу байдаг юм. Миний хүн алдаг ч юу байдаг юм гэж бодож байсан Лутаа энэ тухай ч төдөлгүй мартжээ.

Говийн аймаг руу явж хэдэн адуу хөөж ирсэн Лутаагийн сэтгэл ханасангүй. Урт булагт намаржиж буй “сөлөөн” Лувсангийн нэгэн өдөр буутал найман ханатай гэрийнх нь баруун талд дүүртэл шуудайлсан ноолуур хураалттай байх нь мань эрийн шуналын галыг ноцоогоод өгөх шиг болжээ.

Тэрхүү “Сөлөөн” Лувсан нь өнөөх эртний дайсан ногоон Ойдовын хүү бөгөөд давхар хариугаа авчих бодол ч дурайгаад явчихаж. Тэндээс мордсон цагаас л эхлэн яаж хулгай хийх вэ... Хэнтэй хамжилцах вэ гэсэн шөрмөсөн санаа өвөрлөсөн Лутаа эхнэрийнхээ бага дүү болох Сүрмааг энэ ажилдаа уруу татжээ.

Сүрмаа ч дуртай зөвшөөрч “сөлөөн” Лувсанг чадах ажилд ханцуй шамлан оров. Бүх үйлдлээ нарийн төлөвлөөд намрын жихүүвтэр нэгэн шөнө Лувсангийн уяан дээр сэм бууцгаажээ. Лувсангийнх ганц гэрээрээ намаржиж байсан бөгөөд хатавчаар нь гараа оруулан оньсыг нь мулталсан Сүрмаа сэмхэн гэтсээр орж явчихжээ.

Гэрт анир гүм ноёлон Лувсан, гэргий хоёрынх нь намуухан хурхирах нь үл мэдэгхэн дуулдана. Энэ үед Лутаа гэрийн гадаа үүдэнд нь ханцуй шамлан отоож байлаа. Гадаах амгалан тайван байдлыг хянах, нөгөөтэйгүүр дотроос зөөгдөн гарч ирэх шуудайтай ноолуурыг өргөж мориндоо тохих үүрэгтэй тул Лутаагийн зүрх ерөнхийдөө түгшүүртэй байв.

Хар мянган цэрэгтэй дайсны хуаранд нэвтрэн орсон баатарлаг тагнуулчийн дүртэй гэтсээр

мань Сүрмааг хоёр шуудай ноолуур тэврээд эргэтэл гэрийн зүүн талд сүр сархийх чимээ гарч ...Өө Лууяа... Би бие засмаар байна... гэж эхнэр нь ихэд зовиурлангуй хэлжээ. Тэр үед Лутаагийн эхнэр Норов бие нь тааруухан хэвтэрт байсан юмсанж. Орны пүрш шажигнах чимээ гарч Лувсан босч, эхнэрээ тэврэн үүд рүү зүглэжээ. Балмагдсан Сүрмаа шуудайтай ноолуураа тэврээстэй чигээрээ тэр доороо нам суучихаж.

Хураалттай ноолуурын сүүдэрт бүлтгэнэн суусан Сүрмааг Лувсан харсангүй. Хаалга цэлсхийн онгойж, Лувсанг эхнэрээ тэврэн гарч ирэхэд нь хулгайч Лутаа өмнөөс нь “Хурдан, хурдан” гэж хоолой нь сааралтан өгүүлж гэнэ.

Гэнэт балмагдан цочсон Лувсан нэг муухай орилоод тэвэрч явсан эхнэрээ хаалганы босго тэгнүүлэн алдчихжээ.

Бөөн хашгираан орилоон болж, Лутаа ч моринд мордоод зугтаагаад алга болох нь тэр. Гайхал Сүрмааг Лувсан барьж аваад алахаас наагуур болгож орхижээ. Авгайнх нь сүүж хугарч, эмнэлэгт очоод удахгүй нас барснаас хулгайч Лутаа, Сүрмаа хоёр хуулийн өмнө гөлөлзөх нь тэр.

Ингэж мэргэн түргэн ногоон Ойдов бага бэрээсээ цаг бусаар хагацан гашуудсан ч хулгайг Лутаагийн зам мөрийг гайхалтай тодорхойлон хэлснээрээ хэний хүү хэн бэ? гэдгээ нутаг усныхандаа батлан үзүүлжээ.

## Нас барсан өдрөө чөтгөр болон хувилжээ

Хар Чойжав гэж ажилсаг, нутаг усандаа нэртэй нэгэн байв. Тийм байлаа гээд ямар эрлэгийн элчээс чөлөөлөгдөх биш. Жил шахам хэвтэрт орж өвчилж байгаад л өөд болсон. Гэхдээ хүний ёсоор буцаж чадаагүй гэж зарим хүн талийгаачийн ясыг өндөлзүүлэх нь бий.

Талийгч Чойжав нэгэнт өөрийгөө үхэх нь гэдгийг мэдэж байсан ч амьдралаас төдий л салж чадахгүй эргэж буцсан, нэг л хоргодсон байдалтай байжээ. Хоолойны нарийн өвчнөөр өвчилсөн түүнийг мөс хөлдөөж хэлэн дэр нь тавьж өдөр хоногийг өнгөрөөж байсан гэдэг. Гэхдээ зүгээр нэг ус биш нутгийнх нь рашаанаас авчран хөргөгчинд хөлдөөж хэлэн дээр нь тавьдаг байв. Рашаан бараг өртөө шахам зайтай. Өвлийн сар тул цас ихтэй бартаатай замаар машин тэрэг явахгүй. Тэгээд л дүү нь Чойжавын хайртай хонгор морийг унаж хоёр бидон ганзагалаад рашаанд явжээ. Тэр үед талийгчийн өвчин улам гүнзгийрч хамаг биед хор нь тарчихсан ухаан санаа нь самуурчихсан байлаа. Арьс яс болтлоо турсан Чойжавын яс нь гозойсон шанааг даган нулимс урсана. Ойр дотныхон нь түүнийг өрөвдөн ханцуй дотроо нулимсаа шингээж байв. “Миний хүү ингэж үхэх учиргүй л хүн юмсан” гэж аав нь буурал толгойгоо шааж суув. Гэтэл Чойжав гэнэт өндийн “Энэ тоонон дээгүүр нэг нүцгэн хүн гүйгээд байна. Намайг чи үх. Чиний хувцсыг чинь би хурдан авмаар байна” гэжээ. Ойр дотныхон нь сандралдан унь тооно руу хичнээн хараад юу ч олж үзсэнгүй тул “Өвчиндөө дэмийрч байна, хөөрхий” гэж онош тавьжээ. “Миний морь хаана байна” гэгчхсэн саварны иш шиг болсон гараараа дээлээ өмсөх гэж оролдоход ах, дүүс нь үнэхээр эр хүний ёсоор морио асууж дээлээ өмсөөд үхэх гэж байна хэмээн бэлэгшээжээ. Гэтэл дунд хүү нь “Таны хонгор морийг Цэрэндорж ах унаад рашаан авчрахаар явсан” гэж эрүүл саруул юм шиг байдал үзүүлсэн аавдаа ойртон суугаад хариулжээ.

Чойжав уруулын мах нь барагдсанаас хучих хумих юмгүй болж арзайж ярзайсан шүдээ үл мэдэг хавиран “Чамайг идчихээд үхэх минь” гэжээ. Сахигсад үс толгой нь зарсхийж “Энэ юу хэлэв. Муу ёр” хэмээн айцгаав. Элий балай болсон Чойжав “Миний морь! хаалгаар цулбуурыг... оруулж ир!” гэж амьсгаадан хэлээд мах цусгүй хохимой болсон толгойгоо дэрэн дээр хаяжээ.

“Яанаа ийнээ” гэлцэж ах, дүү ойр дотныхон нь шуугилдаж, бэлэн зэлэн нулимстай бүсгүйчүүд нь аль хэдийнэ уйлж орилж эхэлсэн байв. Энэ үед Чойжавын аавын дүү өвгөн арай сийрэг толгойтой нэгэн тул “Энэ хүн өөрийнхөө эд хөрөнгөнд сэтгэл хоргодож, үхсэн шиг үхэж чадахгүй байгаа юм байна. Хөөрхий Цэрэндоржийг морийг нь унаад рашаанд явчихсаныг нэг муу гадарлаад байгаа юм байна” гэж сэжиглэн бодсон ч үрээ үхэхийг хүлээж суугаа ахдаа эвгүй үг хэлэхээс жийрхэж ёстой байж сууж ядаж байв. Чойжавын амьсгал тасалдаж хөх хулдаас шиг болсон царай нь бүр үнсэн саарал болж ирэв. Зарим бүсгүй, хүүхдийг гэрээс гаргаж хүүхдүүд нь нас бага тул толгойг нь барих учиртай дүү нь рашаанд яваад ирээгүй байгаад хүмүүс сэтгэл өвдөж, үхэж буй хүний биед гар хүрэхгүй гэж сэжиг сүжиг холилдуулсан санаагаар төрсөн дүү нь толгойг нь барих ёстой хэмээн өөр өөрийнхөө биенээс ирэх үйлийн үрийг зайлуулж байв.

Хариугүй үхэх ёстой болчихсон байсан Чойжав гэнэт нүдээ нээн “Мөс, мөс авчир” гэснээ хэлээ гарган орилж, хэл нь сунасаар эрүүг нь давж ирэв. Рашаан ирэхээс өмнө амжиж ус



хөлдөөсөн байсан тул сунаж гарч ирсэн хэл дээр мөсийг тавьбал тургиж, үл мэдэг хэлээ хөдөлгөсөөр түүнийг унагажээ. Чойжавын хэл хэзээ ч хүний хэл тэгэж сунамааргүй, боломжоос хэтэрсэн байдалтай болж цээж рүүгээ орж ирээд тэр уртаар санаа алдаад нөгөө ертөнцөд одов. Энэ үхлийг үзсэн хүмүүс цогцсонд ойртож чадахгүй байсан тул эмнэлгээс асрагч ирсэн боловч угтаа хүртэл гоожиж гарч ирсэн хэл нь буцаж орсонгүй.

Цогцос бараг хөрөх талдаа байсан болохоор засал хийж болохгүй байна гээд асрагч сувилагч нар явжээ. Тэгээд хэлийг унжсан байдалтай нь оршуулахаас өөр аргагүй болж хойдохыг нь уншуулахаар лам залж иржээ.

Лам яаж өөд болсоныг сонсоод нүд нь орой дээрээ гарах шахам айж “Энэ муу ёр болж. Тэр хүн чинь чөтгөрийн шинжийг үзүүлсэн байна” хэмээн өмнөө гаргаж тавиад нэлээд тухлах янзтай байсан хамаг юмаа хамж аваад гарахыг завдаж.

Чойжавын аав ламын замыг хааж,

- Чи юу хэлэв. Энэ хүний хойдохыг л чи даа. Юу хүссэнийг чинь өргөл барьц болгож өгнө гээд шалаад байсан тул лам арга буюу буцаж суудалдаа суужээ. Лам учир мэдэх хэдэн хүнд “хэл сунаж цээжиндээ хүрнэ гэдэг муу ёрын шинж. Талийгч шөнө дөлөөр чөтгөр болон хувилах ч аюул бий” гэж аймшигт домог ярьжээ. Тэгээд энэ байдлыг гаргуулахгүй байхад яах ёстой вэ гэвэл “Чойжоон догжуур” уншина. Жинсрэг цутгана гэдэг шашны үйл хийнэ. “Долоон ламаар гүрэм уншуулж, долоон хар тогоо доош нь харуулж засал хийх ёстой юм аа” гэжээ. Талийгчийн ойр дотныхон нь түүнийг тэнгэрт одсон цагаас эхлэн “Чөтгөр боллоо” гэж үнэмшсэн тул бүх ёс зан үйлийг номоор нь хийлгэжээ. Манжийн үеийн долоон хар тогоог хайж цуглуулсаар тоог нь гүйцээж, ташуу захтай шар дээлтэй хүн элбэг болсон цаг тул жинсрэг, гүрмийн ажил жигдэрч байлаа. Талийгч гэрийнхээ хойморьт ийнхүү сүүлийн замдаа явж байхдаа хэл нь үе үе орны доод талыг өшиглөж “Би үхмээргүй байна” гэж байжээ. Лам нар хоолой уралдуулан ном уншиж доошоо харуулж тавьсан долоон хар тогооны хооронд нэг бор хулгана гүйсээр хэсэг хугацаа өнгөрөв.

Цаг хором өнгөрсөөр гурав дахь тогоо өөрөө хөдөлж “Өврөө” нээхэд нөгөө бор хулгана тэр рүү гүйж оров. Тэр үед л лам нар сэтгэл сэргэж бие амирласан байдалтай хөлсөө арчин өндийжээ. Тэр хар тогооны дээр талийгч Чойжавын хурган дээлийг хучлага болгон тавьснаар үхсэн даруйдаа чөтгөр болсон сүнсийг тонилгож чадсан гэдэг ээ.

## Хасаг, монгол хоёр өвгөний уншлага, хилэнд өртсөн намын дарга нанжидаа хүртжээ

Бидний үеийнхэн шашин шүтлэгээс хол хөндий өссөн бөгөөд янз бүрийн хараал ерөөл уншлага сан гэдэгт итгэж байгаагүй бөгөөд хөгшин настай хүмүүсийг элдвийн юм ярихад нь “Шашны мунхруулгаас салаагүй хөөрхийс” хэмээн боддог байж билээ. Манай нутагт монгол казах хоёр хороолол байдаг бөгөөд урд хороололд байдаг Паньд өвгөнийг ламбугай гэгцгээж хойд хороололд суудаг Дамбай казакийг бөө гэдэг байсан юм. Хоёр өвгөн айлуудын амины үхрийг хариулдаг ба үхэр бүрээс 5 төгрөгний хөлс авдаг, тэгээд ч арван хэдэн жил үхэр хариулахдаа чоно нохойд идүүлж, хулгай зэлгийд алдаж, шавар намагт зоож, ор мөргүй алга болгож үзээгүй тул нутгийн ардууд дуртайяа үхрээ хариулуулан таван төгрөгөө өгч социалист нийгмийн аугаа их бүтээн байгуулалтандаа санаа зоволгүй суудаг бөлгөө. Тэр жил холын нэгэн аймагт ажиллаж байсан гүзээ ихт гүргэр хар нөхөр манай суманд намын хорооны даргаар ирлээ. Говь газар ажиллаж байсан хүмүүс 70 малтай байдаг бол хангайн бүсийн төв суурингийнхан 16 толгой малтай байхыг хуульчилсан байсныг одооны хүүхдүүд санахгүй боловч бичиг үсэгтэй бол дорхноо мэдэж болно. Намын дарга Намжин ирсэн цагаасаа хойш хоёр өвгөнтэй дайн зарлав.

Хамгийн түрүүнд хувиараа мал хариулдгийг нь болиулж орхив. Бодвол ям ямхан тэмцэнэ гэсэн бололтой. Тун удалгүй лекц хурал дээр шашны хоосон мунхруулгад ихэд өртсөн манай сумын зарим албан хаагчдыг нэр заан донгодож ажил албанаас нь зайлуулах ч юм болоодохов. Сумын төвийнхний цайны сүү, тарагны борви дүүргэдэг хэдэн үхэр хариулахгүй явж байгаад вагонд дайруулж нилээд нь нүд аниж эзэндээ төдийгүй улсад хохирол учруулсан гээд төлбөр ялбарт ойчсон хүмүүс хүн зоноос мөнгө зээлэн гүйлдэв. Хэдэн ч үхэр тойрмын намагт зоогдоодохов. Намын дарга хувиараа мал хариулдаг эсэргүү өвгөдтэй дайн зарласан нь сумын иргэдийн амьдралд хор хүргэн зарим айл хар цай уух болов. Намар оройхон намын даргын мал ахуйг туусаар ирснийг үзвэл азарга адуу, хориод үхэр, зуу илүү хонь байх аж. Дарга ч яахав бүрэн эрхэт эзэн тул ойролцоох сайн малчинд ацаглуулж өгсөнөөр өөрийгөө бөндийлгөв. Ирсэн цагаасаа намын дарга манай нутгийн олонд таалагдсангүй. Хүн бүр ам муутай байдаг болов.

Халдварт өвчин гарсан ч юм уу яасан ч юм даргын хуж хонь үхэр сарын дотор үхэж үрэгдэж алга болж бригадын малын эмч, малчин хоёрын нүдийг нь бүлтэлзүүлэн Ардын хянан шалгахын төлөөлөгч байцаан хэд хоногийн дараа аймгийн мөрдөнд суулгахаар авч одлоо. Нутгийнхан улам их зэвүүцэх болов. Гэтэл 11-р сарын дунд үеэр бороо шороогүй, бороо орох биш цас орох болчихсон үеэр тэнгэрт нэгэн дуу тасхийн суман могой шиг цахилгаан гялалзан ирж намын даргын найман ханатай өргөө гэрийг ниргэжээ. Өдрийн цайны цагаар гэртээ ирж явсан дарга гэргий хоёр өөрсдийнхөө 4 нүдээр энэ явдлыг харсан тул мал гайхан цэл хөхөрч хөшиж орхив. Хошуу хамрынхан гүйлдэн ирж гал унтраахаар шороо цацлаа, ус утган гүйлдсэн ч таван минутын дараа үнс нурам үлдэж, дарга өмссөн хувцастайгаа сумын буудал бараадав. Тун удалгүй даргын эхнэр чилээрхэж гэнэ гэсэн чимээг бор шувуу бүхэн тарааж сумын төвийн баруун талд байх хүн эмнэлгийн байшин тийш нүдтэй болгоны нүд, чихтэй болгоны чих дэлдийн юу болохыг чагнах болов. Даргын авгай их муу гэнэ. Энэ тэнэг дарга хоёр өвгөнд очиж хүлцэл өчихгүй бол өөрөөр яах ч аргагүй гэдгийг нутгийнхан сэм шивнэлдэнэ. Үхэрчин хоёр өвгөн өөр өөрсдийн амин зуулгын үхэр малаа туун хээр талд очин

дүнгэр дүнгэр ярилцан хээв нэг амь зууж байв. Байдал бишидсэнийг мэдсэн сумын дарга нэг өдөр жаран ес машинаа хүнгэнүүлэн хоёр өвгөнийг Суврага толгойн цаана булгийн захын харзны хошуунд суух байх үед нь хүрч очлоо.

Мэнд амрыг асууж ойр зуурын элдэв юм ярьж сууснаа асуудлыг тэмээн дээрээс ойчсон мэт шуудхан тас түс тавив.

- За хоёр буурайгаа нутгийнхан минь бүгд мэднэ. Энэ намын шинэ дарга жаахан овилгогүй нөхөр болох нь ч үнэн. Гэхдээ та хоёр арай хийрүүлж байна. Тэр эхнэр нь ямар хамаа байна. Одоо тун үхлүүт байна. Хүн үхүүлбэл хууль цааз чанга. Нутгийн бид та хоёрыг хамгаалж чадахгүй шүү хэмээвэл Дамбай өвгөн сахалнаасаа хэдийг таслан авч амандаа хэдэн үйл бувтнаад үгээн хийсгээд “Эхнэр нь одоо зүгээр ээ дарга аа. Та жаахан харихгүй суугаад аймгаас ирэх тэр замыг харж бай. Намын дарга аймгаас одоо ирж яваа! юу болохыг үзтүгэй” гэж. Тун удалгүй Нарийн хөтлийн даваа уруудаад сумын төв ордог замаар нэг жаран ес машин гарч ирэв. Араас нь нилээн зайтай эмнэлгийн цагаан пургон машин ирж явна. Намын дарга өөрийн биеэр аймаг орж нэгдсэн эмнэлгийнхэнийг түргэн авахуулан эмч авч ирж яваа нь тэр. Паньд өвгөн ирж яваа машины зүг харан сууж байснаа алгаа нэгэнтээ пад хийлгэн дуу чимээ гарган хавсартал өмнө нь явсан жаран ес машин дээр хөөрөн шороо тоос манаруулан онхолдож харагдав.

Сандарсан сумын дарга хоёр өвгөнийг орхиж сүнгэнэтэл давхиж очиход намын даргын жолооч хархүү тоос шороонд хутгалдсан амьтан уйлж зогсох ба намын эрхэм даргын хоёр гуаыг дугуйны лапток царил нэвт сүлбэж эмч нар цус тогтоох, салгаж авах гээд сүйд гэнэ. Сүүлд сонсохнээ намын дарга жолоо барьж явсан гэх ба жолоо шилжүүлсэн гэж хөөрхий жолоочийг 250 төгрөгөөр торгосныг Дамбай хасаг төлсөн дуулдаж Паньд өвгөн байцаагдаж байх хугацааны зардал мөнгийг өгсөн сураг гарч билээ.

Эзэрхэг намын дарга эмнэлэг явж дахин ирээгүй бөгөөд хоёр өвгөн ч үхрээ маллаж таван төгрөгөө авсаар, сумын амьдрал бахь байдаг хуучин хэвэндээ орж тайван налгар болсон юмдаг. Манай сумын дарга миний мэдэхээр үхэн үхтлээ даргынхаа албыг хашиж, хоёр өвгөнийг хүндэлсээр өнгөрцгөөсөн. Нутгийн ардууд тэр бүү хэл сумын эмч хүртэл өвдөж хавдах, ажил үйлс доголдох гээд аль болохгүй юм гарвал хоёр өвгөнтэй уулзаж учирч байхыг нутгаасаа багадаа гараад намын даргаар ирсэн би үзэж элдэв юм хэлж үзэлгүй байсаар ардчилсан хувьсгалтай золгосон юм даа.

## Хятад амбаны нүдийг сохортол хараасан хасаг бөө шувуу болон нисдэг шидтэй...

Арван хэдэн жил алба төлөлгүй зайлж одсон зуугуул иргэд нь Ар халхын Богд ламын авралд багтан Алтайн уулын ар биеэр хөндлөн гулд хэлхэлдэн давхиж, адуу мал нь өсч үржээд бүр нэг дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэж байгаа тухай мэдээ Синжан хэсгийг хамаарч үе дамжин Ванийн сэнтийд залран суугч Манж-Шихуд иржээ. Ороо догшин зантай, омголон морь мэт ааштай, өвөл зунгүй нүүж бууж явдаг малчид жилд нэг удаа агтны алба, шүүсний алба гэдэг татвар төлөх бөгөөд хар багаасаа ноён сууринд сууж, хасаг, цахир торгууд хэнтэй ч болов ярьж хөөрөн ясыг нь хүртэл томсгон Ши Ху ван арван тав зургаан жилийн алба гувчуурт ирэх олзыг бодохлоор байж сууж ядав. Нилээд бодсоны эцэст өөрийн цусны Сү Лан гэгчийг дуудан ирүүлж баруун Алтайн цаад биед шилэрч одсон хасаг отгоос алба авах эрхтэй амбан сайдаар томилон илгээжээ. Урьд өмнө ийм албанд явж байгаагүй Сү Лан амбан хошуу гулгаж алба завшсан отгийн араас ирж Их вангийн зоригийг сонсгон харь хоногт багтаан түмэн агт, түмэн шар үхэр цуглуулах даалгавар өгч тахрууд цус, жалга өвөлжөө хаваржаа тийш адуулан авчирсан мал бүрийг өөрийн биеэр шалган авчээ. Сү Лам амбаа хүрээ газар өгсөн хэдий ч адуу малыг маш сайн мууддаг байв. Эцэг нь нүүдэл иргэдээс гувчуурт авсан адууг өмнө газар хүргүүлэн хорь гуч дахин их үнэр зардаг их гарын наймаачин учир багаасаа адуу мал муугүй болсныг нь гайхах хэрэггүй билээ. Нутгийн иргэд малд нүдтэй амбанд туранхай хөгшин морь, гүүгээ өгөх гэж үзэх боловч ташуурын амт үзэн хөөгдөн гарах бөлгөө.

Хорсож өширхсөн ардууд Ховд голын Ховог сайр хэмээх газар нутаглах Касум нэрт хар хэлт хараалч бөөд очин малд нүдтэй адуунд арчаатай Сү лам амбаныг түр ч болтугай сохор болгож өгөхийг гуйсан байна. Касум бөө хум галуун өмсгөл хэдгэрч тал сараа хэнгэргээ дэлдэж бөөлж гарахад дэргэдийн шумуулууд шир сэрхийн нисэлдэж хуй салхи эргэж хурган эрчилж байв гэнэ. Бөө нилээд удаан бөөлж байснаа адууны хоёр халтар хомоолыг шүүрэн авч үлээн тарнидаж дээш шидсэнд даруй хон хэрээ болон хааг хааг дуугаран нисэн оджээ. Касум бөө явгалан сууж хэц хэнгэрэгээ нүдэн амнаасаа цагаан хөөс цахруулан нэгэн зүйлийг өгүүлэх мэт аялгуулан хэлэх бас сайн сонсвол “Нүдээ өг. Шүдээ өг” гэсэн үг л арай тодхон мэдэгдэж байна гэнэ шүү. Цаг гаруй тийн бөлж суутал хоёр хэрээ нисэн ирж урд нь буухуй бүлтийсэн алаг нүдийг нэг нэгээрээ хошуундаа зуусан байхыг үзсэн ардууд уулга алджээ. Касум бөө хоёр нүдийг аягатай усанд хийж тавиад ухаан алдан унахад дэргэдийн бараа бологчид нь хүйтэн цай уулган айраг цэгээ цутган босгож авчээ. Бөө ихэд ядарсан янзтай босч ирээд гомдол мэдүүлэгч нарт хэлсэн нь.

-Та нарт гай болоод байгаа Сү Лам амбаны нүдийг авах гэж их зовлоо шүү. Үд дунд өргөөндөө заларч хоол цай идээд дуг хийх хооронд тооноор орж арайхийн хоёр нүдийг нь авав. Хүн бүр нэг нэг хонь намар авчирч өгөөрэй. Хүний нүд авахуулсан нүглээ өөрсдөө дагаарай та нар. Түмэн олон тустай юм хийлээ гэж бодоод хүний үрийн нүдийг авчихсан гэм гэхэд хараалч, хэрүүлч гэм сонссоноос биш яг ингэж бөөлж байхыг нь үзээгүй ардууд үг дуугүй сөгдөм сүслээд явж оджээ. Амбан сайдын байх газар ажин түжин сандарсан улс нааш цааш гулбилзан сэлбэлзэн гүйлгэх ба өдрийн зоог барьж дуусаад торгон хөнжилд орон тухалсан амбан гэв гэнэт үхлийн дуугаар орилон хашгирахад үүдэнд байсан унаган боол давхийн орвол нүүр ам нь нил цусанд будагдсан амбан хий самардан арилж байх нь тэрээ. Амбаны буусан өргөө гэрт хэн ч ороогүй гэдгийг үүдэнд нь хэвтдэг унаган боол тайгаа

хийгээд харуул хамгаалалтын цэргүүд давхар давхар батальон бөгөөд нэгэн шивэгчин тоонон дээр нь хоёр хэрээ сууж байсныг мэдүүлжээ. Нэгэнт нүдгүй болсон амбан жуузандаа сууж орилж бархирсаар нутаг буцсан бас алба хураах бусад түшмэлүүд хөгшин туранхай адууг цуглуулан арайхийн Алтай давуулаа туун ирж тамгын жоед хүлээлгэж өгчээ. Тун удалгүй нэвсгэр хоёр хэрээ нисэн ирж адуу захлан хааг хааг хийн нисч бууж байдаг болжээ.

Хол газар туулж ирсэн адуу өнгө зүс засч тарга тэвээрэг авсан намар оройн үеэр адуун сүрэг нэг л шөнө нутгийн зүг унгалдан оджээ. Хойноос нь нэхсэн харийн адуучид хоёр хоногийн дараа гүйцэж ирсэнд хоёр хон хэрээ нэг нэг морин дээр суучихсан эгээ л жолоо цулбууртай юм шиг морьдоо залан түмэн агтны хойноос элдэж явжээ. Нэхүүлийн бараанаар нэг хэрээ урагш нисэн одож тун удалгүй мянга гаруй хар хэрээ нэхүүл адуучдын зүг довтлон нүдийг нь ухчих гэж дайрч энд тэндээс нь тоншин хувцас хунар малгай толгойг нь хатчин унаж яваа морьдынх нь хүзүүг хондлойг тоншин цусыг нь цувируулж бараг идчих дөхсөн тул ам мөлтөс хойш зугтаан гарчээ. Чадал хүч нь хэтийдсэн Хасагийн хараалч бөө олон ардаас татварлан авсан адууг онгодынхоо хүчээр буцаан хурааж нутагтаа авчирсан нь тэр бөгөөд хоёр хар хэрээ Алтайн нурууг даван нисч, буцаж ирсэн гурван сарын турш Касум бөө ухаангүй гөлийж идэш уух нь зүгээр мөртлөө үг хэл хоригдон хэвтэрт байснаа нэг л өдөр гэв гэнэт сэргэж маш их ядарлаа гэм. “Бушуухан хонь гаргаж шинэ мах чана өлсөж байна” гэж жигтэйхэн гэсээр хэлд оров гэнэ.

Түүн шиг чадалтай бөө хэд хэд байсан гэж хөгшчүүл хэлэлцэх бөгөөд ид онгод түшлийг нь орж бөөлөх үедээ буцалж байгаа хар усыг хүйтэн цай шиг залгиж, улайсгасан хүрзийг шир шир долоон голын усыг өөд нь урсгаж, ян хад руу нисч буун авирладаг байсан хэмээн хүүрнэх амай.

## Өвчин өвөртөлж зам унаж ирсэн хужаагийн адыг даржээ

Улаанбаатараас зайдуухан нэгэн гацаанд аль 1980-аад оны эхээр гутал загнаж, алх тог тог хийлгэж суудаг нэгэн өвгөн хужаа амьдардаг байлаа. Баас хатавч өмхийгөө тавихгүй гэгчээр мань өвгөн өөрийн хужаа төрхийг нуухгүй. Пөөнөгөр зузаан өмд, нимгэн ширэн ултай шаахай өмсөж хэн нэгний өндөр дуунд захирагдан гүйх зарц шиг шөөрөгнөнө. Уг гацаа газар тариалангийн нэгэн суурин төв учир хашир хужаа тариаланч, комбайнч, тракторчдын хүнд ажилд нухлагдаж жагсаалаас гарсан гутлыг засч тордож өгөх “зах зээл”-ийг олж харсан байв. Сангийн аж ахуй гэдэг тухайн үедээ танхайчууд ч олонтой, ажилсаг залуус ч цөөнгүй амьдардаг тийм л газар байлаа. Нямдэлэг хэмээх залуу Ар хустайн трактор комбайны ТМС төгсөөд тэнд ирж анхны намрынхаа ургац хураалтад оролцож, хөөрүү зан, хөдөлмөрийн амт хоёрын аль алиныг нь амсч явав. Магадгүй хөдөлмөрийн баатар болно гэж бодож ч байсан биз. Нэг өдөр түүний орос бахиалын түрий тармуурын төмөрт урагдсанаас энэ хэрэг үүсэв. Мань Нямдэлэг мөнөөх гуталчин хужаа дээр давхиж очоод шинэвтэр бакиалынхаа толгойд орос хромын түрий залгуулья гэжээ.

- Хай, орос хромын түрий байхгүй. Байсан ч үнэтэй ва гэж хужаа өвгөн Нямдэлэгийг хулхидаж мэхэлж болмоор гэнэн хүү байна гэж бодсоноос уу эсвэл үнэхээр тэр орос хромын түрий нь тийм үнэтэй байсан уу бүү мэд гэж хэлжээ. Харин Нямдэлэг хүний аманд багтаад хэлснийг нь дагаад байх хүн биш байлаа.

Тийм болохоор,

- Чи муу зөнөг хужаа. Монгол хүний гутлын улыг долоож түрийвчээ түнтийлгэж овоо цадсан байх шив гэж жижигхэн тагз руу нь дайран орж ажлынх нь хамаг багаж хэрэгслийг өшигчиж, талын нэг тараажээ. Хужаа өвгөн ч тэр даруйдаа номхорч,

- Хай, би цагдаа магдаа гэхгүй шүү. Чиний гутлыг үнэгүй засч өгнө. Ер нь дандаа тэгж байя гэж марсайтал инээжээ. Асуудлыг маш амархан бөгөөд ганц ч “улаан гапи” гаргахгүйгээр шийдсэндээ оодорсон Нямдэлэг,

- Тийм байлгүй дээ. Монголын баян оронд замаас өөр унаагүй, нохой явган, гахай нүцгэн орж ирснээ санасан чинь сайн хэрэг болж хэмээн заных загнахын хооронд өгүүлээд гутлаа орхин явж оджээ. Мөнөөх хужаа өвгөн,

- Хай цагийн дараа ирэхэд болно шүү гэж инээмсэглэн хоцорчээ. Цааш эргэмэгц нь хойноос нь хүйтэн хөх нүдээр хорсол суунаглалат харж, хөрзгөр нүүрээ чинэрэлдүүлэн чичрүүлж байгааг нь хөөрүү залуу Нямдэлэг яахин мэдэх билээ. Эргэж ч харалгүй

- Манай бригад дээр аваад очоорой. Төв үтрэм дээр шүү гэж дээрэнгүй өнгөөр хашгирчээ. Бараг Нямдэлэгийг үтрэм дээр очоогүй байхад Хужаа Дорлиг гялалзтал тосолсон урт хар түрийтэй гутал барьчихсан нэгэн мотоциклийн араар сууж очжээ.

- Ай, түнш. Их сайн болсон шүү гээд гутлыг Нямдэлэгт өгчээ. Нямдэлэг ч гутлыг илтэд таалагдсан тул,

- Сохорсон биш завшив гэгч боллоо. Одоо өмсөхгүй ээ. Үдэшлэг дээр гангардаг хэрэг ээ гэж хүүхэд зангаар хөөрөн дуу алджээ. Хужаа Дорлиг сандрах шиг болж,

- Ээ чи юу хэлнэ. Сайн дүү чи одоо өмс. Би дараа чамд ганган гутал урлаж өгөмз. Тэр гутлыг өмсөөд ёстой л танц гишгээд байж дээ гэж долигонов. Гутлын хувьд толгой өвдөхгүй байнгын “ивээн тэтгэгч” олж авсан Нямдэлэг ч засуулсан гутлаа өмсөв. Хажууд нь зогссон бригадынх нь зарим хүн,

- Нямдэлэг ээ, чи хужаа Дорлигийн өргөмөл хүүхэд аятай хайр халамжийг нь хүртээд байдаг чинь юу вэ? Цаадах чинь их л дотор тамиртай хүн байгаа юм даа гэжээ. Нямдэлэг ч өөрийгөө ихэд тоодог хүний ёсоор,

- Би хужаагийн өргөмөл хүү болно гэж үү. Сая үнэрхээд байхаар нь заамдаж аваад жаал айлгаж орхисон юм. Тэгэхгүй бол давраад... гэжээ. Маргааш өглөө нь Нямдэлэг хамаг биеэр нь гүвдрүү туурч ихэд халууран хоножээ. Зүгээр арьсан дээр хумсаараа хатгахад ус мэлс хийн гарч ирэх нь Нямдэлэг хүн биш усан байцаа болсон юм шиг сэтгэгдэл төрнө. Нямдэлэг тэр даруйдаа Сангийн аж ахуйн эмнэлэгт очсонд ядаргаа энэ тэр гэхээс олигтой онош тавьсангүй. Эмнэлэгт нэг хоноход толгой ба бүх бие өвдөх бөгөөд халуун хижиг ийм байдаг болов уу гэмээр. Байдал нэгэнт ийм болоод байтал Нямдэлэгийг бригадынхан нь эргэж ирэв. Бригадын хамгийн өндөр настай Насан-Очир гуай Нямдэлэгийн цээжийг сөхөж үзээд нүд нь орой дээр гарах шахав тэгээд,

- Миний хүү хойшоо хараад хэвт дээ гэжээ. Нямдэлэг ч зовиурилан байж хойш эргэхэд өвгөн Насан-Очир юу ч хэлсэнгүй царайгаа хачин болгон гарч оджээ. Хамт явсан бригадын тариаланчдын зарим нь түүний хойноос гараад юу болсныг асуухад тэр хэлсэн нь:

- Энэ хүү хужаагийн хорлолд автжээ. Би сая харлаа. Бүх бие нь усан балин шиг болоод өвчүүнд нь 8 ширхэг шар үс ургажээ. Арай хорлолт өвчин газар аваагүй болов уу гэж горьдоод нурууг нь үзлээ. Ард нь 7 ширхэг шар үс ургажээ. Ийм хорыг манай нутгийнхан сайн мэднэ. Хужаагийн “Ямдам” бузар ч гэдэг юм. Бөөсөөр л их амархан тархдаг гэдэг. Муу санасан хүндээ хужаа нар хорлол шингээсэн бөөсөө хувцас хунарт нь хийчихдэг гэж манай нутгийнхан ярьдаг юм. Өвгөн Насан-Очирын үгийг сонсоод бригадынхан адал явдал, ад хорын аймшигт хүчинд тэрхэн зуур автах шиг болжээ. Харин хоёр хоногийн өмнө Нямдэлэг хужаа Дорлигийг айлгаж байгаад гутлаа засуулж авсан тухай нь сонссоноо бригадын нэг гишүүн хэлснээр “Хужаагийн ад” гэдэг онош дээр тэр хамт олон тогтжээ.

Гэхдээ хор адын талаар ярих нь хориотой цаг байсан болохоор учир мэдэх хоёр хүн хужаа Дорлигийг хорлолоо буцааж ав гэж ятгахаар очжээ. Дорлиг өвгөн ихэд уурлаж:

- Социалист нийгмийн үед та нар юу ярьж яваа юм бэ? Ядарсан муу өвгөнийг яаж ч доромжилж болно гэж бодоо юу? Би Монгол улсын бүрэн эрхт иргэн хүн шүү. Намын орлогч гишүүн хүртэл байсан удаатай гэж ирээд загнаж хавьтуулсангүй. “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө” гэсэн лоозонтой цаг байсан болохоор хоорондоо эвсэн хуйвалдаж сангийн аж ахуйн самосвалаар дарга хэнхэгүүдээс нуун байж Насан-Очир гуай жолооч болон өөр нэг хүний хамт нэг тийш явах болов. Энэ нь Булган аймгийн Номгон орчмоор нутагладаг мэргэн Мэнгээхэмээх хүн гэнэ. Тэр баруун аймгийн бага ястан хүн бөгөөд нутаг орондоо

шашин сурталчилсан хэргээр аймгийн намын хорооны товчоог хуралдуулж нутаг заагдан хөөгдсөн нэгэн аж. Насан-Очир гуай тэр хүнийг нэг аргалж магадгүй гэж боджээ. Шөнө дөлөөр Мэнгээ мэргэний гадаа очиход нууцаар очиж мэргэлүүлэгсэд бүхэл бүтэн авто баазын машины дараалан үүсгэсэн байв гэнэ. Мань хэд ч “оочерлосоор байж өглөө болгох нь. Өглөө болоход НАХ, Нам хавсарсан улаан матаачид ажилд садаа болно. Яадаг билээ. Ийдэг билээ” гэсээр тэрүүнхэндээ сандралд оржээ. Гэтэл гэрээс нэг хүн гарч ирээд “Та нар Төв аймгаас ирсэн үү. Мэргэн та нарыг ороод ир гэж байна” гэжээ. Насан-Очир нар ч уухайн тас ухасхийв.

Мэргэнд бараалхаж болсон явдлыг нэгд нэгэнгүй хэлэв. Мэнгээ мэргэн Насан-Очир өвгөнийг ихэд хүндэтгэн “Турсан нь их, сурсан сонссон нь ч их хүн байна. Та зөв бодож” гээд шар тосонд арвайн гурил зуурч дээр нь оронго хэмээх гөрөөсний эврээс нунтаглаж хийгээд баахан л ном уншиж, тарнидаж сэржим өргөжээ. Тэгээд Мэргэн “Та хэд маш хурдан давхи, энэ гурилан бүтээлээр өвчтөний биеийг тавхайнаас нь дээшлүүлэн арчиж цэвэрлэ. Бүх биеийг цэвэрлэж дуусахад энэ гурил улаан хүрэн өнгөтэй болсон байх ёстой. Ганц ч ширхэг гурил унагаж болохгүй. Цөмийг нь цаасанд боож аваад тэр хор үйлдсэн хүний галд аваачаад хийчих. Тэгвэл зүгээр болох вий” гэжээ.

Насан-Очир нар давхисаар өглөө ажил цуглаж эмч нар ирэхээс өмнө САА-ынхаа эмнэлэг дээр хүрч очив. Бүх зүйлийг мэргэний заасан ёсоор хийж дуусгахад хужаа Дорлигийн галд дог өргөх ажил л хамгийн хэцүү нь болж хувирав. Тэгээд нэг арга сэдэв. Үтрэмийн хаалгаар онгойлгож хэдэн шуудай сайн сортын буудай хулгайлсан хэрэг гарлаа гэж зохиол бичив. Мөрийг нь мөшгөхөд хулгайч явсаар хужаа Дорлигийн ойролцоо ирсэн гэж утга санааг нь гүнзгийрүүлэв. Тэгээд шууд хэсгийн төлөөлөгчид хандаж,

- Гарсан хэргийн талаар мэдэгджээ. Хэсгийн төлөөлөгчийг дагаж явахдаа хужаа Дорлиг арзгар шар шүдээ ярзайлган инээж энгэр мөрнийх нь дээр наалдсан элдэв хялгас мэтийг түүж “долигноход” Насан-Очир өвгөн түүний гарыг алгадаж “Хол бай” хэмээн шүднийхээ завсраар өгүүлжээ.

Насан-Очир хужаа Дорлигийг бас хэсгийн төлөөлөгч залуугийн зах руу нөгөө хорт бөөсөө тавьчихаж магадгүй гэж болгоомжилж түүний гарын хөдөлгөөнийг нүд салгалгүй харав. Хужаа Дорлигийг байцаагдах зуур Нямдэлэгийн бригадын Цэрэнпүрэв зууханд мөнөөх хүрэн улаан болсон гурилаа хийж шатаажээ. Тэр явдлын дараа төдий л удалгүй Нямдэлэгийн өвчүүнд ургасан 8 шар, ард ургасан 7 шар хялгас хуйхлагдан унаж биеийн гүвдрүү усан хаван нь аньжээ. Зам унаж, өвчин өвөрлөж явдаг хужаа нар түүхийн ямар ч үед санаагаа хадгалж явдаг гэсэн шүү!



## “Ялгагчийн гэгээн” хэмээн алдаршсан нэгэн бүсгүйн шид

Эрт цагт гэж болох тийм үед юм гэнэ лээ. Үнэн мөнийг олох шүүх гэж бараг үгүй. Тэгээд шүүх гэдэг чинь яг үнэн мөнийг ялгаж чаддаг эсэх нь өнөөдөр ч эргэлзээтэй байгаа болохоор ихэс ноёд үнэнийг тунгаахдаа үзмэрч мэргэдийг ашигладаг байжээ. Баруун нутгийн нэгэн хийдийн лам винайн ёсыг зөрчиж бузар эмтэй энгэр зөрүүлсэн гэх. Түүнийгээ өөрөө үл зөвшөөрсөн тул үнэн мөнийг ялгах бүрэлдэхүүн Богдын хүрээнээс Алтай нутгийг зүглэн хөдөлж дээ. Уг лам Доржцэвээн нь хар багаас хамт тоглож өссөн нэгэн бүсгүйн гэрт хоног төөрүүлсэн нь энэ хэргийн эхлэл болсон байна.

Гэхдээ тухайн үеийн лам нарын дотор эм хүнтэй энгэр зөрүүлэх нь бүү хэл эзэн ноёныхоо өврөөс эхнэр хатдыг нь суйлах явдал элбэг байсан гэдэг. Доржцэвээн лам ганцаараа яагаад Ванайн ариун ёсыг сахих шаардлагатай болчихов гэдэг нь учир явдалтай байжээ.

Доржцэвээн нь хийдийнхээ хамбатай тэрсэлдэж, хамбын шунахай сувдагийг шүүмжилж шашин номыг жинхэнэ мөн чанараар нь хөгжүүлэх гэх мэтээр тухайн үедээ шинэлэг гэж болох үзэл баримтлалыг дэвшүүлж. Гэтэл хамба лам нь өөртэй нь тэрссэн Доржцэвээнийг элдвээр хавчин гадуурхаж, мөшгөн мөрджээ. Харин нэг удаа Доржцэвээн лам ганц бие эмэгтэйн гэрт хоног төөрүүлснийг хамба ламын туршуул олж харснаар түүнийг “Винайн ёсыг сахиж чадаагүй ёсыг ус болгон эвдэж орхисон” хэмээн Монголын шашин төрийн тэргүүнд айлтгаснаар Богд гэгээнтэн дэргэдийн лам болон Гандангийн хэдэн лам нараас бүрдсэн үнэн мөнийг тунгааж хар цагааныг ялгах шашны ёсон дахь шүүх бүрэлдэхүүнийг явуулсан байна.

Сүсэгтэн олныг цуглуулж цадиггүй Доржцэвээний “сахилыг эвдэж шар шувтлуулна” хэмээн зарласан нь одоогийноор сонгуулийн сурталчилгаа маягтай юм байв. Түмэн олон түжигнэж лам хүний нүглийг үзэж, нүд тайлах гэсэн хэрэгт дурлах байдал ч газар аван гаарчээ.

Хамба ламтан буцалмал халуун устай саванд хоёр хар чулуу хийж “Шүүгчдийн” өмнө авчирчээ. Энэ буцалмал усанд хар цагаан хоёр чулуу байгаа гэжээ. Доржцэвээн үнэхээр нүгэлтэй бол буцалмал уснаас хар чулууг авна. Нүгэлгүй бол цагааныг нь авна. Энэ бол “Шүүх ажиллагаа” юм. Гэтэл цугларагсдын дотроос нэгэн эмэгтэй,

- Наад буцалмал устай саванд чинь хоёр хар чулуу байна. Энэ үнэн мөнийг олох биш хүнийг заль мэхээр унагах гэсэн арга байна гэж хашгирчээ. Хүмүүс ч эхэндээ гайхаж тээнэгэлзэж байгаад,

- Ялгагчийн гэгээн хэлж байна. Савтай усыг асгаж үз гэжээ. Энэ үед хийдийн хамба минчийтэл улайж Богдын хүрээнээс ирсэн “шүүгчдэд” хандан,

- Энэ бол хар зүгийн хар тэнгэртэй бузар эм. Ламын шашны ариун сүмд хөл тавих ч эрхгүй гэжээ. Лам нар ёстой л улаан шарыг тунаруулан мөнөөх бүсгүйг хөөж явуулах гэсэн боловч сүсэгтэн олон түүний талд орж эсэргүүцсэн учир арга буюу олны шаардлагаар мөнөөх савтай усыг асгажээ. Гэтэл үнэхээр хоёр хар чулуу гарч иржээ. Хүрээний лам нар Доржцэвээнийг шүүх ёстойгоо бараг мартаж нөгөө эмэгтэйг үнэхээр тийм мэргэн түргэнийг нь үзэхээр

шийджээ.

- Үнэн мөнийг ялгаж чаддаг бузар эм чи юм бол ус сүү хоёрыг холиод өгье. Хар цагаанаар нь ялгаадах гэжээ. “Ялгагчийн гэгээн” гэгдсэн бүсгүй:

- Зөвхөн иймхэн юмаар намайг туршиж байгаа юм уу? гээд хоромхон зуур сүү, ус хоёрыг тус тусад нь ялгаж саванд юүлжээ. Энэ үед Улиастайн сайдан газраас бараа бололцож очсон түшмэл Жамьяндорж гэдэг залуухан эр ухаан алдан унасан хэрэг гарав. Хүрээний “шүүгчид” Жамьяндоржийг эмчлэх үү, Доржцэвээний шарыг шувтлах уу гэдгийнхээ алийг нь ч шийдэж чадахгүй байж байтал “Ялгагчийн гэгээн” ирж хилсээр шийтгэгдэх гэж байгаа Доржцэвээн ламтаны үнэн мөнийг та нарт нотолж чадсан гэж бодож байна. Түүнийг нүгэл үйлдээгүй гэж үзвэл би энэ түшмэлийг эмчилж болох юм гэжээ. Хүрээнийхэн ч бүсгүйн үгэнд орж Доржцэвээнийг шар шувталж хүрээ хийдийн газраас хөөж явуулахгүй гэж ам өчгөө өгцгөөжээ. “Ялгагчийн гэгээн” бөөгийн толиндоо залуу түшмэлийн хувь заяаг харав. Тэгээд хэлсэн нь:

- Та нар хар муу үйл хийхээр явахдаа зүгээр явсангүй. Замдаа төрийн түвшин түшмэлийг дагуулжээ. Тэр худал хуурмаг явдал чинь Жамьяндорж түшмэлд муу уршиг даллажээ. “Үнэн мөнөөрөө явж буй хүнийг үхүүлсү, алсу гэсэн нэгэн нүгэл, ялыг тогтоох эрхгүй мөртлөө ямба эдэлсэн хоёр нүгэл, тэгээд дээр нь төрийн түшмэлийг хууран мэхэлж зохисгүй үгээр хордуулсан түмэн нүглийг” хүрээний лам нар та бүхэнд үүрүүлэх болох нь.

Тэгэхгүй бол энэ хүний амь нас сүйтгэгдэж болзошгүй. Яах вэ? гэжээ. Төрийн түшмэлийн амь насанд санаа зовниж байсан нөгөө лам нар ч дорхноо хувирч өөрчлөгдөж зарим нь,

- Түшмэлийн шороо нь бургисан газар энэ хийдийн гол дуганы муутай баганын дэргэд байсан нь миний зурлага зурхайд ил байна гэж мөчөөрхжээ. Тэгсэнд “Ялгагчийн гэгээн” лам нарыг цаашлуулж түшмэлийн амьсгал хураах цаг нар, биенээс нь сүнс дайжих агшин хормыг өөрсдөөр нь нэгд нэгэнгүй хэлүүлж аваад, инээд алдан өгүүлсэн нь:

- Та нар үнэхээр манай бөглүү нутагт шашин төрийн хууль номыг сахиулах гэж ирээгүй юм байна. Би одоо энэ түшмэлийн амийг аварья гээд хир даг болсон сэмэрхий хадаг гарган хэдэнтээ шувтарсанд лам нарыг аль хэдийнэ диваажинд очуулахаар болоод байсан Жамьяндорж түшмэл өндөсхийн цочсоноо,

- Ёох, би яасан удаан унтав даа. Тэгэж байтал цав цагаан унага давхиж ирээд миний гутлын хоншоорыг цавчлав гэж зүүдлээд ийн сэрэв хэмээн босч иржээ. Болсон явдлыг сэрсэн даруйдаа мэдсэн Жамьяндорж лам нарыг тус бүр хорь хорин удаа банздаж Винайн ёсыг сахиж ирсэн гэх бие эрхтнийг нь яр шарханд бариулж орхисон гэдэг.

## Амхай удганд эмээгийнх нь сүнс байнга харагддаг байв

Сүүлийн үед зургаа дахь мэдрэхүй нь хөгжсөн хүний тухай бидний ойлголт мухар сохроор шүтэхээс арай өөр байдлаар илэрч эхлэв. Асуудлыг үнэн бодит байдлаар харуулах нь Монголоор дүүрчихсэн бөө удган, мэргэн төлгөч үзмэрчдийн нэр хүндэд хэрэгтэй. Тийм нэвтрүүлгийн ОХУ болон Европын олон оронд явуулдаг. Тэр нэвтрүүлгийг шууд орчуулахад “Зөн билгийн тулаан” гэж манай арилжааны телевизүүдээр гарах болсон шинэвтэр бөгөөд “шипитэй” нэвтрүүлэг болж байгаа юм. Энэ нэвтрүүлэгт хүрэлцэн ирж оролцоосой гэдэг үүднээс нэгэн удганы талаарх яриа, түүнтэй хоромхон зуур ч атугай ярилцсан талаар бичвэрийг толилуулъя.

Түүнийг шүтсэн үгс:

- Татчихсан гар хөл нь тэнийчихэж гэнэ.
- Мэдээгүй бие нь мэдрэл орж эдгэрчээ.
- Хэдхэн тоолуулаад хэл орчихжээ
- Бүдэг хараа нь тарнидуулаад тодорчихож гэнэ.
- Яасан ам буянтай хүн бэ?
- Тэр одоо хаана явна.

Ингэж Увс аймгийн зүүн сумдын хүүхэд шуухад, хөгшид хөвөөгүй ярилцаж байв. Эл бүрхэг ярианы учиг сүлдийг олж мэдрэхсэн. Энэ бол сэтгүүлч хүний “өвчин”. Түүнийг Дүгэрхүүгийн Амаржаргал гэнэ. Одоо тавин настай. IV анги төгссөн, амьдралын гачигдлын улмаас цаашид сургууль соёлын мөр хөөгөөгүй. Харин нөхөр улсын аварга комбайнч болж байсан. Баруунтурууны САА ид цэцэглэж байхад баатрууд жагсах ирээдүй харагдаж байхад ийн ажиллаж байжээ. Тэр даруухан зан гаргаж байв.

- Мэргэн, ид шидтэй удган гэж таныг нутаг усныхан чинь шагшицгаах юм. Энэ үнэн үү? гэхэд гомдох гонгинохгүй юм хоолойгоо засаад,

- Олноос онцгой түмнээс төгөлдөр гэж би өөрийгөө дөвийлгөхгүй. Үнэнийг шууд хэлье. Би удам дамжсан удган хүн. Ингэж түс тасхан хэлснийх нь дараа бидний яриа ярилцлагын хэлбэр шилжихээс өөр аргагүй болов.

- Удган бөө гэдэг чинь заавал удам дамждаг гэл үү? Таны хувьд ямар удам байна вэ?

- Тэгэлгүй яах вэ? Миний эмэг эх Чимгээ гэж нутагтаа цуутай удган байсан. Эмээ минь 1960-аад оны эцсээр өөд болсон. Түүнээс өмнө таван үеийн удган бөө манайд байсан гэнэ лээ.

- Удган эмэг ээжээсээ юу юу өвлөсөн бэ?

- Хамгийн гол нь надад онгон сахиус нь уламжлагдан оршсон. Эмээгийн минь удганы хувьд хэрэглэж байсан зэмсэг, эдийн зүйл бараг надад бүтнээрээ бий.

- Онгон сахиус оршино гэдгээ арай дэлгэрэнгүй тайлбарлана уу?

- Удган бөө бүхэн өөртөө тэнгэрээс заяасан онгон сахиустай. Тэр онгон сахиус биед нь оршдог. Түүнийхээ хүчээр бөөлдөг гэж ойлгож болно. Удган бөөг ертөнцийн мөнх бусыг үзүүлэхэд өнөөх онгод нь ойр төрлийн хүнд шилжиж очдог байна. Энэ жамын дагуу эмээгийн онгон ач охин надад улиран заларчээ.

- Үүнийг яаж мэдсэн юм бэ?

- Энэ чинь андашгүй юм билээ. Эмээ минь надад ойр ойрхон зүүдлэгдээд шөнө бүхэн сүнс нь намайг эргэж “удганыхаа онгон сахиусыг чамд өвлүүлээ. Ингэхийг тэнгэр эцэг, газар эх даатгав” гэж улиран ятгадаг байв. Үүнээс би айж, ёстой л богино хавирга минь шир ширхийн, борхон зүрх минь пол пол цохилдог байсан. Угийн ухаалаг эцэг минь миний байдлыг зөнгөөрөө мэдэж, удганы удамшил, учир жаягийг надад хэлж өгч сэтгэлийн түгшүүрээс аварсан.

- Удган бөөгийн онгоныг залгамжлан авсан хүн анхандаа өвчтэй юм шиг татаж унаад байдаг гэж үнэн үү?

- Яг үнэн. Би 12 настайдаа өөрийн эрхгүй муужирч унасан. Унах унахдаа татаж унасныг яана. Ингэснээс үе үе унаж хавь ойрынхныгоо сандаргадаг байлаа. Аймаг сумын эмч нар “татаж унадаг өвчтэй охин, төрөлхийн гажигтай” хэмээн оношилж, элдэв эм өгч хүчтэй тариа хийсэн боловч өчүүхэн ч төдий засал аваагүй. Харин эцэг минь “Охин минь татаж унадаг өвчтэй боллоо гэж битгий зов. Өнөө талийгаач болсон ээж удганы онгон биед чинь оршиж, бөөлөхийг нэхэж байгаа хэрэг” гэж тайтгаруулдаг байв. Амнаасаа цагаан хөөс цахруулан үхэдхийн татаж унадаг “өвчтэй” надаас тэр үед зарим хүн сэжиглэдэг байсан байх.

- Тэгээд хэдийнээс татаж унахаа больсон бэ?

- Азаар гэх үү дээ. Ардчилал шинэчлэлийн улирал эхэлж, ил тод байдал нэвтэрсний ачаар язгуураасаа цаанаасаа нэхээд шаардаад байсан онгоноо амилуулан бөөлдөг болсон. Ингэснээс хойш хар зөнгөөрөө татаж унахаа больсон доо. Өөрөөр хэлбэл 1989 оны сүүлчээс эхлэн бөөлдөг болсноор татаж унадаг “өвчтэй бүсгүй” гэсэн муу нэр луу данснаас салсан.

- Бөөлөх хэцүү юу?

- Хүн бүхэн бөөлж чаддаггүй шүү дээ. Зөвхөн онгон сахиус оршсон хүн л бөлдөг. Хэрэглэлээ өмсч, зэмсгээ агсаж, уншлага тамлагаа гүйцээж, онгоноо урин дуудаж бөөлөх ч яах вэ болдог зүйлийн нэг. Харин бөөлж дууссаны дараа буюу онгод гарсны сүүлд бие цогцос тамтаггүй ядардаг. Ёстой л тулгар эх амаржсан юм шиг бүх бие салбайсан байдаг.

- Бөөгийн биед онгод нь хэдий хугацаанд байдаг вэ?

- Онгон бол удган бөөгийн биед есөн есөн дүйцэн өдөр буюу сар бүрийн 9, 19, 29, 30-нд бас заримдаа шинийн нэгэн буюу 5-нд оршин, ойр байдаг юм. Энэ өдрүүдэд бөөлөхөд их зохилдлоготой. Бөөлөхөд онгод орох хугацаа дунджаар нэг мөчлөг буюу 10-15 минут үргэлжилдэг юм билээ.

- Онгод орох буюу ирэх үед удган бөөг орчноосоо тасарч хүний ухаанаа гээдэг гэдэг үнэн үү?

- Онгод орох үедээ удган бөө хүн чинь орчин тойрондоо юу болж байгааг, хэл юу хэлснийг огт мэддэггүй. Гагцхүү бөөлж буй зүйлдээ зүрх сэтгэлээ өгч, онгон сахиустайгаа ярьж маргаж, зөвшиж байдаг торгон мөч гэх үү дээ. Тэгэхээр тийм үед ухаанаа “гээдэг” гэж үзэж болно.

- Бөө удган буюу улаач нар хувь хувийн хэлмэрчтэй байдаг гэдэг дээ?

- Үнэн шүү. Онгод орох үеэр ярьж хэлж буй зүйлийг хүн бүхэн бүрэн ойлгодоггүй. Тиймээс удган өөрийн дотно шадар хүнээрээ хэлмэрч хийлгэдэг юм. Ийм хүн удган болон бөөлүүлж буй хүмүүсийн хооронд мэдээ дамжуулж, онгон сахиустайгаа бөөгийн ярьж “шийдсэнийг” хэлж тайлбарладаг зууч шүү дээ. Бөө удган бид чинь өөрсдийгөө улаач нар гэж нэрлэдэг нь цаад онгон сахиусаа хүндэтгэж байдгийн гэрч.

- Нууц биш бол “хэлмэрч”, зуучлагчаа та нэрлэнэ үү?

- Нууцсаад байх юмгүй. Төрсөн болон хадам эгч хоёроо л дагуулдаг. Тэр хоёр маань онгодыг минь мэдэрч, үйлдлийг ажиглаж, үг яриа, аяг сэжгийг өрөөлд орхигдуулалгүй дамжуулдаг чадвартай.

- Таны мэргэ хэр цэцэн бэ?

- Түмний буян, тэнгэрийн зохиолоор надад зөн мэдрэмж заяажээ гэж боддог. Амьдрал олон талтай алаг цоогтой болохоор хүмүүсийн асууж лавласан, аргалуулж авруулахсан гэсэн олон зүйлд оновчтой хариу өгөх учиртай. Юм бүхэнд бөөлж онгодоо уриад байвал бие минь хөөрхий болно. Тэгэхлээр мэргэ буюу зөв мэдрэмжээрээ тэр бүхэнд хариу өгдөг. Илт зөн мэдрэмжээрээ дийлэхгүй юманд онгодоо урьж, түүнтэй элбэдэг хамждаг гэвэл үнэнд нийцнэ. Зовж зүдэрсэн, өвчилж шаналсан хүмүүст тусалж, тэдний өвчин зовлонгийн уг үндсийг олж, засаж залруулах, эдгээж илаарьшуулдаг. Мэргэлдэг засдаг, эдгэрүүлдэг эв аргаа би зөн мэдрэмжээрээ гүйцэлдүүлж байна.

- Зөн мэдрэмж гэж таны бодлоор юу вэ?

- Зөн мэдрэмж бол хувь хүнд заяасан бурхны өглөг, тэнгэрийн хишиг. Хүнтэй ярилцах, тухайн юмыг эргэцүүлэхэд зөн орж сэтгэлд гялсхийсэн санаа сэдэл төрдөг юм. Үүгээрээ би хүмүүст тус дэм үзүүлж ирлээ.

Төгсгөлд өгүүлэх нь: Д.Амаржаргал бол хөх тэнгэрээс заяатай монголчуудын язгуурын шүтлэг, удмын мэдлэг бөө мөргөлийг төрөл арилжуулахгүй залгамжилж ирсэн хүмүүсийн нэг. Түүний мэргэ төлгө, бөөгийн увидас шидийн талаар хүмүүс олныг өгүүлж, батлан

хэлэлцдэг билээ. Баруунтуруун сумын малчин Т.Магалжав:

- Амхай (Амаржаргалыг хэлж байна) маань хол ойрын олон хүнд тус болж, тэднийг өвчин зовлонгоос салгаж байна. Тухайлбал манай эндхийн нэг тракторчны хөл олон жил өвдлөө. Цөхөртлөө эмчлүүлээд төдийлөн засрал авсангүй. Тэгтэл түүнийг Амхай үзээд “Та чинь онгон газраас мод огтолчихсон юм уу даа. Тэр газраа даруй тахиул. Наминчлан мөргө” гэдэг юм байна. Өвдөж зовсон амьтан хэлснийг нь биелүүлэхгүй яахав. Амхай өөрөө тэр газрыг нь тайж тахив. Үнэхээр тэр хүн арваад жилийн өмнө Харцагаан ус (Зүүнтурууны гол) эхнээс зулзаган мод огтолсон ажээ. Тайлга мөргөлийн дараа түүний хөл өргөс авсан юм шиг илаарьшсан юм. Сонин зүйл аль тохиолдохыг тэр гэх вэ. Манай саахалтын айлын нэг охины бие гэнэт муудлаа. Амхайг залж үзүүлэв. Тэгсэн яасан гэж санана. Охины эцэг эх болон гэрт байсан хүмүүсийг гадаа гаргалаа. Амхай тэр хоёр нэлээд ярилцав. Төдөлгүй Амхай ойрын нэг сархиагт очиж сан хүж тавьж ариутгалаа. Охиныг ширэглэж, хормой хотыг нь ариулж сагналаа. Ингэснээр муудсан охин гэнэт сэхэж билээ. Хожим сонсвол амин судалтай газар өдрөө ололгүй энгэр зөрүүлснээс гэнэн охин айж цочирдож өвдсөн ажээ. Түүний арандгийг Амхай номхотгож ачилсан нь тэр дээ”. Түүний тухай энэ мэтийн яриаг хэдэн хуудас ч үргэлжлүүлж болох ажаам.

Нээрээ ч тийм юм уу даа гэх бодол надад төрж билээ.

## Аяганд ниргүүлсэн хүний сүнс үлдэхгүй тонилдог

Нутгийн нэгэн өвгөн номчтой хууч хөөрөн суухын хажуугаар сүнсний тухай жаахан яриулчих юмсан гэж би бодож байв. Өвгөний ярьснаар хүн бүхэнд сүнс байдаг. Харин аяганд ниргүүлж үхсэн хүний сүнс алга болчихдог. Үлддэггүй юм гэдэг хэмээн ярьсан юм. Яагаад? гэж давшлах миний сонирхлын хариу болгож өвгөн номч нэгэн түүхийг ярьсан юм.

Баруун нутагт нэгэн хараал гэхэд хараал биш гүн ухаан гэхэд гүн ухаан биш “сүнсээ түймэрдсэн амьтан бэ?” гэсэн үг байдаг. Өвгөний ярьсан түүх бол энэ үгийн тайлал шиг санагдсанаас ийнхүү дурьдсан хэрэг л дээ.

Энэ насандаа их нүгэл үйлдсэн хүнийг “Сүнсгүй амьтан, ёстой нэг сүнсээ түймэрдсэн амьтан даа” гэж ярьдаг нь одоо ч монголчууд бидний хар яриан дотор байж л байдаг юм.

Түүхийн нэгэн эгзэгтэй үед гэнэ лээ. Октябрын хувьсгалаар хөөгдсөн цагаантны үлдэгдлүүд Монголын баруун хязгаар Тагнын нурууг давж, амгалан монгол орон руу шуналын нүдээ бүлтийлгэж, сувдаг шүдээ ярзайлган орж ирж байсан цаг. Хөх Дамиран Александр хэмээх орос худалдаачинтай наймаа хийдэг байж дээ тэр үед. Самгалтайн хүрээн дээр (одоогийн Тувагийн Тэсхем Районы Самгалтайн Кошуун) наймааны ажлаар явж байсан хөх Дамиран урт буу үүрсэн бөөн бөөн орос цэргүүд орж ирэн сүм хийдийг түйвээж лам нарыг тамлан зовоож байгааг хараад сэтгэл нь ханаж харийн тэр дээрэмчдэд тал засах маягтай толгой дохин зогсч байв. Цагааны нэг ноён түүнийг хараад хуруугаар занган дуудаж Самгалтайн хүрээний нэгэн өндөр зиндааны ламыг ташуурдах тушаал буулгажээ. Мэдээж цагааны ноён хөх Дамиран татгалзах байх. Тэгвэл өөрийг нь залхаан цээрлүүлж байгаад хүчээр нүгэл хийлгэнэ гэж тооцоолжээ. Энэ нь орос ноёны монголчуудын дунд яс хаясан бодлого байв. Гэтэл юу болсон гэж санана. Мань Дамиран Орос даргын ташуурыг шүүрэн авч өвгөн ламын нүцгэн биеийг улаан нялга болтол нь ташуурдаж гарав. Дамиран бүр дүрдээ итгэчихсэн өвгөн ламтныг улайран ташуурджээ. Монгол хүн монгол хүнээ харийн зандалчны өмнө ийнхүү хайр найргүй залхаажээ. Харин Цагаан цэргийн дарга түүнийг сэжиглэн харж “Одоо болно” гэж түлхэн хойш болгосон гэдэг. Түүнээс хойш хоёр жилийн дараа 1922 оны зун хөх Дамиран нэгэн адуу малынхаа эрэлд явж байтал бөөн үүл гэнэт гарч ирэн аянга цахилгаан нижигнэжээ.

Яах ийхийн зуургүй хөх Дамиранг аянгын гал гортиглон аваад “байныхаа 10” дээр оруулан нирхийлгэв. Хашир эр энэ үед ташуураа шидсэн гэдэг. Морь нь айсандаа чавхны чулуу сүнхийж байв. Төдөлгүй дахин нэг аянгын гал Дамиранг бүслэв. Мөн л урьдын адилаар... Энэ удаад малгайгаа “хаяж өгөөд” бүслэлтээс гарсан байна. Энэ мэтээр бүс дээл юу л байна тэр бүхнээ тайлж шидэн зугтсаар байсан ч Тарвагатайн уудам хөдөөг туултал өдий тул хамаг хувцсаа аяганд тавьж идүүлсээр морин дээрээ чармай нүцгэн үлджээ. Аянгын дуу холдох шинжтэй байснаа гэнэт бөөгнөрөн хуйлрах их хар хүчний төв дунд Дамиран орж явчих шиг болжээ. Энэ удаад тэр аяганд ниргүүлж, морьтойгоо хамт хуйхлагдан, хярвас

үнэртүүлэн хэвтжээ. Аяганд нэрвүүлсэн түүний хойдохыг уншуулах гэсэн боловч түүнд хойдын үйл, хойд нас гэж үлдсэнгүй ажээ. Энэ бүхнийг ярьсан өвгөн номч,

- Аргагүй шүү дээ. Сүг сүүдэр, сүлд сүнс гэж бид ярьдаг шүү дээ. Аянгын хурц гэрэл догшин

гүйдэлд дайрагдсан амьтны сүүдэр нь эхэлж шатаагддаг юм гэнэ лээ. Тэгэхлээр бас сүнс нь хамт явчихаж байгаа хэрэг шүү дээ гэв.



## Булшин дээр хачин амьтантай таарч буудан хороов

Жараад оны дундуур хангайн онгон догшин уул нуруу, Идэр, Тэс голын хөндий газруудаар ийм нэгэн домог гэвэл домог биш үнэн гэвэл үнэмшмээргүй яриа хөвөрч байжээ. Анчин Даржаа хэмээх эр намрын сард олон хоногоор авлахаар бэлдэж хангай хайрханыхаа хишигт мөргөн, эхнэр хүүхдээ үнсээд л гараад өгчээ. Даржаа бол хар багаасаа уулаар тэнэж, хадаар хань хийж явсан нэгэн болохоор айж сандрах гэгчийг мартсан нэгэн байв. Тийм болохоор өмнө нь өгүүлэх гээд “домог шиг” хэмээсэн зүйлийг олж харахаар, болж өгвөл барьж ирэхээр дотор хүнтэйгээ ярьж “тохирсон” байлаа.

Нөгөө ярихаас дөлөөд байгаа “домог шиг” зүйл маань юу вэ гэвэл ийм юм. Хангайн ноён нуруу өндөрлөг газарт бол урт хар хүн шиг амьтан болж үзэгдэх, гол мөрнүүдийн сав нам дор газраар бол үнэг болж харагдах нэгэн албин шидтэй амьтан тэр нутагт бий болсон гэх яриа ихэд дэлгэрчээ. Тэр амьтантай уулзаж учран балрах шахсан, араас нь нэхэж яваад айгаад буцсан гэх төрөл бүрийн яриа янз бүрийн хүний амнаас сонсогдох боллоо. Зарим хүнд хүүхэн хүний дүр төрхөөр ч харагдсан гэнэ. Намжил гэгч дунд хэрийн насны нэгэн эрийг голын хөвөөгөөр хадлангийн талбайгаа эргэж явтал урт гялалзсан саатай саарь хүзүүндээ унжуулсан энэтхэг бүсгүй даллан дуудсан гэнэ. Мань эр ч зүрх зоригоор нимгэн нэгэн тул уухайн тас мориндоо ташуур өгөн давхижээ. Гэтэл мөнөөх дорно дахины гоо үзэсгэлэнг бүрдүүлсэн бүсгүй түүнтэй зэрэгцэн гүйж, харин хөлийнх нь тавхайнаас гал маналзаж үе үе утаа пур пурхийн байсан ч гэх.

Социализмын их бүтээн байгуулалтын үед хадны мангаа шиг сонсогддог байсан улсын хөрөнгө мөнгийг идэж шамшигдуулаад оргож боссон хүмүүсийн тухай аймшигт ярианд энэ бүхэн тулж очно. Тэгээд элдвээр цуурч байж хэрэгт холбогдох бий вий гэх болгоомжлолоор энэхүү яриа ийм байдалд хүрээд зогсох бүлгээ.

Даржаа анчин нэг иймэрхүү л битүү мэдээлэл, давс хужир түрхсэн хуудуу мэдлэгтэйгээр гэрээсээ гарчээ. Хангай дэлхий зээрэн хөнжил нөмөрсөн мэт нэлэнхүйдээ шаргалтан дуниартана. Хулгар шар бараг ичиж дуусаж байв. Мөнгөн хяруу цавцайсан өглөө Даржаа эртлэн босч өвсөн овоохойгоо үүд хаалгыг нь бэхэлж, хүнсний зүйлээ элдэв амьтанд “хулгайлуулчих” вий хэмээн нууж далдлаад мөнөөх урт хар хүн, эсвэл зальт шар үнэг, урт саарь алчууртай бүсгүйн аль нь болохыг хэлж мэдэхгүй амьтаны эрэлд морджээ. Аян замын хань болсон бугаа үүрч, дурангаа авахаа мартсангүй. Мориндоо ташуур өгч ширүүхэн галгиулсаар нэгэн бэлчир газар гарч ирлээ. Гэрийн эзэн өрхийн тэргүүн болоод нутаг усандаа нэр нүүртэй хүний хувьд айл саахалтынхаа адуу малын байр байцыг мэдэхээр өндөр хиргисүүрүүдийн (булшны) дэргэд мориноосоо бууж эргэн тойрныг тандах мэт дурандав. Тэртээ энгэрт хонин сүрэг идээшилж байгааг ажиж “эзгүй хээр ийм эрт хэний хонь байдаг билээ?!” хэмээн уулга алдтал муур шийхтнах шиг, нохой улих шиг, хүүхэд уйлах шиг, эр хүн эрмэг цолгиун исгэрэх шиг холион бантан гэмээр чимээ сонстов.

Юу вэ хэмээн чагнаарах зуур морь нь ч хамраа тачигнуулан үргэж бүсэндээ хавчуулсан байсан цулбуурыг суга татан давхиж одов. Гөлмөө дэрвүүлэн үргэж одсон морь нь төдөлгүй номхорч сульдсан байдалтай шээс алдан шогшиж иржээ. Мориных нь хүзүү омлуурын доогуур нэгэн үсэрхэг нүүр цухуйх шиг болжээ. Даржаа гайхаж бас айсандаа ухаан алдах

шахав. Тэр “Карл Марксаас” өөр ийм үс ноосондоо баригдсан амьтны үнэн дүрийг байтугай зураг патиарийг ч амьдралдаа үзээгүй байжээ. Тэгснээ мөнөөх ноосон нүүртэй амьтан мориных нь эгц ар талд гарч сүүдийсэн өндөр саарал юм болж үзэгдэхэд дотор палхийж толгойны үс өрвөсхийлээ. Морь нь тэсч ядах мэт чарлаж өнөөх зэвүүн саарал амьтныг өшиглөж тангарав.

Мөнөөх амьтны хүнийх шиг урт хөл морины хурц туурайнд оногдох боловч өчүүхэн ч өвдсөн, цохиулсан байдал үзүүлэхгүй ажээ. Морь урд хоёр хөлөөрөө цахдан хойд хоёр хөлөөрөө үсэргэн өшиглөтөл зэвхий ягаан саарал амьтан унах шиг бүртгэсхийлээ. Эзнээсээ ивээл хүсэх мэт морь нь дугуйран эргэнэ. Мөнөөх зэвхий амьтан хойд хоёр хөл дээрээ оцойтол босч ирээд Даржаа руу улаан халз дайрлаа. Даржаа, үл мэдэх амьтан хоёрын “тулалдаан” эхэллээ.

Сүнсээ зайлтал айсан Даржаа түүний өөдөөс чулуу мөндөр буулгав. Тэнэсэн сум тархинд гэгчээр аягын чинээ чулуу амин газрыг нь онов бололтой мөнөөх амьтан дөрвөн хөллөж унаж тусав. Энэхэн зуур Даржаа сэхээ авч бугаа шүүрч аван хараалж цээжин биед нь баараггүй буудав. Ёолон гаслах, чарлан халаглах мэт бүтэл зэхий хахирган дуун хадаасаар гайхал амьтан чимээгүй болов. Даржаагийн хамаг биенийх нь хар хөлс асарч, амьсгаа давхацжээ.

“Юу гээч болчихов оо” хэмээн эргэлзэж “Ялагдсан” үхэдийг тойрч үзээд мэл гайхаж цэл хөхрөв. Муу зүгийн юм хичнээн аймшиггүй хүн ч гэсэн Даржаагийн толгойд орж муужран унах шахлаа. Ерөнхийдөө хүнэрхүү дүрстэй мөртлөө урд хоёр хөл богино, хойд хоёр хөл урт, арагшаа гээдэн толгойтой, хар сээрээрээ бөгтөр, намхан налчгар хамартай түгдгэр нуруутай, хавтгай цээж шувтан бөгстэй дугариг соотон чихтэй, бэгбаатарынх шиг нүүртэй, хацрын яс товгор, намхан налчгар хамартай, хавшгар яйнагар эрүүтэй, дарвагар том амтай, өргөн биш духтай, улцан ягаан зүстэй их биедээ үсгүй, зөвхөн сүүлнийхээ үзүүрт үл мэдэг хүрэвтэр хялгасан оромтой, Даржаа байтугай хэн ч урд өмнө нь огт үзээгүй, ор төсөөлөхгүй амьтан байлаа. “Аа жигтэй юм байна” гэж хэзээний хэнэггүй зангаараа Даржаа завилан сууж галзуу улаан дүнсээ угсарч байтал өнөөх амьтан гэнэт амилж гөлтгөр хоёр нүдээ цох хорхой шиг гялалзуулж дахин өндийв. Хэрэг бишидсэнийг Даржаа мэдэрмэгц бугаа сумлан гайхлын цохонд хараалан ониллоо.

Гайхал амьтан урд хоёр гар (уг нь хөл л гэмээр)-аараа цохоо дарж “Битгий бууд” гэсэн шиг зовиурлан гасалсаар... Буун дуун тасхийж түүний цохонд мэргэн тусав. Ахиад тэр өндийсөнгүй. Түүнийг чирч хүн амьтан үзэг гэж улаан зам дээр гаргаж орхив. Чингэхдээ гэдэс хээлийг нь ажиж хавтгай өвчүүний хоёр этгээдэд товойж байгааг анзаарч “Эм хөсрий” хэмээн Даржаа амандаа шивнэлээ. Бас арзгар шүд, ёрдгор соёо, майгадуу хөлийг нь хяламхийн харахдаа “Чононоос арай бэсрэг, үнэгнээс илт том биетэй юм уу даа” гэж бодож амжив. Даржаа мориндоо аливхийн мордож,

- Ум базарваань хум пад муу муухай бүхэн чигээр дуусаг! хэмээн амандаа шившээд үл мэдэг амьтныг дийлсэндээ урамшиж, цааш одлоо. Нутгийнхаа хашир өвгөнийг дагуулан буцаж ирэхэд нөгөө сонин амьтны цогцос ч үгүй болчихсон, харин Хиргисүүрийн (булшны) чулуу нүх гарч ямар нэгэн амьтан тэр рүү ухаж орсон байдалтай байжээ. Ёс мэддэггүй хүнд ёр халддаггүй гэгчээр Даржаа болон түүний ойр дотныхонд үүнээс болж муу юм тохиолдоогүй гэдэг.

## Торгонд шүглэсэн хараал бүсгүйг хорложээ

Торгон Бадарч гэж цэмцгэр ганган эр социализмын үед дарга мяндагтангуудын дургүйцлийг байнга хүргэдэг байв. Тэр хэзээ ч нийгмийн тустай хөдөлмөрт оролцож, социализмыг хурдан байгуулаад дуусчихъя гэж ханцуй шамлаж явсангүй. Нэг удаа сумын төвийн хүн толгойтой бүхнийг гэрээс нь хөөж гаргаад хог цэвэрлэж цементээр явган хүний зам цутгах ажилд дайчлав. Мэдээж энэ нь жил жилийн 4 сард Лениний мэндэлсэн өдрөөр зохиогддог коммунист субботник юм. Торгон Бадарч энэ удаа хашаа, гэрийнхээ үүд хаалгыг давхар цоожлоод ч барсангүй. Субботникт хүчээр дайчлагджээ.

Мань эр дуртай дургүй нэг шуудай бариад гэлдэрч явав. Гэтэл өмнө нь Дарь чавганц хазганан гүйж хог новшийг шүүрдэж цэвэрлэж тэрхүү коммунист үйлдэлдээ хөөрч баярлаж байв. Бадарч шилээ шөргөөж чавганцыг хялайн харснаа,

- Хм. Та юунд ингэж хазгар хөлөө хугалчих шахаж явдаг юм бэ? Май, энэ шуудайны нөгөө өнцгөөс бариатах. Хоёулаа хөдөлж ядаж байтал энэ хөнгөн хөндий амьтад амжуулчихна гайгүй хэмээн чавганцыг өөртөө элсүүлэв. Чавганц ч хөгширснөөс үхсэн биш гэдэгчлэн сум аймагтаа гайхагдсан ганган эртэй мөр зэрэгцэн яваадаа бас чиг маадгар байв. Аль бүхэнд лазантаж сурсан Бадарч Дарь чавганцын хөл муутай, нас өндөртэй болсон зэрэг төвөгтэй байдлаар өөрийгөө халхлан бие амар үлдэх заль хэрэглэж байгааг эвлэлийн үүрийн дарга Пунцаг мэдээд Балзан өвгөнийг хөтлөн Дарь чавганцын хажууд очоод,

- Дарь гуай та энэ хүнтэй хоршсон нь дээр. Харин ганган

Бадарч зам цутгах ажил дээр очоорой гэжээ. Энэ мэтийн жижиг сажиг юмыг авч хэлэлцэхгүй хэмжээний эр байтлаа Бадарч их эмзэг хүн байв. Тэр нүүрнийхээ арьсанд хамаг цусаа авчирч ууталж орхив уу гэлтэй чинэрүүлэн уурлаж,

- Пунцаг аа, чи дандаа намайг илүү харж билүү долоож явахаа боль. Та нарын сүйд болж жил жилд цутгадаг зам чинь хэзээ ч хүнд хэрэгтэй юм болохгүй. Гантай зуны баян бүрдийн шавар шиг удахгүй хатаж барзайгаад хагарч салж унах юм чинь хэмээн үгээр дайрав. Үнэндээ торгон Бадарч л хэлснээс биш энэ нь ёстой орой руу орсон үнэн үг байв. Нэг удаа торгон Бадарч хэд хичнээн төгрөгийн хөрөнгө гарах юм, тэрнийгээ тооцоолоод надад хариуцуулчих би энэ сумын төвийн гутал булхсан элс шороог үгүй хийж цардмал замтай болгоод өгье гэж сумын захиргаанд хандахад

- Сумын төвийн бүх албан байгууллага нийлж хамтраад ч бүтэхгүй байгаа юмыг торгон Бадарч ганцаараа хийчих юм гэнэ. Улсын хөрөнгийг мангасын аманд тавьж өгөх гэж үү? хэмээн хариуцлагатай албан хаагчид түүнийг гарсан хойно нь инээлдэж байжээ. Одоо бодоход торгон Бадарч тэр үед одоогийн зах зээлийн ухаанаар аливааг шийдэж сурсан нэгэн байж уу дээ.

Бадарч энэ удаагийн субботникт дайчлагдсандаа шарлахсан уу яасан маргааш нь гурван дугуйтаа асаагаад эртлэн аймгийн төв рүү гарч өгчээ. Нэг л субботник эхэлчихвэл бараг долоо, арав хоног юу хийж байгаагаа ч мэдэхгүй мөртлөө албадлагын хөдөлмөр эрхэлдэг

байсан тухайн үед Бадарч дараа дараачийн субботникуудаас зугтсан ч байж болох юм. Торгон

Бадарч дарга нар болон хэнхэг сэхээтнүүдэд ад үзэгддэгээс биш бүсгүйчүүлийн хувьд нэр хүнд нь асар өндөр нэгэн байв. Юу гэвэл нөхөр нь хэзээ ч авчирч өгөх нь бүү хэл санаанд нь ч багтахгүй хятад торго, түвд хоргойг Бадарч л авчирч бүсгүйчүүдийг олны өмнө нүүр улайхгүй хувцас өмсөх боломжтой болгоно. Маргааш нь Бадарчийн хаалгыг цохиход хэн ч гарч ирсэнгүйд аймгийн төв рүү явсан гэж Пунцагт хөрш нь хэлжээ.

- Муу феодалын үлдэгдэл. Нөгөө муусайн торго, хоргойгоо авчирч эхнэр хүүхнүүдийн нүдийг хужирлаж, тэднийг хэрэгтэй хэрэггүй зүйлээр мэхлэх гэж байгаа юм гэж Пунцаг дарга сүрхий уурсаж бараг Бадарчийн өмнөөс хамгийн дуулгавартай, үлгэр жишээч хүнийг гурилаар хийгээд тавьчихмаар аятай санаа сэтгэл нь тогтворгүйтэж байв. Үнэхээр торгон Бадарч аймгийн төвөөс Улаанбаатар руу нисч одсон бөгөөд хэд хоногийн дараа хуй хуйгаар торго, ам амаар нь хоргойг ачиж иржээ.

Тэр үед Мао-Зэ-Дуны зурагтай торгыг урд хөршид үйлдвэрлэдэг байсан аж. Бас Орос, Хятадын харилцаа муудаад байсан болохоор Орос ахаа дагасан Монгол бас л Хятадтай таагүй харьцах болоод байв. Гэхдээ энэ айл гурван улс гурвуулаа коммунист чиг баримжаагаар хөгжиж байсан билээ. Эвлэлийн үүрийн дарга Пунцаг торгон Бадарчийнд эртлэн орж,

- За Бадарч минь бид нэг нутгийн хүмүүс. Ийм болоод л би чамайг хүн шиг яваасай гэж боддог юм. Одоо бол харин яах ч арга алга. Чи Мао Зэдуны толгойтой торго зарж, хятадын дээрэнгүй үзлийг дэврээж байгаа чинь тоогүй гэх мэтээр ухуулж сэнхрүүлэхээсээ айлгаж сүрдүүлэх гэсэн маягтай үг хэлжээ. Торгон Бадарч мөчөөгөө өгсөнгүй,

- Чи хэдхэн жилийн өмнө “Урд зүгээс наран мандлаа. Их Мао Зэдун Хятадад төрлөө” гээд дуулж явсан чинь юу вэ. Тэгж ярих юм бол би ямар тэр торгыг өөрөө хийчихсэн биш гэж амыг нь таглажээ. Пунцаг сүүлчийн мэхээ хэрэглэж,

- Чи надтай юм яриад нэмэргүй. Би коммунист хүн. Намын төв хороо хүртэл заргалдах эрхтэй. Гэтэл дамын панзчин чиний үгийг хэн сонсох юм хэмээн аархаж амыг нь асуужээ. Торгон Бадарч ёжтойхон инээмсэглэж,

- Чи ингэж дүвчигнэж байхаар Сүрмаагийн захиад байсан торгыг хоргой эмжээртэй нь хүргээд өгчих гэжээ. Пунцаг давхийтэл цочоод түүнийгээ нууж босоод хаалга саван гарч оджээ. Сүрмаа гэдэг нь Пунцаг даргын эхнэр ажээ. Пунцаг бол олон нийтийн газар сүржигнэж коммунист царай гаргадаг боловч эхнэрийнхээ дэргэд бол хурга шиг болдог байв. Мэдээж үүнийг торгон Бадарч мэдэлгүй яахав дээ. Торгон Бадарч бол торгон дээл торгон өмд, торгон оймсноос салдаггүй нэгэн. Удмаараа л эднийхэн ийм гялгар тольгор хүмүүс байгаа юм гэж нутгийнхан нь ярилцана. Бас зарим нь “эднийхний хоёр гавьжийн юм энэ Бадарчид л үлдсэн байх учиртай даа” гэнэ. Энэ юун тухай үг вэ гэвэл Бадарчийн хоёр авга ламыг эсэргүү гээд баривчилж одсон гэдэг. Тэгээд л тэдний бурхан шүтээн, эрдэм увидасыг Бадарчид өвлөгдсөн байх учиртай гэж хүмүүс ярилцдаг байв. Пунцаг эхнэр Сүрмаагаа “Бадарчаас битгий торго ав” гэж хичнээн ятгаад ч нэмэр болсонгүй. Тэр зүтгэсээр байж Мао Зэдуны зурагтай хар хөх өнгөтэй торго авчээ. Хүүхэддээ мөнгө өгч гүйлгэж авахуулахад Бадарч дуртайяа өгч явуулжээ. Пунцаг түүнийг дургүйлхэхгүй байна уу гэхэд,

- Юу гэнэ вэ. Эд нь мөнх эзэн нь хэврэг байг гэж байна гээд хэлчихээрэй гэсэн гэв. Гэвч тэд энэ үгийн учрыг ойлгосонгүй. Ерөөл дэмбэрэлийн утгатай үгийг өөрчлөөд хараалын чанартай болгосныг нь хэн ч анзаарсангүй. Сүрмаа торгоороо дээл оёулах гэж сумын урдаа барьдаг уран Жавзангаар эсгүүлж байв. Тэгсэн чинь гэнэт Жавзангийн царай хачин болж, барьж байсан хайчаа алдах нь холгүй алмайрч орхижээ. Тэгснээ:

- Энэ торгоны хээ (Мао Зедуны дүрс) болгоны цаанаас цус харагдаж байна. Ер нь эд болохгүй л зүйл байна даа гэж хэг ёгхийсэн үг хэлжээ. Социализмдаа дэндүү итгэдэг Пунцаг, Сүрмаа хоёр эхэндээ гайхаж тээнэгэлзэж байснаа,

- Та олон юм ярилгүй зүгээр л эсгээд оёод өг гэжээ. Сүрмаагийн хадам ээж нь хаа газарт байдаг хэрэг дуртай чавганц нарын нэг тул энэ бүхнийг сонсоод,

- Сэвтэй торгоор эд хийж болдоггүй юм. Намайг багад сэмэрхий хадгийг муу санасан хүндээ барьдаг гэж ярьцгаадаг байсансан гэж хүч нэмэгдүүлсэн боловч түүний үгэнд хэн ч орсонгүй. Зуны сар гарч удаж төдөлгүй наадам болох гэж байсан болохоор Сүрмаагийн арга ч үгүй биз. Тэр нутгийнхан сумаараа зусланд гарна. Сумын захиргаа эмнэлэг гээд албан газрууд гэр барьж зуслангийн байдалтай үйл ажиллагаа явуулна. Наадмын өглөө Сүрмаа бага залуу насандаа үеийн охидтой хамт яаж наадам үздэг байснаа дурсан дүү охинтойгоо хамт мориор наадам явах болов. Пунцаг бэлэн машин байхад суугаад явчихгүй. Хөдөө өссөн моринд эрэмгий нь ганцхан чи юм уу гэх мэтээр хичнээн үглээд ч нэмэр болсонгүй. Ёстой үнээ тугал нийлүүлдэг хоёр Мөнхийн үеийн орон нутгийн наадам ч шударга сайхан болдог байсан болохоор нударга зангидсан нийгмийн дунд ганц харах юм бол наадам л байлаа. Сүрмаа хөнгөн явдалтай хонгор мориндоо мордонгуут ташуур өгч инээд алдан давхиулав. Дүү нь түүнийг гүйцсэнгүй. Наадам болох газар хориод км-ийн зайтай тул энэ хооронд Сүрмаа дүүтэйгээ хэд хэдэн удаа мориныхоо шандсыг сорьж хүүхэд ахуй насныхаа баяр хөөрийг хээр хөдөөгийн анхилам агаар лугаа залгихын мөрөөс болж байв...

Хонгор морь толгойгоо урд хоёр хөлнийхөө завсар оруулах шахам тонгойж ирээд цахилан хурдлах нь хажуунаас харсан хэний ч нүдэнд “казбек” тамхины зураг шиг харагдана. Энэ омголон басхүү баяр хөөр бялхсан агшин удаан үргэжилсэнгүй. Түүний амьдралын ийм торгон агшныг мөнхийн цаг хугацаанаас огтолон авах гэсэн шиг Сүрмаагийн урд нэгэн гүнзгий жалга шүдээ ярзайлгах араатын аварга том ам лугаа харлаж байв. Төдөлгүй тэр жалга бүсгүйг “залгиж” орхив. Сүрмаа морьтойгоо харваж унаад нас баржээ. Хүн бүхэнд гоё инээд баясал аз жаргалаар бялхсан ганган хувцсаа өмсөж наадмын өдөр Эвлэлийн үүрийн дарга Пунцаг хайрт эхнэрээсээ хангацсан ажээ. Түүнээс хойш хар хөх торгон дээлтэй бүсгүй хүн амьтан олон цугласан газруудаар үзэгдэх болсон гэх жиг жуг яриа нутгийнхны ам дамжих болов. Энэ нь ч Пунцагийн чихэнд хүрчээ. Тэр хүмүүсийн өмнө өөрөө буруутай мэт айн хулчийж явдаг байлаа. Нэг өдөр торгон Бадарч Пунцагтай таарахдаа,

- Эд нь мөнх эзэн нь хэврэг хорвоо юм даа гэж эмгэнэлийг нь хуваалцаж сэтгэлийг нь “зассан” гэдэг.

## Нүглээ нуусан ч нүүрэн дээр нь гарч ирээд болсонгүй

“Бузартчихжээ” гэхэд л “Яадаг билээ, ийдэг билээ. Аварч өршөөгтүн” гэж үглэж дуулаад байдаг цаг нэгэнт өнгөрсөн ч гэсэн бузрын хорлол гэдэг нь ямар нэгэн шинжлэх ухаанд барагдаж “олзлогдон” тайлбарлагдаагүй гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрдөг. Тийм болохоор биеийн тэнхэл доройтож, өвчин эмгэгт баригдчихсан тохиолдолд ямар ч лам “Анагаах ухаанаар яв. Бас ном гүрэм уншуул” гэж хэлдэг болсон нь аль алийг нь бодсон хэрэг юм. Эртний Тонвадонсал хэмээх номонд “Биед бузар тусвал бие хүндрэх бөгөөд тэнхээ тамиргүй болж өнгө зүс доройтож, бүх бие булран зодуулж зодуулчихсан мэт санагдана. Хэлэнд бузар тусвал хэл нь тодорхойгүй бөгөөд гэнэт дуу хаагдаж хэлгийрч үг ариун бус болж тэнүүчлэх болно. Энэ үед хэлийг нь жанлавлах ба таван мах бодын тарнийг олон тоол. Сэтгэлд бузар тусвал мартагч нь их бөгөөд унтууцах, ялимгүй зүйлд сэтгэл амаргүй нойр хүрэх болно.

Бодол харанхуйлах, сэжиг ихдэх, ажил үйлс доройтох болно. Түүнд “Бие, хэл, сэтгэл гурвын бузрыг арилгах санг үдшийн цагт олон тавьж уг” хэмээсэн байна. Энэ бүхэн бидний амьдрал дээр цаг үргэлжид тохиолддог ч гэсэн магадгүй алгуурлах зангаасаа болоод хэн маань ч анзаардаггүй байх. Тийм гэж үзээд нэгэн жишээг татъя. Ядамжавыг махаа барж, арьс яс болж өөд болоход олон хүн харамсан гашууджээ. Бас бурхан шашин, буян, нүгэл мэтийн ойлголтыг ч үгүйсгэх бодолтой хүн ч гарч ирэв. Энэ нь юу болсноос вэ гэвэл Ядамжав хар багадаа эцгээсээ өнчирч үлдсэн нэгэн. Айлын том хүү тул амьдралын хатуу хүтүүг хар багаасаа үзэж, зовлон зүдгүүр амсчээ. Өнчин өрөөсөн өссөн түүнд омголон догшин ааш зан төлөвшсөнгүй. Бас хүн хүний ая эвийг олж амьдралаа болгох сэтгэл зүйтэй нэг бодлын бусдаас хараат нэгэн болж өсчээ. Түүнийг сайн таньж мэдэхгүй хүн бол “Хөөрхий дөө, мөрөөрөө амьтан шүү. Ажилч хичээнгүй. Бас олонтой нийцтэй” хэмээн хамаг л сайн сайхан үгийг олж ядан түүнд зориулдаг байв.

Гэтэл нэрэндээ тийм боловч Ядамжав нидэр дээр ааш зан нь адсага шиг, үг хэл нь хараалаар багтаж ядсан хүн аж. Доожоогүй байдлаа хэн хүний нүүрэн дээр ил гаргадаггүй боловч нүдэн далддаа ёстой нэг хэнийг ч тамын ёроолд унагаж, халуун галд шатааж өгдөг байлаа. Энэ нь хараал урсгаж, хачин байж боломжгүй үгийг ар араас нь хөврүүлдэг байв. “Хүнийг муу муухайгаар хэлсэн хүн өөрөө л тийм болдог юм” гэж ах зах хүмүүс, ээж нь хүртэл түүнд хэлээд хүлээж авахгүй. Олны нүдэн дээр бол ёстой л мөрөөрөө сайхан эр байх, орон гэртээ орж ирээд л бухимдаж бухаж гардаг аж.

Нэг удаа Ядамжав албан газрын хадлангийн талбайд манаачаар ажиллаж байв. Зуны улирал талбай руу хонь мал орох нь даанч дэндүү. Яльгүй жижигхэн зайгаар ч шургаж орхино. Ядамжав талбайгаа эргэж явтал баахан ямаа ороод дүүрчихсэн усалгаатай талбайн өвсийг ёстой нэг талхалж өгч байв. Ядамжав ч ухасхийв. Ямаа ч ухасхийв. Тэр амжиж нэг ямааг ар талынх нь хөлнөөс барьж аваад хашааны төмөр шонг савж орхив. Ямаа нэг муухай орилоод хэдэнтээ татвалзан хөдөлж байгаад үхчихэв. Ямааг үхэх хооронд Ядамжавын орилдог хараадаг онцгой авьяас нь тодорч

- Сүүлээ таслуулж, сүүгээ асгуул. Үр нь тасарч үндэс нь ялзар! гэж ирээд хэнд юунд хандаж байгаа нь үл мэдэгдэх хараалыг ам хуурайгүй урсгаж байв. Ямаагаа хайж явсан өвгөн Гомбо

түүний үглэж дуулахыг сонсч байгаад очиж,

- Хүү минь чи халуун зунаар хөгшин бид хоёрыг хар цай уулгаж яах гэсэн юм бэ? Сүү нь тасар! гэж малаа хараадаг монгол хүнийг анх удаа харав. Өөрт чинь л муу болж амны чинь хишиг зайлна шүү дээ гэх мэтээр ухуулах уурлахын хооронд баахан юм ярьжээ. Ядамжав сурсан зангаараа худлаа инээж,

- Ах минь, би ажилдаа түүртээд тийм юм хэлчихлээ. Ямааг тань төлж өгье. Манай компанийнхан гэж хэл ам таталсан хүмүүс байдаг юм. Гадны мал хадлангийн талбайг цөлмөж байна гээд л эртүүд сүр бадруулаад байсан юм. Хэцүү байна шүү. Хэцүү байна гэжээ. Хар нялхаасаа эцгийнхээ орыг залгаж хэдэн дүүгээ ээжтэйгээ хамтад нь тээж тэтгэх гэж зовж зүдэрч зожиг зан сурсан хүүгээ ээж нь авир аашийг нь засах гэж их л оролдож лам харгуйд очиж үзжээ. Хэн нь ч,

- Хүү чинь нүгэлтэй гэдэг байв. Үнэхээр ч Ядамжав идэр дөчин хэдхэн насандаа дал наятай хүний өвчлөх өвчнөөр өөд болов. Хүмүүс Ядамжав шиг худал хэлж хулгай хийдэггүй, тамын зовлонг энэ насандаа эдэлчихсэн болохоор тэр л жаргах ёстой гэж бодож байж.

Гэтэл нөгөө бүх зовлонгоо хар нялхдаа эдэлж, жаргахаас өөр замгүй үлдсэн Ядамжав нь хүний хорвоод олигтой сайныг үзэж, олонтой наргиж чадалгүй хорвоог орхижээ. Мэдээж хамгийн том хүү нь хачин өвчнөөр өвдөөд араг яс шиг болтлоо турж байгаад нас барсанд ээж нь сэжиглэн шаналж байв. Ядамжавын аавын удамд ч, түүний ээж болох зовлонд унасан энэ хөгшний удамд ч нарийнтаж үхсэн хүн байгаагүй юм. Тийм болохоор талийгаач Ядамжавын ээж хүүгийнхээ хар залуугаар жигтэй байдлаар үхсэн талаар хожим Зонгоров хэмээх ламаас асуужээ.

Түүнийг эртний монгол заншлаар ил задгай оршуулсан хийгээд хэрэглэж байсан хувцас хэрэглэлийг нь хажуухантай нь шатаасан зэргийг сонсоод Зонгоров лам буруу оршуулжээ. Ядамжавын хувцаснаас хэдэн шинэ хувцас үлдээж хожим үр хүүхдэд нь хэрэглүүлэх байсан юм байна. Гэтэл бүгдийг нь шатааж устгасан байна гэх зэргээр ярьжээ. Энэ нь юу гэсэн утгатай вэ гэвэл Ядамжав өвчиндөө шаналж байхдаа, нөгөө шонд савуулж үхсэн ямаа шигээ муухай дуугарч зовиурлаж, тайвшруулах эм хичнээн тарьсан ч үхэж байгаа ямаа шиг орилсоор байжээ. Амьсгал хураахаасаа хэдхэн минутын өмнө тэр эв эрүүл хүн шиг алгуурхан нүдээ нээжээ. Гэр дотор нь түүнийг сахигчид сүүлчийн горьдлого тээж ухаан санаа нь эрүүл саруул болчихлоо гэхэд нэг хашир өвгөн,

- Энэ нэг л биш зам нь шуударчихсан байна. Сүүлчийн үгийг нь хэлүүлэх гэж хөөрхийг ингэж эрүүл саруул болгодог юм гэж байв. Ядамжав амьсгаадан байж,

- Би үхэхгүй. Сая надтай сүүл нь тасарсан нэг муу ямаа үг хэлэлцэж, цэц булаацалдаж байна. Намайг чи шалдан буцах ёстой. Чамд хүн шиг амьдарсан удаа байхгүй. Чи үхсэн нь чамд л ашигтай гэж байна. Би зүүрмэглэж байсан юм уу.

Миний хурганы арьсан дотортой хоёр гурван дээл бий гэж хүртэл хэллээ. Миний дээл хувцас байгаа биз дээ гэж эхнэр рүүгээ хэзээний л захирч сурсан өнгөөр хэлэв. Мэдээж тэр дээл хувцас нь хаачив л гэж. Тэр бүхнийг үзэн харж санаа нь амарсан байдалтай болоод

- Хувцас үлдэнэ. Надаас хүн үлдэхгүй. Надад сайхан сэтгэл, зөв бодол, бусдад туслах санаа гэх мэт хүнд хэрэгтэй бүхэн байгаагүй. Тийм болохоор надад хүнээсээ үлдээх юм байхгүй. Тийм болохоор намайг төлөөлж дээл хувцас л үлдэх учиртай гэжээ. Энэ бүхнийг нь тухайн үедээ мартсанаас түүний талийгаач болсны дараахан нь бүх хувцсыг нь шатаасан аж. Энэ нь түүний хувьд үлдээх юмгүй болгосон хэрэг болов. Өсөх насандаа зовсон хүн өглөх насандаа жаргах хувьтай байдаг юм гэнэ лээ гэж ярьдаг үг шал дэмий усан үг бололтой. Хэлний бузарт унасан хүн энэ насандаа хичнээн зовлон бэрхшээл үзээд нүглээ арилгаж, цэвэршиж ариусч чаддаггүй аж. Хамгийн “том” бузар бол хэлний бузар гэнэ лээ.

## ОРШУУЛСНЫ ДАРАА ДҮҮГИЙНХЭЭ ГЭРТ СУУЖ БАЙЖЭЭ

Төрсний эцэст үхдэг нь амьтны ёс. “Мөнхрөхгүйгээс хойш” гэсэн зоримог сайхан үг байдаг ч “Арай л эртхэн хорвоог орхилоо” гэсэн эргэж хургасан, хоргодсон байдал ч элбэг тохиолддог. Тэр бол “арай л эртхэн явчихлаа” гэсэн ангилалд багтах нэгэн байлаа. Түүнд отгон дүү нь дэндүү хайртай байжээ.

Жил мэнгэ нь таарахгүй байсан ч заавал оршуулганд нь оролцоно хэмээжээ. Хэн ч хориглоод дийлсэнгүй. “Газар дээрх ганц хайртай ахынхаа оршуулганд оролцохгүй бол дүү нь болж төрсний хэрэг гэж юу байдаг юм” гэсэн түүний үгийг хэн ч няцааж чадсангүй. Бич жилтэй хүний цогцсонд гар хүрэх нь хонь жилтэй байх учиртай. Тийм болохоор талийгаач Сосор бич жилтэй, дүү Дугаржав нь хулгана жилтэй. Оршуулганд явж яасан ч таарахгүй л байв. Дугаржав нэгэнт хэнд ч хоригдоогүй болохоор гарынхаа алган дээр хонь зураад оршуулганд оролцов. Ахынхаа хөлнөөс өргөж, урьдаас бэлдсэн нүхэнд нь хийжээ. Тэр үед Дугаржав яагаад ч юм асар их уясал, уярал цөхрөлийн байдалд орчихож билээ.

Шарилын нүх ухаж хажууханд нь овоолсон сул шороонд гараа далд ортол нь зоож,

- Даанч дээ, ийм эрт явчихыг нь мэдсэн бол ганц шил архи ахиухан аваад өгчих минь яалаа гэх зэргээр бага жижгээс баахан ихийг хүртэлх бүх гомдол цөхрөлийн үгийг дурдаж дурсаж байв. Шарилын дээр эхэлж шороо хаях хүн нь Дугаржав тул бусад нь хөдөлж ч чадахгүй, дуугарах ч үгүй зогссоор... Сосор, Дугаржав нарын нагац талын хамаатан нэг хүн уурлаж,

- Та нар хүнийг оршуулах гэж ирсэн биз дээ? Яах гэж байгаа юм бэ, одоо. Булж чадахүй юм бол буцаагаад аваад харих хэрэгтэй ш дээ гэсэн ясанд янхийж, цусанд цурсхийсэн үг хэлээтэхэв. Дугаржав орилон чарлан уйлсаар хүрз авч ахынхаа шарилын дээрээс шороо хаяж эхлэв. Хүмүүс ч амь орсон юм шиг ухасхийн хөдөлж төдөлгүй шарилыг булж орхив. Оршуулгыг удирдсан лам,

- Шарилын газраас гэр рүү хөдлөхдөө хэн нь ч эргэж харж болохгүй гэсэн билээ. Энэ үгийг хүн бүхэн санаж хичээж байв. Машиныуд асч зугуухан хөдөлцгөөн дараалалд орж төдөлгүй хурд аван давхицгаав. Шарилыг авчрахдаа үлэмж хүндэтгэл, үлэмж гашуудал эмгэнэлийг тээж явсан бол одоо хог новш хаячихаад ум хумгүй зугтаж байгаа юм шиг хурд нэмэн давхиж байв. Энэ бүхэн Дугаржавт нэг л сонин санагдсан тул “Хөөрхий муу ах минь, шарил цогцсоо булуулсан энэ мөчөөсөө эхлээд хүмүүст мартагдаж эхэллээ дээ” гэж харамсан бодож байв. Энэ бодол цээжинд нь гал мэт асч, түймэр адил дүрэлзсэний учир тэсэхийн аргагүй болов.



Тэгээд Дугаржав торойн хоцорсон ахынхаа шарилын хөшөө рүү эргэн харав. Гэтэл хажууханд нь зэрэгцэн сууж явсан нэг хамаатан нь түүнийг эргэж харж болохгүй гэдгийг ойлгуулжээ. Гэсэн ч тэссэнгүй. Тэр хэд хэдэн удаа эргэж харжээ. Хол ойроос ирсэн ах, дүүс нь ар арынхаа ажилд санаа зовниж эхэлсэн тул долоо хоног дээр нь цээрээ тавьж, арга засал, ерөөл даллага, буян номын ажлыг арвин их хийлгэжээ.

Тэр орой Дугаржав гэр гэрийн зүг одох ах, дүү хамаатан садангуудаа үдэж өгөөд гэртээ орж ирвэл хоймор нь нэг л танил хүн цаашаа хараад сууж байв гэнэ.

- За байз, биднийг эзэнгүй хойно ямар хүн орж ирдэг билээ гэж бодсон Дугаржав хоолойгоо засан дохио өгсөнд мань эр огтоос тоохгүй байв. Нарийн ажиглавал бэргэн эгчийнх нь,

- Ахынхаа эдэлж хэрэглэж явсан зүйлээс дуртайгаа ав. Үүнийг ав гэсээр байж хүчээр шахам өгсөн мөнгөн хэт хутгыг хоймор тушаа униндаа хавчуулсан байсан бөгөөд мөнөөх хүн тэр хэт хутгыг авах гэж оролдоод байгаа нь мэдэгджээ. Хойшоо харж завилж суусан тэр хүн босох чадалгүй нэгэн бололтой. Дугаржав гүйж очин нүүрийг нь харах гэтэл өмнөөс нь үнсэн саарал царайтай хүн гэхэд бэрхтэй амьтан нэгэн шар дөл цацруулсан хачин нүдээр өөдөөс нь тургин харсан нь түүний сүнсийг амьдаар нь тууж одох шиг болов.

Тэр хүний аймшигтай дүр төрх Дугаржавын бодол санаанаас хэд хоносон ч арчигдсангүй. Шөнө болгон зүүдэнд нь орно. Заримдаа талийгаач ах Сосор нь болчихно. Зүүд гэдэг хэзээд барим тавим байдаг болохоор тэр амьтан улсын сайд, том дарга хүртэл болж хувирна. Тэгсээр байж тэрхүү хачин дүр төрхтэй, шар дөл цацруулсан улаан цог шиг нүдтэй хүний царай Дугаржавт ихэд дотно нэгэн болон төлөвшжээ. Зүүдэндээ орилж хашгиран сэрэх, нойрмог явсаар талийгч ахынхаа шарил дээр очих тохиолдол ч Дугаржавт гарчээ.

Энэ бүхэнд цэг тавья гэж шийдсэн Дугаржав ламд очиж үзсэн харсан болоод зүүд нойронд давтагдах бүхнийг нэгд нэгэнгүй ярьжээ. Жил, мэнгэ таарахгүйгээс талийгчийн оршуулганд явсан. Бас шарилын газраас бараа тасартал эргэж харж болохгүй гэсэн ламын үгийг зөрчсөнөөс талийгч Сосорын сүнс дүү Дугаржавтаа шингэсэн байжээ.

Засал хийж, хэд хэдэн догжуур шатаасны эцэст Дугаржавын зүүд тунгалагшин цэвэршсэн гэдэг.

## Нас барсан бүсгүйн сүнс осолд орсон цэрэг эрийн биед шингэжээ

Энэ явдал 1980-аад оны дундуур Дархан, Эрдэнэтийн замд болсон гэдэг юм. Тэр үед ямар одооных шиг засмал шулуун дардан зам байсан биш. Тухайн үед Эрдэнэтэд ардын армийн томоохон дивиз байрладаг байлаа. Тэр үед цэргүүдийн хооронд оны ялгаа гэж айхтар дэг тогтсон байжээ. Шинээр цэрэгт татагдан ирсэн дайчдыг хуучин цэргүүд зодож дээрэлхэн дарамталдаг явдал байсныг гэрчлээд өгөх бас эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирсон олон аавын хүүхдүүд өнөөдөр ч бэлхнээ нотлох буй за. Басхүү хэрвээ дайн болбол тэр битгий хэл зовлон үзэж тангараг өргөсөн дайчид халагдах цэргээс шанаа авах нь ээждээ илүүлэхтэй адил хэмээн даналзах хүн ч байдаг. Гэхдээ энд цэргийн тухай өгүүлэх гэж байгаа юм биш. Харин Эрдэнэтийн дивизийн нэгэн ангид болсон нэгэн сонин тохиолдлын тухай өгүүлэх юм.

Зуны дунд сард цэрэгт татагдаж ирсэн шинэ цэргүүд карантинд гарчээ. Мэдээжийн өөрсдийнхөө халааг хүлээж бас хэдэн сар уйдсан цэргүүд намар эртийн цагаан хяруу буусан өдрүүдэд карантинаас бууж ирэх шинэ цэргүүдийг тэсч ядан хүлээжээ. Ингээд төд удалгүй шинэ цэргүүд тангараг өргөөд ангидаа ирж салаа ротод хуваарилагдаж өвлийн сургалт, шинэ хичээлийн бэлтгэл ажилд борви бохисхийх завгүй нухлуулж байсан хуучин цэргүүдийн нурууг тэнийлгэж байна. Орой үдшийн цагаар уйдаж залхсан хал цэргүүд ч зугаагаа гаргах юмтай болж шинэковуудыг өөрсдийнхөө үзэмжээр элдэвлэж тамлан зовоож эхэлсэн байна. Харин энэ дэглэлтийг ганцхан цэрэг л эсэргүүцэн хал цэргүүдтэй ана мана үзэлцэж багагүй зодуур амсчээ. Түүнийг Болд-Эрдэнэ гэх бөгөөд түүнийг цэрэгт явахад хамаатных нь нэг залуу “Чи цэрэгт очоод халууны зодуурыг битгий тэвчээрэй. Шууд л гар зөрүүл, тэд яаж ч чадахгүй, чи чинь боксын зэрэгтэй тамирчин хүн шүү дээ” хэмээн баадууг нь мушгиад мордуулсан юмсанж.

Үнэхээр ч Болд-Эрдэнэ хал цэргүүдэд зүгээр номхон зогсч байгаад элэг, шанаа аваад байсангүй. Ингээд нэг орой “ах” нарын бүслэлтэд орж аргагүйн эрхэнд хүчин мөхөсдөн нэвширтэл зодуулан тархиндаа хүнд гэмтэлтэйгээр цэргийн эмнэлэгт хүргэгджээ.

Өөрийн гэсэн ухаангүй хүргэгдсэн цэргийг сэхээн амьдруулах тасагт хэвтүүлж, яаралтай мэс ажилбар хийн тархинд нь хуралдаж бөөгнөрсөн цусыг хусч авснаар хэд хоногийн дараа ухаан оржээ. Гайхалтай нь ухаан орсон цэрэг хажуудаа байсан эмчээс “Миний нөхөр, охин хоёр яасан бэ? Зүгээр үү? Тэр хоёр маань амьд уу?” гэж асуужээ.

Мэдээж ийм үг сонссон эмч маш их гайхжээ. Цэргийн албанд татагдаж ирсэн хүн эхнэр, хүүхдээ л асууна уу гэхээс юу гэж нөхөр, охин гэж балайтах билээ. Тиймээс эхэндээ цэргийн үгэнд эмч төдий л ач холбогдол өгөлгүй “Солиорч байна” гэж бодоод өнгөрсөн байна. Гэхдээ жижүүрийн эмч ерөнхий эмчдээ “Цэрэг залуугийн ухаан орон гарч солиорлын байдалтай байна” гэдгээ хэлжээ. Амьдралдаа элдвийн л адал явдалтай таарч бас хажуугаар нь судалгаа шинжилгээний ажил хийдэг хурандаа мэдрэлийн эмчийнхээ үгийг сонсоод өвчтөний өрөөнд оржээ. Гэтэл тэрээр огтхон ч түгдрэлгүйгээр “Миний нэрийг Саранчимэг гэдэг. Би одоо 38 настай. Сая нөхөр охинтойгоо хамт Дарханаас Эрдэнэт орох гэж яваад Хангал өртөөний тэнд осолд орчихсон юм. Гэнэтхэн л машин маань жолоодлогогүй болж газрын уруу эрчээрээ буусныг л санаж байна” гэжээ.

Түүний ярианаас үзвэл тэрхүү осол нь Эрдэнэтээс бараг 100-гаад километрийн цаана болсон байх магадлалтайг хашир хурандаа мэдэрчээ. Гэвч ихэнх эмч нар залуугийн тархинд өөрчлөлт орсон учир солиорч байна гэсэн дүгнэлтэд хүрч Улаанбаатар руу цэргийн төв госпиталь руу шилжүүлэхийг санал болгосон ч хурандаа зөвшөөрөөгүй байна. Тэр цэргийн эрүүл мэндийг өөрийнхөө хяналтад авч түүний хэлсэн ярьсан бүхнийг шалгаж үзэхээр шийдсэн байна. Гайхалтай нь өвчтөн Болд-Эрдэнэ нэг өглөө гэнэт баруун гараа харснаа “Хөөе, энэ чинь миний гар биш байна. Миний хуримын бөгж хаачсан юм бол” хэмээжээ. Энэ үгийг сонсоод ерөнхий эмч, хурандаа Эрдэнэтийн замын цагдаагийн газарт очиж сүүлийн үед гарсан автын ослын талаар лавлагаа автал үнэхээр хориод хоногийн өмнө Улаантолгойн САА-н цаахна орших төмөр замын “Хангал” өртөөний замд цэрэг Болд-Эрдэнийн барин тавин ярьж буй осол болж Саранчимэг хэмээх бүсгүй нас барж нөхөр, охин хоёртойгоо эмгэнэлт хэрэг гарсан болохыг олж мэджээ. Ийм үг сонссон өвгөн хурандаа өөрийгөө арай галзуураагүй байгаа хэмээн бодох шахав. Тэгээд эмнэлгийн орон дээр тархи толгой нь битүү боолттой хэвтэж байгаа “Саранчимэг”-т чи аль хэдийн нас барчихсан юм байна шүү дээ гэж хэлэхийг яарсангүй.

Туршилт цааш үргэлжилж, хурандаа элдвийн таамаглал дотроо дэвшүүлэн өвчтөнөө өөрөө гардан эмчилж байлаа. Нэг удаа Болд-Эрдэнээс “Чи тэр өдөр ямар машинтай явж байсан бэ?” гэж өдөөн хатгалт маягаар нууцхан асуусанд “Манай нөхрийн ахын Нива машинтай явж байсан” гэж огт түгдрэлгүй хариулсан байна.

Ийнхүү ерөнхий эмч маань амьдралынх нь туршид огт тохиолдож байгаагүй оньсого шиг зүйл таарсанд цэргийн ар гэрийнхнийг дуудуулжээ. Алс баруун хязгаараас ирсэн түүний аав, ээжтэй уулзаж өвчтөний ерөнхий байдлыг хэлж тархи нь хүнд гэмтсэн учраас аль болох цочоож айлгахгүй байхыг хэлж түүний баг насных нь түүхийг тэмдэглэж авсан байна. Өвчтөн Болд-Эрдэнэ өөрийнхөө аав, ээжийг ер танихгүй байжээ. Гэвч залуу хархүүг галзуурч солиорсондоо ийм зүйл яриагүй гэдгийг эмч нар санал нэгтэй зөвшөөрч ээж, аавд нь ч хэлсэн байна.

Түүнийг тусгай өрөөнд хэвтүүлж байнга тайвшруулах тариа хийх болжээ. Анхаарал халамжийг ч сайтар хангасан байна. Энэ завсар судалгаа гэмээр асуултыг байнга тавьж хурандаа өдөр шөнөгүй ажиллаж байлаа. Нэг удаа эмч түүнийг бараг өндийгөөд суучихсан байхаар нь хэсэг зуур энгийн байдлаар ярилцахаар шийджээ. “За, Саранчимэг ээ, бие чинь яаж байна даа? Ямар нэгэн зовиур байна уу?” хэмээн асуужээ. Гэтэл өвчтөн “Гайгүй болж байна аа. Харин бүх бие аймаар хөндүүр байх юм. Уг нь хугарч гэмтсэн зүйл байхгүй л юм шиг. Мөн энэ бие минийх биш юм шиг муухай бодол төрөөд байх юм. Та надад толь өгөхгүй юу, би өөрийгөө нэг хармаар байна” гэжээ. Энэ зуур эмч түүнд өөр асуулт тавихаар шийдсэн байна. Тэгээд “Та өөрийгөө толинд хараад нэмэргүй дээ. Учир нь чамд үнэнийг хэлэх ёстой болчихоод байгаа юм. Та чинь ингэхэд тэрхүү ослын улмаас нас барчихсан шүү дээ” гэжээ. Мөн “Та арай ч нөгөө ертөнцөд хараахан очоогүй байна аа. Огт өөр хүний биед ухаан санаа чинь шингэчихээд байна. Та саяхан нас барсан нэгэн цэргийн биед хувилчихсан гэдгийг хэлье. Чухам яаж гэдгийг зөвхөн бурхан тэнгэр л мэдэх байх” хэмээн шуудхан хэлж орхижээ.

Цэрэг залуу нэлээд хугацаанд чимээгүй сууснаа “Энэ явдал хэр удаан үргэлжлэх бол? Би ингэхэд ер нь яах ёстой гэж та бодож байна” хэмээн асуухад хурандаа жаахан балмагдан

“Чухамдаа л энэ талаар хоёулаа ярилцъя гэж бодсон юм. Хэр удаан энэ байдал үргэлжлэхийг мэдэхгүй байна. Яагаад гэхлээр миний амьдралд анх удаа ийм явдал тохиолдож байна. Одоо таны өмнө хоёрхон зам үлдсэн. Юуны өмнө чи хуучин амьдралдаа эргэж орох боломж огтхон ч байхгүй гэдгийг хэлье. Өөрөөр хэлбэл хайртай нөхрийнхөө эхнэр хөөрхөн охиныхоо ээж байх боломж огтхон ч байхгүй гэсэн үг. Хамгийн гол нь энэ бүх бодлоо өөрийнхөө бодлоос бүрмөсөн арчиж хаях хэрэгтэй. Харин нөхөр, охин хоёртоо захидал бичиж болно гэж бодож байна. Уг захиа яах аргагүй чамаас иржээ гэдэгт тэд бүрэн итгэсэн байх шаардлагатай гэдгийг харгалзаж үзээрэй. Тэдэнд ямар захиа илгээх, түүнд чухам юу гэж бичихээ та өөрөө бодож ол. Харин ар гэрийнхэн чинь чамайг амьд гэдгийг мэдсэн ч уулзах боломжгүй гэдгийг ойлгох ёстой. Ингэснээр та өөрийнхөө хамгийн дотно хүмүүст учирсан гай зовлон, уйтгар гунигийг багагүй хэмжээгээр нимгэлэх болно.

Харин би эмэгтэй хүн бас нөхөр хүүхэдтэй гээд зүтгээд байвал өөрийг чинь эмч нар шууд л галзуурч гэж үзээд Шар хадны галзуугийн эмнэлэгт шилжүүлчихнэ. Нөгөө нэг боломж нь та өөрийгөө дөнгөж 20 хүрэх гэж байгаа залуу хүн гэж бодох хэрэгтэй байна. Тэгээд л амьдралаа цоо шинээр эхлэ. Чамайг тархи нугасны хүнд гэмтлийн улмаас санах процессоо алдсан гэсэн оноштойгоор эмнэлгээс гаргах болно. Тэгээд шууд л энэ залуугийн гэрт шууд очих болно” гээд өөрийнх нь цэрэг хувцастай зургийг өгөөд “Чиний эцэг, эх, төрөл төрөгсөд ч хүүгээ амьд байгаад баярлаж хүлээж авах болно” гээд гарчээ. Маргааш өглөө нь эмчийг өрөөнд нь явж ороход Болд-Эрдэнэ “Би хэзээ эмнэлгээс гарч нөхөр, охин хоёр дээрээ очих вэ? Би захиа биччихсэн” гээд орон дээрээ өндийгөөд суучихсан байжээ.

Ингээд түүнийг дээр өгүүлсэнчлэн тархи нугасны хүнд гэмтлийн улмаас санах ой тогтоомжоо алдсан гэсэн оноштойгоор эцэг, эхийнх нь асрамжинд хүлээлгэн өгсөн байна.

## **Овоон дээрээс хүүхдээр мөнгөн эдлэл авахуулж хорлов**

Манай нөгөө барам л явж өгөхгүй юм. Сумын төв дээр нэг хэсэг дэмий тэнэх ажилтай юм байх. Тэгээд ч манай ээж гэж нэг дураараа хөгшин хүүхэд эрхлүүлээд яагаа ч үгүй том толгой суулгачихаж байгаа юм гэж Нанзад сум дундын шүүгчид гомдол мэдүүлж байгаа юм шиг гоморхож тунирхан Цэрэнгийн орж ирэв. Нанзад, Цэрэн үе тэнгийн хоёр өвлийн амралтаар Нанзад сумын төв орж нөгөө “том толгойтоо” авахаар явахад нь Цэрэн охиноо захиж морийг нь хөтлүүлэн явуулжээ. Тэгээд л Цэрэнгийн үг шуутай, үнэрхэл тунирхалтай орж ирж байгаа нь тэр. Сурагч охин ч гэртээ ирсэндээ баярлаж догдлон, дүү нартай эрхлэлдэж, мал хунараа ямар болсныг үзэж харахаар орж гарч гүйнэ. Нанзад ч Цэрэнгийн хэсэг саатаад гэрийн зүг оджээ. Орой нь Цэрэнгийн охин Сэржмаа халуурч эхлэв. Замдаа даарсан эсэхийг лавласанд,

- Нанзад ах Цагаан толгойн овоон дээр бууж тамхи татаж байгаад “Миний охин тэр овоон дээр байгаа эмээлийн даруулгыг аваад өг” гэсэн гэжээ. Цагаан толгойн овоо гэдэг учиргүй догшин бас тоймгүй баян толгод юм. Хүн болгон хайртай цээртэй морь малынхаа толгой тэргүүнийг аваачиж, тэнгэрт таалцуулж бурханд бүртгүүлж өргөсөөр байгаад бүхэл бүтэн адууны толгойн ясаар уул босохоо дөхжээ.

Тэгээд ч зогсохгүй өөрт нь өргөсөн даатгасан болгоныг харж хамгаалж байдаг ид шидийн “амьтан” болсон юм шиг түүнийг үзнэ. Цэрэн охиныхоо үгийг сонсоод ихэд бухимдав.

- Чамайг даа, учир мэдэхгүй нялх үрээр минь догшин овооны эзэнд гар хүргүүлнэ гэнээ гээд юу юугүй л “Сэрэлт” кинон дээр гардаг шиг цамнаж гарав. Эхнэр нь Нанзадын олз ашигт шунамхай, хар санаатай хүн гэдгийг чи одоо л мэдээ юу? Түүний оронд охиныхоо биеийг яаж эмчилж сайжруулахаа эхэлж бодсон нь дээр байх аа...

Энэ үг Цэрэнгийн уур бухимдлыг намжаав. Тэрүүхэнд бөгтөгнөн ач охиноо харж сэтгэл зовж байсан Цэрэнгийн ээж,

- Эмчид ч оч. Төмөр гуайндаа ч оч. Эмч лам хоёр элбээд ирэхээр Нанзадын санаа биелэлдээ хүрэхгүй биз хэмээн шүд зуух аядав. Төмөр гуай гэдэг нь ном судар шагайж суудаг жирийн нэг өвгөн. Гэхдээ хар авдарт ном байдаг, халтар өвгөдөд эрдэм бий гэж эртний үгтэй юм хойно. Цэрэн ээжийнхээ үгэнд орж Төмөр гуайнд очжээ. Болсон явдлыг ярьжээ.

Өвгөн ч “Наадахыг аргалах гээд оролдож болох юм. Нэг дом байдаг юм билээ. Аль эртний хүүхэд байхдаа л би настайчуулыг дагаж яваад олж мэдсэн юм” гэж ярьснаа ер нь юмыг яаж мэдэхэв гэсэн үү яасан “Энэ бол миний хийж байгаа зүйл биш. Домыг яаж хийх тухай ярьсан хэрэг” хэмээн араа батлав. Цэрэн,

- Ямар ч байсан та тэр домоо хийж аль гээд салсангүй тул өвгөн зөвшөөрчээ.

Өвгөний өөртөө итгэлтэй байгааг далимдуулж Цэрэн “Охиноор минь буруу зүйл хийлгэж хорлосон Нанзадыг хараагаад зам мөрийг нь баллаад өгвөл сайн байна” гэж нэг сумаар хоёр туулай буудаж сурсан анчин шиг шалж шаардав. Явах гээд хувцсаа өмсч байсан өвгөн маш ихээр уурлаж,

- Чи хүнийг хэлэхээргүй муухай дотортой хүн юм. Би ямар хараалч юм уу? Тэгж хүний зовлонгоор жаргал хийж, зовлонгоор зоос цутгаж байдаг хүн үү гэж ирээд буцаад суудалдаа суучихав. Цэрэн ч буруутсанаа тэр даруйхнаа ойлгож, гэмшиж ятгасаар өвгөнийг дагуулж харив. Охины хөл тэсэхийн аргагүй өвдөн халуурч байв. Хүмүүс сандралдаж,

- Нанзадынх руу очиж овоон дээрээс авсан эмээлийн мөнгөн бааврыг буцааж өг гэж гуйя гэх зэргээр өөр өөрийн бодлоо илэрхийлнэ. Төмөр гуай төдий л сандралгүй,

- Цэрээн! Чи хурдан хээрийнхээ арьсыг хадгалж байгаа юу гэв. Цэрэнгийн хурдан хээр морь хоёр жилийн өмнө хөгширч үхсэн билээ. Тэр үед эзэн нь ихэд гашуудаж арьсыг нь маш нямбай өвчиж аваад адсага (дэвсгэр) хийсэн байжээ. Цэрэнг хариулж амжаагүй байтал,

- Тэр байна. Тамга нь зурайж байна шүү гэж хоймрын орны доогуур хагасыг нь оруулж дэвссэн хээр морины адсагыг Төмөр гуай заав. Морины адсаганы дээрх дэгээтэй саран тамгыг өвчтэй хүүхдийн гарын бугуйн дээр улаан харандаагаар зураад арьсны үсийг эсрэг нь хэдэнтээ илбүүлжээ. Энэ нь мөнөөх нас барсан хурдан аргамгийн ид шидийг сэргээж байгаа үйлдэл гэнэ. Мөнөөх өвчнийг намтгах (эдгээх ч гэж болно) мундаг үйлдэл нь ийм л юм байв.

Тэгээд мөнөөх адсаганы (арьсан дэвсгэр) үсийг дотогш харуулан хуйлж эвхээд Цагаан толгойн овоон дээр аваачиж тавьжээ. Юм гэдэг яльгүй учир холбогдлоос болж хичнээн зуу мянган хувиар ч өөрчлөгдөж хувьсдагийг мэдэх аргагүй. Төмөр гуайн хийсэн тэр арга дом үйлчилсэн үү, нөгөө хүүхдийн хувь заяаны чивцаан тийм байсан уу тэр даруйхнаа өвчин нь намдаж эдгэрчээ.

Хүний шунал тачаал гэдэг хязгааргүй гэнэ. Тийм учраас Нанзадын овоон дээрээс өөрийнхөө хүүхэдтэй адилхан хүүхдийн хувь заяа, бараг амь насыг золиослон байж авсан хэдэн мөнгөн бааварны тухай ямар ч үг дурсахгүй байхыг өвгөн Төмөр хүмүүст аминчлан захьсан хэмээмү.

## Язгууртны булшийг ухаж баяжих гээд буруутав

Хүн гэдэг амьтан зовлогоо зовоохгүй шиг байж байгаад л арвин зоос олоод авчих юмсан хэмээн бодож явдаг амьтан аж. Энэ төрөлхийн гэмээр зан авираасаа төө ч холдож салж чадаагүй хүн бол Цэрэндондог юм. Тэр яаж байгаад амар хялбар аргаар бэлэн зэхээний юман дээр буучих вэ гэж өдрийн бодол, шөнийн зүүд болж явна. Тэр чинээгээрээ бага их олзыг дэлсч явсан ч түүх олон бий. Цэрэндондогийн нутгаас археологчид хэдэн мянган жилийн өмнө амьдарч байсан хүний булш олж дэлхийн түүх судлалд том хувь нэмэр оруулсан байна. Энэ үгийг мань эр газар ухаж байсан хэдэн нөхөд нэгнийгээ гэнэтхэн тэврэн баярлалдаж ганц нэг шил юмны бөглөө мулталж хоорондоо ам булаалдан байгуулсан гавьяагаа тэмдэглэж байхад нь сонссон хэрэг. Тэдний ярилцах нь газрын гүнээс мөстлөг энэ тэр ч гэнэ үү, тэндээс олдсон эртний хүний шарил нь алтан шаргал үстэй, монхор хамартай байсан магадлалтай, бараг өндөр Гонгороос дутахгүй урт мөчтэй, бас хажуунаас нь ваар, шилбүүр зэрэг олдсон нь Монгол газар хэдэн мянган жилийн өмнө цагаан арьстнууд нутаглаж байсан гэх баримт гарцаагүй мөөн гэлцэн гар хуруугаа гозойлгон ярьцгааж байсныг ч Цэрэндондог өөрийн “мэдлэгийн сандаа” хэзээ ч мартагдахгүйгээр тэмдэглэж авчээ.

Хөлжих, баяжих хүслээс өөр онц бодолгүй шахам хөдөөх эр Цэрэндондог,

- Та нар энэ аль дивангарт үхсэн хүний өгөр ясыг маш үнэтэй зүйл гээд байх юм. Яг хэдэн төгрөг хүрэх вэ? гэж нэг мэргэжилтнээс сэм асуув.

- Маш их үнэтэй. Үүний үнэ цэнийг та бид хоёр илэрхийлж, ойлголцож чадахгүй болов уу гэж археологич залуу үнэн голоосоо хэлжээ. Цэрэндондог мориндоо мордож гэрийн зүг шогшиж байхдаа “Арай ч дээ. Үхсэн хүний шарил ийм үнэд хүрдгийг мэдсэнгүй. За байз” хэмээн бодолхийлж байв. Тэр өдрөөс хойш мань эр царил, жоотуу, хүрз, алх гээд л хайгуул хийхэд хэрэг болох багажуудаа цуглуулж тааранд боогоод амбаартаа хадгалав. Авгай хүүхэд нь “Хүрз хаана байна” гэж эрэл зүхэл болж байхад манай хүн түүнийг огтхон ч сонсохгүй толгойныхоо ард хоёр гараа салаалан тэврээд хэвтэж байв. “Байрмын хиргисүүр (эртний булш) тийм үнэд хүрч байгаа юм чинь Өтгөн харынх бол түүнээс дутахгүй байх” хэмээн санааширна. Цэрэндондог нэг л өдөр хоол цай базааж, “хайгуулчны багажаа” дүүрч явсаар Өтгөн хар хэмээх бяцхан уулын өвөр бэлд орших иртэй хүрэн чулуудыг уур омог, уйтгар харууслын илэрхийлэл болгосон юм шиг шовх үзүүрийг нь дээш харуулан шивэлж босгосон эртний булшин дээр очоод царил, жоотуу зэргээ сүртэй гэгч нь шиджээ.

Хэдэн ч үе улирч хөрс шороондоо урган төлжсөн нь эс мэдэгдэх догшин хүрэн чулуудад хүрсэн түүний царил, жоотуу зүрхшээн халирах шиг “жин” гэсэн жижигхэн чимээ гаргахаас цаашилсангүй. Цэрэндондогт хиргисүүрийг нурааж олон зуун мянган жилийн өмнөх үхсэн хүний өгөр ясыг гаргаж ирэхэд ядах юмгүй санагдана. Гэвч нэг л зүйл саад болж байв. Энэ нь Өтгөн харын орой дээр гарч мал бараагаа дурандах нутгийн өлөн цөөврүүд. Цэрэндондог хиргисүүрийн зулай дээрх ургаа том чулууны ёроол руу царилаа зоож орхиод дахин “өлөн цөөврүүд” гэж үзэн ядахын дээд цэг дээр гараад завилаад суучихсан хүний араншинг асгаж байв. Нөгөө “Өлөн цөөврүүд” нь өөртэй нь адилхан хэдэн малынхаа хойноос л малгай шүүрэн ухасхийдэг ижил зиндааны малчид, магадгүй хамаатан садных нь хүмүүс шүү дээ. Цэрэндондог хэсэг тээнэгэлзэж байснаа шийдэв бололтой гэнэт ухасхийн царилаа шүүрч

аваад мөнөөх “хүрэн үхэр” чулууг учир зүггүй нүдэж гарав. Царил нь махийх атал мөнөөх “хүрэн үхэр” мөөрөх ч үгүй аж. Гэнэт толгой нь заадсаараа салж, тэнгэрийн заадал шиг хоёр тийш ярагдаад дундаас нь нэгэн сүүмгэр хөх гэрэл гарч ирээд тэрбээр ухаан алдан унажээ. Түүнийг сэрэхэд толгой дээр нь хонх дамрын дуу тачигнаж, арц хүжийн өтгөн утаан дундаас тойрон суусан хүмүүсийн зүс царай нэг ялгаран бас буцаж бүдгэрэн байлаа. Цэрэндондог эргэж ирж байгаа нь тэр бүлгээ.

Ламын айлдсан нь дээдсийн газарт гар хүрснээс хиргисүүрийн сахиус хилэгнэж, саа дайрсан гэнэ. “Одоо зүгээр” гээд явахдаа түүний хамрын баруун талын нүхийг эр ямааны хуухнагийн хявас, өмхий хүрний хатаасан махаар утаж бай хэмээн эхнэрт нь захиад явсан гэнэ лээ.



## **Бодь суварга босгосон ч сүнс нь хүүгээсээ үнэнийг л нэхлээ**

Олон жил удирдах алба хашиж, дээдсийн хүрээлэлд байр сууриа засч хүний амьдралд хоргодон тачаах нь хэтэрхий болсон Гэндэнжав эмч өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалж чадсангүй. Ер нь хүн өөрийнхөө сайн мэддэг, сайтар хийж чадах зүйлдээ бүдэрдэг гэдэг. Усч хүн усандаа, баатар дайчин эр сум сэлмийн ирэнд амь насаа өргөдөг нь түүхээр шалгагдаж, түмэнд батлагдсан ажгуу. Гэндэнжав эмч сар тутамд шинжилгээ хийлгэдэг байсан бөгөөд нэг удаагийн шинжилгээгээр түүнд хавдрын шинж тэмдэг илэрчээ. Дөнгөж илэрсэн нөхцөлд хорт хавдрыг эмчлэх боломжтой тул айх сандрах зүйл байсангүй. Гэтэл өмнөх сар тутмын үзлэг шинжилгээ нь худал хуумгай болж байснаас элэгний өөрчлөлт нь өндөр зэрэгтэй болсон байлаа. Хятад, Солонгосгүй явж эмчилгээ хийлгэх гэсэн ч нэгэнт хугацаа алдсан байсан тул өвчний хурдцыг удаашруулах төдий үйлчилгээтэй эм тариа хэрэглэх болов. Өвгөн эмчийн бие өдрөөс өдөрт сульдаж доройтсоор хэдхэн сарын дотор арьс яс болтлоо туржээ. Дээдсийн зиндаанд амьдарч жаран насыг жаргаж туулсан түүнийг үхлийн үүдэн дээр очоод байхад уулзаад салах гэсэн хүмүүсийн цуваа хүн чанар, үгүйдээ ёс жудгаа бодолцон цуварч байлаа. Эмчийнх гурван хүүтэй. Хоёр эр, нэг охины хувьтай хүн гэж жаахан халамцаад ирэхээрээ өөрийгөө дөвийлгөдөг байжээ.

Хоёр хүү нь нэр нөлөөтэй эцгийнхээ өв залгамжлагч болохоор өрсөлдөж эхлэв. Үнэндээ Гэндэнжав гуай амьсгал хураах хүртлээ хоёр хүүгийнхээ хэнийг нь ч албан ёсны өв залгамжлагчаар зарлаж, голомт манах эрхийг нь олгоогүй юм. Тиймээс л хоёр хүү нь эцэгтээ таалагдах гэж янз бүрийн арга саам хэрэглэж байв. Том хүү нь ганц хоёр ах болохоор дүүгээсээ арай холыг бодож нөгөө ертөнцөд одох болсон хүний сэтгэл зүйд нөлөөлөхүйц зүйлийг бодож олжээ. Том хүүг Цацралт, багыг нь Цогоо гэнэ. Харин хүргэн нь тэдний өв залгамжлах гэсэн өрсөлдөөнийг холоос харж суув. Эхнэрээ ч “Хоёр арслангийн дундуур битгий ор” гэж хориглосон аж. Гэндэнжав эмч эмнэлгийнхээ орон дээр дусалтай дүүжлүүрийн хүчээр энэ хорвоод уяатай байгаа юм шиг хэвтэж өдөр хоногийг өнгөрүүлнэ. Өвчнийх нь шаналгаа мэдэгдэм хэцүү болох тусам өвгөн эмчийн нүд амарлингуй, эрүүл саруул байснаасаа ч илүү ухаалаг болно. Эхэндээ тэр,

- Гурван жил амьд байгаад үхэх юмсан гэж хэлдэг байсан бол сүүл рүүгээ илүү хоёр өдөр амьдарсан ч сайхан, хоёр өдрийн өмнө үхсэн ч сайхан, эрлэг намайг хэрэгсэх болсонд л баярлаад барахгүй байна гэж хээв нэг хэлдэг болжээ. Нэг удаа дүүжилсэн дусал дундрахын үед Гэндэнжав гуай зүүрмэглэснээ:

- Одонтуяа минь! Ванчинхүү, чи намайг уучлаач гэж хашгираад сэрчихэв. Сувилагч бүсгүй урагш ахин хөнжил хучлагыг нь засаад,

- Зүүдлэв үү? Бие чинь яаж байна гэж ёсыг бодон асуужээ.

- Тэглээ. Бие гайгүй, өвдөх бол хэцүү юм биш. Надаар эмчлүүлж байгаад нас барсан өвчтөнүүд л зүүдэнд ороодянз бүрийн ааш авир гаргаад намайг шаналгаж зовоогоод байна. Миний алдаанаас болсон болов уу гэж өөртөө сэжиг хурааснаас тэр үү өвчтөнүүдийн сүнс амилаад зүүрмэглэх аядахад л хүрч ирж элдэв юм ярьж үймүүлэх юм гэжээ. Ийнхүү өвгөн эмч сувилагч бүсгүйтэй ярьж байтал том хүү Цацралт нь нүүрэндээ гэрэл цацруулан орж

ирэв. Тэр,

- Аав аа, би танд буяны бодь суварга босгуулах болсон. Харин хоёр сая төгрөгөөр босох юм гэсэн. Би хагасыг нь гаргая, харин таны данснаас хагасыг нь авахаас өөр аргагүй боллоо гэжээ. Зөөлөн суудалтай машинд Гэндэнжав эмчийг суулгаж зуслангийн газарт ойр ногоон бүсэд босгосон гоёмсог суваргыг үзүүлжээ. Гэндэнжав гуай ч баярлаж, үхлээ гээд сүнсээ хадгалуулах “гэртэй” байна гэдэг том хувь заяа хэмээн үг алджээ. Энэ үед бага хүү Цогоо нь ихэд дурамжхан байсан бөгөөд хүргэн Ганболд нь “ага” нарын зөрчлийг сэм ажиглаж байв. Амьддаа өөртөө зориулсан бодь суваргыг харж, том хүүгийнхээ холч хэрсүүг үнэлсэн Гэндэнжав гэртээ хэвтэж байгаад үхнэ гэсэн шийдвэр гаргаснаар тэндээс шууд гэртээ хүргүүлжээ. Мань өвгөн өвчин зовуурь нь эмээр намдахгүй болмогц том хүүдээ,

- Намайг ухаан алдахад битгий удаан зовоогоорой. Шууд л тариа хийчих. Үүнийг хийснээрээ чи миний хамгийн хайртай хүү болж, миний голомтыг авч явах эрхтэй болно гэжээ. Энэ санамсаргүй шийдвэрийг Цацралтын дүү Цогоо болон бусад ах дүүс нь бүгдээрээ сонсчээ. Өвгөнийг өөд болоход сүүр дуулиантай оршуулаад 49 хоног дээр нь эдэлж хэрэглэж байсан эд зүйл болон цай идээ зэргээр суваргыг нь дүүргэж, нүсэр зан үйл хийжээ. Талийгаачид Цацралт хэлэхдээ,

- Таны хэрэглэж байсан бүх эд зүйлийг энэ суваргад авчран байрлуулна гэсэн байжээ. Яг цаг дээрээ хүн гэдэг амьтан амьдралынхаа туршид хурааж цуглуулсан зүйл нь тухайн суваргад багтах нь бүү хэл хэдэн хүнд даацын машинаар ачаад дуусахгүй их аж. Тийм болохоор арай хэрэг болохгүй гэсэн зүйлийг нь суваргын тооноор чихээд битүүлэн шаварджээ. Цацралт эцгийнхээ өв залгамжлагчаар тодорсон хүний хувьд бүхий л ажилд манлайлах үүрэгтэй оролцов. Цугларсан хүмүүс ч талийгаач Гэндэнжавын хамгийн сайн сайхан чанаруудыг үйл явдлаар амилуулан ярьсаар зоогийн ширээн дээр өрсөн хоол гүнцэгийг хоосолж орхиод таржээ. Цацралт оройхон гэртээ харихад эхнэр нь түүний амжилтад талархаж, хүзүүгээр нь тэврэн үнсчээ.

Бас дүү Цогоо нь ямар нэг зүйлийг Цацралттай булаацалдаж, хэл ам гаргаж магадгүй учир маш болгоомжтой байхыг ч тэр нөхөртөө захиж байв. Цацралт зөөлөн диван дээр тарвайн хэвтээд эцгээсээ өвлөсөн хөрөнгөө яаж зүсийг нь хувиргаж дүүгийнхээ өлөн нүдийг төөрөлдүүлэх вэ? гэж бодож байв. Бас өөрийгөө үнэлдэг хүний хувьд “Бодь суварга гэнэ шүү” гэж инээд алдав. Үнэндээ тэр бодь суварга гэгч тоосгоор босгож шавардаж шохойдсон тагзыг гурван сая дотор л нэг барилгын компаниар хийлгэж орхисон билээ. Тэгээд 22 сая төгрөгөөр боссон гэж худлаа залсан юм. Суварганаас унагасан хориод сая төгрөгөө эхнэртээ ч мэдэгдээгүй юм. Энэ нь ямар учиртай вэ гэхээр Цацралт 9-р ангид байхдаа нэгэн зохиолчийн охинд хайртай, майртай гэж байгаад жирэмслүүлж орхисон. Түүнээс гарсан хүүхэд нь одоо бараг хорь хүрсэн залуу болжээ. Дараа нь жирийн ажилчин хүний охиноор “тоглож” охин дэгдээхэй дагуул болгон явуулсан байна.

Түүний залуудаа үйлдсэн эдгээр “нүглийн” нүд одоо түүнийг онилоод ээжүүд нь Энэ хүүхдээ ав! гэж Цацралтыг дарамтлах болов. Бас сүүлийн эхнэр ч түүний урьдын явдлыг мөрдөж мөшгин нууц хүүхдүүдтэй нь уулзуулахгүй байхыг чармайх болов. Тэгэхээр мань Цацралт хэрэг болох өдөр ирнэ гэж эцгийнхээ амьдад нь мэхэлж суварганы үнийг суга нэмж дамлах арга хэрэглэсэн байна. Энэ бүхнийгээ эргэцүүлж нэг хэсэгтээ толгой өвдөхгүй байж болно

гэж бодож хэвтсэн Цацралт зүүрмэглэж орхижээ. Гэтэл зүүдэнд нь эцэг нь хаанаас ч олж өмссөн юм бүү мэд нэг муу шар дээлийн тамтаг өмсчихсөн ирээд уйлж байна. Цацралт аавыгаа ингэж уйлж байхыг амьдад нь хараагүй байв. Өвгөн эмч Гэндэнжав,

- Хүү минь, би тэр диваажинд чинь очих гэсэн боловч намайг миний гарт үрэгдсэн өвчтнүүдийн сүнс оруулахгүй байна. Тамд оч гэж намайг хөөгөөд болохгүй юм. Арга барахдаа чиний босгосон бодь суварганд очиж толгой хоргодоё гэтэл бас болохгүй. Энэ чинь буяны суварга биш бузар шингэж, шунал шургалсан муу ёрын оромж гэж эрлэгийн элчүүд намайг хөөв. Хүү минь, чи даанч яав даа. Яахлаараа тэр суварга чинь шунал, бузар шингэсэн газар байдаг билээ гэж гаслан уйлж байв. Энэ бүхнийг Цацралт сэрүүн байгаа юм шиг мэдэж байлаа. Эхнэр нь гал тогооны өрөөнд тачигнатал төмс хэрчиж байна. Үхсэнийхээ хойно өр нэхэж ирсэн эцгээсээ салах гэж, хар дарсан зүүднээсээ сэрэх гэж Цацралт хэдэн хором оролдов.

Гар нь хөдөлж өгөхгүй, хашгирах гэхэд дуу нь гарахгүй баахан тарчилж хар хөлстэйгөө хутгалдаж арайтаа л үхэхийн наана сэржээ.

Цацралтын нөгөө мундаг “хужаа” төлөвлөгөө аль нэгтэйд хийсэн оджээ. Эцгийнхээ үзэшгүй муухай болсон нүүр царай, тамтаг шиг хувцас хунар ер нь зэвүүн байдал нь түүний толгойноос салахгүй байв. Ёстой л түүний сүнс нь зайлчихсан юм шиг ямар ч хийморь лундаагаа гэсэн мэт сулавгар болжээ. Айхад аргал хөдөлдөг гэдэг. Энэ үгийг батлах гэсэн юм шиг сервант дээр өрөөд тавьчихсан Гэндэнжав эмчийн мөнгөн аяганууд чичирч доргин дуугарч хоорондоо зодолдох амьдлаг чимээг сонсгов. Толгойных нь үс босч зараа шиг болсон Цацралт айн чичирч байв. Огцом эргэж хана руу харахад эцгийнх нь гавьяатын тэмдэгтэй зурагны нүд улаанаар эргэлдэж, Цацралттай мөргөлдөх гэж байгаа юм шиг харагджээ. Түүгээр ч зогсохгүй эмчийн зураг эвэртэй болж тэр шовх үзүүрээр Цацралтыг учиргүй сүлбэж орхих нь гэлтэй толгойгоо духуйлгаж, нүд нь улам улаанаар эргэлдэх авай. Цацралт айхдаа чацгаа савируулах шахаж эхнэрийнхээ хоол зэхэж байсан гал тогооны өрөө рүү зугтаах мэт оржээ. Нэрэлхсэндээ энэхүү болсон явдлыг тэр эхнэртээ хэлсэнгүй. Маргааш нь ламд очиход,

- Чи эцгийнхээ сүүлчийн хүслийг биелүүлж, бодлыг нь мухарлаж чадаагүй байна. Тийм болохоор талийгаачийн сүнс очих газаргүй болж хамгийн ихээр итгэсэн хүү чамаасаа буян нэхсэн байна хэмээжээ. Цацралт мөнөөх ламын зөвлөснөөр өвлийн хүйтэнд хунгаралсан цасан дундуур унаж тусан явсаар аавынхаа суварга дээр очжээ. Нүцгэрсэн ойн бяцхан цорхойдцаснаас үл ялгаран харагдах суварганы орой дээр нэгэн муу ёрын хар хэрээ суугаад зэвүүн муухай дуугаар “гуага-гуага” хэмээн тонголзон хашгичиж байлаа. Цацралтын дотор жихүүцэж үхсэн эцгийнхээ сүнсийг ч амраах хувьгүй нүгэлт үйл хийснээ ухааран байваа. Тэгээд тэрбээр ламд хандаж,

- Та эцгийн минь сүнсийг орох оронтой болгож өгөгтүн гэж уйлах шахам урвалзан гуйжээ. Ламбугай аяны хар тогоо гаргаж доош харуулан тавиад хэдэн багц номыг дүнгэр дүнгэр дуугарган уншиж гарав. Доош харуулж тавьсан тогооны ойр хавиар цас хайлж төдөлгүй хавар болсон мэт гэрийн буурийн чинээ газар харлаж доороос нь нялх ногоо, ноднингийн хэнз өвсний хамт цухуйж харагджээ. Ламын уншлага үл тасалдан нүргэлж байв. Хэдэн цаг өнгөрсний дараа, ламтан

- За, чиний эцгийн сүнс энэ тогоотой холбогдлоо. Цас ханзарсан энэ хэсэг газар бол эцгийн чинь сүнс дураараа зугаалж эрх дураараа байж болох газар юм. Тийм болохоор боломжтой бол хайс хашаа барьж бусад ан амьтан, хүн мал ойртож, орж гарахаас сэргийлэх хэрэгтэй. Хэрэвзээ хэн нэгэн амьтан энэхүү сүнсний эзэмшилд ойртвол түүний хорлолыг амсах юм. Үүнээс хойш талийгаачийн үр хүүхэд, чи өөрөө ч гэсэн энэ хайсан дотор орж болохгүй. Холоос суваргыг харж залбирч байгаад буцаж болно. Ийм л байна даа хэмээн хэлжээ. Харин Цацралт аавынхаа талийгаач болсны зуу дахь хоног дээр суварга бүтээхдээ зувчуулж үлдсэн арван хэдэн сая төгрөгийг “Аавын минь сүүлчийн өглөг энэ шүү” хэмээн баруун, солгойгүй цацсан гэдэг. Эцгийн сүнс хүүгээ хүмүүжүүлсэн нь энэ болой.

## **Чөтгөртэй найзалж гавжийн дамжаа барих шахсан нь**

Зэрэг мяндагт зэгсэн хорхойсох болсон Чүлтэм гэвш шавь нарынхаа хамаг байдгийг булаах шахан хэдэн тэрэг ачаа болгон авчраад Хүй мандлын хөндийд гэр майхан барьж суужээ. Хэдэн тэрэг ачаа нь түүнийг Гавжийн дамжаа барихад хэрэг болох шар тос айраг, хонь мал, архи дарс алт мөнгө билээ. Номынхоо хэр зиндааг үзэж зэрэг дэвшихэд хоол унд, хоргой торго оролддог нь өнөөгийн хэлээр тэр үед “авлига” байсныг илтгэнэ. Шавь нэртэй зарц нар нь Чүлтэм ламын энэ увайгүй байдалд далдуур дургүйцэх боловч “Зэрэг нэмэхийн өмнө” гэдэг кинонд гардаг шиг тэр дургүйцлээ илт илэрхийлж чадахгүй. Чүлтэм гэвш байсгээд л хөл хөнгөнтэй хонгор морио унаж, аль таарсан шавь албатынхаа нэгийг дагуулан Гандан хийд дээр очно.

Орон хотон олон жил амьдарч, дамнуурчны гудамжны шавар шавхайн дундаас л хааяа нэг сувд түүх болсон суурин лам нар Чүлтэм гэвшийн хээрийн салхи сэнгэнүүлсэн хийморь цогтой байдалд агаархана. Гэхдээ тэд хүнд л байдаг агаархуу жөтөөрхүү зангаараа номын цэц булаалдах, улмаар Гавьжийн дамжаа барих үед нь Чүлтэм гэвшид нэг зүйлийг мэдрүүлэх гэж боджээ. Аз болоход Чүлтэм гэвшийн нутгийн нэг лам жинчин дагаж хүрээнд ирээд Гандан хийдэд сууж нэлээд нэр нөлөөтэй болсон нэг лам байв. Түүнийг Алтан гэнэ. Энэ түүний жинхэнэ нэр үү, эсвэл хоч нь уу гэдгийг Чүлтэм мэдэхгүй. Түүнийг мэдээд ч яах билээ. Алтангийн нүүр толгой нь гялтганасан төмөрлөг шар аж. Магадгүй түүнээс болж мань эрийг энэ дэлхийн хамгийн үнэтэйд тооцогдох металлын нэрээр хочилж орхисон ч байхыг үгүйсгэхгүй. Алтан гэсгүйн гэрт Чүлтэм гэвш нэг орой нутгаасаа авчирсан идээ цагаа мах шүүсний дээжийг авчран багагүй хугацааг баржээ. Алтан гэсгүй,

- Ном сурахад нохойн амнаас ч үг сонсдог гэдэг юм. Гавж болоход гайтай зийтэй амьтантай ч нөхцөж байж бүтээдэг юм гэжээ. Үүний учрыг Чүлтэм эхэндээ ойлгосонгүй. Гэтэл Алтан гэсгүй бурхан залсан хоймрынхоо хүрэн авдар дотроор зүс царай гэж аймшгийн дүрстэй амьтны загвар гаргаж иржээ. Одоогийнхоор бодоход олиг муутайхан хүүхэлдэй л байсан юм уу даа. Илбэ шидийн юмандаа сайн гэж Гандан даяар шивэр авир ярианд өртөж явдаг Алтан гэсгүй хэдэнтээ ном уншиж, аяганд хийж тавьсан ус буруу тийшээ хурд аван эргэлдсээр нэг томхон хар цаг болж хувирахад түүнийг авч мөнөөх зэвүүн дүрстэй хүний загварын сэгсгэр толгой руу цацаж орхижээ. Мөнөөх зүйл ч хоромхон зуур алга болчихов. Алтан гэсгүй хэлж байна.

- Сая амь орсон тэр зүйл бол гавьжийн дамжаа барихад тус болох учиртай юм. Чиний зүүн мөрөн дээр түүнийг заларч яваа гэж бод. Ямар нэг туслалцаа хэрэгтэй болсон үедээ түүнд хэлж бай. Түүнийг “Жинбээ” гэж дуудаж байгаарай гэжээ. Тэндээсээ Чүлтэм гэвшийг гарч ирэхэд хүрээний хэдэн том банди нар түүнийг өдөж,

- Цавын будаа идэх нь үү? Цавуутай толгойгоо өөрөөсөө яаж салгах гэж байгаа юм бэ? гэж хашгиралдан инээлдэж байв. Нэг биерхүү банди гүйж очин Чүлтэмийн морийг тайлж хормойгоо дэвэн үргээж орхив. Суурин газрын шургааган хашаа, энд тэндгүй хэрзийж ёрдойсон шон зэрэгт дасал болж амжаагүй морь гөлмөө дэрвүүлэн үргэж одов. Банди нар тачигнатал инээж,

- Гомбо бурхан хүрэн халзан мориноосоо салчихлаа. Хувилгаан хүн болохоороо юу алзахав? гэж Чүлтэм гэвшээс ам асуух, өөрсдийгөө хөгжөөхийн хооронд шуугилдана. Чүлтэм,

- Жинбээ, чи байна уу? гэхэд нарийн жонгинуур хоолойгоор “Тийм ээ, эзэнтээн” гэх нь тэр. Чүлтэм гэвш Алтан гэсгүйн хэлснийг санаж,

- Жинбээ, чи морийг минь аваад ир! гэжээ. Төдөлгүй үргэж бусган тачигнатал давхиж одсон түүний морь хар устайгаа хутгалдаж хөлөрчихсөн, чихээ буулгаж омог нь дарагдчихсан баруун талын урд хөл нь яльгүй доголчихсон ирж Чүлтэм гэвшийн хажууд гэмших мэт зогсчээ. Түүнээс хойш Чүлтэм гэвш үл үзэгдэгч итгэлт нэгэн зарцтай болжээ. Түүнийг дагаж ирсэн бараа бологсад нь Чүлтэм гэвшийг гэнэтхэн бүх зүйлээ өөрөө хийх болсонд гайхаж,

- Ариун номын оронд ирсэнээр зан ааш нь хатсан шир шиг, залхуу хойрго нь хад чулуу шиг Чүлтэм гэвшийн байдал өөрчлөгдлөө. Бурхны оронд буг хүртэл өөрчлөгдөж буяны замд ордог юм байна гэж өвөр хоорондоо ярилцаж байв. Урд хойгуур хөөцөлдөж, хээл хахуулийн сувгийг бий болгосны хүчинд Чүлтэм гэвш арав гаруйхан хоногийн дараа Гавьжийн дамжаа барихаар тов нь тогтжээ. Гандан хийдийн нөлөө бүхий нэгэн дацанг толгойлдог их халзан толгойтой улаан шаргал лам Чүлтэмийг хүлээж аваад,

- За, чи Чоймбол номын хааны нутгаас ирсэн юм биз дээ? Бид хар багадаа Түвдэд хамтдаа шашны номд суралцаж байсан юм. Чоймболын нутгаас ирсэн ламын чойг нь үзээд яахав. Дамжаа барих өдөр чинь би нэг даалгавар өгнө. Түүнийг чи биелүүлбэл болох нь тэр гэжээ. Чүлтэм гэвш их ламыг ямар даалгавар өгөх бол гэж бодон шаналсаар сүүлдээ сэтгэл мэдрэлийн өвчтэй болох шахжээ. Нутгийн Алтан гэсгүйд ч их ламын хэлснийг дуулгажээ. Гэсгүй ч үүнийг огтоос тоохгүй,

- Тэгнээ тэр, тийм учраас л би чамд Жинбээг амилуулж өгсөн юм. Манайхан эхэндээ шашныг жинхэнэ утгаар нь мандуулна гэж сүржигнэж байсан. Сүүлдээ нөгөө үзэн ядаад, үнс болгох гэж шүдэнз зураад байдаг бөөгийн шидийг ашиглан эвлэрч эвхэв биш үү хэмээв. Нэг сайхан намуухан өглөө Чүлтэм гэвш дамжаа барих хувь төөрөгтэй байжээ. Үнэхээр Да хүрээнийх ийм байдаг гэдэг шиг том улбар нар мэлтрэн байв. Олон мяндагтнууд ёслолын хувцсаа өмсч бүрээ бишгүүрийн дуу хангинана. Дамжаа барих хуралдаан ёс төртэй эхлэв. Бага таван ухааны мэдлэгийг нь сорих эхний шалгуур явагдаж байхад их лам,

- Чоймбол номын хаан (Номын хаан гэдэг нь арван ухаанд хэтийдсэн эрдэмтэй ламд өгдөг баруун нутгийнхны аман ярианы цол хэргэм бололтой)-ы нутгаас ирсэн Чүлтэм гэсгүйд ийм асуулт тавьж яах гэсэн юм. Чоймбол Гандан хийдэд мөргөхгүй гэж ам өргөсөн хүн. Чи түүний нутгийн хүн бараг шавь нь болохоор Чоймбол ламын алхыг олж авчир. Арав хоногийн хугацаа өгье. Тэр алх бол олон арван догшид бурхны алт мөнгөөр урлахад хэрэглэгдэж байсан номын буян ид шид шингэсэн алх юм шүү гэжээ. Чүлтэм гэвш Чоймбол номын хааныг их уран хүн гэж сонссон байснаас түүнийг яаж бурхан бүтээдгийг нь холоос ч болов харсан нь үгүй билээ. Их ламын үгийг сонссон Гавжийн дамжаа бариулах ёслолын зохион байгуулагчид үйл ажиллагаагаа даруйхан зогсоож Чоймбол номын хааны алх ирэхийг хүлээхээр болжээ. Чүлтэм гэсгүй итгэлт туслагч Жинбээгээ дуудав.

- Жинбээ, чи байна уу?

- Тийм ээ, эзэнтээн.

- Чамд найдаж байна.

Чи Чоймбол номын хааны бурхан бүтээдэг дарханы алхыг надад авчир. Тэгэж гэмээнэ би Гавжийн дамжаагаа шууд барьсанд тооцогдож цол хэргэмээ авах юм.

- За, хичээеэ. Гэхдээ энэ удаагийн даалгаврыг тань би биелүүлж чадахгүй байх вий гэж айж байна. Та намайг явснаас хойш нохойны баасаар утлага хийж ирэн ирэх хүртэл тасралтгүй уугиулан, Чойжоон догжуурыг буруу залаад байж байгаарай гэжээ. Тэгж хэлмэгц Жинбээ хоромхон зуур алга болчихжээ. Маргааш өглөөний мандахын улаан нарнаар өрнө зүгийн бүрэнхий нь арилаагүй хар хөх тэнгэрийн доогуур гал, цахилгаан маналзаж хоёр амьтан урд хойноо орон хөөцөлдөх шиг дүрс харагджээ. Чүлтэм лам нохойны баасаар сан тавих байснаа мартаад нэг чимх арц гал дээрээ нэмэхэд хажууханд мөнөөх Жинбээ нь аймшгийн дүр царайтай тоглоомон хүүхэлдэй болон ирж унажээ. Буурал сахалтай булай өвгөн түүний гараас жижигхэн мөнгөлөг алхаа аваад дээрээс нь нэг том далайж цохиод явж одов. Тэр өвгөн бол Чоймбол номын хаан байжээ. Жинбээ нохойны баасаар тавьсан утлаган дээр арц нэмснээс болж хүч тамираа алдан хойноосоо хөөж ирсэн номын хаанд дийлдэж “Амь эрсэдсэн нь” тэр байжээ.

Чүлтэм гэвш Чоймбол номын хааны ид шидтэй алхыг Гандангийн их ламд аваачиж өгч чадаагүй тул Гавжийн дамжаа барих ном хаялцсанд үнэнээсээ оролцоод шүүлтүүрийг дааж чадалгүй нутаг буцжээ. Тэр дамжаа барина гэж өчнөөн өр зээл тавьж хээл хахуульд хамаг бүхнээ бараад үхэх тухай бодсоор нутаг буцжээ. Замдаа хамт явсан хүмүүсээсээ зугтаж бадарчилж одсон гэдэг.

# Table of Contents

<a href="#">Чөтгөр болсон андыгаа “хороож” нялх хүүхдийг аварсан түүх</a>
<a href="#">Хөх даяанчийг дууриаж хөгөө чирсэн эр</a>
<a href="#">Шар толгойн хүүрийн газар тоглож өссөн найзууд бүгдээрээ цаг бусаар нас баржээ</a>
<a href="#">Хар хэлтэй бүсгүйд таалагдсан Сайнбуянгийн амьдрал сүйрэх шахжээ</a>
<a href="#">Чөтгөр шүглэснээс болж хүүгээ буудаж өөрийнхөө хоолойг хэрчжээ</a>
<a href="#">Чөтгөртэй нөхөрлөж, түүнийг мохоож явсан аюуш хувилгааны нэгэн тохиолдол</a>
<a href="#">Арабууд монголын говьд үхэр нядалж, эзнийх нь сүнсэнд хоригджээ</a>
<a href="#">Охиных нь сүнс шоронгоос аавыгаа гаргажээ</a>
<a href="#">Хөөргөнд шүглэсэн чөтгөр буюу түүнийг өвөртлөж явдаг ламтан</a>
<a href="#">“Ална шүү” гэдэг үгийн хор сүнсийг нь авч оджээ</a>
<a href="#">Үхээрийн шувууг буудах гээд амиа алджээ</a>
<a href="#">Талийгаачаа зөв зүгт нь гаргаж чадаагүйгээс сүнстэй нь зууралдах болов</a>
<a href="#">Далд ертөнцийг хардаг Раашийн учрал явдлууд</a>
<a href="#">Далан давхарт буугаад моргт амьдарч байгаагаа мэдэв</a>
<a href="#">Тэнэг Цэрэндоржийн тэнхээг чөтгөр ч дийлээгүй гэдэг</a>
<a href="#">Тува бөөтэй тулам нэгтгэсэн хулгайч үзэгдэшгүй шидийг олжээ</a>
<a href="#">Номонд хоргодсон сүнс</a>
<a href="#">Оонын эвэр шиг ах, дүүс гуйлгачин болж нас бараад олон хүнд гай уджээ</a>
<a href="#">Нэгэн хийдийн шүтээнд тохиолдсон адал явдал</a>
<a href="#">Шаравсамбуу бөөгийн ном үйлчлэхгүй болохоор инээд алдаад байдаг гэнэ</a>
<a href="#">Эрийн сайнаар бус ламын сайнаар эхнэр авчээ</a>
<a href="#">Хэлмэгдсэн цэргийн сүнс олон машин эвдэлжээ</a>
<a href="#">Урд төрөлдөө бөө байсан эмэгтэй охиныхоо ид шидийг биширдэг</a>
<a href="#">Хамбын овооны ламын чөмгөөр ганлин хийгээд шийтгүүлсэн нь</a>
<a href="#">Хэвлий дотроо үхээд, өмхийрчихсэн хүүхдийг хувьсгалын эсэргүү оточ огтлон авч байжээ</a>
<a href="#">Бөөгийн адууг хөөгөөд хөлийнхөө хурууг тасартал хараалгав</a>
<a href="#">“Толгойгоо шаах цаг ирнэ дээ” гэж хараагаад хэлсэндээ хүрчээ</a>
<a href="#">Нас барсан өдрөө чөтгөр болон хувилжээ</a>
<a href="#">Хасаг, монгол хоёр өвгөний уншлага, хилэнд өртсөн намын дарга нанжидаа хүртжээ</a>
<a href="#">Хятад амбаны нүдийг сохортол хараасан хасаг бөө шувуу болон нисдэг шидтэй...</a>
<a href="#">Өвчин өвөртөлж зам унаж ирсэн хужаагийн адыг даржээ</a>
<a href="#">“Ялгагчийн гэгээн” хэмээн алдаршсан нэгэн бүсгүйн шид</a>
<a href="#">Амхай удганд эмээгийнх нь сүнс байнга харагддаг байв</a>
<a href="#">Аяганд ниргүүлсэн хүний сүнс үлдэхгүй тонилдог</a>
<a href="#">Булшин дээр хачин амьтантай таарч буудан хороов</a>
<a href="#">Торгонд шүглэсэн хараал бүсгүйг хорложээ</a>
<a href="#">Нүглээ нуусан ч нүүрэн дээр нь гарч ирээд болсонгүй</a>
<a href="#">Нас барсан бүсгүйн сүнс осолд орсон цэрэг эрийн биед шингэжээ</a>
<a href="#">Овоон дээрээс хүүхдээр мөнгөн эдлэл авахуулж хорлов</a>
<a href="#">Язгууртны булшийг ухаж баяжих гээд буруутав</a>
<a href="#">Бодь суварга босгосон ч сүнс нь хүүгээсээ үнэнийг л нэхлээ</a>



Чөтгөртэй найзалж гавжийн дамжаа барих шахсан нь